Public Disclosure Authorized
Public Disclosure Authorized
Public Disclosure Authorized
Public Disclosure Authorized

58366

Тотгвортой хөгжил - Зүүн Ази, Номхон Далайн Бүс

ХЭЛЭЛЦҮҮЛГИЙН БАРИМТ БИЧИГ

МОНГОЛ УЛС

Монгол орны байгалийн чухал нутгуудын хамгааллыг эдийн засгийн хөгжилтэй уялдуулан баталгаажуулах нь

2009 оны 1 сар

BirdLife INTERNATIONAL

Wildlife Science and Conservation Center of Mongolia

Монгол орны байгалийн чухал нутгуудын хамгааллыг эдийн засгийн хөгжилтэй уялдуулан баталгаажуулах нь

2009 оны 1 сар

BirdLife INTERNATIONAL

Wildlife Science and Conservation Center of Mongolia

© October 2008 The International Bank for Reconstruction and Development/THE WORLD BANK

1818 H Street, NW

Washington, DC 20433 USA

October 2008

All rights reserved.

Энэ баримт бичгийг Зүүн Ази, Номхон далайн бүс нутгийн хөдөөгийн хөгжил, байгаль орчин, байгалийн нөөцийн ба салбарын нэгж, BirdLife Asia (Токио хот) болон Зэрлэг амьтан судлан хамгаалах төвтэй (Улаанбаатар хот) хамтран бэлтгэж, Японы итгэлцлэлийн сангаас санхүүжүүлэв. Энэ тэргүүнд тулгамдсан асуудлуудыг тодорхойлох, тогтвортой хөгжлийн бодлого, бүтэц, зохион байгуулалтын цар хүрээг бэхжүүлэн, төсөл, хөтөлбөр, бодлогын чанартай яриа хэлэлцээ, зээлийн бус үйлчилгээ болон түншлэлийн замаар байгаль орчин, нийгмийн хөгжлийн гол сорилтуудыг даван туулах үзэл баримтлалыг Дэлхийн банкнаас боловсруулсан Бүс нутгийн байгаль орчин, нийгмийн хөгжлийн стратегийн баримт бичигт тусгажээ. Зүүн Ази, Номхон далайн Тогтвортой хөгжлийн хэлэлцүүлгийн баримт бичгийн ийм цуврал нь хөгжиж буй орнуудын хамтын нийгэмлэгийн болон өөрийн харилцагч орнуудын хүрээнд бодлогын чанартай асуудлаар туршлагаа хэлэлцүүлэх өргөн боломж олгодог учиртай. Энэ баримт бичгийн талаар ГМТ-ны мэдээллийн хамтаар www.worldbank.org/eapenvironment болон www.worldbank.org.mn гэдэг хаягаар орж үзнэ үү.

Иш татах эх сурвалж:

BirdLife Asia. 2008 он. “Монгол орны байгалийн чухал нутгуудын хамгааллыг эдийн засгийн хөгжилтэй уялдуулан баталгаажуулах асуудал”. Зүүн Ази, Номхон далайн бүс нутгийн тогтвортой хөгжлийн хэлэлцүүлгийн баримт бичиг. Зүүн Ази, Номхон далайн бүс нутгийн тогтвортой хөгжлийн департмент, Дэлхийн банк, Вашингтон хот.

Судалгааны багтай холбогдох мэдээлэл:

BirdLife Asia,
TM Suidobashi Building, 4F, Misaki-cho 2-14-6, Chiyoda-ku,
Tokyo 106-0061, Japan
Утас: +81 3 52130461, Факс: +81 3 52130422
Цахим шуудангийн хаяг: info@birdlife-asia.org
Веб хуудас: www.birdlife-asia.org

Энэ баримт бичиг Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк/ Дэлхийн банкны багийн бүтээгдэхүүн болно. Баримт бичигт дурьдсан асуудал, тайлбар болон дүгнэлт Дэлхийн банкны гүйцэтгэх захирлууд, эсвэл тэдгээрийн төлөөлж буй засгийн газрын үзэл баримтлалыг тусгаагүй болно. Уг баримт бичигт хавсаргасан газрын зурагт харуулсан хил хязгаар, өнгө, хэмжээ, масштаб болон бусад мэдээлэл нь аливаа нутаг дэвсгэрийн хууль ёсны статус, эсвэл тухайн хил хязгаарыг дэмжиж, хүлээн зөвшөөрч буй асуудлаар Дэлхийн банкны байр суурийг илэрхийлэхгүй. Энэ баримт бичгийн материалд зохиогчийн эрх хамааралтай. Уг баримт бичгийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн зөвшөөрөлгүйгээр хуулбарлаж, шилжүүлэх нь холбогдох хууль зөрчсөнд тооцогдоно. Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банк/ Дэлхийн банк энэхүү бүтээлийг нийтийн хүртээл болгон түгээхийг дэмжиж, шаардлагатай бол үүний холбогдох хэсгийг дахин хэвлэх зөвшөөрөл өгөхөд ч бэлэн.

Энэ бүтээлийн хэсгийг хуулбарлаж, дахин хэвлэх зөвшөөрлийн хүсэлтийг бүрэн мэдээллийн хамтаар Copyright Clearance Center, Inc., 222 Rosewood Drive, Danvers, MA 01923, USA, telephone +1 978-750-8400, fax +1 978-750-4470, www.copyright.com. гэсэн хаягаар ирүүлж болно. Эрх болон тусгай зөвшөөрөлтэй холбоотой бусад бүх хүсэлтийг Office of the Publisher, The World Bank, 1818 H Street NW, Washington, DC 20433, USA, fax +1 202-522-2422, e-mail pubrights@worldbank.org гэсэн хаягаар ирүүлнэ үү.

Гарчиг

Өмнөх үг vi
Нэр томьёоны тайлбар viii
Товчилсон үг, хэллэг ix
Талархал xi
Хураангуй xiii
1. Танилцуулга 1
2. Судалгааны үндэслэл 3
2.1 Аюулд өртөж буй биологийн төрөл зүйл 3
2.2 Газар нутаг, амьдрах орчныг хамгаалах талаар Дэлхийн банкны баримтлах байр суурь 4
3. Судалгааны зорилтууд 7
4. Байгалийн чухал нутгуудыг тодорхойлох ажил 9
4.1 Мэдээллийн эх сурвалжууд 10
4.2 Улсын тусгай хамгаалалттай газрууд 12
4.3 Орон нутгийн тусгай хамгаалалттай газрууд 14
4.4 Олон улсын хэмжээнд хамгаалагдсан газрууд 15
4.5 Монгол дахь тахилага шүтлэгтэй газрууд 17
4.6 Монгол дахь шувуунд чухал газрууд 17
4.7 Байгалийн чухал нутгуудын нэгдсэн байдал 21
5. Монгол улсын хөгжлийн төлөвлөлтийн өнөөгийн байдал 23
5.1 Мэдээлийн эх сурвалж 23
5.2 Уул уурхайн салбарын хөгжил 24
5.3 Дэд бүтцийн салбарын хөгжил 29
5.4 Аялал жуучлалын салбарын хөгжил 35
6. Зохицуулалт, бүтэц, зохион байгуулалтын шинжилгээ 39
6.1 Байгаль орчны хамгааллын зохицуулалт, бүтэц, зохион байгуулалт 39
6.2 Уул уурхайн зохицуулалт, бүтэц, зохион байгуулалт 40
6.3 Аялал жуулчлалын зохицуулалт, бүтэц, зохион байгуулалт 42
6.4 Газар нутгийг хамгаалахад чиглэгдсэн бодлогууд 45

7. Байгаль орчинд хөгжлийн төлөвлөлтөөс үзүүлж буй нөлөө 47
7.1 Уул уурхайн хайгуулын тусгай зөвшөөрөл олгогдсон болон байгалийн чухал нутгууд хоорондын давхардлын дүн шинжилгээ 47
7.2 Уул уурхайн хайгуулын тусгай зөвшөөрөл олгогдсон болон байгалийн чухал нутгууд хоорондын давхардлын үр дагавар 49
7.3 Олборлолтын тусгай зөвшөөрөл олгогдсон болон байгалийн чухал нутгууд хоорондын давхардлын дүн шинжилгээ 51
7.4 Олборлолтын тусгай зөвшөөрөл олгогдсон болон байгалийн чухал нутгууд хоорондын давхардлын үр дагавар 55
7.5 Уул уурхайтай холбоотой дэд бүтэц болон байгалийн чухал нутгууд хоорондын давхардлын дүн шинжилгээ 58
7.6 Уул уурхайтай холбоотой дэд бүтэц болон байгалийн чухал нутгууд хоорондын давхардлын үр дагавар 59
7.7 Хайгуул болон олборлолтоос үүдэлтэй нөлөөнд өртөж буй байгалийн чухал нутгууд 61
7.8 Аялал жуулчлалын салбарын хөгжлийн төлөвлөгөө болон байгалийн чухал нутгуудын давхардлын дүн шинжилгээ 66

8. Зөвлөмж 75
8.1 Уул уурхай, дэд бүтцийн үйл ажиллагаатай холбоотой амьдрах орчны хамгааллын талаар 78
8.2 Аялал жуулчлалын салбарын үйл ажиллагаатай холбоотой амьдрах орчны хамгааллын талаар 81

9. Амьдрах орчны хамгаалал болон сөрөг үр дагаварыг багасгахад хэрэглэдэг тэргүүн туршлагууд 81
9.1 Уул уурхай, дэд бүтцийн үйл ажиллагаатай холбоотой тэргүүн туршлага 81
9.2 Аялал жуулчлалын үйл ажиллагаатай холбоотой тэргүүн туршлага 99

Ишлэл авсан бүтээлүүд 107

Хавсралтууд 113
Хавсралт 1. Улсын тусгай хамгаалалттай газрууд 113
Хавсралт 2. Орон нутгийн тусгай хамгаалалттай газрууд 117
Хавсралт 3. Монгол дахь олон улсын хэмжээнд хамгаалагдсан газрууд 118
Хавсралт 4. Монгол дахь тахилага шүтлэгтэй газрууд 120
Хавсралт 5. Монгол дахь шувуудад чухал газрууд 122
Хавсралт 6. Байгаль хамгааллыг зохицуулах тогтолцоо 125
Хавсралт 7. Уул уурхайг зохицуулах тогтолцоо 132
Хавсралт 8. Олон улсын хөгжлийн банкуудын байгаль орчныг хамгаалах бодлогууд 138
Хавсралт 9. Улсын тусгай хамгаалалттай газар ба хайгуул, олборлолт, уул уурхайн холбоотой дэд бүтцээс үүдэлтэй эрсдэлд нэрвэгдэх аюул бүхий газруудын хоорондын давхардал 141
Хавсралт 10. Шувуунд чухал газар ба хайгуул, олборлолт болон уул уурхайн холбогдолтой дэд бүтцээс үүдэлтэй эрсдэлд нэрвэгдэх аюул бүхий газруудын хоорондын давхардал 144
Хавсралт 11. Улсын тусгай хамгаалалттай газруудын хилийн дотор болон ойролцоо байршилтай аялал жуулчлалын баазууд 148
Хавсралт 12. Орон нутгийн тусгай хамгаалалттай газруудын хилийн дотор болон ойролцоо байршилтай аялал жуулчлалын баазууд 151
Хавсралт 13. Шувуудад чухал газруудын хилийн дотор болон ойролцоо байршилтай аялал жуулчлалын баазууд 152

Газрын зургууд

Газрын зураг 1. Улсын тусгай хамгаалалттай газрууд /2008 оны 6 сарын байдлаар/ 154
Газрын зураг 2. Орон нутгийн тусгай хамгаалалттай газрууд /2008 оны 5 сарын байдлаар/ 155
Газрын зураг 3. Монгол дахь олон улсын хэмжээнд хамгаалагдсан газрууд 156
Газрын зураг 4. Монгол дахь тахилага шүтлэгтэй газрууд 157
Газрын зураг 5. Монгол дахь шувуудад чухал газрууд 158
Газрын зураг 6. Байгалийн чухал нутгуудын нэгдсэн байдлын зураг 159
Газрын зураг 7. Хайгуулын тусгай зөвшөөрөл олгогдсон газрын зураг /2008 оны 6 сарын байдлаар/ 160
Газрын зураг 8. Аялал жуулчлалын баазуудын байршил 161
Газрын зураг 9. Байгалийн чухал нутгууд болон хайгуулын тусгай зөвшөөрлийн давхардал 162
Газрын зураг 10. Байгалийн чухал нутгууд болон олборлолтын тусгай зөвшөөрлийн давхардал 163
Газрын зураг 11. Олборлолтын тусгай зөвшөөрөл бүхий талбай, түүнээс 20 км зайд орших газрууд болон байгалийн чухал нутгуудын давхардал 164
Газрын зураг 12. Байгалийн чухал нутгууд болон аялал жуулчлалын баазуудын давхардал 165
Газрын зураг 13. Байгалийн чухал нутгууд болон Дорнод аймгийн зүүн хойд хэсгийн хайгуул, олборлолтын тусгай зөвшөөрөл бүхий газруудын давхардал 166
Газрын зураг 14. Улсын тусгай хамгаалалтай газрууд, шувуудад чухал газрууд болон Өмнөговь аймаг дахь олборлолтын тусгай зөвшөөрөл бүхий газруудын давхардал 167
Газрын зураг 15. Их Газрын Чулууны байгалийн нөөц газар болон хайгуул, олборлолтын тусгай зөвшөөрөл бүхий газруудын давхардал 168
Газрын зураг 16. Нагалханы байгалийн нөөц газар болон хайгуул, олборлолтын тусгай зөвшөөрөл бүхий газруудын давхардал 169
Газрын зураг 17. Сүйхэнт уулын дурсгалт газар болон хайгуул, олборлолтын тусгай зөвшөөрөл бүхий газруудын давхардал 170
Газрын зураг 18. Таван Толгойн орон нутгийн тусгай хамгаалалттай газар болон хайгуул, олборлолтын тусгай зөвшөөрөл бүхий газруудын давхардал 171
Газрын зураг 19. Дашинчилэнгийн Баян нуурын шувуудад чухал газар болон хайгуул, олборлолтын тусгай зөвшөөрөл бүхий газруудын давхардал 172
Газрын зураг 20. Ташгайн Таван нуурын шувуудад чухал газар болон хайгуул, олборлолтын тусгай зөвшөөрөл бүхий газруудын давхардал 173
Газрын зураг 21. Цэнгэл Хайрхан уулын шувуудад чухал газар болон хайгуул, олборлолтын тусгай зөвшөөрөл бүхий газруудын давхардал 174
Газрын зураг 22. Шаазан нуурын шувуудад чухал газар болон хайгуул, олборлолтын тусгай зөвшөөрөл бүхий газруудын давхардал 175
Газрын зураг 23. Галбын говийн шувуудад чухал газар болон хайгуул, олборлолтын тусгай зөвшөөрөл бүхий газруудын давхардал 176

Өмнөх үг

Хойд зүгийн тайгаас өмнө зүгийн цөл, Алтайн нурууны ноён оргилоос эцэс төгсгөлгүй үргэлжлэх тал хээр, жижиг баянбүрдээс дэлхий цэнгэг усны томоохон нөөц болох томоохон нуурууд бүхий Монгол орны газар нутаг нь үндэсний баялгийн салшгүй хэсэг билээ. Энэ газар нутаг Монголын хөдөө, орон нутгийн хүн амын нүүдлийн аж ахуйг тэтгэж, байгалийн аялал жуулчлалын хөгжлийн үндэс суурийг бүрдүүлэхийн зэрэгцээ цэнгэг ус, түлш болон онцгой хэрэгцээ шаардлагатай экологийн бараа, үйлчилгээг хүргүүлдэг. Үүний зэрэгцээ дэлхий дээр хаа сайгүй ажиглагдах амьдрах орчны доройтол, сүйрэл болон өөрчлөлтийн чиг хандлагын дагуу бусад улс орнуудад олонхи нь цөөрч устан, бүс нутагт болон дэлхий нийтэд аюулд өртсөн зэрлэг амьтны зүйлийг Монгол орны байгаль өнөөг хүртэл тэтгэсээр байна.

Монгол орон уул уурхай, эрчим хүч, хөдөө аж ахуй болон аялал жуулчлал зэрэг салбарын хурдацтай өсөлтийг дагуулсан эдийн засгийн огцом өсөлтийн эрин үетэй золголоо. Үр ашигтай төлөвлөлт, сөрөг нөлөөллийг багасгах арга хэмжээ авах замаар л Монгол орны эдийн засаг, нийгмийн үндэс суурь болсон газар нутаг, амьдрах орчин бүрт дээрх үйл явцын улмаас учирч буй аюул хөнөөлийг даван туулах учиртай. Үүнд нэн тэргүүнд байгаль хамгаалалд чухал газар нутгуудыг эдийн засгийн хөгжлийн сөрөг нөлөөллөөс хамгаалж, эдгээр газар нутгийг хамгаалах арга хэмжээ хэрэгжүүлэх санхүүжилтын шинэ эх үүсвэрүүдийг чухалчлах хэрэгтэй.

Дэлхийн банкнаас хөгжлийн чанартай үйл ажиллагаа явуулахдаа 2001 оны 6 дугаар сард батлагдсан Газар нутаг, амьдрах орчны талаарх үйл ажиллагааны бодлого (OP4.04)-д тусгасан байгаль хамгаалалд чухал газар нутгуудыг хамгаалах чиглэлээр тэргүүлэгч байр суурь баримталж байна. Монгол орны байгаль хамгааллыг бэхжүүлэх үүднээс Дэлхийн банкнаас Японы итгэлцлэлийн сангийн санхүүжилтээр Монгол орны байгаль хамгаалалд чухал газар нутгуудын хамгааллыг эдийн засгийн хөгжилтэй уялдуулан баталгаажуулах судалгаа хийсэн юм. Уг судалгааг Зүүн Ази, Номхон далайн бүс нутгийн Хөдөөгийн хөгжил, байгалийн нөөц ба байгаль орчны салбарын нэгж, Bird-Life Asia (Токио хот) болон Зэрлэг амьтан судлан хамгаалах төвтэй (Улаанбаатар хот) хамтран бэлтгэлээ.

Энэхүү судалгаанд анх удаа “чухал газар нутгийн” талаарх бүх мэдээллийг (манай бодлогод тодорхойлогдсоны дагуу) үндэсний хэмжээнд нэгтгэж, эдийн засгийн гурван гол салбарын (уул уурхай, дэд бүтэц болон аялал жуулчлал) хөгжлийн төлөвлөгөөтэй уялдуулан Монгол орны байгалийн чухал нутгуудад хөгжлийн уг үйл явцын болзошгүй нөлөөлөлд стратегийн дүн шинжилгээ хийх зорилго тавьсан юм. Өсөлтийг эрэлхийлсэн эрэлт хэрэгцээ, тухайн орны нөхөгдөшгүй байгалийн баялгийг хадгалж хамгаалах хэрэгцээ шаардлагыг тэнцвэржүүлэх тогтвортой хөгжлийн төлөвлөлт болон бодлогыг хэрэгжүүлэхэд энэ тайланд

тусгагдсан нарийвчилсан дүн шинжилгээ, анхаарууштай зөвлөмжүүд зохих үүрэг гүйцэтгэнэ гэдэгт гүнээ найдаж байна.

Судлагааны багт энэ ялдамд баяр хүргээд, Монгол орон болон Азийн газар нутаг, амьдрах орчныг хамгаалахад оруулж буй хувь нэмэр, мэргэжлийн өндөр төвшин болон тууштай хүчин чармайлтад талархаж буйгаа илэрхийлье.

Аршад Сайед
Дэлхийн банкны
Монгол дахь Суурин төлөөлөгч
Улаанбаатар хот,
Монгол Улс

Нэр томьёоны тайлбар

Хүчлийн чулуун өрөмдөлт эсхүл хүчлийн уурхайн өрөмдөлт Үндсэн ордтой холбоотой гарах байгаль орчны томоохон эсдэл, ба үүний улмаас сульфидын агуулга бүхий бодис ус, агаарт нэвтэрч хүчил гаргадаг нь хүн, амьтны ундны усны чанарт муугаар нөлөөлдөг

Аймаг: Мужтай төстэй засаг захиргааны хамгийн том нэгж. Монгол 21 аймаг, нэг нийслэл хоттой.

Баг: Дэд дүүрэгтэй төстэй, сумаас бага засаг захиргааны нэгж.

Иргэдийн төлөөлөгчдийн хурал: Аймаг, сумын төвшний орон нутгийн хууль тогтоох байгууллага

Гэр баазууд Аялагчдыг нүүдэлчдийн уламжлалт орон сууцанд байрлуулдаг аялал жуулчлалын бааз

Их Хурал Монголын Парламент

Орон нутгийн тусгай хамгаалалттай газар Орон нутгийн төвшний хамгаалалттай газар. Орон нутгийн ТХГ-ыг аймаг (нийслэл хот) буюу сумын (дүүргийн) төвшинд тодорхойлдог

Мянганы зам Монголын газар нутгийг өргөөш хамрах баруун-зүүнийг холбосон коридор замыг санал болгож буй төсөл

Сум Аймгийн түвшнөөс доогуур, дүүрэгтэй дүйцэх засаг захиргааны нэгж. Нийслэл хот сумаас биш, дүүргүүдээс бүрдэнэ.

Улсын тусгай хамгаалалттай газар Улсын төвшний хамгаалалттай газар. Улсын ТХГ-ыг дархан цаазат газар, байгалийн цогцолборт газар, нөөц газар болон түүх, соёлын дурсгалт газар гэж ангилдаг

Товчилсон үг, хэллэг

ADB	-	Азийн хөгжлийн банк
ALAGC	-	Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар
ARC	-	Шашин ба Байгаль хамгааллын холбоо
BBOP	-	Бизнес ба Биологийн төрөл зүйл нөхөн тэнцвэржүүлэлтийн хөтөлбөр
CBD	-	Биологийн төрөл зүйлийн конвенци
EIA	-	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ
EITI	-	Олборлох салбарын ил тод байдлын санаачлага
EPA	-	Байгаль хамгаалах алба
GMI	-	Дэлхийн уул уурхайн санаачлага
GMIA	-	Геологи, уул уурхайн хяналтын агентлаг
IBA	-	Шувуудад чухал газар
IBAMA	-	Бразилийн байгаль орчин сэргээгдэх эрчим хүчний хүрээлэн
ICMM	-	Олон улсын уул уурхай, металлын зөвлөл
IFC	-	Олон улсын санхүүгийн корпораци
INAP	-	Хүчлээс сэргийлэх олон улсын сүлжээ
ITM	-	Олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн
IUCN	-	Олон улсын байгаль хамгаалах холбоо
JICA	-	Японы олон улсын хамтын ажиллагааны байгууллага
MIT	-	Үйлдвэр, худалдааны яам
MNE	-	Байгаль орчны яам
MoFE	-	Түлш, эрчим хүчний яам
MoRTT	-	Зам, тээвэр, аялал жуулчлалын яам
MRPAM	-	Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газар
NEMO	-	Нидерланд- Монголын байгаль орчны итгэлийн сан
NMFS	-	Далайн загас агнуурын үндэсний алба
NPI	-	Цэвэр эерэг нөлөөлөл
OP 4.04	-	Газар нутаг, амьдрах орчны талаарх Дэлхийн банкны үйл ажиллагааны бодлого
OP 4.11	-	Соёлын дурсгалт зүйлсийн өвийн талаарх Дэлхийн банкны үйл ажиллагааны бодлого

OSM - Газрын гадаргуйн олборлолт, нөхөн сэргээлтийн алба

RAPPAM - Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн түргэн үнэлгээ, тэргүүний ач холбогдлын жагсаалт

REA - Бүс нутгийн байгаль орчны үнэлгээ

SCA - Тусгай хамгаалалттай газар

SCI - Орон нутгийн иргэдэд чухал газар нутаг

SDC - Швейцарийн хөгжил, хамтын ажиллагааны байгууллага

SEA - Байгаль орчны стратегийн үнэлгээ

SMCRA - Газрын гадаргын олборлолтын хяналт, нөхөн сэргээлтийн тухай хууль

SPA - Тусгай хамгаалалттай газар нутаг

STDC - Тогтвортой аялал жуулчлалын хөгжлийн төв

TNC - Нэче Консерванси буюу байгаль хамгаалал

UNESCO - НҮБ-ын боловсрол,шинжлэх ухаан, соёлын байгууллага

UNIDO - НҮБ-ын аж үйлдвэрийн хөгжлийн байгууллага

USFWS - АНУ-ын Загас, зэрлэг амьтны алба

WSCC - Зэрлэг амьтан судлан хамгаалах төв

WWF - Дэлхийн байгаль хамгаалах сан

ТАЛАРХАЛ

Энэ баримт бичиг нь ***Монгол орны байгалийн чухал нутгуудын хамгааллыг эдийн засгийн хөгжилтэй уялдуулах асуудал*** сэдвээр Дэлхийн банкны Японы итгэлцлэлийн сангийн санхүүжилтээр Дэлхийн банкнаас хийсэн судалгааны үр дүн юм. Судалгааг Зүүн Ази, Номхон далайн бүс нутгийн хөдөөгийн хөгжил, байгалийн нөөц, байгаль орчны нэгж хийсэн ба үүнд судалгааны багийг удирдан чиглүүлсэн Биологийн төрөл зүйлийн ахлах мэргэжилтэн Тони Уитэн-д онцлон талархаж байна. Уг судлагааг хийхэд Дэлхийн банкны Монгол дахь суурин төлөөлөгчийн газраас дэмжлэг туслалцаа үзүүлсэн суурин төлөөлөгч Аршад Сайед, Ичинхорлоогийн Бямбабаатар болон Хөдөөгийн хөгжил, байгаль орчин хариуцсан мэргэжилтэн Бадарчийн Эрдэнэ- Очир нарт талархал илэрхийлье.

Судалгааг Норитака Ичидагийн (BirdLife Asia, Токио хот) ахлаж, Кэйко Сузуе (BirdLife Asia, Токио хот), Ричард Гримет (өмнө нь BirdLife Asia, Токио хот-д ажиллаж байгаад одоо BirdLife International, Кэмбридж-д буй), Симба Чан (BirdLife Asia, Токио хот) болон Батбаярын Нямбаяр (Зэрлэг амьтан судлан хамгаалах төв, Улаанбаатар хот) нараас бүрдсэн үндсэн баг гүйцэтгэв. Рио Тинто-ийн BirdLife International хөтөлбөрийн Эндрю “Жак” Тордоф болон Жонатан Стэйси нар техникийн туслалцаа үзүүлсэн юм.

Байгаль хамгаалалд чухал газар нутгийн болон уул уурхай, дэд бүтэц, аялал жуулчлалын салбарын тухай мэдээллийг өгч сэтгэл харамгүй тусалсан бусад байгууллагуудын дэмжлэггүйгээр уг судалгааг хийх боломжгүй байлаа. Улсын тусгай хамгаалалттай газрын мэдээллийг Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газар болон Байгаль орчны яамнаас, орон нутгийн тусгай хамгаалалттай газрын тухай мэдээллийг Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газар, Нэче Консерванси болон Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрууд (ГЗБГЗЗГ)-аас тус тус авав. Мөн Рамсарт бүртгэлтэй газруудын тухай мэдээллийг Монгол Улсын Шинжлэх ухааны академийн Биологийн хүрээлэнгээс, тахилага шүтлэгтэй газрын тухай мэдээллийг Шашин ба байгаль хамгаллын холбоо, ДБХС-ийн Монгол дахь хөтөлбөрийн газруудаас тус тус авсан болно. Шувуудад чухал газар нутгийн тухай мэдээллийг BirdLife Asia, Зэрлэг амьтан судлан хамгаалах төв болон Монгол Улсын Шинжлэх ухааны академийн Биологийн хүрээлэнгээс тус тус авлаа. Хайгуул, олборлолтын тусгай зөвшөөрлийн тухай мэдээллийг Монгол Улсын Ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газрын (АМГТХЭГ) Геологи, уул уурхайн кадастрын албаас авав. Аялал жуулчлалын салбарын тухай мэдээллийг Монгол Улсын Их сургуулийн нийгмийн газар зүйн тэнхим, Монголын аялал жуулчлалын холбоо болон Зэрлэг амьтан судлан хамгаалах төвөөс авсан ба уг судалгааны хүрээнд явагдсан санал асуулгад чин сэтгэлээсээ оролцсон жуулчны баазуудын 85 операторт талархал илэрхийлье.

Жадамбаа Даваабаатар (ГЗБГЗЗГ), Мягмарсүрэн Буяндэлгэр (ГЗБГЗЗГ), Гуидо Вербум (Шашин ба байгаль хамгаалалын холбоо), Шэйн Розентал (АХБ), Робин Грейсон

(EcoMinex), Чимэд-Эрдэнэ Баатар (EcoMinex), Ханс- Рудолф Хофман (Германы хамтын ажиллагааны байгууллага- ГХАБ), хатагтай П. Сувд (ГХАБ), Др. Н. Цэвээнмядаг (ШУА-ийн Биологийн хүрээлэн), Кэйт Маршал (Ivanhoe Mines Mongolia Inc.), Лэйтон Крофт (Ivanhoe Mines Mongolia Inc.), Глэйн Эйнсвэрф (Ivanhoe Mines Mongolia Inc.), Михо Сасаки (Жайкаийн Монгол дахь салбар), Даваадоржийн Дэлгэрцогт (Байгаль орчны яамны дэд сайд), Банзрагч Цэсэд (БОЯ-ны байгаль орчин, байгалийн баялгийн газар), А. Намхай (БОЯны Тусгай хамгаалалттай газрын удирдлагын газар), Шинго Сато (БОЯ-ны Усны сав газрын менежментийн загвар төсөл), Др. Г. Ёндонгомбо (ЗТАЖЯ-ны Аялал жуулчлалын газрын дарга), Баттулга Эрхэмбаяр (ЗТАЖЯ), Лхагва Шагдар (Mongol Kaze Travel Company Ltd.), Дамдинсүрэн Батнасан (Монголын аялал жуулчлалын холбоо), Содномваанчиг Ганбаатар (АМГТХЭГ), Базарсад Алтан-Очир (АМГТХЭГ), хатагтай Д. Нарантуяа (Байгалийн баялгийн менежментийн үндэсний гео-информатикийн төв), хатагтай М. Баясгалан (Байгалийн баялгийн менежментийн үндэсний гео-информатикийн төв), Профессор Г. Баатарцоож (Монгол Улсын Их сургууль), Профессор Рэнчин Цолмон (Монгол Улсын Их сургууль), Ян Вигстен (Nomadic Jorneys), хатагтай А. Ариунаа (Nomads Tours and Expeditions), Трэсэй Ньютон (Pact Mongolia), Эндрю Куртбэртсон (Rio Tinto Mongolia), Эмма Пиннэл (Rio Tinto Mongolia), Сугар Гончигжанцан (Rio Tinto Mongolia), Бадамсамбуу Батдэмбэрэл (Улсын мэргэжлийн хяналтын алба), Ребека Дарлинг (Азийн сан), Шэла Розентал (Азийн сан), Сюзан Антэнэн (Нэче Косерванси), Мат Дурнин (Нэче Консерванси), Аманда Файн (Зэрлэг ан амьтдыг хамгаалах нийгэмлэгийн Монгол дахь салбар), Лхамжав Очирхуяг (Зэрлэг ан амьтдаг хамгаалах нийгэмлэгийн Монгол дахь салбар), Граем Хэнкок (Дэлхийн банкны Монгол дахь суурин төлөөлөгчийн газар), Аршад Сайед (Дэлхийн банкны Монгол дахь суурин төлөөлөгчийн газар), Баянбаатар Ичинхорлоо (Дэлхийн банкны Монгол дахь суурин төлөөлөгчийн газар), Жим Рейчерт (Дэлхийн банкны Монгол дахь суурин төлөөлөгчийн газар), Базарсад Чимэдочир (ДБХС-ийн Монгол дахь салбар), Доржгүрхэм Батболд (ДБХС-ийн Монгол дахь салбар), ноён Д. Санжмятав (ДБХС-ийн Монгол дахь салбар), Жонатан Бэйли (Лондонгийн зоологийн нийгэмлэг), Др. Шэлдон Северинхауз (бие даасан байгаль орчны ажилтан бөгөөд улс төр судлаач) болон Ариун Санжаажамц (уул уурхайн бие даасан зөвлөх) нарын Засгийн газар, эрдэм шинжилгээний байгууллага, хувийн хэвшил, хандивлагч болон ТББ-ын хамтын нийгэмлэгийн төлөөлөгчдийн өгсөн зөвлөмжүүд уг судалгаанд ихээхэн тус дөхөм болсоныг зориуд тэмдэглэе.

Эцэст нь уг баримт бичгийн өмнөх хувилбаруудыг хянан тохиолдуулж саналаа нэмэрлэсэн Картер Брэндон (Дэлхийн банк), Кристофер Финч (Дэлхийн банк), Граем Хэнкок (Дэлхийн банк), Аги Кис (Дэлхийн банк), Пати Муур (Олон улсын байгаль хамгаалах холбоо), Жудит Шлэйчер (Дэлхийн банк), Панир Сэлвам (Дэлхийн банк) болон Жан Вингстен (Nomadic Journeys)-д гүн талархал илэрхийлье.

ХУРААНГУЙ

Судалгааны үндэслэл

Монгол орон харьцангуй байгалийн төрхөө хадгалсан ой, тайга, хээр тал, цөл, заримдаг цөлийн амьдрах орчин бүхий өргөн уудам нутагтай, мөн олон улсын чухал ач холбогдол бүхий ус намгархаг газар олонтой. Байгалийн төрхөөрөө байгаа тэдгээр амьдрах орчин нь тархцын ихэнх хэсэгтээ тоо толгой эрс цөөрч, олон улсын хэмжээнд ховордсон олон зүйлийн зэрлэг амьтдыг тэтгэдэг. Хэдийгээр өнөөгийн байдлаар эдгээр амьдрах орчин бүхий газар нутгууд хөгжлөөр дорой эсвэл огт хөгжөөгүй байх нь нийтлэг боловч эдийн засгийн бэрхшээлтэй үед малын бэлчээр, хүнсний нэмэлт нөөцийн эх үүсвэр бий болгох зэргээр хөдөө орон нутгийхны амьдрал, хөгжлийн эдийн засгийн гол үндэс суурь болдог билээ.

Улс орны зах зээлийн эдийн засгийн шинэтгэл үргэлжилж, эдийн засаг эрс хурдацтай өсөхийн зэрэгцээ **Монгол орны байгаль, хүрээлэн буй орчин урьд өмнө үзэгдэж байгаагүй дарамт бэрхшээл бүхий нэгэн шинэ үед шилжин орлоо.** Ой, хөдөө аж ахуйн (мал аж ахуй) зэрэгцээ улам бүр цар хүрээгээ тэлэх уул уурхай, дэд бүтэц болон аялал жуулчлалын салбар гээд хөгжлийн бүхий л хэлбэрүүд хүрээлэн буй орчин, түүнд орогнох зэрлэг амьтдыг асар их дарамт шахалтад оруулж байна.

Эдийн засгийн хөгжилтэй уялдан байгаль, хүрээлэн буй орчинд нүүрлээд буй бэрхшээл, дарам, шахалтууд нэмэгдсээр байна. Иймд байгаль хамгаалалд чухал газар нутгуудад учирч буй бэрхшээлүүдийг үнэлэн, хамгааллыг нь баталгаажуулах асуудлыг улам бүр сайжруулах, гарч болзошгүй сөрөг нөлөөллөөс зайлсхийх, бууруулах, нөхөн төлөх зарчим, арга барилыг өөр улс орнуудад хэрэглэгдэж байгаа тэргүүн туршлагуудаас жишээ аван танилцуулах шаардлагатай байна. ИймшаардлагынүүднээсДэлхийнбанк BirdLife Asia-тай гэрээ байгуулан Монголын байгалийн чухал нутгуудад уул уурхай, дэд бүтэц, аялал жуулчлалын зүгээс учирч болох нөлөөллийн тухай энэхүү судлагааны ажлыг хийлгэсэн болно.

Монгол орны байгалийн чухал нутгууд

Дэлхийн банк байгаль хамгаалалд чухал газар нутгуудын хамгааллыг баталгаажуулах талаар өөрийн гэсэн дэвшилтэт байр суурь баримталдаг бөгөөд үүнийгээ байгаль дахь амьдрах орчны талаар баримтлах үйл ажиллагааны бодлого (ОР 4.04) болгон тодорхойлсон байдаг. **Энэхүү бодлогын хүрээнд байгалийн чухал нутгуудад ноцтой өөрчлөлт, доройтол үзүүлж болохуйц гэж үзсэн төслүүдэд дэмжлэг үзүүлэхгүй байх зарчмыг баримталдаг.**

Энэхүү судалгааны зорилгод нийцүүлж Монгол орны байгалийн чухал нутгуудад дараах газруудыг багтаав. Үүнд:

1. Албан ёсны хамгаалалт бүхий дараах газрууд:

   А. Улсын тусгай хамгаалалттай газрууд (Улсын Тусгай хамгаалалттай газар нутаг-УТХГН)

   Б. Орон нутгийн тусгай хамгаалалттай газрууд (Орон нутгийн Тусгай

хамгаалалттай газар нутаг-Орон нутгийн ТХГН)

В. Олон улсын хэмжээд хамгаалагдсан газрууд (Рамсарт бүртгэгдсэн газрууд, дэлхийн өвд бүртгэгдсэн газрууд болон дэлхийн шим мандлын цөм газрууд)

2. Орон нутгийн ард иргэдийн хүрээнд хамгаалагдсан газрууд (Тахилага шүтлэгтэй газар нутгууд)
3. Хамгаалалттай газруудын хэвийн төрх байдлыг хадгалахад чухал ач холбогдолтой бусад газрууд
4. Ховор, эмзэг, нүүдлийн, устах аюулд өртсөн зүйлүүдэд чухал газар нутгууд (Шувуунд чухал газрууд)

Монгол орны нутаг дэвсгэрийн дөрөвний нэг нь дээр дурьдсан байгалийн чухал нутгуудын нэг болон хэд хэдэн ангилалд нь хамрагдаж байдаг. Энэ судалгааны явцад Монгол орны байгалийн чухал нутгуудын 95 хувь нь ямар нэгэн тусгай хамгаалалттай газарт харьяалагддаг болох нь тогтоогдсон. Гэвч тэдгээрийн нилээд хэсэг нь одоогийн байдлаар хамгааллын менежментийн арга хэмжээ огт авагдаагүй орон нутгийн ТХГН-тай давхцаж байна.

Монгол орны уул уурхай, дэд бүтэц, аялал жуулчлалын салбаруудын хөгжил

Эрдэс баялгийн дэлхийн зах зээлийн үнэ өртөг, Хятад, Оросын хооронд орших стратегийн байршил зэрэг хүчин зүйл Монгол орны эрдэс баялгийн салбарын огцом өсөлтийг жолоодож байна. Өнөөгийн байдлаар уул уурхайн салбар Монгол орны ДНБ-ний гуравны нэг орчим, аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний болон экспортын орлогын бараг тэн хагасыг бүрдүүлж байна. 2008 оны 5 дугаар сарын байдлаар 40 сая, 400 мянган га газрыг хамарсан хайгуулын 3500, олборлолтын 1000 тусгай зөвшөөрөл тус тус олгосон байна. Өмнөговь, Дорноговь аймгууд л гэхэд тус улсын уул уурхайн зориулалттай газар нутгийн тэн хагасыг эзлэж байгаа бөгөөд голчлон алт, барилгын материал, нүүрс болон жонш зэрэг ашигт малтмалын хайгуул, олборлолт зонхилдог ажээ.

Эрчимтэй хотжилт, Орос, Хятадтай хийж буй олон улсын худалдааны өсөлт, уул уурхайн салбарын өсөлт зэргээс хамааран дараагийн арван жилд Монгол оронд дэд бүтэц үлэмж ихээр өсөх төлөвтэй. Эрдэс баялгийн томоохон орд газрууд байршдаг, алслагдсан бүс нутгуудад уул уурхай дэд бүтцийн хөгжлийг дагуулах эдийн засаг, улс төрийн гол хүчин зүйл болох шинжтэй. Эдгээр байгалийн баялгийн олборлолт, боловсруулалт, экспортыг дэмжихэд ус, цахилгаан эрчим хүч болон барилгын дэд бүтэц шаардлагатай.

Монголын аялал жуулчлалын салбар голтөлөв хөдөөгийн хүн амын нүүдлийн аж амьдрал дээр суурилдаг ба өргөн, уудам газар нутаг, даяарчлагдсан хөгжлөөс хөндий байдал уг салбарт бас багагүй нөлөөлдөг. Засгийн газраас олгосон тусгай зөвшөөрөл бүхий газруудад үйл ажиллагаа явуулдаг аялал жуулчлалын операторуудын гэр баазуудад жуулчдыг голлон байрлуулдаг. Мөн өнөөгийн байдлаар тусгай хамгаалалттай газар нутгууд аялал жуулчлалын хөгжлийн цөм газар болж байна. 1990-ээд оноос эхлэлтэй эдийн засгийн шинэтгэл хийж, аялал жуулчлалын салбарыг хувьчилж, жуулчлалын огцом өсөлтийг бий болгосон. Энэхүү өсөлтийн улмаас зорчигч, аялагчдын тоо нэмэгдэж, үүнтэй холбоотой дэд бүтцийн хөгжлөөс улбаалж тусгай хамгаалалттай зарим газар нутгуудад нэмэлт дарамт учруулах боллоо.

Байгаль орчны хамгааллын зохицуулалт, бүтэц, зохион байгуулалт

1990 оноос хойш Монгол оронд байгаль орчны хамгаалалтай холбоотой хэд хэдэн хууль эрх зүйн акт батлагджээ. Гэвч эдгээр хуульд зарим нэгэн цоорхой болон хязгаарлалтууд бий. Зарим ажиглагчдын үзэж буйгаар олон нийтийг оролцоог хангахын хувьд одоогоор үйлчилж буй зохицуулалтын цар хүрээ сул байна гэж үздэг. **1994 онд батлагдсан Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуульд Улсын ТХГН-т хайгуул, олборлолт**

хийхийг хориглож, зарим бүсүүдэд аялал жуулчлалын үйл ажиллагааг хязгаарласан байдаг. 2007 онд батлагдсан Ойн тухай хуульд хайгуул, олборлолтын хоригийг “хамгаалалттай ойн бүсэд” гэсэн нилээд өргөн ойлголтод хамруулжээ.

Уул уурхайн зохицуулалт, бүтэц, зохион байгуулалт

2006 онд батлагдсан Ашигт малтмалын хуулиар уул уурхайн томоохон хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл олгох ажилбарыг тусгасан. **Ашигт малтмалын хуулиар Улсын болон орон нутгийн ТХГН-ийг хамардаг “Тусгай хэрэгцээний газрууд”-д хайгуул, олборлолтын ажиллагаа явуулахыг хориглосон.** Гэвч уг хуулинд эдгээр хамгаалалтын арга хэмжээг үр ашигтай хэрэгжүүлэхэд шаардлагатай процедурын алхмуудыг тусгаагүйн зэрэгцээ тусгай зөвшөөрөл олгох үйл явцад олон нийтийн үр ашиг бүхий оролцоог хангахад хэд хэдэн хязгаарлалт тавьсан байдаг. Монгол дахь олныг хамарсан албан бус гар аргаар олборлох ажиллагааг зохицуулах үүднээс тусгай хамгаалалттай газар нутгуудад гар аргаар болон бичил уул уурхайн ажиллагаа явуулахыг хориглосон. Гар аргаар олборлолт хийх, бичил уул уурхайн үйл ажиллагааг зохицуулах түр журмыг Засгийн газар саяхан баталсан юм.

Байгалийн чухал нутгуудад ашигт малтмалын хайгуулын нөлөө

Одоогоор **Монгол орны нутаг дэвсгэрийн 4 сая орчим га газар хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий бүс нутагт хамрагдаж байна.** Харин орон нутгийн ТХГН болон Шувуудад чухал газруудын тус бүс нутагтай давхцаж байгаа байдал нь Улсын ТХГН, Олон улсын хэмжээнд хамгаалагдсан газруудтай харьцуулбал нилээд их байна. Энэ нь ихэнх орон нутгийн ТХГН-ийг саявтар тодорхойлсон учраас давхацсан хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий газрыг тогтоосон цаг хугацаанаас сүүлд байгаатай холбоотой. Нөгөөтэйгүүр, дээрх давхардал нь тусгай хамгаалалттай газар нутаг гэж тогтоогдсоноос бусад тохиолдолд одоогоор хүчин төгөлдөр үйлчилж буй хуулийн дагуу шувуудад чухал газруудын байгаль орчныг хайгуулын үйл ажиллагаанаас хамгаалаагүйтэй холбоотой.

Хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий газруудтай давхардсан нь байгалийн чухал нутгуудын хувьд дараах үр дагавартай болно. Үүнд:

- Хайгуулын үйл ажиллагаанаас биологийн төрөл зүйлд шууд нөлөөлнө.
- Хайгуулын үйл ажиллагаанаас биологийн төрөл зүйлд үзүүлэх дам нөлөөлөл бий болно.
- Хамгаалалттай газруудын байгууламжид саад бэрхшээл үүсгэнэ.
- Тусгай хамгаалалттай газар нутгийн статусыг цуцлахад чиглэсэн дарамтыг буй болгоно.

Байгалийн чухал нутгуудад уул уурхайн үйл ажиллаагаа нөлөөлөх нь

Өнөөгийн байдлаар **Монгол орны байгалийн чухал нутгуудын нэг хувийн тэн хагасаас бага нутаг дэвсгэр уул уурхайн тусгай зөвшөөрөл бүхий газарт** хамрагдаж байгаа ба тэдгээр нь бараг бүхэлдээ орон нутгийн ТХГН юм. Уул уурхайн тусгай зөвшөөрөл бүхий газар болон амьдрах орчны чухал газар нутгийн давхардлын гуравны хоёрыг нүүрсний олборлолтын зургаан тусгай зөвшөөрөл бүхий газартай давхарддаг Өмнөговь аймаг дахь Таван Толгойн орон нутгийн ТХГН эзэлж байна. Энэ газар нутаг болон Орон нутгийн бусад ТХГН-тай давхцаж байгаа газарт орон нутгийн засаг захиргаа санаатайгаар олборлолтын тусгай зөвшөөрөл олгосон байх юм.

Олборлолтын тусгай зөвшөөрөл бүхий болон амьдрах орчны чухал газар нутаг давхцаж байгаа тохиолдлын 90 хувийг хоёр төрлийн ашигт малтмал (нүүрс,алт) эзлэж байна. Харин олборлолтын тусгай зөвшөөрөл бүхий үлэмж газар нутгийг эзэлдэг зэс, вольфрам хоёр нь амьдрах орчны чухал газар нутагт байдаггүй нь сонирхууштай юм.

Уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой шууд нөлөөлөлд усны бохирдолт (жишээ нь

гол мөрөнд хаягдлаа хаяхтай холбоотой), агаарын бохирдолт (тоос, металл хайлуулах төхөөрөмжийн агаарт ялгаруулах хорт утаа) болон хүрээлэн буй орчны сүйрэл (жишээ нь хайгуулын өрөмдөлт, хаягдлын хуримтлал болон хорт хаягдлын бөөгнөрөл) гэх зэрэг орно. Уул уурхайн тусгай зөвшөөрөл бүхий болон амьдрах орчны чухал газар нутгуудын давхардлаас гарах үр дагаврыг дараах хүчин зүйлээр тодорхойлно. Үүнд:

- Тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжийн байгаль орчны үйл ажиллагаа
- Олборлох ашигт малтмалын шинж чанар
- Нөлөөлөлд өртсөн экологийн тогтолцооны мэдрэмтгийн байдал

Уул уурхайн үйл ажиллагааны шууд нөлөөлөл нь орон нутгийн хувьд хүндрэлтэй ч мал аж ахуйн зэрэг бусад салбартай харьцуулбал ерөнхийдөө бага байдаг. Түүнчлэн, бэлчээр талхлалт болон ан агнуур зэрэг бусад аюулаас тухайн газар нутгийг хамгаалах арга хэмжээтэй хослуулсан тохиолдолд уул уурхайн үйл ажиллагааны зарим төрөл амьдрах орчинд чухал газар нутгуудын нэгдмэл байдлыг хадгалан хамгаалахад сөргөөр нөлөөлдөггүй.

Байгалийн чухал нутгуудад дэд бүтцийн салбарын нөлөө

Уул уурхайн салбарын ирээдүйн огцом өсөлт, шинэ уурхайг дэмжин үйлчлэх дэд бүтцийн хэрэгцээ шаардлага болон хүний хөл хараахан хүрч амжаагүй газруудад уурхай ажиллуулах хэрэгцээ шаардлагын улмаас уул уурхайтай холбоотой **дэд бүтцийн салбарын хөгжил амьдрах орчны чухал газар нутгуудад хамгийн их сөрөг нөлөө үзүүлж болзошгүйд тооцогдож байна.**

Дараагийн арван жилд Монгол орны амьдрах орчны чухал газар нутгуудад нөлөөлж болзошгүй дэд бүтцийн хөгжлийн бусад төрлүүдийг хэдийнээ төлөвлөсөн ба үүнд улсын зам харгуй, төмөр замын өргөтгөл, шинээр цахилгаан эрчим хүч хуримтлуулж дамжуулах дэд бүтэц зэрэг орж байна. Цаг хугацаа бага байсан тул судалгааны явцад эдгээр үйл явц болон амьдрах орчны чухал газар нутгуудын давхардлыг тооцон үнэлэх боломжгүй байлаа. Иймээс уг судалгааны хүрээнд уул уурхайтай холбоотой дэд бүтцэд анхаарлаа хандуулав.

Хэдийгээр амьдрах орчны чухал газар нутгуудын зөвхөн 160 мянган га газар уул уурхайн тусгай зөвшөөрөл бүхий талбайд байдаг ч 6,5 га газар уул уурхайн тусгай зөвшөөрөл бүхий газруудаас 20 км зайд оршдог юм. Эдгээр газар нутаг уул уурхайтай холбоотой дэд бүтцийн нөлөөлөлд автах онцгой эрсдэл бүхий газарт тооцогдоно. Гэхдээ эрсдлээс зайлсхийж (дэд бүтцийн иж бүрдэл болгоныг сайтар тооцоолж байршуулах аргаар) эсвэл багасгаж (нөлөөллийн сөрөг үр дагаврыг намжаах зүй зохистой арга хэмжээ авах замаар) болдог тул нөлөөллийн эрсдэл гэдэг нь нөлөөлөлтэй ижил төстэй зүйл биш.

Байгалийн чухал нутгуудад аялал жуулчлалын нөлөө

Судалгаанд хамрагдсан жуулчны баазын 70 хувь Улсын буюу Орон нутгийн ТХГН-ын нутаг дэвсгэр дээр буюу түүний ойролцоо байршиж байна. Хамгийн олон тооны жуулчны баазтай тусгай хамгаалалттай газруудад: Горхи Тэрэлж (38), Богд Хаан уул (13), Хөвсгөл нуур (11) болон Хангайн нуруу (9) орно. Жуулчны баазын байршил болон шувуудад чухал газруудын харьцуулалтаас үзэхэд товлох боломжтой жуулчны баазуудын бараг тэн хагас нь шувуудад чухал буюу ойролцоох газар байршиж байна.

Энэхүү судалгааны нэгэн хэсэг болгож Монгол улсын их сургуулийн нийгмийн газар зүйн тэнхим, Монголын аялал жуулчлалын ассоциаци болон Зэрлэг амьтан судлан хамгаалах төвтэй хамтран жуулчны баазын байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг судлах санал асуулга явуулсан юм. Улаанбаатарт 2008 оны 5 дугаар сард болсон олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн яармагийн үеэр оролцогч 85 жуулчны баазын төлөөлөгчдөөс холбогдох мэдээллийг цуглуулжээ. Байгаль орчинд хамгийн ноцтой нөлөөлөлтэй гэж үзэж болох газрууд, тулгамдсан асуудлууд болон аялал жуулчлалын аж ахуйн нэгж засгийн газартай хамтран авч болох арга хэмжээг

жуулчны баазын операторууд тодорхойлсон юм.

Амьдрах орчны чухал газар нутгийн удирдлагын санхүүжилтэд шууд хувь нэмэр оруулж, эсхүл орон нутгийн эдийн засагт хувь нэмэр оруулснаар улс төрийн болон орон нутгийн ард иргэдийн дэмжлэгийг нэмэгдүүлэх замаар эдгээр газрыг хамгаалах үйлст үлэмж хувь нэмэр оруулах боломж аялал жуулчлалын салбарт байгаа юм. Гэхдээ нөгөөтэйгүүр аялал жуулчлалын салбар амьдрах орчны чухал газар нутгуудад сөргөөр ч нөлөөлж болзошгүй. Зэрлэг ан амьтанд сөргөөр нөлөөлөх, бэлчээрийн газар нутаг, цөлийн доройтол болон гол нуурын бохирдолт зэрэг аялал жуулчлалаас улбаатай долоон гол нөлөөллийг энэхүү судалгаанд тусгав.

Одоогоор нөлөөллийн цар хүрээг ихэнх тохиолдолд орон нутгийн чанартай гэж үздэг тул аялал жуулчлалын салбарын учруулах аюул хөнөөлийг уул уурхай, дэд бүтцийн салбартай харьцуулахад харьцангүй бага гэдэг. Эдгээр асуудлуудын ихэнх нь хүчин чадал, нөөц бололцооны дутмаг байдал, удирдлагын бүсчлэлийг маруухан нэвтрүүлсэн болон олон нийтэд таниулах, зочдыг зохицуулах хөтөлбөр байхгүй зэрэг тусгай хамгаалалттай газрын удирдлагатай холбоотой асуудлууд байдаг.

Уул уурхай, дэд бүтцийн үйл ажиллагаатай байгаль орчны хамгаалллыг уялдуулах тухай зөвлөмж

Хийсэн дүн шинжилгээнд үндэслэн уул уурхай, дэд бүтцийн сөрөг нөлөөллөөс амьдрах орчны чухал газар нутгуудыг хамгаалахад доорх зөвлөмжийг чухалчилж үзэв. Үүнд:

1. Уул уурхайн тусгай зөвшөөрөл олгох үйл явцад байгаль орчны хамгаалллын хяналтыг чангатгах. Ялангуяа, 1998 онд батлагдсан Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, 2006 онд батлагдсан Ашигт малтмалын тухай хуулинд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх, уул уурхайн тусгай зөвшөөрөл олгоход олон нийтийн хэлэлцүүлэг явуулах шаардлага бүхий заалтыг оруулах.
2. Хайгуул, олборлолтын тусгай зөвшөөрөл бүхий газрууд болон амьдрах орчны чухал газар нутгуудын давхардлыг арилгах. АМГТХЭГ-аас Улсын болон Орон нутгийн ТХГН-ад шинээр уул уурхайн тусгай зөвшөөрөл олгохгүй байх.
3. Тусгай хамгаалалттай газраас гадуур амьдрах орчны чухал газар нутгуудын хамгаалалтыг чангатгах. Ялангуяа, 2002 онд батлагдсан Газрын тухай хуулинд олон улсын байгаль орчны гэрээ, хэлэлцээрт зориулагдсан газар, Тусгай хэрэгцээний газар зэрэг тахилага шүтлэгтэй газрыг хүлээн зөвшөөрч тусгах. Мөн Дэлхийн банкнаас Монголын шувуудад чухал газруудын жагсаалтыг амьдрах орчны чухал газар нутгийн нэмэлт жагсаалт болгон албан ёсоор батлах.
4. Тусгай хамгаалалттай газруудын удирдлагын үр ашгийг дээшлүүлж Тусгай хэрэгцээний газрууд дахь гар аргаар олборлолт хийх ажилбарыг хянах хяналтыг чангатгах, Улсын мэргэжлийн хяналтын байгууллагын газар дээр хяналт шинжилгээ хийх, байгаль орчны хамгаалллын хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах, үйл ажиллагааны үр ашгийг дээшлүүлэх замаар амьдрах орчны чухал газар нутгуудын хамгаалллыг сайжруулах.
5. Уул уурхайн үйл ажиллагааны байгаль орчны үзүүлэлтийг сайжруулах шаардлагатай. Тухайлбал, алтны шороон ордод Засгийн газраас хамгийн боломжийн арга техник нэвтрүүлэхийг аль болох дэмжиж, тодорхой газруудад үйл ажиллагаа явуулахыг хориглосон гар аргаар болон бичил уул уурхайн хууль батлан мөрдүүлэх.
6. Мөн Монголын Засгийн газраас биологийн төрөл зүйлд хөрөнгө оруулж сөрөг нөлөөллийг намжаасны дараа биологийн төрөл зүйлд нөлөөлөх нөлөөллийг нөхөж төлбөр хийх шаардлага бүхий журмыг нэвтрүүлэх.

Аялал жуулчлалын салбарын хөгжлийг байгаль орчны хамгаалалтай уялдуулах тухай зөвлөмж

Судалгааны үр дүнгээс үндэслэн аялал жуулчлалын салбарын хөгжлөөс улбаатай сөрөг нөлөөллөөс амьдрах орчны чухал газар нутгуудыг хамгаалах талаар дараахь зөвлөмжийг санал болгож байна. Үүнд:

1. Байгаль орчны яамнаас аялал жуулчлал хөгжих магадлал бүхий тусгай хамгаалалттай газрын багцыг тодорхойлсон, дотоодын болон мэргэжлийн зөвлөмжинд үндэслэсэн хөтөлбөр боловсруулах шаардлагатай.
2. ЗТАЖЯ, БОЯ-аас Байгаль орчин хамгаалах олон улсын холбооны *Зүүн Азийн байгалийн цогцолборт газрууд болон тусгай хамгаалалттай газруудын журам*-ыг үндэслэн тодорхой газар бүрт тохируулан тогтвортой аялал жуулчлалын төлөвлөгөө боловсруулах шаардлагатай. Аялал жуулчлалын үйл ажиллагаа идэвхитэй явагддаг тусгай хамгаалалттай газар бүрээр уг төлөвлөгөөг боловсруулах шаардлагатай ба ялангуяа анхаарал улам бүр татах болон ирээдүйд аялал жуулчлал хөгжих боломжтой газар нутгуудыг үүнд түлхүү хамруулах
3. Бизнес төлөвлөгөө боловсруулах, удирдлагын зөвлөлд хувийн хэвшлийн төлөөллийг оруулах болон орлого хураалтыг төвлөрсөн бус байдлаар зохион байгуулах гэх зэрэг санхүүжилт, засаг захиргааны загварчилсан туршилтыг сонгомол газруудад явуулах. Тусгай хамгаалалттай газар буюу түүний орчны бүст явагдаж буй аялал жуулчлалын үйл ажиллагаанаас орох орлогыг тусгах техник, эдийн засгийн үндэслэлийн судалгаа хийх
4. Үндэсний тогтвортой аялал жуулчлалын стратегийг Монголын засгийн газар холбогдох сонирхогч талуудын хамтаар боловсруулж, уг стратегид тусгагдах зорилтыг биелүүлэх хамтын хүчин чармайлтыг дэмжих нэг буюу хэд хэдэн сонирхогч хандивлагчдын оролцоотойгоор салбар дундын сан байгуулах

1. Танилцуулга

Монголын эдийн засгийн шинэтгэл үргэлжилж, улс оронд эдийн засгийн өсөлт бий болохын хирээр байгаль орчин урьд өмнө байгаагүй дарамт хүндрэлтэй учрах болов. Ялангуяа уул уурхай, дэд бүтцийн хөгжил, аялал жуулчлалын үйл ажиллагаа Монгол орны дэлхий дахины ач холбогдол бүхий биологийн төрөл зүйлийг эрсдэлд оруулж байна.

Монгол орны байгалийн чухал газруудын хамгааллын үйл явцыг хянах арга хэмжээг бэхжүүлж, байгалийн амьдрах орчны талаар баримтлах үйл ажиллагааны бодлого (OP4.04)-ын хэрэгжилтийг баталгаажуулах үүднээс Дэлхийн банк Birdlife Asia байгууллагатай гэрээ байгуулан, Монгол орны байгалийн чухал газруудыг тодорхойлж, тэдгээрийн хөгжлийн төлөвлөгөөтэй давхардаж буй байдалд үнэлгээ өгөх ажлыг хийлгэсэн болно. Энэ судалгааг BirdLife Asia байгууллага Монголын зэрлэг амьтныг судлан хамгаалах төвтэй хамтран гүйцэтгэв.

Уг судалгаагаар байгалийн чухал газрууд болон уул уурхайн тусгай зөвшөөрөл бүхий талбай, дэд бүтцийн томоохон төлөвлөгөө болон аялал жуулчлалын баазуудын байршил хоорондын давхардлын цар хүрээг тодорхойлов. Мөн үндэсний хэмжээнд уг давхардлын төвшинг тогтоож, болзошгүй нөлөөллийн стратегийн үнэлэлт дүгнэлт өгч, анхаарвал зохих газар нутгуудыг тодорхойллоо. Монголоос бусад орнуудын шилдэг туршлага, дүрэм журмын загварыг санал болгон, байгаль орчинд нүүрлээд байгаа тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга замуудын талаар зөвлөлгөө өглөө.

Энэхүү тайлангийн зэрэгцээ BirdLife Asia байгууллага болон Зэрлэг амьтан хамгаалан судлах төвөөс уг төслийн хүрээнд боловсруулж бүрдүүлсэн GIS-ийн мэдээлэл болон дүн шинжилгээний өндөр нарийвчлал бүхий газрын зургийг үйлдэж Дэлхийн банкинд хүргүүлсэн билээ. Түүнчлэн Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газар, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар зэрэг байгууллагуудын хамтын ажиллагаа энэхүү ажилд ихээхэн тус дэмтэй байлаа. Мөн засгийн газар, салбар, төрийн бус байгууллагын төлөөлөлтэй хийсэн хамтарсан хуралдаанууд болон Хариуцлагатай уул уурхай, байгалийн баялаг ашиглах талаар явуулсан бүлгийн хэлэлцүүлгээр шилдэг туршлагуудын жишээг хэлэлцэж, эдгээр хэлэлцүүлэгт оролцогчид санаа бодлоо хуваалцсан болно.

Монгол орны байгалийн чухал газруудын хамгааллыг бэхжүүлэх, салбарын үйл ажиллагааны талаар мэдээлэх, төсөл санхүүжүүлэх болон бодлогын яриа хэлэлцээ хийхэд энэхүү судалгаа тус дөхөм болно гэдэгт найдаж байна.

2. Судалгааны үндэслэл

2.1 Аюулд өртөж буй биологийн олон янз байдал

Монгол орон харьцангуй унаган төрхөөрөө тал хээр (ойт хээр, уулархаг хээр нутгийг хамран), заримдаг цөл болон цөл зэрэг амьдрах орчны өргөн уудам газар нутагтай. Зүүн Европоос Баруун болон Төв Азиар дамжин Зүүн Хойт Азийг хамран өөрчлөгдөх Евразийн тал хээрийн нэг хэсгийг бүрдүүлж байдаг. Дэлхийн байгаль хамгаалах сангаас дэлхий дахины ач холбогдолтой 200 Эко бүс нутаг хэмээн тодорхойлогдсон Дагуурын хээрийн цөм нутгийг Монголын хээр бүрдүүлдэг билээ. Дэлхийн онгон төрхөөрөө буй тал хээрийн экосистемийн сонгодог жишээ бол Дагуурын хээр юм. Энэ бүс нутаг сээр нуруутай амьтдын тоо толгойн тогтвортой байдлыг хангаж байдаг Палеарктикийн томоохон хэсгийн нэг (ДБХС, 2008).

Монголын хөрш Хятад болон Орос орнууд тал хээр нутгаа хөдөө аж ахуйн зориулалтаар хувирган ашиглах болсоноос үүдэн тэнд амьдардаг, Олон Улсын Байгаль Хамгаалах Холбооны Улаан дансанд бүртгэгдсэн ховор ан амьтад устах аюул нүүрлээд байна. Гэтэл эдгээр ховор амьтад Монголын тал хээрт тархан амьдарч байдаг билээ. Харин 1950-иад оноос хойш 3 дахин нэмэгдсэн хүн амын болон малын тооны өсөлтийн улмаас эдгээр газар нутагт ихээхэн дарамт бэрхшээл учран бэлчээрийн талхагдал, дороитол болон цөлжилт явагдах болжээ.

Тал хээрт дарамт учруулж буй бусад хүчин зүйлд: шувуудад хор хөнөөлтэй, ихэвчлэн хавар зуны улиралд гардаг тал хээрийн түймэр, өвчний тархалтыг зогсоох зорилгоор зарим мэрэгчдийг устгах химийн бодис, хөрсний үлэмж бохирдол, усны түвшний бууралт, малын усан хамгамжийн хомсдол зэрэг орно. Түүнчлэн засгийн газраас боловсруулсан хөдөө аж ахуй, дэд бүтцийн салбарыг хөгжүүлэх төлөвлөгөө ч аюулд өртөж буй тал хээрт амьдардаг амьд биеүүдэд ихээхэн нөлөөлж болзошгүй юм (энэ талаар дор өгүүлнэ).

Тал хээрийн бүсэд усны шувууд нүүдлийн болон үржлийн үедээ олнооров орогнодог олон улсын ач холбогдол бүхий цэнгэг ус, намгархаг газрууд олон бий. Сүүлийн хэдэн арван жилд тал хээрийн бүсэд орших олон нуурын усны төвшин багасч, зарим намгархаг газрууд бүрмөсөн ширгэж хатжээ. Түүнчлэн тал хээрээс бусад газруудад ч уур амьсгалын өөрчлөлтийн нөлөө байгааг үгүйсгэх аргагүй бөгөөд зарим газарт ган болж зун хэт халж байхад, харин өвөл цас багатай, дулаан байна. Үүний зэрэгцээ малын тоо толгой өсөж байгаа нь тал хээрийн бүсэд орших чийглэг газруудад сөргөөр нөлөөлж байна. Мөн тал хээрийн түймрийн улмаас олон зүйлийн ургамал устаж байна.

Хэнтий уулархаг нутгууд, Хөвсгөл нуурын орчим газрууд, Хангайн нурууны хойд болон зүүн бие, Хан Хөхийн зарим нутгууд шилмүүст ой ихтэй. Эдгээр ой нь Хойд Европоос Оросоор дамжин Номхон далайн эрэг хүртэлх шилмүүст ой тайгын бүсийн өмнөд хил юм. Эдгээр шилмүүст ойн ихэнх хэсэг харьцангуй

байгалийн төрхөөрөө байгаа ч зарим газарт ой багасаж, тайрагдсан байна. Мөн өндөр уулын зүйлүүдийн амьдралыг тэтгэж байдаг Алтайн уулс болон Монгол орны баруун ба төвийн бүсийн өндөр уулархаг газруудад оршдог тайга бидний анхаарлын төвд байдаг.

Монголын газар нутагт дээрх хүндрэлтэй асуудлууд байдаг ч зэргэлдээ орших Хятад оронтой харьцуулбал байгалийн чухал газруудад учирч буй дарамт харьцангүй бага. Гэвч Монголын зах зээлийн эдийн засгийн шинэтгэл үргэлжилж, эдийн засгийн огцом өсөлт буй болсноор (ихэвчлэн Хятадын эрэлт хэрэгцээнээс улбаатай) Монголын байгаль урьд өмнө байгаагүй дарамттай учраад байна. Уул уурхай, дэд бүтэц, аялал жуулчлалын салбарын хөгжил сүүлийн үед эрчимжсэнээр Монголын биологийн төрөл зүйлийг ихээхэн эрсдэлд оруулах болов. Түүнчлэн Монгол орон тусгай хамгаалалттай газар нутгийн тогтолцоог албан ёсоор бий болгох талаар ихээхэн амжилт олж байгаа боловч байгалийн олон чухал газрууд өнөөг хүртэл хамгаалалтгүй хэвээр байна.

Монгол орон эрдэс баялагаар арвин боловч түүнийхээ ихэнхийг бараг ашиглаагүй байсан бөгөөд харин сүүлийн үед Монголын уул уурхайн салбар дэлхий дээр хамгийн хурдацтай өсч буй салбаруудын нэг боллоо. (Хэсэг 5.2-ыг үз). Харин энэ салбарт өнөөдөр байгаль орчны зүй зохистой хамгаалал үгүйлэгдэж байгаагаас (Хэсэг 6.1, 6.2-ыг үз) уул уурхайн олборлолт бүхий газрууд нь биологийн төрөл зүйлийн өндөр ач холбогдол бүхий газруудтайгаа давхцаж байна. Уул уурхайн үйл ажиллагаа биологийн төрөл зүйлд шууд болон дам байдлаар нөлөөлдөг. Уул уурхайн үйл ажиллагаатай холбоотой шууд нөлөө гэдэгт усны бохирдол (жишээ нь гол мөрөнд хаягдлаа хаяхтай холбоотой), агаарын бохирдол (тоос, металл хайлуулах төхөөрөмжийн агаарт ялгаруулах хорт утаа) болон хүрээлэн буй орчны сүйрэл (жишээ нь хайгуулын өрөмдөлт, хаягдлын хуримтлал, хортой хаягдлын овоолол) зэрэг багтана. Дам нөлөө гэдэгт төлөвлөсөн болон төлөвлөөгүй хөгжлийн үйл явцтай (зам харгуй, төмөр зам болон шинэ суурин газрууд зэрэг) холбоотой нөлөөлөл нь Монгол орны хувьд шууд нөлөөнөөс ч илүү хөнөөлтэй.

Эдийн засгийн өсөлт нэмэгдэж, худалдаа арилжаа өргөжих тусам (ялангуяа Орос, Хятад болон Солонгостой) зам, төмөр замын сүлжээ, усан цахилгаан станц, цахилгаан дамжуулах шугам зэрэг дэд бүтцэд дорвитой хөрөнгө оруулалт хийх шаардлага гарч байна. Нөмрөгийн дархан цаазат газрын нутаг дэвсгэрээр дайрч Монголын зүүн хэсгийг Хятадтай холбох шинэ гүүрийн барилга байгууламж, Өмнөговь аймагт барих дулааны цахилгаан станц, мөн тэндхийн уул уурхайн үйл ажиллагааг дэмжих, “Мянганы зам” болон тус улсын хойд өмнөд хэсгийг холбох нэмэлт таван зам тавих зэрэг нь хөгжлийн төлөвлөсөн үйл явц гэдэгт хамаарагдана. Дэд бүтцийн ийм төлөвлөсөн хөгжил нь уул уурхайн салбарын санхүүжилт, эдийн засгийн үндэслэлээс ихээхэн хамаарна.

Аялал жуулчлалын салбар байгалийн болон соёлын аялал жуулчлалын өнгө аястайгаар эрчимтэй хөгжиж байна. Хүний үйл ажиллагаанд ихээхэн эмзэг газруудад жуулчны бааз байгуулсаар байгаа нь сэтгэл түгшээж байгаа юм. Сүүлийн үед олон улсын ач холбогдол бүхий ус намгархаг газруудад жуулчны гэр баазууд олноор байгуулсан нь суурин болон нүүдлийн шувуудад ихээхэн хор хөнөөл учруулж байна.

Эдгээр чиг хандлагаас үүдэлтэй хөгжлийн сөрөг үр дагавраас сэргийлэх үүднээс байгалийн чухал газруудыг (хамаалалттай ба хамаалалтгүй) яаралтай хамгаалах бодит шаардлага урган гарч байна.

2.2 Газар нутаг, амьдрах орчныг хамгаалах талаар Дэлхийн банкны баримтлах байр суурь

Хөгжлийн чанартай үйл ажиллагаа явуулахдаа Дэлхийн банк байгалийн чухал газруудыг хамгаалах чиглэлээр тэргүүлэх байр суурь баримталж байгаа юм. Хөгжлийн бусад банкууд ч байгалийн чухал газруудыг хамгаалах талаар ижил байр суурьтай байдаг. Дэлхийн банк ийм байр сууриа байгалийн амьдрах орчны талаар баримтлах

үйл ажиллагааны бодлого (ОР 4.04, 2001 оны 6 сар)-доо тусгасан бөгөөд энэ бодлого нь дараах агуулгатай. Үүнд:

- Байгалийн чухал газруудын хамгаалал, хадгалалт болон нөхөн сэргээлт, тэдгээрийн үйл ажиллагааг өөрийн эдийн засаг, салбарын ажил, төслийн санхүүжилт болон бодлогын чанартай яриа хэлэлцээ зэргээр дэмжих

- Банкны эдийн засаг болон салбарын үйл ажиллагаанд дараах асуудлыг тодорхойлдог. Үүнд: а. Байгалийн чухал газрууд ба тодорхойлсон (нэн ялангуяа онцгой ач холбогдол бүхий газар нутгуудад) газар нутгуудад учирч буй аюул хөнөөлтэй холбоотой газар нутгуудын орчны хамгааллын онцгой хэрэгцээ шаардлага б. Эдгээр газар нутгуудад улс орны эдийн засгийн хөгжлийн стратегийн агуулгатай нийцүүлж хамгаалалтын арга хэмжээ авах

- Байгалийн чухал газруудад дорвитой өөрчлөлт, доройтол бий болгож болзошгүй төслүүдэд банк дэмжлэг үзүүлэхгүй

- Байгалийн чухал газрууд, тэдгээрийн гүйцэтгэх экологийн үүрэг функц, газар нутгуудад нүүрлэж буй аюул хөнөөл, хамгаалах арга хэмжээний дэс дараалал, холбогдох урсгал санхүүжилт болон хүчин чадавхи бүрдүүлэх, хэрэгцээ шаардлагыг тодорхойлох зэргээр байгалийн амьдрах орчны томоохон асуудлыг өөрийн хөгжлийн хийгээд байгаль орчны стратегид тусгасан байхыг Банкны зээлдэгч нартаа уриалдаг.

Энэхүү бодлого болон санхүүгийн бусад байгууллагын зээлдүүлэх бодлогын талаар / хэсэг 6.4/-д тусгасан болно.

Монгол орны байгалийн чухал газруудын хамгааллыг чангатгах үүднээс Саяхан Дэлхийн банк, Японы итгэлцлэлийн сангаас шувуудыг биологийн төрөл зүйлийн нийт үнэлгээний үзүүлэлт болгон ашиглаж, байгалийн чухал газруудын тооллого явуулж түүнийг бүртгэх ажлыг санхүүжүүлсэн юм. Шувуудад чухал ач холбогдолтой 70 газрыг (шувууд болон биологийн бусад төрөл зүйлийг хамгаалах зорилготой дэлхийн түвшний чухал газрууд) тодорхойлж баримтжуулав. Шувуудад чухал эдгээр газрууд нь одоо байгаа болон шинээр санал болгож буй тусгай хамгаалалттай газруудын гадна байгааг илэрхийлэхийн зэрэгцээ байгалийн чухал нутгуудад Дэлхийн банкны зүгээс тавьдаг шалгуур үзүүлэлтэд нийцэхүйц газруудыг тодорхойлоход тус дөхөм болох учиртай.

3. Судалгааны зорилтууд

Монголын биологийн төрөл зүйлд нүүрлэж буй хөгжлийн улбаатай дарамт шахалтын улмаас байгалийн чухал газруудад учирч буй аюул хөнөөлийг үнэлэх, хамгаллын арга хэмжээг чангатгах, нөлөөллөөс зайлсхийх, түүнийг бууруулах, нөхөн төлбөр хийх зэрэг олон асуудлаар бусад орны хуримтлуулсан тэргүүний туршлагаас суралцах шаардлагатай байна. Уг шаардлагыг харгалзан BirdLife Asia байгууллагад дараах асуудлаар судалгаа хийх хүсэлт тавьж гэрээ байгуулсан юм. Үүнд:

1. Дэлхийн банкны Монголд дахь Хяналт үнэлгээний үйл явцыг бэхжүүлж өөрийн эдийн засаг, салбарын үйл ажиллагаа, төслийн санхүүжилт, бодлогын яриа хэлэлцээ зэрэгтээ байгалийн чухал газруудын асуудлыг тусгаж байх

2. Монголын байгалийн чухал газруудын тухай мэдээллийг бизнесийн тэргүүлэгч байгууллагууд, бодлого боловсруулагчид, төлөвлөгчид, улсын болон орон нутгийн засаг захиргаа, санхүүгийн бусад байгууллагуудад хүргүүлж байх

3. А. Уул уурхайн хөгжил, Б. Дэд бүтцийн хөгжил в. Аялал жуулчлалын хөгжил зэрэгт нөлөөлөхүйц байгалийн хамгийн чухал эмзэг газруудыг тодорхойлох

4. Эдгээр хөгжлийн үйл явцын байгалийн чухал газруудад үзүүлж болзошгүй нөлөөллөөс урьдчилан сэргийлэх

5. Байгалийн чухал газруудын хамгаллын талаарх дэлхий дахины тэргүүний туршлагыг Монголын засгийн газар, бизнесийн манлайлагч байгууллагуудад танилцуулах

Судалгааны ажлын үр дүн:

1. Монгол орны байгалийн чухал газруудтай уул уурхай, дэд бүтэц, аялал жуулчлалын төлөвлөгөөний давхцалыг харуулсан газар зүйн мэдээллийн тогтолцоо бүхий мэдээлэл, газрын зураг үйлдэв.

2. Хөгжлийн эдгээр үйл явц нь байгалийн чухал газруудад нөлөөлөх нөлөөний стратегийн үнэлгээг чухал газруудын хамгаалал, нөлөөллийг багасгах саналуудын хамт боловсруулав.

3. Дэлхийн улс орнуудын байгалийн чухал газруудын хамгаалал, сөрөг нөлөөллийг багасгах аргуудын жишээг шийдвэр гаргагч болон бизнесийн манлайлагч аж ахуйн нэгжүүдэд танилцуулав.

4. Монгол орны байгалийн чухал газруудыг тодорхойлох ажил

Энэ судалгааны зорилгод нийцүүлж BirdLife Asia байгууллагаас байгалийн чухал газрууд гэдэгт Дэлхийн банкны үйл ажиллагааны хөтөлбөр 4.04-т тодорхойлсон байгалийн чухал газруудын шалгуурыг хангаж буй газруудыг оруулав (хэсэг 6.4-ийг үзнэ үү). Иймээс YAX 4.04-ийн дагуу байгалийн чухал газрууд гэдэгт:

(i) Одоогийн тусгай хамгаалалттай газар нутгууд, мөн засгийн газраас тусгай хамгаалалттай болгох санал бүхий газрууд, орон нутгийн уугуул иргэд анхнаасаа тусгай хамгаалалттай хэмээн өргөмжилсөн газрууд, эдгээр тусгай хамгаалалттай газруудын оршин тогтноход шаардлагатай нөхцлийг бүрдүүлэх газар нутгуудыг хамруулав.

(ii) Дэлхийн банк болон эрх мэдэл бүхий бусад байгууллагын боловсруулсан нэмэлт жагсаалтанд орсон газар нутгууд. Нэмэлт жагсаалтанд орсон газрууд гэдэгт: орон нутгийн уугуул иргэдийн өргөмжлөн тогтоосон газар нутгууд, биологийн төрөл зүйлийг хамгаалахад хамгийн тохиромжтой гэгдэх газрууд, ховор, эмзэг, нүүдлийн хийгээд устах аюулд өртсөн ан амьтдад чухал газруудыг хамруулав. Ан амьтны зүйлийн түгээмэл байдал, эндемизмийн төвшин, ховордол, бүрэлдэхүүн зүйлүүдийн эмзэг байдал, төлөөлөл ба экологийн тогтолцооны үйл явцын нэгдмэл байдал зэрэг хүчин зүйлийн системчилсэн үнэлгээний үндсэн дээр уг нэмэлт жагсаалтыг гаргадаг.

Монголын хувьд байгалийн чухал газруудыг YAX 4.04-т тусгасан шалгуур үзүүлэлтээр тодорхойлсон бөгөөд үүнийг хүснэгт 1-д үзүүлэв.

Зураг 1. Тусгай хамгаалалттай газар нутгийн ангилал



Мэдээлийн эх сурвалж: 1994 онд батлагдан Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль

Хүснэгт 1. Монгол орны байгалийн чухал газруудын ангилал

Ангилал	YAX 4.04-т тусгагдсан шалгуур үзүүлэлт	Монголд хэрэглэж буй байдал
Албан ёсны тусгай хамгаалалттай газрууд	Одоогоор тусгай хамгаалалттай газрууд ба засгийн газраас тусгай хамгаалалтад авах санал бүхий газрууд (Олон улсын байгаль хамгаалах холбооны ангиллын дагуу шалгуур үзүүлэлтэд нийцэх нөөц)	Монголд албан ёсны тусгай хамгаалалттай газруудын гурван ангилал бий. Үүнд: (а) **улсын тусгай хамгаалалттай газрууд** (б) **орон нутгийн тусгай хамгаалалттай газрууд** (в) **олон улсын хэмжээнд хамгаалагдсан газрууд (**Рамсарт бүртгэлтэй газрууд, Дэлхийн өвийн санд бүртгэгдсэн газрууд ба биологийн нөөц газрууд**)**
Орон нутгийн тусгай хамгаалалттай газрууд	Анхнаасаа орон нутгийн уугуул иргэдийн тусгай хамгаалалттай хэмээн өргөмжилсөн газрууд (тахилага шүтлэгтэй газар нутаг)	Байгалийн чухал зарим газар нутгийг (уул, нуур г.м.) **тахилага шүтлэгтэй газрууд хэмээдэг**
Туслах чанарын газрууд	Тусгай хамгаалалттай газар нутгуудын хувьд онцгой чухал нөхцлийг бүрдүүлдэг газар нутгууд (байгаль орчны үнэлгээний үйл явцаар тогтоогдсон)	Байгаль хамгаалалд чухал зарим газар нутгууд тусгай хамгаалалттай газрын хувьд онцгой чухал нөхцөл бүрдүүлдэг (нуурын ус цуглуулах талбайг хамгаалдаг ой, зэрлэг ан амьтны корридор г.м.). Цаг хугацаа, мэдээлэл хомс байсан тул энэхүү судалгаагаар эдгээр газруудыг тодорхойлох боломжгүй байлаа.
Нэмэлт газар нутгууд	Эдгээрт: орон нутгийн уугуул иргэдийн өргөмжилсөн, биологийн төрөл зүйлийг хамгаалахад нэн тохиромжтой, ховор, эмзэг, нүүдлийн буюу устах аюулд өртсөн зүйлийн газар нутгууд	Орон нутгийн уугуул иргэдийн өргөмжилсөн газар нутгийг тахилага шүтлэгтэй газар гэдэг ангилалд оруулсан. Монгол орны **Шувуудад чухал газар** хэмээх сүлжээнд ховор, эмзэг, нүүдлийн буюу устах аюулд өртсөн зүйл онцгой ач холбогдолтой биологийн төрөл зүйлд нэн тохиромжтой газруудыг оруулна.

Монгол орны байгалийн чухал нутгуудыг 4 ангилдаг. Үүнд: албан ёсны тусгай хамгаалалттай газрууд, орон нутгийн тусгай хамгаалалтай газрууд, туслах чанарын газрууд, нэмэлт газар нутгууд зэрэг болно (Хүснэгт 1). Судалгааны явцад нэмэлт газар нутгуудаас бусад газар нутгийг эдгээр ангилал бүрээр тодорхойлж тэмдэглэх боломжтой байв. Энэ судалгаанаас өмнө тусгай хамгаалалттай газрын нөхцөл байдлыг хадгалахад гол үүрэг бүхий экологийн нөхцөлтэй газруудын улсын хэмжээний ийм дүн шинжилгээ өнөөг хүртэл хийгдэж байгаагүй ажээ. Бид байгаа мэдээлэлд үндэслэж ийм судалгаа хийсэн бөгөөд үүнээс гадна дүн шинжилгээ хийсэн байхыг ч үгүйсгэхгүй юм. Судалгааны тайлангийн дараагийн хэсгүүдэд байгалийн чухал нутгуудын ангилал бүрийг тайлбарласан ба нарийвчилсан мэдээллийг Хавсралт 1-5-д харуулав. Эдгээр ангиллууд харилцан бие биенээ үгүйсгэхгүй ба зарим газрууд хэд хэдэн ангилалд ч хамрагдаж байна.

4.1 Мэдээллийн эх сурвалж

Албан ёсны тусгай хамгаалалттай газрууд

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай 1994 онд батлагдсан хуулийн 3 дугаар зүйлд Монгол орны тусгай хамгаалалттай газар нутгийг Улсын Тусгай хамгаалалттай газар нутаг (Улсын ТХГН), Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг (Орон нутгийн ТХГН) гэж ангилжээ. Улмаар Улсын ТХГН-ийг Дархан цаазат газар, байгалийн цогцолборт газар, байгалийн нөөц газар болон байгалийн

түүх, соёлын дурсгалт газрууд гэж ангилдаг (Зураг 1).

Улсын ТХГН-ийн газарзүйн мэдээллийн системийг Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газраас авсан болно. Албан ёсны тусгай хамгаалалттай газрууд болон ТХГН-ийн байгуулагдсан хугацааг Байгаль орчны яамны албан ёсны баримтууд, мөн www.mne.mn веб хуудаснаас татаж авав. Эдгээр мэдээллийн эх сурвалжаас авсан мэдээллүүд нь 2008 оны 6 сарын байдлаарх мэдээлэл юм.

Албан ёсны баримт бичгүүд болон газарзүйн мэдээллийн системийн полигонд тусагдсан Улсын ТХГН-уудын хил хязгаар нь нийт талбайнхаа 3 хүрэхгүй хувьд нь зарим нэг зөрүү байгаа. Энэхүү тайланд хэрэглэсэн тоо баримтыг газарзүйн мэдээллийн системийн полигоноос авав. Түүнчлэн зарим албан ёсны баримтуудад хэд хэдэн салбартай тусгай хамгаалалттай газар нутгийг (Их Говийн “А” болон Их Говийн “Б”) нэг газар мэт тайлбарладаг ба бид энэ тайлангийн зорилгод нийцүүлж тус тусдаа хамгаалалттай газар гэж тооцлоо.

Орон нутгийн ТХГН-ийн тухай мэдээллийг Дэлхийн байгаль хамгаалах сангийн Монгол дахь хөтөлбөрийн газар болон Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газарт харьяалагддаг Байгаль хамгаалах төвөөс авсан болно. Эдгээр мэдээллийг аймаг (нийслэл хотын) засаг захиргаанаас авсан бөгөөд тэдгээрийг нягтлан шалгаад цахим хэлбэрт оруулав. Энэ тайланд нэгтгэж оруулсан мэдээлэл нь 2008 оны 5 сарын байдлаарх мэдээлэл юм. Гэхдээ Орон нутгийн ТХГН-ийг орон нутгийн төвшинд аймаг, сумдын засаг захиргаанаас тогтоодог бөгөөд цаашид ийм нутгуудын хамрах хүрээ улам бүр тэлэх төлөвтэй байна.

Энэ тайланд Монгол орны Орон нутгийн тусгай хамгаалттай бүх нутгийн жагсаалтыг тусгаагүй бөгөөд энэ нь ихээхэн зай эзлэх байв. 2007 оны 12 сарын байдлаарх иж бүрэн жагсаалтыг ГЗБГЗЗГ-аас Дэлхийн байгаль хамгаалах сантай хамтран хэвлэжээ (2008).

Тайланд олон улсын хэмжээнд хамгаалагдсан газар нутгуудын гурван төрлийн мэдээллийг тусгав. Тухайлбал, Дэлхийн өвийн санд бүртгэлтэй газрууд, Шим мандлын нөөцийн мэдээллийг UNESCO-ийн www.unesco.org веб хуудаснаас, Рамсарт бүртгэлтэй газруудын тухай мэдээллийг Рамсарын мэдээллийн үйлчилгээний www.wetlands.org/rsis/ веб хуудаснаас тус тус авав. Монгол дахь Рамсарт бүртгэлтэй газруудын хил хязгаарын полигоныг тогтоохдоо анх Рамсарын ангилалд оруулах газруудын саналыг боловсруулсан Монгол Улсын Шинжлэх ухааны академийн судлаачдын цаасан дээр үйлдсэн зургаас цахим хэлбэрт шилжүүлэн ашиглах замаар гүйцэтгэв. Олон улсын хэмжээнд хамгаалагдсан газрын бүх мэдээллийг 2008 оны 6 сарын байдлаар тусгав.

Рамсарт бүртгэлтэй газрын хувьд Рамсарын газрын мэдээллийн үйлчилгээ, газарзүйн мэдээллийн системийн полигон зэргээс тооцоолж гаргасан мэдээллүүдийн хооронд зарим нэг зөрүү гарч байв. Эдгээр зөрүү нь албан ёсны баримтад зөвхөн усан гадаргуу бүхий газрыг тусгаад, түүний ойр орчмын амьдрах орчныг харуулаагүйтэй холбоотой байх магадлалтай. Ганга нуур болон түүний ойр орчмын ус намгархаг газруудад эдгээр зөрүү нилээд тодорхой ажиглагдана. Ер нь Рамсарт орсон газар нутгууд нь голдуу ус намгархаг амьдрах орчнуудын бүрдэл болж орших олон жижиг нуурууд л байдаг. Энэхүү тайлангийн тоо баримт нь газар зүйн мэдээллийн системийн полигоноос тооцоолсон тоо баримтад тулгуурласан болно. Ер нь цаашдаа бүх газар нутгийн талбайг бүрэн тусгахын тулд Рамсарт орсон газар нутгийн мэдээлэлд дурьдагдсан албан ёсны тоо баримтыг нягтлан үзэх шаардлагатай байна.

Нутгийн иргэдийн хамгаалдаг газрууд

Энэ судалгааны зорилгын дагуу орон нутгийн иргэдийн хамгаалдаг газруудыг тахилага шүтлэгтэй газар нутгууд гэж тодорхойлоод хүснэгт 1-д үзүүлэв.

Монгол орны тахилага шүтлэгтэй газруудын нэрийг www.buddhistecology.org/sacredsite-sofmongolia.shtml Буддистуудын экологийн веб хуудаснаас авав. Энэхүү жагсаалтыг Шашины байгууллагууд, байгаль хамгаалах холбоо, Дэлхийн байгаль хамгаалах сангийн

Монгол дахь хөтөлбөрийн газрууд хамтран гаргажээ. Орон нутгийн ард иргэдэд соёл, шашны ач холбогдолтой бүхий байгалийн онцлогуудыг (уул, ус) төрөл бүрийн мэдээллийн эх сурвалжид дурьдсан байна. Бидэнд цаг хугацаа хомс байсан тул энэхүү судлагаанд тухайн газруудын дэлгэрэнгүй мэдээллийг оруулаагүй болно.

Нэмэлт газар нутгууд

Энэ судалгааны зорилгын дагуу шувуудад чухал газруудыг тусгах үүднээс нэмэлт газруудыг тодорхойлов (Хүснэгт 1). Монгол орны бусад газрууд ч YAX 4.04-т тусгагдсан нэмэлт газруудын шалгуурт нийцэхийг ч үгүйсгэхгүй. Гэхдээ одоогоор шувуунаас бусад ангилал зүйн бүлгүүдийн хувьд системтэй тооллого хийгээгүй байна. Шувуунд чухал газруудын тухай мэдээлэл нь 2008 оны 6 сарын байдлаар тусгагдсан бөгөөд Монголын Зэрлэг амьтан хамгаалан судлах төв, Монгол Улсын ШУА-ийн Биологийн хүрээлэнгээс (Батбаярын боловсруулсан) хамтран хийсэн шувуунд чухал газруудын тооллогын бүртгэлд үндэслэгдсэн болно. Энэ тооллогод 2007 оны 4 сард Улаанбаатарт зохиогдсон "*Монгол орны байгалийн чухал газар нутгуудыг тодорхойлж хамгаалах нь*" сэдэвт семинарын үр дүнг тусгасан болно. Уг семинарыг БОЯ, Дэлхийн банк хамтран зохион байгуулсан бөгөөд үүнд засгийн газар, эрдэм шинжилгээний байгууллагууд, олон улсын болон дотоодын ТББ-ын төлөөлөгчид оролцсон болно. Семинарт оролцогсод BirdLife International байгууллагаас тогтоосон олон янзын шалгуур үзүүлэлтүүдийг ашигласан юм. Үүний үр дүнд уг семинараар Азийн Шувуудад (BirdLife International, 2004) чухал газруудын жагсаалтанд тусгагдсан, Монголын шувуудад чухал 40 газрын урьдчилсан жагсаалтыг боловсруулсан билээ. Монгол орны Шувуудад чухал газруудын талаарх нарийн мэдээллийг Монголын зэрлэг амьтдыг судлан хамгаалах төвийн www.wscc.org.mn/iba.html веб хуудаснаас авч болно.

4.2. Монгол орны улсын тусгай хамгаалалттай газрууд

Монголчууд тэртээ 13 дугаар зууны эхээр Чингис Хааны өргөмжилсөн тахилага шүтлэгтэй гурван уулын үеэс эхлэн газар нутгаа хамгаалж байжээ. Иймээс Монгол орон газар нутгаа тусгай хамгаалалд авах талаараа дэлхийн хамгийн эртний уламжлалтай орнуудын нэг юм (Энэбиш, Мягмарсүрэн, 2000, Фаррингтон, 2005). Улаанбаатар хотын өмнө хэсэгт орших Богдхан ууланд мод бэлтгэж, ан хийхийг албан ёсоор хориглосон хоригийг 1778 онд тогтоосон нь дэлхийн хамгийн эртний тусгай хамгаалалттай газрыг бий болгож байжээ (Жонстад, Ридинг 2003). Ийм хоригийг 1818 онд Отгонтэнгэр болон Булган ууланд нэвтрүүлжээ (Энэбиш, Мягмарсүрэн).

Улсын ТХГН-ийн тогтолцоог анх 1950 оноос хойш нэвтрүүлж 1990-ээд онд ардчилсан тогтолцоонд шилжсэн цаг үеэс хойш энэ арга хэмжээ улам өргөжсөн байна. (Фарингтон, 2005). 2000 оноос хойш улс даяар Орон нутгийн ТХГН-ийн тогтолцоо ихээхэн өргөжсөн байхад, харин Улсын ТХГН-ийн тогтолцоо нилээд хумигдсан байх юм (Хэсэг 4.3-ыг үз).

Хүснэгт 2. Монгол орны Улсын ТХГН (2008 оны 6 сарын байдлаар)

Ангилал	№	ГМТ-ны газар (га)	Албан ёсны газар (га)
Дархан цаазат газар	18	10,987,403	10,494,283
Байгалийн цогцолборт газар	26	9,263,347	9,214,153
Байгалийн нөөц газар	20	2,057,621	2,002,228
Байгалийн түүх, соёлын дурсгалт газар	8	104,765	97,645
Нийт	**72**	22,413,136	21,808,309

Мэдээлийн эх сурвалж: Монгол дахь ДБХС ба БОЯ

Зураг 2: Монгол орны Улсын ТХГН-ийн тооны өсөлт



Мэдээллийн эх сурвалж: Дэлхийн байгаль хамгаалах сан, БОЯ

Монголын засгийн газар тусгай хамгаалалттай газруудын тогтолцоог өргөжүүлэхийн зэрэгцээ тусгай хамгаалалттай газруудын үйл ажиллагааг зохицуулах зохицуулалтын цар хүрээг тогтоожээ. Тусгай хамгаалалттай газар нутгийн анхны хууль тогтоомжийг 1975 онд батлаж, "Монгол Улсын Дархан цаазат газрын шалгуурыг мөрдөж эхлэсэн юм. Тусгай хамгаалалттай газрууд болон орчны бүсийн тухай гарсан анхны хууль эрхийн баримт бичгүүд бол 1994 оны Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, 1997 оны ТХГН-ийн орчны бүсийн тухай хуулиуд юм. (Хэсэг 6.1 үз).

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулинд улсын тусгай хамгаалалттай газар нутгийн дөрвөн гол ангиллыг тодорхойлжээ. Үүнд: (i) Дархан цаазат газар, (ii) Байгалийн цогцолборт газар, (iii) Байгалийн нөөц газар, (iv) Байгалийн түүх, соёлын дурсгалт газар зэрэг орно. **Дархан цаазат газар** гэдэг нь байгалийн нөхцөл байдлаа маш сайн хадгалсан, хүний үйл ажиллагааг хатуу хориглосон газар нутаг. **Байгалийн цогцолборт газар** гэдэг нь байгалийн нөхцөл байдлаа харьцангуй сайн хадгалсан, түүх, соёл, шинжлэх ухаан, боловсрол болон экологийн ач холбогдол бүхий газар нутаг. **Байгалийн нөөц газар** гэдэг нь экологи, биологи, палеонтологи буюу геологийн онцлогийг хамгаалах, хадгалах болон нөхөн сэргээх зорилгоор хамгаалдаг газар нутаг. **Байгалийн түүх, соёлын дурсгалт газар** гэдэг нь байгалийн өвийг хадгалах зорилгоор хамгаалдаг, түүх, соёлын ач холбогдол бүхий газар нутаг (Жонстад, Ридинг 2003).

2008 оны 6 сарын байдлаар Монголын Улсын ТХГН нийт 22 сая га газар буюу нийт газар нутгийн 14 хувийг эзлэж байжээ (Хүснэгт 2). Уг тогтолцоо нь Дархан цаазат 18 газар (тайлбайн хувьд уг тогтолцооны 49 хувийг эзлэх), Байгалийн цогцолборт 26 газар (41 хувь), Байгалийн нөөц 20 газар (9 хувь) ба Байгалийн түүх, соёлын дурсгалт , газраас (1 хувиас бага) бүрддэг юм. Монголын Улсын ТХГН-ийн бүрэн жагсаалтыг Хавсралт 1 болон Газрын зураг 1-т харуулсан болно.

Биологийн төрөл зүйлийг хамгаалах олон улсын Конвенцийн дагуу Монгол улс өөрийн

тусгайхамгаалалттайгазарнутгийнтогтолцоог 2010 он хүртэл өргөтгөх төлөвлөгөөг боловсруулсан билээ. Энэ төлөвлөгөө нь хамгаалалттай газруудын цогц, үр дүнтэй удирдлага, экологийн төлөөлөл бүхий сүлжээ байгуулан тэдгээрийг тогтвортой ажиллуулах зорилготой юм. Тусгай хамгаалалттай газрын биологийн төрөл зүйлийн ажлын хөтөлбөрийн тухай Конвенцийн хүрээнд Монголын засгийн газраас ТХГН-ийн Үндэсний хөтөлбөр хэрэгжүүлж байна. Энэхүү хөтөлбөрийн хоёр дахь үе шат (2005-2015) "бүх газар нутгийн 30 хувийг ТХГН болгох" зорилгыг агуулж байгаа. Монгол Улсын Их Хурлаас 1992 онд анх тунхагласан нийт газар нутгийн 30 хувийг тусгай хамгаалалттай статусын аль нэгэн хэлбэрт хамруулна гэсэн зорилгыг энэ нь давтаж байгаа юм (Жонстад, Ридинг 2003). Улсын хэмжээнд Орон нутгийн ТХГН-ийн тогтолцоонд сүүлийн үед гарсан өсөлт нь Монгол Улс дээрх зорилгод хүрэх бүрэн боломжтойг харуулж байна.

Венесуэлийн Каракас хотноо 1992 онд болсон Байгаль хамгаалах олон улсын холбооны Дэлхийн цогцолбор газруудын их хурлаас 2000 он гэхэд хамгийн багаар бодоход дэлхийн гол биомуудын 10 хувийг хамрах зорилгоортусгайхамгаалалттайгазарнутгийн талбайг өргөжүүлэх зорилт дэвшүүлжээ. Гэтэл Монголын засгийн газар нийт нутгийнхаа 30 хувийг тусгай хамгаалалтад авахаар заасан нь дээрх зорилтоос хол давж байгаагаараа анхаарал татаж байна. Гэхдээ энэхүү том зөрүү нь дараах хүчин зүйлээс үүдэлтэй. Үүнд: *нэгдүгээрт*, Монгол орон жижиг тасархай нутаг дэвсгэрт тэр болгон хамгаалаад байх боломжгүй томоохон амьтны аймаг бүхий байгалийн өргөн уудам экологийн тогтолцоотой юм. *Хоёрдугаарт*, Байгаль хамгаалах олон улсын холбооны зорилтот 10 хувь бол хийсвэр тоо бөгөөд байгаль хамгаалах шинжлэх ухааны хүрээнд гол төлөв прагматик хандлагыг харуулж буй хувь хэмжээ болно.

БОЯ-ныүзэжбайгаагаартусгайхамгаалалттай газар нутгийн хэмжээг өсгөнө гэдэг нь зөвхөн сүлжээний тайлбайг нэмэгдүүлнэ гэсэн үг биш харин чухал ач холбогдолтой зүйл, байгалийн чухал нутгуудын хамрах хүрээг өргөтгөнө гэсэн үг (Дэлгэрцогт, 2008). Иймээс одоогоор уг зөрүүг судлаж, нягтлан шинжилгээ хийх үйл ажиллагаа явагдаж байгаа бөгөөд үүнд одоогийн тогтолцоогоор бүрэн гүйцэт хамрагдаагүй зүйл, амьдрах орчныг өргөнөөр хамруулах асуудлууд чухал байгаа юм.

4.3. Орон нутгийн тусгай хамгаалалттай газрууд

ТХГН-ийн тухай хуулийн 28-р зүйлд орон нутгийн ТХГН, түүний хил хязгаар, тэнд мөрдөх дүрэм журмыг тогтоох эрхийг аймаг (нийслэл), сум (дүүргийн)-ын Иргэдийн төлөөлөгчдийн хуралд олгосон байдаг (Хэсэг 6.1-ийг үз). Өнөөг хүртэл орон нутгийн ТХГН-ийг байгуулах тухай шийдвэрийг Улаанбаатар хот болон нэг аймгаас бусад 21 аймагт[1] гаргаж байжээ. Анх гурван аймаг (Монгол орны төв хэсгийн) өөрийн бүхий л нутаг дэвсгэрийг орон нутгийн ТХГН болгохоор шийдвэрлэж байжээ (Чимэд-Очир, 2008). Гэвч засгийн газраас үүнийг хэрэгжүүлэх шаардлага тавимагц тэдгээр аймгууд бүхий л газар нутгаа бус харин зөвхөн заримыг нь орон нутгийн ТХГН болгожээ.

2008 оны 5 сарын байдлаар Монгол орны орон нутгийн 937 ТХГН байгаа бөгөөд эдгээр нь нийт газар нутгийн 10 хувьтай тэнцэх буюу 16.5 сая га газрыг эзэлж байна. Эдгээрийн 492 газар (багаар бодоход 11.5 сая га газар) нь аймаг (нийслэл)-д, 399 нь (багаар бодоход 3.6 сая га газар) сумын төвшинд байгаа ба үлдсэн 46 газрын тухай холбогдох мэдээлэл үгүй байна. Аймаг (нийслэл) бүрийн орон нутгийн ТХГН-ийн товчооныг Хавсралт 2, Газрын зураг 2-д тус тус харуулав.

[1]Орон нутгийн ТХГН-ийн ихэнхид уг газруудыг хамгаалалтад авахаас өмнө тэдгээр газруудад биологийн төрөл зүйлийн болон бусад шалгуур үзүүлэлтээр албан ёсны үнэлгээ өгсөн эсэх нь тодорхойгүй. Иймээс цаашдаа улсын хэмжээний болон орон нутгийн ач холбогдол бүхий биологийн төрөл зүйлийг хамгаалахад хамгийн их нөлөөлөх газруудад хязгаарлагдмал нөөцийг ашиглах үүднээс Орон нутгийн ТХГН-ийн сүлжээг төгөлдөржүүлэх шаардлагатай байна.

Орон нутгийн ТХГН-ийн хэмжээ нэг га-аас бараг нэг сая га газар хүртэл хэлбэлздэг (Баянхонгор аймгийн Хангайн бүсийн орон нутгийн ТХГН). Зөвхөн 40 орон нутгийн ТХГН л гэхэд хэмжээгээрээ 100 мянган га-аас их байгаа бөгөөд орон нутгийн ТХГН-ийн тогтолцоонд хамрагдсан нийт газар нутгийн тэн хагастай тэнцүү юм. Холбогдох мэдээлэл бүхий орон нутгийн ТХГН-ийн дөрөвний гурав нь 2000 оны 1 дүгээр сараас хойш байгуулагдсан ажээ (Зураг 3). 2000 оноос хойш удаашралтай явагдсан Улсын ТХГН-ийн тогтолцооны өргөжлөөс дээрх үйл ажиллагаа эрс өөр юм (Зураг 2).

Зураг 3: Орон нутгийн ТХГН-ийн тооны өсөлт



Мэдээллийн эх сурвалж: ДБХС-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар, нечур консерванси, болон ГЗБГЗЗГ

Улсын ТХГН, Орон нутгийн ТХГН-ийн хооронд бага зэргийн давхардал байдаг. Давхардлын нийт талбай 929,202 га газар ба Орон нутгийн ТХГН-ийн 6 хувьтай тэнцэнэ. Давхардлын тэн хагас нь Баянхонгор аймагт байдаг нь сонирхолтой бөгөөд 222,820 га газар нь Их Богдын байгалийн цогцолборт газар, 194,395 га газар нь Говь гурван сайхны байгалийн цогцолборт газартай давхцаж байна. Их Богдын хувьд Улсын ТХГН-ийн сүлжээнд саяхан (2007 онд) орсон учраас урьд өмнө байсан Орон нутгийн ТХГН-тай давхардсан бололтой.

Улсын болон Орон нутгийн ТХГН-ууд нийтдээ 38.015.439 га нутгийг хамардаг бөгөөд энэ нь улсын нийт газар нутгийн 24 орчим хувьтай тэнцэж байна.

4.4. Олон улсын хэмжээнд хамгаалагдсан газрууд

Улсын болон орон нутгийн ТХГН-ийн тогтолцооны зэрэгцээ Рамсарын Конвенц, Дэлхийн өвийн тухай Конвенци, UNESCO-ийн хүн ба шим мандлын хөтөлбөр зэрэг нэгдэн орсон олон улсын гэрээ, конвенцийн хүрээнд Монгол Улс хэд хэдэн газар нутгийг товлосон байдаг. Эдгээр газар нутгийг Олон улсын хэмжээнд хамгаалагдсан газар нутгууд гэдэг.

Рамсарт бүртгэлтэй газрууд

Усны шувуудын амьдрах орчин зэрэг олон улсын ач холбогдол бүхий ус намгархаг газрын тухай Рамсарын Конвенци нь 1975 оноос эхлэн албан ёсоор хүчин төгөлдөр

болжээ. Уг конвенциор ус намгархаг газрыг хамгаалж, тэдгээрийг зүй зохистой ашиглах чиглэлээр өрнүүлэх олон улсын хамтын ажиллагааны цар хүрээг тодорхойлжээ. Конвенцид нэгдэн орсон улс гүрнүүд өөрийн нутаг дэвсгэртээ ус намгархаг газрыг зохистой ашиглаж, холбогдох газруудыг олон улсын ач холбогдол бүхий ус намгархаг газрын (Рамсарын газар) жагсаалтад оруулах санал дэвшүүлэн, тэдгээрийг хамгаалах чиглэлээр ажиллах юм.

Монгол Улс уг конвенцид 1998 онд нэгдэн орсон ба одоогоор Рамсарт бүртгэлтэй 1.695.598 га талбай бүхий 11 газартай. Үүний бүрэн жагсаалтыг Хавсралт 3, Газрын зураг 3-д тус тус харуулсан болно. Рамсарт орсон газрын 10 нь Улсын болон Орон нутгийн ТХГН-т хэсэгчлэн хамрагдсан ба 1 газар нь бүрэн хамгаалалттай газар нутаг байна. Рамсарт орсон нийт 455.069 га газар улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газрын тогтолцооноос гадуур байгаа бөгөөд тэдгээрийг тухайн орны байгалийн чухал нутгуудад хамруулж байна.

Дэлхийн өвийн санд бүртгэлтэй газрууд

Дэлхийн өвийн газрын тухай 1975 онд батлагдсан Конвенцийн зорилго нь түүх, соёлын дурсгалт газар болон онцгой үнэлэмж бүхий газруудыг тодорхойлж хамгаалахад оршино. Уг Конвенцид нэгдэн орсон талууд холбогдох газар нутгийг Дэлхийн өвийн санд бүртгүүлж, UNESCO-оор хүлээн зөвшөөрүүлэх чиглэлээр ажиллаж байна.

Монгол Улс уг конвенцид 1990 онд нэгдэн орсон ба одоогоор нэг газрыг Дэлхийн байгалийн өвийн санд (Увс нуурын сав газар), нэг газрыг Дэлхийн соёлын өвийн санд (Орхоны хөндий)-д оруулаад байна. Дэлхийн өвийн санд орсон энэ хоёр газрын нийт хамрах талбай нь 932.201 га газар юм. Эдгээр хоёр газрын тухай нарийн мэдээллийг Хавсралт 3, Газрын зураг 3-аас үзнэ үү.

Увс нуурын сав газар нийтдээ 12 тусдаа газраас бүрддэг ба түүний тав нь Монголд, үлдсэн 7 нь Оросын нутаг дэвсгэрт бий. Монголын нутаг дахь таван газар бүгд Улсын ТХГН-т багтдаг. Үүнтэй нэгэн адил Орхоны хөндий бүхэлдээ Улсын хоёр ТХГН-т хамрагддаг. Сүүлийн үед засгийн газраас Хөвсгөл нуурыг гурав дахь газар болгон Байгалийн Дэлхийн өвийн санд багтаахаар санал оруулсан юм. Энэ газар нь бүхэлдээ улсын ТХГН-т хамрагддаг. Иймээс одоогоор тодорхойлогдсон болон санал болгож буй Монгол дахь Дэлхийн өвийн санд орсон газрууд нь YAX 4.04-ийн дагуу байгалийн чухал нутгуудад бага ч болов хувь нэмэр (27721 га) оруулж байна.

Дэлхийн шим мандлын нөөц газар

Хүн, шим мандлын тухай хөтөлбөрийг анх 1971 онд UNESCO санаачилсан юм. Энэ хөтөлбөр нь биологийн төрөл зүйлийг хамгаалж, тогтвортой ашиглах үндэс суурийг боловсруулж хүн ба байгаль орчны хоорондын харилцааг сайжруулахад чиглэгдсэн байдаг. Уг хөтөлбөрт оролцож буй улс орнууд шим мандлын болон далайн эрэг орчмын экологийн тогтолцооны жишээ болох нэг буюу түүнээс дээш шим мандлын нөөцийг тодорхойлж, биологийн төрөл зүйлийн хамгааллыг тогтвортой хөгжилтэй хэрхэн уялдуулах тухай шийдлийг санал болгох юм.

Шим мандлын нөөц газар нь Тусгай хамгаалалттай гол газар нутгуудыг орон нутгийн ард иргэд, үйлдвэр аж ахуйн газрууд тогтвортой хөгжлийг хөхүүлэн дэмждэг бүс нутагтай хослуулан, уламжлалт байдлаар тогтоосон хамгааллын бүсээс бүрдэнэ. Шим мандлын нөөцийг зохицуулах тогтолцоо нь гол төлөв нилээд шинэлэг байдаг бөгөөд зарим тохиолдолд шинээр хууль эрх зүйн актуудыг ч гаргаж болдог. Шим мандал нь өөр хоорондоо уялдаа холбоо бүхий дараах үүрэгтэй. Үүнд:

- Хамгааллын үүрэг: Тухайлбал ландшафт, экологийн тогтолцоо, амьд биеийн зүйлийн болон генетикийн олон янз байдлыг хамгаалах

- Хөгжлийн үүрэг: Тухайлбал эдийн засаг, хүний болон соёлын хувьд дасан зохицсон хөгжлийг бий болгох

- Ложистик дэмжлэгийн үүрэг: Тухайлбал судалгаа шинжилгээ, мониторинг, байгаль орчны боловсрол ба сургалт зэргийг дэмжих

Шим мандлын нөөц газрыг гурван төрлийн бүст ангилан үздэг (гол газар нутгууд, түүний орны бүсийн газрууд, шилжилтийн (завсрын) газрууд). Бүсчлэлийн бүдүүвчийг газар зүй, нийгэм-эдийн засгийн нөхцөл байдал, мөрдөж буй хууль эрх зүйн хамгаллын арга хэмжээ болон дотоод хязгаарлалтуудын улмаас өөр өөрөөр хэрэглэдэг. Гэхдээ шим мандлын нөөцийн гол газар нутгууд л хууль эрх зүйн хамгаалал шаарддаг тул байгалийн нөөц болон цогцолборт газар зэрэг одоогоор оршиж буй тусгай хамгаалалттай газар нутагтай уялддаг (UNESCO, 2008). Ийм учраас энэ тайлангийн зорилгын дагуу зөвхөн шим мандлын нөөцийн гол газруудыг байгалийн чухал нутгуудад хамруулав.

Эдүгээ Монголд шим мандлын 6 газрыг тогтоогоод байгаа бөгөөд анхныхыг нь (Их Говь) 1990 онд, сүүлчийнхийг нь (Монгол дагуур) 2007 онд тогтоожээ. Эдгээр 6 газар нийтдээ 16.078.072 га талбайг эзэлдэг. Гэхдээ эдгээрийн зөвхөн 2.064.505 га газар нь гол газар нутагт тооцогддог ба энэ тухай нарийн мэдээллийг Хавсралт 3, Газрын зураг 3-д тусгасан болно. Монголын шим мандлын 6 газрын гол газар нутгууд нь Улсын ТХГН-т багтдаг. Иймээс эдгээр газрууд Монгол орны байгалийн чухал нутгуудын талбайд нөлөөлөхгүй юм.

4.5. Монгол орны тахилага шүтлэгтэй газрууд

Тахилага шүтлэгтэй газар нутгууд өргөн утгаараа хоёр ангилалд хуваагддаг. Үүнд: (i) нутгийн уугуул ард иргэдийн тахин шүтдэг уул, нуурууд; (ii) сүм хийд, хад чулуу, хадны бичиг болон булш бунхан зэрэг соёлын ач холбогдол бүхий газрууд (Вербум, 2008). Энэ тайланд зөвхөн тахилага шүтлэгтэй газруудыг YAX 4.04-ийн дагуу “орон нутгийн уугуул иргэдийн тахин шүтдэг” гэдгээр нь байгалийн чухал нутгуудад хамруулав. Соёлын тахилага шүтлэгтэй газар нь угтаа байгаль дахь амьдрах орчны бүс юм. Соёлын тахилага шүтлэгтэй газруудын хамгааллын асуудал, археологи буюу палеонтологийн сонирхол бүхий газруудыг Дэлхийн банкны соёлын өв сангийн талаарх үйл ажиллагааны бодлого (OP 4.11 2006 оны 7 сар)-д тусгасан болно.

Буддистуудын экологийн веб хуудсанд тусгагдсан тахилага шүтлэгтэй газрын нэгдсэн жагсаалтанд Монгол орны тахилага шүтлэгтэй 47 газар байна. Эдгээр газруудаас Ерөнхийлөгчийн зарлигаар 3 нь улсын хэмжээнд, 34 нь аймаг (нийслэлийн) хэмжээнд, 10 нь “бүс нутгийн хэмжээнд” (хэд хэдэн аймаг дундын) өргөмжлөгдсөн байна. Монголын 21 аймагт бүгдэд нь, мөн нийслэл хотод ч тахилага шүтлэгтэй газар байдаг. Тахилага шүтлэгтэй газрын тоогоор нэгдүгээрт Хөвсгөл, Өвөрхангай (тус бүр 4 газартай) аймгууд ордог. Тахилага шүтлэгтэй газрын бүрэн жагсаалтыг Хавсралт 4 болон Газрын зураг 4-д тусгав.

Монгол орны тахилага шүтлэгтэй 47 газрын 16 нь Улсын ТХГН-ийн хүрээнд хамгаалагддаг ба 8-ыг нь Орон нутгийн ТХГН-ийн хүрээнд хамгаалдаг. Үлдсэн 23 нь Монголын байгалийн чухал нутгуудын нэмэлт газруудад багтдаг. Хил хязгаарыг нь албан ёсоор тогтоогоогүй тул эдгээрийг судалгааны явцад зөвхөн цэгээр тэмдэглэв. Иймээс эдгээр нэмэлт газруудын нийт эзлэх газар нутгийн хэмжээг тооцон гаргах боломжгүй байв. Гэхдээ тахилага шүтлэгтэй газруудын Монголын байгалийн чухал нутгуудын талбайд эзлэх хувийн жин бага юм.

4.6. Шувуудад чухал газрууд

Танилцуулга

Дэлхийн банк одоо байгаа болон цаашид хамгаалалтанд авахаар санал болгож буй тусгай хамгаалалттай газруудын зэрэгцээ “ховор, эмзэг, нүүдлийн болон устах аюулд өртөж байгаа биологийн төрөл, зүйлүүдийн” амьдрах орчныг байгалийн чухал газрууд хэмээн хүлээн зөвшөөрдөг (Хэсэг 6.4). Эдгээр газруудын талаарх мэдээлэл нь тохиролцсон, зорилготойгоор үнэлж дүгнэсэн, стандартчилсан хэлбэрээр олддоггүй ба ялангуяа улсын тусгай хамгаалалттай газар нутгийн сүлжээнээс гадуурх газруудын

хувьд бүр ч бүрхэг байна. Мэдээллийн ийм хомсдолтой байдал нь урьд өмнө хэрэгжүүлсэн хөгжлийн төслүүдэд байгалийн чухал нутгуудын хамгаллын асуудлыг огт тусгаагүйтэй шууд холбоотой бөгөөд одоо үүнийг арилгахад ихээхэн хөрөнгө зардал шаардагдана.

Бүхий л улс орнуудад тусгай хамгаалалттай газрын албан статусыг үл харгалзан тусгай хамгаалалтад авах чухал газруудыг Дэлхийн банкны YAX 4.04-ийн дагуу тодорхойлдог цорын ганц байгууллага бол BirdLife International юм. Энэ байгууллага шувуудад чухал газар нутгуудыг стандарт, олон улсын хүлээн зөвшөөрсөн шалгуур үзүүлэлтийг ашиглаж ТББ, мэргэжлийн хүмүүс, төрийн байгууллагын төлөөлөгчдийг оролцуулсан үндэсний хэмжээний болон орон нутгийн зөвлөлдөх уулзалтыг зохион байгуулах замаар тодорхойлдог. Шувууд бол биологийн бусад төрөл зүйлээ төлөөлөх боломжтой обьект бөгөөд шувуудад чухал нутгийг тодорхойлж хамгаалсанаар бусад амьтан, ургамалд чухал газар нутгийг давхар тодорхойлж байдгаараа ач холбогдолтой юм.

Шувууд бол биологийн төрөл зүйлд чухал ач холбогдол бүхий газар нутгуудыг сонгоход маш сайн үзүүлэлт болохуйц хэд хэдэн онцлогтой. Тухайлбал,

- Шувуудын дунд нийтээрээ устах аюулд өртсөн, тооны хувьд үлэмж цөөрсөн олон зүйл байхаас гадна тэдгээрийн ерөнхий тархац нутаг нь дэлхийд ховордсон, эндемик шинжтэй, ангилал зүйн хувьд тодорхойгүй олон зүйл шувуудын тархац нутагтай давхцаж байдаг.
- Шувууд нь бүхий л амьдрах орчинд (хагас байгалийн нөхцлийг оролцуулан), газарзүйн бүхий л бүс нутагт өргөн тархдаг онцлогтой.
- Шувууд нь тархацынхаа болон амьдрах орчныхоо шаардлагыг маш ойлгомжтойгоор илэрхийлж байдгийн зэрэгцээ тэдгээрийг хээрийн нөхцөлд нь бүртгэж тодорхойлоход ч харьцангүй хялбар байдаг.
- Шувууд нь амьдрах орчны нөхцөл, хүний үйл ажиллагаа зэргийн сайн таниур /индикатор/ болохын зэрэгцээ цаг хугацааны явцад экологийн өөрчлөлтийг хянаж байх харьцангүй сайн хэрэгсэл болдог.
- Шувууд нь Дэлхий дахины болон бүс нутгийн төвшинд шувуудад чухал газар нутгийг бодитойгоор тодорхойлох шалгуур үзүүлэлт (20 гаруй жилийн турш боловсрогдоод байгаа) болдог.
- Шувууд нь байгаль хамгааллын дөхөмтэй хэрэгслийн нэг болохын зэрэгцээ ба тэдгээрийг хамгаалах чиглэлээр ажиллах хүсэлтэй жирийн иргэд, буяны үйлстэн болон мэргэжилтнүүд зэрэг хүмүүсийн томоохон нийгэмлэгийг бий болгодгоороо онцлогтой.

Шувууд нь мөн өөрийн эрхийн хувьд хамгааллын чухал обьект юм. Тэдгээр нь экологийн тогтолцоонд чухал ач холбогдол бүхий үр тараах, тоос хүртээх зэрэг олон үүрэгтэй бөгөөд Монголын үйлдвэрлэлд томоохон байр эзлэх байгалийн аялал жуулчлалын бааз суурь болдгоороо эдийн засгийн ихээхэн ач холбогдолтой.

Монгол дахь Шувуудад чухал газруудыг тодорхойлох шалгуур үзүүлэлт

Монгол дахь ШЧГ (Шувуудад чухал газар)-ыг тодорхойлох шалгуур үзүүлэлтийг тогтооход Азийн ШЧГ-ын тооллогыг ашигласан юм (BirdLife International, 2004). Стандартчилсан эдгээр үзүүлэлтийг дэлхий дахины ач холбогдол бүхий газруудыг тодорхойлох зорилгоор гаргажээ. Эдгээр үзүүлэлт нь тухайн нэг орныг түүний хөрш орнуудтай болон бүс нутаг, дэлхий дахины төвшинд ч бүрэн харьцуулалт хийх боломжтой.

Хүснэгт 3. ШЧГ-ыг тодорхойлох дэлхий дахины ангилал, шалгуур үзүүлэлтийн товчоо

Ангилал	Шалгуур үзүүлэлт	Монголд хэрэглэж буй байдал
A1: Дэлхий хэмжээнд устах аюулд орсон зүйлүүд	Дэлхийн хэмжээнд устах аюулд орсон зүйлүүд болон дэлхийн төвшинд хамгаалвал зохих бусад зүйлүүд олноороо байнга нутагладаг газрууд	Тухайн газарт онцгой, устах аюулд өртсөн, эмзэг (устах аюулд ойрхон болон мэдээлэл хомс зүйлүүдийг энэ ангилалд оруулаагүй болно) ангиллын популяцитай болох нь тогтоогдсон, тооцогдсон, төсөөлсөн зүйлүүд
A2: Тархац нутаг хязгаарлагдмал зүйлүүд	Үржлийн тархац нутгийнх нь дийлэнх хэсэг эндемик шувууны нутаг дэвсгэр эсвэл хоёхдогч нутаг дэвсгэр болдог зүйлүүд уг нутат тогтмол, тоо толгойн хувьд дэлхийн эсвэл бүс нутгийн популяцид чухал нөлөөтэй байхаар тоотой үзэгддэг эсвэл байгаа гэж үздэг газар нутгууд	Эндемик шувуудын нутаг эсвэл хоёрдагч нутгаар хязгаарлагдмал зүйлүүд тоо толгойн хувьд тогтмол өндөр мөн тэдгээр мэдэгдэж байгаа чухал нутгуудын ядаж нэг хэсэг байх нөхцөл бүрдэж байх ёстой.
A3:Биом хязгаарлагдмал зүйлүүд	Энэ популяцийн тархацын дийлэнх хэсэг эсвэл бүхлээрээ нэг биомд багтах зүйлүүд байгаа нь тогтоогдсон эсвэл байгаа гэж үздэг газар нутгууд орно.	Хэрэв тухайн газар тархац нутаг нь аль нэг биомд бүхлээрээ хязгаарлагддаг шувууны зүйлийн хангалттай гэгдэх төлөөллийг агуулж байвал шаардлагад нийцнэ.
A4:Шувуу олноороо цугладаг дэлхий дахины ач холбогдол бүхий газрууд	(**I**) Усны шувуудын газарзүйн популяцийн 1% болон түүнээс дээш хувь нь тогтмол цуглардаг эсвэл байгаа гэж үздэг газрууд	Олон тоогоор цуглардаг зүйлд Олон улсын ач холбогдол бүхий ус намгархаг газрын (2000) усны шувууны үнэлгээнд дурьдсан шувуудыг хамруулав. Зүйл бүрийг бүс нутгаар тодорхойлж дэлхийн популяцийн 1%-иар тооцож үнэлэв.
Эсвэл	(**II**) Далай тэнгисийн эсвэл хуурай газрын шувуудын зүйлийн дэлхийн популяцийн 1% болон түүнээс дээш хувь тогтмол цуглардаг эсвэл байгаа гэж үздэг газрууд	Үүнд Олон улсын ач холбогдол бүхий ус намгархаг газрын тодорхойлтод (2002) хамрагдаагүй далай тэнгисийн шувуудын зүйлийг хамруулна. Зүйл бүрийн босго хэмжээг дэлхий дээрх популяцийн 1% байхаар тооцов.
Эсвэл	(**III**) Тогтмол 20.000 түүнээс дээш тооны усны шувууд эсвэл нэг ба хэд хэдэн зүйлийн далай тэнгисийн шувууны 10.000-аас дээш тооны үржлийн хос тогтмол байгаа гэж үздэг газрууд	Энэ бол Рамсарын Конвенцын 5 дугаар шалгуур үзүүлэлт бөгөөд үүнийг тухайн газарт (I) эсвэл (II) шалгуурт тэнцэхээр мэдээлэл сайн байгаа бол хэрэглэхийг татгалзах хэрэгтэй гэж зөвлөдөг.
Эсвэл	(**IV**) Нүүдлийн шувууд олноороо дайран өнгөрдөг хүзүүвч газрууд	Жилд доод тал нь 20.000 махчин шувуу, эсвэл тогоруу хавар намрын нүүдлийн улиралд тогтмол дайрч гардаг байвал шаардлагад нийцнэ.

ШЧГ нь хүснэгт 3-д заасан шалгуурт нийцэхийн зэрэгцээ дараах шаардлагыг хангасан байх учиртай. Үүнд:

- Амьдрах орчин, шувуу судлалын ач холбогдлоороо ойр орчмын газраасаа өөр байх
- Орчны бүстэй эсвэл орчны бүсгүй, одоо байгаа болон цаашид байгуулагдах тусгай хамгаалалттай газар нутаг, байгаль хамгаалах зорилгоор удирдан зохицуулах боломжтой байх
- Дангаараа эсвэл бусад газрын хамтаар шувуудад шаардлагатай бүхий л нөхцлийг бүрдүүлсэн байх

ШЧГ (Шувуудад чухал газрууд)-ын дутагдалтай талууд

Байгалийн чухал нутгуудыг тодорхойлохдоо ШЧГ-ууд гэж ялгаж үзэх нь хэд хэдэн бэрхшээл учруулдаг.

Нэгдүгээрт, шувуудын зүйлийн тоо нь тэдгээрийн амьдралын бүхий л хугацаанд, эсвэл тодорхой нэг үе шатандаа тархацын хувьд өргөн байж болох юм. Энэ нь бага нягтралтайгаар өргөн уудам газар нутагт тархсан, эсвэл маш том газар нутгийг хамарсан байгалийн амьдрах орчинд ч түгээмэл байна. Ийм нөхцөлд тухайн зүйлийн популяци болон түүний эзэмшил нутгийн зөвхөн багахан хувь нь ШЧГ-ын сүлжээнд хамрагддаг. Монгол дахь ийм зүйлийн жишээнд идээшил нутаг элбэгтэй тал хээр, тайгын шувууд орно. Ийм нөхцөлд ШЧГ-аар зөвхөн төлөөллийн газрыг сонгох ба тухайн зүйлийн популяцийг хадгалж хамгаалах зорилго агуулж байгаа бол томоохон газар нутгийг хамарсан бусад ландшафтын арга хэмжээ авах шаардлагатай. Эдгээр арга хэмжээ нь тодорхой нэгэн газрыг онилсон арга хэмжээ бус харин газар ашиглалттай холбоотой улсын буюу орон нутгийн бодлого, төлөвлөгөө хэлбэрээр хэрэгжих боломжтой.

Хоёрдугаарт, зарим зүйлд нүүрлэж буй аюул хөнөөл нь ШЧГ-ын хүрээг тэлэх боломжтой. Жишээ нь, арилжааны зорилгоор ан агнуур хийх, хорогдол зэргийн улмаас зүйлийн популяцийн тоо толгой буурах магадлалтай. Иймээс уг асуудлыг цаашид тодруулах шаардлагатай ба энэ хэрэгцээ шаардлагын улмаас шувуудаас өөр амьтан, ургамлын аймагт хамаатай бусад газрууд байж болох юм. Улмаар холбогдох газар нутгийг сонгох нэмэлт шалгуур үзүүлэлтийг боловсруулах, судалгаа хийх, зөвлөлдөх зэргээр эрчимтэй ажиллах шаардлагатай байна.

Иймэрхүү тухайн газрыг тусгайлан зорьсон арга хэмжээ авахын зэрэгцээ үндэсний эсвэл бүс нутгийн оролцоог хангах хэрэгтэй болно.

Гуравдугаарт, шувууд бол биологийн олон янз байдлыг үнэлэхэд төдийлөн сайн индикатор /таниур/ болдоггүй. Шувууд хэдийгээр бүхий л амьдрах орчин болон газар зүйн байршлаар түгээмэл байдаг ч тэдгээрийн тархац болон амьдрах орчин нь бусад бүлгийн амьтдыг толь мэт тусгах боломжгүй. Жишээ нь, ургамал болон цэнгэг усны загас заавал шувуудтай ижил төстэй олон янз байдлын загвар, эндемизм зэргийг илэрхийлэхгүй. Мөн шувууд нь агуйн амьтны аймагт чухал газруудын сайн индикатор болж чадахгүй нь илт ойлгомжтой.

Монгол дахь шувуудад чухал газрууд

Өнөөгийн байдлаар ШЧГ Монголд 70 байгааг тодорхойлжээ. Тэдгээрийн дотор нэгээс бусад бүх газар А1 (устах аюулд өртсөн зүйл), 4 газар А2 (хязгаарлагдмал хэмжээний зүйл), 39 нь А3 (биом хязгаарлагдмал бүлгэмдэл), 43 нь А4 (глобал ач холбогдол бүхий конгрегаци) гэсэн газрын ангилалд багтаж байна. ШЧГ-ууд Монголын 21 аймгийн 18-д нь бүртгэгджээ. Харин хамгийн их тооны ШЧГ-тай аймгуудад Дорнод (10), Завхан (8) ба Ховд, Хөвсгөл (тус бүр 7) багтаж байна. Монгол орны ШЧГ-ын бүрэн жагсаалтыг Хавсралт 5, Газрын зураг 5-т харуулав.

Монгол орны Шувуудад чухал газрууд нийт газар нутгийн 5 хувьтай тэнцэх 8.358.313га газрыг эзлэдэг. Шувуудад чухал газрын сүлжээний 70 хувь нь улсын ТХГН-ийн хүрээнд хамгаалагддаг. Сүлжээний 6 хувь нь (519341 га) Орон нутгийн ТХГН-аар хамгаалагддаг бөгөөд үүний 389633 га нь Улсын ТХГН-аар хамгаалагддаг. Шувуудад чухал газрын сүлжээний арван долоон хувь

(1390317 га) олон улсын төвшинд Рамсарт орсон газар, Дэлхийн өвийн санд орсон газар болон Шим мандлын нөөцийн цөм газар гэж тодорхойлогдсон ба үүний 280481 га нь улсын буюу орон нутгийн ТХГН-аар хамгаалагддаг. Иймээс шувуудад чухал газрын сүлжээний 1829386 га газар (нийт газрын 22 хувь) орон нутаг, улс болон олон улсын төвшинд ямар нэгэн хамгаалалтад хамрагдаагүй байна. Ийм байдал нь Монголын хувьд байгалийн чухал нутгуудын тоог нэмэгдүүлж байгаа юм. (Хүснэгт 4).

Хүснэгт 4. Шувуудад чухал газрын орон нутаг, улс, олон улсын хамгаалалттай газруудад хамрагдсан байдал

Шувуудад чухал газрын статистик	Нийт талбай (га)	Хамгаалалтад хамрагдаагүй талбай (га)
Улсын ТХГН-т хамрагдсан талбай	5858813	5858813
Орон нутгийн ТХГН-т хамрагдсан талбай	519341	389633
Олон улсын хэмжээнд хамгаалагдсан газарт хамрагдах талбай	1390317	280481
Хамгаалалтгүй талбай	1829386	1829386
Шувуудад чухал газрын сүлжээний нийт талбай	-	8358313

4.7 Байгалийн чухал нутгуудын нэгдсэн байдал

Дэлхийн банкны YAX 4.04-т тусгагдсаны дагуу Монголын байгалийн чухал нутгуудын шалгуурт нийцэх газрын 4 ангилал байдаг. Үүнд:

1. Дараахь газраас бүрдэх албан ёсны тусгай хамгаалалттай газар:
   - А. Улсын тусгай хамгаалалттай газар нутаг (Улсын ТХГН)
   - Б. Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг (Орон нутгийн ТХГН)
   - В. Олон улсын хэмжээнд хамгаалагдсан газар (Рамсарт бүртгэлтэй газар, Дэлхийн өвийн санд бүртгэлтэй газар, болон шим мандлын нөөцийн цөм нутгууд)
2. Орон нутгийн ард иргэдээс өргөмжилсөн тахилага шүтлэгтэй газар (тахилага шүтлэг бүхий бүх газар)
3. Туслах чанарын газар (тусгай хамгаалалттай газруудад ач холбогдол бүхий газрууд)
4. Нэмэлт газрууд (Шувуудад чухал газрууд)

Эдгээр газрууд нэг нэгэнтэйгээ давхардсан байдлаар **Монголын нийт газар нутгийн дөрөвний нэгтэй тэнцэх буюу 40.3 сая га нь газар байгалийн чухал нутгийн нэгдсэн багцад ногдож байна (**Хүснэгт 5 ба Газрын зураг 6**).**

Хүснэгт 5-д тусгагдсан тоо баримтаас үзвэл уг тайланд тодорхойлсон байгалийн чухал нутгуудын 56 хувь нь Улсын ТХГН-т багтаж байна. Монгол Улсын хууль тогтоомжоор Улсын ТХГН-ийн статус нь уул уурхай, дэд бүтэц болон аялал жуулчлалын хөгжлийн сөрөг нөлөөллийн улмаас хамгийн өндөр төвшний хамгаалалтанд байх ёстой (Хэсэг 6.1-ийг үз). Энэ баримт бичигт тусгагдсан байгалийн чухал нутгуудын 39 хувь нь орон нутгийн ТХГН-т багтдаг ч үндсэндээ улсын төвшний хамгаалалтанд байдаг юм. Хэдийгээр Монгол Улсын хуулиар орон нутгийн ТХГН-ийг сөрөг үр дагавраас хамгаалах тодорхой төвшний хамгаалалтыг бүрдүүлсэн ч байгаль орчныг хамгаалах тэдгээр дүрэм журмыг хэрхэн биелүүлэх талаар тодорхой тогтсон тууштай практик байхгүй байна. (Хэсэг 6.1-ийг үз). Ялангуяа, орон нутгийн ТХГН-ийн хувьд стандарт менежментийн зохицуулалт одоогоор байхгүй юм.

Хүснэгт 5: Монгол орны байгалийн чухал нутгуудын нэгдсэн байдал

Байгалийн чухал нутгууд	Газрын тоо	Талбайн хэмжээ (га)	Байгалийн чухал нутгуудад нэмж орох газрууд (га)
1. Албан ёсны тусгай хамгаалалттай газрууд			
а. Улсын тусгай хамгаалалттай газрууд	72	22,413,136	22,413,136
b.Орон нутгийн тусгай хамгаалалттай газрууд	937	16,531,505	15,602,303
в. Олон улсын хэмжээнд хамгаалагдсан газрууд	-	-	-
(i). Рамсарт бүртгэлтэй газрууд	11	1,695,598	455,069
(ii). Дэлхийн өвийн санд бүртгэгдсэн газар	2	932,201	27,721
(iii). Дэлхийн шим мандлын нөөц газар	6	2,064,505	0
2. Орон нутгийн ард иргэдийн өргөмжилж хамгаалдаг газар			
Тахилага шүтлэгтэй газар	47	мэдэгдэхгүй	[23 sites]
3. Туслах чанарын газрууд			
[судалгаагаар нэг ч тогтоогдоогүй]	Үгүй	Үгүй	Үгүй
4. Нэмэлт газар			
Шувуудад чухал газар	70	8,358,313	1,829,386
Нийт			40,327,615

Монголын байгалийн чухал нутгуудын нэгдсэн багцын зөвхөн 5 хувь нь улсын буюу орон нутгийн ТХГН-т хамрагдаагүйг энэхүү судалгаагаар тогтоов. Уг талбайн зөвхөн багахан хэсэг нь байгаль орчныг хамгаалах олон талт гэрээ хэлэлцээрээр хамгаалагддаг ба үлдсэн хэсэг нь ямар нэгэн хамгаалалтад огт хамрагдаагүй байна (Рамсар болон Дэлхийн өвийн санд орсон газар г.м.). Улсын болон орон нутгийн ТХГН-аас гадуур орших байгалийн чухал нутгууд нь ус намгархаг газар мэт харьцангүй жижиг бөгөөд тэдгээрийн нийлбэр талбай цөл, заримдаг цөл болон тайгын ойн амьдрах орчныг хамардаг тусгай хамгаалалттай газрын сүлжээний нийт талбайтай харьцуулбал бага байдагтай холбоотой. Нөгөөтэйгүүр, бүс нутгийн бусад улс оронтой харьцуулбал Улсын болон Орон нутгийн ТХГН-ийн нийлбэр талбайн хамрах хэмжээ харьцангүй өндөр юм.

Монгол орны байгалийн чухал нутгуудын 95 хувь нь хамгаалалттай, 5 хувийг хамгаалалтгүй гэж ойлгож болохгүй. **Нэгдүгээрт,** Албан ёсны тусгай хамгаалалттай газраар тогтоох явдал Орон нутгийн ТХГН-ийн хувьд яг газар дээрээ хамгаалалттай байна гэсэн үг биш бөгөөд эдгээр газрын ихэнхид нь хамгаалалттай газрын менежментийн тогтолцоо нэвтрээгүй байгаа, бодит байдал дээр “цаасан дээрх хамгаалалт” төдий л байна. **Хоёрдугаарт,** энэхүү судалгаагаар тогтоогдоогүй, нэн ялангуяа шувуудаас бусад ангилал зүйн бүлгийн ховор, эмзэг, нүүдлийн болон устах аюулд өртөж буй зүйлийн хувьд нэмэлт газар зэрэг байгалийн чухал бусад нутгууд байгаа нь эргэлзээгүй. Жишээ нь, ургамал, эмгэн хумс болон ангилал зүйн бусад бүлгүүдийн хувьд эндемизм ихтэй байгалийн чухал нутгуудыг олж тогтоогоогүй болно.

Түүнчлэн тахилага шүтлэгтэй 23 газар нь байгалийн чухал ямар нэгэн газар нутагтай давхардахгүй байна. Эдгээр газрын хил хязгаарыг одоогоор тогтоогоогүй тул Монгол орны байгалийн чухал нутгуудын нэгдсэн багцад эдгээрийн нөлөөлж буй хувь хэмжээг тооцох боломжгүй юм.

5. Монгол Улсын хөгжлийн төлөвлөлтийн өнөөгийн байдал

5.2. Мэдээллийн эх сурвалж

Уул уурхайн салбар

Монголын хайгуул, олборлолтын тусгай зөвшөөрөл бүхий 2008 оны 5 сарын 19-ний байдлаарх газарзүйн мэдээллийн системийн тоо баримтыг Монголын ашигт малтмал, газрын тосны хэрэг эрхлэх газрын Геологи, уул уурхайн кадастрын албанаас авав. Энэхүү баримт бичигт хавсаргасан мэдээлэлд хоёр төрлийн тусгай зөвшөөрлийн олгогдсон огноо болон эзэмшигчийн нэр тусгагдсан байгаа. Гэхдээ олборлож буй ашигт малтмалын тухай мэдээллийг зөвхөн олборлолтын тусгай зөвшөөрлийн тохиолдолд олж ашиглав.

Дэд бүтцийн салбар

Одоогоор ашиглагдаж буй болон ашиглахаар төлөвлөгдөж буй авто зам, төмөр зам болон нисэх онгоцны буудлын тухай мэдээллийг Монголын үндэсний тээврийн стратегийн баримт бичгээс авч цахим хэлбэрт оруулж (MoRTT 2007), Үндэсний газрын менежментийн мастер төлөвлөгөөнд тусгагдсан газрын зураг, хүснэгтэй (ALAGC 2003) харьцуулан ашиглав. Одоогоор хэрэглэгдэж буй болон ашиглалтанд орохоор төлөвлөгдөж буй эрчим хүчний дэд бүтцийн тухай мэдээллийг Үндэсний газрын менежментийн 2004-2023 оны мастер төлөвлөгөөнд тусгагдсан газрын зураг, хүснэгтээс татаж цахим хэлбэрт оруулан ашиглав.

Аялал жуулчлалын салбар

Монгол Улсын Их сургуулийн Нийгмийн газар зүйн тэнхим, Монголын аялал жуулчлалын холбоо болон ДБХС-аас уг судалгааны хүрээнд байгаль орчинд жуулчны баазын нөлөөлж буй нөлөөллийг үнэлж дүгнэх санал асуулга явуулсан юм. Уг санал асуулгыг Монголын Зам, тээвэр, аялал жуулчлалын яам дэмжсэн болно (ЗТАЖЯ).

Мэдээллийг Улаанбаатар хотод 2008 оны 3 сарын 29-нд зохиогдсон аялал жуулчлалын томоохон арга хэмжээ болох Олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн яармагт оролцсон оролцогчдоос цуглуулсан болно. Уг үзэсгэлэн яармагийг Монголын аялал жуулчлалын холбоо болон ЗТАЖЯ-аас зохион байгуулав. Санал асуулгыг нүүр тулсан асуулга хэлбэрээр явуулав. Санал асуулгын баг хоёр тэргүүлэгч, нэг туслахаас бүрдсэн байв. Профессор Баатарцоожийн удирдлаган дор Монгол Улсын Их сургуулийн бакалавр, магистрын шатны суралцагчдаас сайн дурын туслагчаар 12 оюутан уг судалгаанд оролцов. Санал асуулга гурван хэсгээс бүрдсэн нь (i) аялал жуулчлалын баазын түүх,(ii) аялагчдын тухай мэдээлэл болон (iii) байгаль орчинтой холбоотой мэдээлэл байв.

Олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн яармагт оролцсон 76 жуулчны баазын 71 нь (93 хувь) уг санал асуулгад хариулав. Тус үзэсгэлэн яармагт өөрийн сурталчилгааны материалаа дэлгэн оролцоогүй бусад 14 жуулчны баазаас мөн мэдээлэл авсан ба нийтдээ санал асуулгад оролцсон баазын тоо 85 байв. Энэ нь 2006 онд ЗТАЖЯ-нд бүртгэлтэй 200 жуулчны баазын тэн хагасаас бага (42 хувь) тоо юм. Жуулчны баазын байршил зэрэг нэмэлт мэдээллийг хэвлэмэл

материал, веб хуудас болон ДБХС-ийн бусад эх сурвалжаас авав.

5.2. Уул уурхайн салбарын хөгжил

Монголын эдийн засаг дахь уул уурхайн ач холбогдол

Дэлхийн ач холбогдол бүхий ашигт малтмал, Хятад, Оросын хооронд орших стратегийн байршил зэрэг нь Монголын уул уурхайн салбарын огцом өсөлтийг нөхцөлдүүлж байгаа ба үүгээрээ уг салбарыг дэлхийн хамгийн том болон хурдацтай хөгжиж буй эдийн засгуудын эрдэс баялгийн нийлүүлэгч болгож байна. Уул уурхай нь Монголын эдийн засгийн ДНБ-ий гуравны нэг, аж үйлдвэрийн бүтээгдэхүүн, экспортын орлогын тэн хагасыг бүрдүүлж байна (Дэлхийн банк ба PPIAF 2007, IMMI 2007). Экспортын гол нэрийн ашигт малтмалд зэс, молибден, алт, нүүрс (дулааны болон коксжих хоёул орно) болон жонш зэрэг орно (Дэлхийн банк, 2006).

Уул уурхайн албан салбарт өнөөгийн байдлаар нийт 12 мянган хүн ажиллаж байхад албан бус (гар аргаар олборлогчид) салбарт энэ тоог хэд дахин давах тооны хүн ажиллаж байна (Дэлхийн банк, 2006). Хэдийгээр Монголчуудын хувьд энэ төрлийн үйл ажиллагаа урьд өмнө байгаагүй ч эдийн засгийн хүндрэлийн үед гар аргаар олборлох үйл ажиллагаа нь нийгмийн баталгааг хангах чухал арга хэлбэр болсон ба өнөөгийн байдлаар олон мянган хүний амжиргааны гол эх үүсвэр болж байна. (30-100 мянган хүн оролцдог гэсэн тооцоо байна, Дэлхийн банк, 2006).

Уул уурхайн салбарын хөгжил

1992 онд зах зээлийн эдийн засагт шилжин орохоос өмнө Монгол орны уул уурхайн салбар Монгол, ЗХУ, Болгар, Чехословак, Зүүн Герман болон Унгартай хамтарсан улсын мэдлийн аж ахуйн нэгж давамгайлсан салбар байлаа (Дэлхийн банк). ЗХУ задарч, Монгол орны малын гаралтай түүхий эдийг хүлээн авагч Зөвлөлтийн блокийн зах зээл нуран унасны дараа уул уурхайн салбар Монгол орны огцом өсөлт бүхий хамгийн чухал салбаруудын нэг болж, 1993-2003 онуудад жилийн 8-13 хувийн өсөлттэй салбар болов (Жаргалсайхан, 2004, Фарингтон, 2005). Хайгуул, олборлолтын үйл ажиллагаа явуулдаг хувийн аж ахуйн нэгжийн (гол төлөв Монгол, заримдаа Канад, Их Британи, Австрали, Орос болон Хятадын компанитай хамтарсан) тоо өсчээ (Дэлхийн банк).

1997 онд Ашигт малтмалын тухай хуулийг баталсан, алтны 10 хувийн татварыг цуцалсан болон 2001 онд өргөн дэлгэр сурталчилсан Оюу Толгойн орд газрыг нээн илрүүлсэн зэрэг нь 1990–ээд оны сүүлч 2000 оны эхээр уул уурхайн хайгуулын ажлын эрчимтэй өсөлтийг нөхцөлдүүлсэн байна (Дэлхийн банк). Энэ хугацаанд нэг жилд олгогдсон олборлолтын тусгай зөвшөөрлийн тоо эрс өсч, 1998 онд 4 байснаас 2004 онд 580-д хүрчээ (Хүснэгт 4). Уул уурхайн салбарын гадаадын хөрөнгө оруулалт мөн огцом өсч 2002 онд байсан 43 тэр бум төгрөгөөс (37 сая ам. доллар) 2006 гэхэд 227 тэр бум төгрөгт (195 сая ам. доллар) хүрчээ (IMMI 2007 он). Энэ хугацаанд хувийн хөрөнгө оруулагчид гол төлөв зөвхөн зургаан нэр төрлийн өндөр үнэлгээ бүхий ашигт малтмалд төвлөрч байсан ба үүнд: алт, зэс, цинк, уран, жонш болон нүүрс орж байна (Дэлхийн банк, 2006).

Засгийн газраас 2006 онд уул уурхайн салбарын огцом өсөлтөд хариу болгож хувийн хэвшлийн зэрэгцээ засгийн газрыг түншлэлийн зарчмаар хамтран оролцох боломж бүрдүүлсэн Ашигт малтмалын шинэ хууль батласан юм. Энэ шинэ хууль нь иргэний нийгмийн бодит дэмжлэг болон зэс, алтны гэнэтийн ашгийн татварын хамтаар Монголд хөрөнгө оруулах хөрөнгө оруулагчдын урамыг хугалжээ (Азийн сан, 2007). Зураг 4-т харуулсанаас үзэхэд 2004 оноос хойш олборлолтын тусгай зөвшөөрөл олгох үйл явц хумигдсан байна.

Монгол орны хайгуул, олборлолтын өнөөгийн байдал

Монголд уул уурхайн хоёр төрлийн тусгай зөвшөөрөл байдаг ба “хайгуулын тусгай зөвшөөрөл ” нь судалгаа, хайгуул хийх эрх олгодог бол харин “олборлолтын тусгай зөвшөөрөл” (эсвэл үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл) нь ашиглалтын үйл ажиллагаа явуулах эрх олгодог юм.

Зураг 4. Жилд олгогдсон олборлолтын тусгай зөвшөөрлийн тоо болон талбай



Мэдээллийн эх сурвалж: АМГТХЭГ-ын Геологи, Кадастрын алба

2008 оны 5 сарын 19-ий байдлаар Монголын нийт газар нутгийн дөрөвний нэгтэй тэнцэх буюу нийтдээ 40027296 га газар хамарсан 3572 хайгуулын тусгай зөвшөөрөл олгогджээ. Эдгээр тусгай зөвшөөрлийн 80 гаруй хувийг 2007 оны 5 сарын 19-ий өдрөөс хойш 12 сарын хугацаанд олгосон байна. Зураг 5-д харуулсанаас үзэхэд Монголын Улсын ТХГ-ын өргөтгөлийн ихэнхийг 2000 он хүртэлх хугацаанд хийсэн байхад хайгуулын тусгай зөвшөөрөл олголтын ид оргил үе 2001 оноос эхэлжээ. Иймээс Улсын ТХГН-ийн тогтоосон цаг хугацаа хайгуулын тусгай зөвшөөрлийн олголтоос өмнөх юм.

Хэмжээний хувьд хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий талбай 2 га-гаас 380.000 гаруй га газар байна. Хайгуулын талбайн голч нь 11.206 га ба дундаж нь зөвхөн 2.674 га ба энэ нь цөөн тооны томоохон талбай газар голчид нөлөөлж буйг харуулж байна. 2006 оны Ашигт малтмалын тухай хуулийн 17-р зүйлд хайгуулын талбайг 25-аас 400.000 га газар байхаар заажээ. **Хэдийгээр хуулинд заасан талбайн хамгийн дээд хэмжээг нэг ч хайгуулын талбай хэтрүүлээгүй ч ойролцоогоор нэг хувь нь 25 га газрын хамгийн бага талбайн хэмжээнээс ч бага байна.**

Хайгуулын тусгай зөвшөөрөл улс даяар жигд тархаагүй ба хэд хэдэн аймгуудад төвлөрсөн байна (Хүснэгт 6, Газрын зураг 7). Тусгай хамгаалалттай газраас гадуур Өмнөговь болон Дорноговь аймгуудын зарим хэсэг бүхэлдээ хайгуулын тусгай зөвшөөрөлд хамрагдсан байна. Энэ нь Таван Толгойн нүүрсний орд, Оюу Толгойн алт, зэсийн орд зэрэг ашигт малтмалын тогтоогдсон томоохон нөөцтэй нь тохиолдлын зүйл биш. Хайгуулын тусгай зөвшөөрлийн ихээхэн нягтрал баруун талд Говь-Алтай, Хойт зүгт Булган, Орхон, зүүн зүгт Дорнод болон төв хэсэгт Дундговь болон Говь Сүмбэр аймгуудад байна.

Харин олборлолтын тусгай зөвшөөрлийн хувьд 2008 оны 5 сарын 19-ний өдрийн байдлаар 1066 тусгай зөвшөөрөл олгогдсон ба Монголын нийт газар нутгийн дөрөвний нэгтэй тэнцэх буюу 398306 га газар эзлэж байна. Талбайн хувьд хайгуулын тусгай зөвшөөрөлтэй харьцуулбал олборлолтын тусгай зөвшөөрөл зөвхөн ойролцоогоор нэг хувьтай л тэнцүү байна. **Харин нөлөөллийн хувьд олборлолтын тусгай зөвшөөрөл эзлэж буй талбайнхаа биологийн төрөл зүйлд нөлөөлөх сөрөг нөлөөлөл нь энэ тэнцүү биш юм. Энэ нь олборлолтын үйл ажиллагаа шууд бус байдлаар нөлөөлж (зам харгуй, төмөр замын хөгжил, өндөр хүчдэлийн шугам барих тавих) улмаар тэдгээрийн шууд ул мөрөөс хол давах хор хөнөөлтэй холбоотой.**

Зураг 5. Монгол орны хайгуулын тусгай зөвшөөрөл болон Улсын ТХГН-ийн талбайн өсөлт



Эх сурвалж: АМГТХЭГ-ын Геологи, Кадастрын алба ба ДБХС-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар

Хүснэгт 6. Хайгуулын тусгай зөвшөөрөл олгосон байдал (аймгаар)

Аймгийн нэр	Нийт талбай (га)	Хайгуулын талбай (га)	Нийт талбайд хайгуулын талбайн эзлэх хувийн жин
Архангай	5,509,445	578,829	10.5
Баянхонгор	11,496,246	1,526,766	13.3
Баян-Өлгий	4,713,266	674,412	14.3
Булган	4,749,907	1,278,579	26.9
Дархан-Уул	318,342	46,811	14.7
Дорнод	12,389,523	3,756,170	30.3
Дорноговь	10,914,054	6,565,096	60.2
Дундговь	7,424,510	2,165,917	29.2
Говь-Алтай	14,203,734	4,501,843	31.7
Говь-Сүмбэр	545,291	227,506	41.7
Хэнтий	8,061,439	1,210,159	15.0
Ховд	7,729,575	1,290,851	16.7
Хөвсгөл	10,073,127	536,122	5.3
Өмнөговь	16,309,375	9,328,091	57.2
Орхон	81,022	44,096	54.4
Өвөрхангай	6,246,365	510,840	8.2
Сэлэнгэ	4,112,396	649,691	15.8
Сүхбаатар	8,224,176	2,132,036	25.9
Төв	7,867,003	1,234,388	15.7

Улаанбаатар	135,778	3,353	2.5
Увс	7,041,905	945,592	13.4
Завхан	8,265,690	820,147	9.9
Нийт	**156,412,168**	**40,027,296**	**25.6**

Олборлолтын тусгай зөвшөөрөл бүхий талбай хэмжээний хувьд 1 га-гаас 37000 га хүртэл хэлбэлзэж байна. Талбайн голч нь 374 га ба дундаж нь 71 га бөгөөд хайгуулын тусгай зөвшөөрөлтэй харьцуулбал хамаагүй бага байна. 2006 оны Ашигт малтмалын тухай хуулийн 24-д давс болон түгээмэл ашигт малтмалын хувьд олборлолтын талбай 1 га-гаас багагүй, бусад металлын хувьд 25 га-гаас багагүй гэж заагаад дээд хязгаарыг тусгаагүй байна. Зөвхөн гурван олборлолтын талбай нэгээс бага га газар эзлэж байна.

Олборлолтын тусгай зөвшөөрлийн газар зүйн төвлөрөл нь хайгуулын тусгай зөвшөөрлийнхтэй адил ба энэ нь төдийлөн гайхах зүйл биш юм (Газрын зураг 8). Хамгийн их олборлолтын тусгай зөвшөөрөл бүхий аймагт Өмнөговь, Дорноговь орох ба Монгол орны нийт олборлолтын талбайн тэн хагастай тэнцэж байна. Дархан-Уул, Орхон аймгууд болон Улаанбаатар хот олборлолтын тусгай зөвшөөрлийн нягтралаараа Өмнөговь болон Дорноговиос их байгаа нь олборлолтын талбайн томыг бус харин тэдгээр аймгийн хэмжээний багыг харуулж буй хэрэг юм. Тус улсын үлдсэн хэсгийн хувьд олборлолтын тусгай зөвшөөрөл аймгийн талбайн нэгээс бага хувийг, заримдаа бүр ч багыг эзэлж байна. (Хүснэгт 7).

Товлож буй ашигт малтмалын хувьд Хүснэгт 8-д алт, барилгын материал, нүүрс болон жонш зэрэг нь тооны хувьд маш их эрэлт хэрэгцээтэй болох нь харагдаж байна. Эдгээр дөрвөн төрлийн ашигт малтмал хамтдаа 2008 оны 5 сарын байдлаар олгосон нийт олборлолтын тусгай зөвшөөрлийн 84 хувьтай тэнцэж байна. Эдгээр ашигт малтмалын барилгын материал болон жоншны тус тусын олборлолтын талбай нь бага байх хандлагатай (дунджаар тус бүр 55 болон 79 га). Иймээс уурхайн нийт тооны томоохон хэсгийг тэд бүрдүүлдэг ч хөрсөнд нөлөөлөх тэдний нөлөөлөл харьцангуй бага юм (тохиолдол бүрт 10000 га-аас ялигүй их).

Хүснэгт 7. Олборлолтын тусгай зөвшөөрөл олгосон байдал (аймгаар)

Аймгийн нэр	Нийт талбай (га)	Олборлолтын талбай (га)	Нийт талбайд олборлолтын талбайн эзлэх хувийн жин
Архангай	5,509,445	9,521	0.17
Баянхонгор	11,496,246	12,229	0.11
Баян-Өлгий	4,713,266	4,267	0.09
Булган	4,749,907	10,086	0.21
Дархан-Уул	318,342	7,048	2.21
Дорнод	12,389,523	10,655	0.09
Дорноговь	10,914,054	43,149	0.40
Дундговь	7,424,510	5,535	0.07
Говь-Алтай	14,203,734	963	0.01
Говь-Сүмбэр	545,291	4,650	0.85
Хэнтий	8,061,439	12,687	0.16
Ховд	7,729,575	5,056	0.07
Хөвсгөл	10,073,127	1,413	0.01
Өмнөговь	16,309,375	168,889	1.04

Орхон	81,022	2,672	3.30
Өвөрхангай	6,246,365	12,295	0.20
Сэлэнгэ	4,112,396	28,625	0.70
Сүхбаатар	8,224,176	2,274	0.03
Төв	7,867,003	40,848	0.52
Улаанбаатар	135,778	3,731	2.75
Увс	7,041,905	4,936	0.07
Завхан	8,265,690	6,778	0.08
Нийт	**156,412,168**	**398,306**	**0.25**

Хамгийн том талбайг эзлэх хандлага бүхий олборлолтын тусгай зөвшөөрөлд зэс (голч нь 3812 га) болон нүүрс (голч нь 1280 га) орж байна. Иймээс энэ хоёр ашигт малтмал олборлолтын тусгай зөвшөөрлийн нийт талбайн үлэмж хувийг эзлэдэг (Зураг 6). Нийлбэр нөлөөллөөр хамгийн томоороо дараачийн ашигт малтмал бол алт. Ийм ч учраас алтны олборлолтын тусгай зөвшөөрөл нэгж уурхайн талбайн хэмжээтэй харьцуулбал олон байна (Хүснэгт 8). Хамтдаа алт, зэс болон нүүрс нь одоогоор Монголын тусгай зөвшөөрөл бүхий нийт газар нутгийн 87 хувьтай тэнцэж байна. Эдгээр ашигт малтмалын биологийн төрөл зүйлд нөлөөлөх нөлөөллийг тус бүрээр нь Хэсэг 7.4-т тайлбарласан болно.

Энэ хэсэгт тусгагдсан тоо баримт нь 2008 онд Гар аргаар болон Бичил уул уурхайн үйл ажиллагааг зохицуулах түр журам гарахаас өмнө үндсэндээ ямар ч зохицуулалтгүй байсан гар аргын олборлолтыг харуулаагүй юм (Хэсэг 6.2-ыг үз). Гар аргын олборлолтын тоо баримт олдоцтой байсан аваас алттай холбоотой уул уурхайн нөлөөллийн хувь хэмжээг одоогийнхтой харьцуулбал үлэмж их байх магадлалтай.

Хүснэгт 8. Олборлолтын тусгай зөвшөөрөл олгосон байдал (ашигт малтмалын төрлөөр)

Ашигт малтмал	Тусгай зөвшөөр-лийн дугаар	Нийт талбайд эзлэх хувийн жин	Олбор-лолтын талбай (га)	Нийт талбайд эзлэх хувийн жин	Олбор-лолтын талбайн голч (га)
Алт	469	44.00	113,956	28.61	243
Барилгын материал	186	17.45	10,184	2.56	55
Нүүрс	161	15.10	206,106	51.75	1,280
Жонш	130	12.20	10,237	2.57	79
Төмрийн хүдэр	24	2.25	8,205	2.06	342
Давс	14	1.31	674	0.17	48
Вольфрам	10	0.94	6,647	1.67	665
Холимог метал	9	0.84	3,995	1.00	444
Зэс	7	0.66	26,684	6.70	3,812
Цагаан тугалаг	7	0.66	5,153	1.29	736
Фосфат	6	0.56	826	0.21	138
Цинк	4	0.38	1,200	0.30	300
Алабастер	4	0.38	212	0.05	53

Ховор хөрс	3	0.28	675	0.17	225
Молибден	2	0.19	202	0.05	101
Болор	2	0.19	136	0.03	68
Мөнгө	2	0.19	41	0.01	20
Уран	1	0.09	264	0.07	264
Бусад	18	1.69	1,604	0.40	89
Үл мэдэгдэх	7	0.66	1,304	0.33	186
Нийт	**1,066**	**100**	**398,306**	**100**	374

Зураг 6 : Олборлолтын талбайн тархалт, ашигт малтмалын төрлөөр (га)



Уул уурхайн салбарын ирээдүйн чиг хандлага

Томоохон төслүүд батлагдаж, зүй зохистой байдлаар амжилттай хэрэгжсэн нөхцөлд уул уурхайн салбарын үйлдвэрлэл 2003 оны төвшнөөс 2010 он гэхэд хоёр дахин, эсвэл бүр гурав дахин нэмэгдэх төлөвтэй байна (Дэлхийн банк ба PPIAF 2007). Ойрын 10-аад жилд Монголын хувьд ашигт малтмалын экспорт орлогын гол эх үүсвэр хэвээр байх төлөвтэй (Фарингтон, 2005). Монголын хойт хэсэгт орших Бороогийн алтны уурхай, Өмнөговьд орших Оюу толгойн зэс алтны уурхай, мөн аймагт орших Таван толгойн нүүрсний уурхай зэрэг шинэ уурхайг ашиглалтанд оруулах төлөвтэй. Оюу толгойн уурхай дангаараа Монголын экспортын хэмжээг 2 дахин нэмэгдүүлэх бөгөөд Таван толгойг оролцуулбал 3 дахин нэмэгдүүлнэ. Үүгээр худалдааны үлэмж их нэмэлт орлого буй болох бөгөөд нөгөөтэйгүүр улсын эдийн засагт багагүй нөлөө үзүүлэх төлөвтэй (Ханкок, 2008). Нийгэм, эдийн засагт нөлөөлөх нөлөөллийн зэрэгцээ уул уурхайн салбарын үргэлжлэх өсөлт байгалийн чухал нутгуудын амьтан, ургамлын аймагт хэд хэдэн нөлөө үзүүлнэ. Үүнийг 7-р хэсэгт нарийвчлан тайлбарлав.

5.3. Дэд бүтцийн салбарын хөгжил

Монголын дэд бүтцийн хөгжлийн нийгмийн болон эдийн засгийн агуулга

Өмнөх хэсэгт дурьдсанчлан одоогийн байдлаар Монгол оронд урьд өмнө үзэгдээгүй эдийн засгийн өсөлт гарч буй нь гол төлөв олборлолтын үйлдвэрлэлийн (уул уурхай болон газрын тос, хий) өсөлтөөс улбаатай

юм. Монгол Улс дэлхийн ангиллын ашигт малтмалын баялагтай болохын зэрэгцээ Москва Бээжинг холбох хамгийн богино замын дунд байршилтай. 2000-2005 оны хооронд Орос, Хятадын худалдаа 200 хувиар өсчээ (Дэлхийн банк, PPIAF 2007). Монголын хөгжлийн чиг хандлагад нөлөөлөх 3 дахь хүчин зүйл бол огцом хотжилт. Нүүдлийн, хөдөө аж ахуйн эдийн засаг өөрийн байр сууриа суурин, үйлчилгээнд тулгуурласан эдийн засагт тавьж өгч байна. Иймээс уул, уурхай, худалдаа болон цаашид үргэлжлэх хотжилт зэрэгтэй уялдан Монгол орон эрс хөгжих хандлагатай боллоо.

Уул уурхай, дэд бүтцийн холбоо

Ирэх 10 жилд дэд бүтцийн хөгжлийг тодорхойлох эдийн засаг, улс төрийн гол хөдөлгүүр нь уул уурхай байх төлөвтэй. Ашигт малтмал ихэвчлэн дэд бүтэц муухан хөгжсөн алслагдмал газруудад байршжээ. Байгалийн эдгээр баялгийг ашиглах аваас олборлолт, боловсруулалтыг явуулах ус, цахилгаан эрчим хүчний дэд бүтэц, мөн гадаад зах зээлд экспортоор гаргах тээврийн дэд бүтцийг барьж байгуулах шаардлагатай (ялангуяа Хятад руу чиглэсэн). Саяхан Дэлхийн банкнаас хийсэн судалгаанд “Монголд өрнөх уул уурхайн дунд болон том оврын бүхий л үйл ажиллагаа үлэмж их хэмжээний цахилгааны шинэ эх үүсвэр, ус болон тээврийн дэд бүтцийг шаардана” хэмээжээ. (Дэлхийн банк болон PPIAF, 2007).

Тээврийн дэд бүтцийн хувьд Орос, Хятадын хоорондын худалдааны эргэлт өсч, төмөр замын тээврийн ачаалал ихсэх төлөвтэй тул үүнийг одоогийн гол шугаманд өргөтгөл хийх замаар шийдвэрлэх болов уу (Дэлхийн банк болон PPIAF 2007). Иймээс төмөр замын сүлжээг шинэ газар нутаг руу өргөтгөх эдийн засгийн голлох хүчин зүйл мөн л уул уурхайн хөгжил юм.

Цахилгаан, эрчим хүчний дэд бүтцийн хувьд, Монгол орны эрчим хүчний нэг хүнд ногдох харьцангуй өндөр хэрэглээ нь (1300 кВ) мөн л уул уурхайн салбарын цахилгаан эрчим хүчний эрэлт хэрэгцээнээс үүдэлтэй (Дэлхийн банк болон PPIAF 2007). Таван толгойн ойролцоо дулааны цахилгаан станц барьж, түүнийг төвийн эрчим хүчний системтэй холбох өндөр хүчдэлийн шугам татах зэрэг хэд хэдэн цахилгаан эрчим хүчний санал болгож буй төслүүд нь шинээр үүсэн хөгжих уурхайн эрэлт хэрэгцээ, Улаанбаатар хот болон хөрш зэргэлдээ орнуудын хэрэглэгчдэд илүүдэл эрчим хүчээ экспортлох боломжтой болгох юм.

Хотын хөгжлийн хувьд гэвэл, Эрдэнэт зэрэг үйл ажиллагаа явуулж буй уурхайнууд аль хэдийнээ тэлэн хөгжиж буй хотжилтын үйл явцыг амсаж байгаа тул нэмэлт дэд бүтцийг шаардах болов (Дэлхийн банк болон PPIAF 2007). Шинэ уурхайнууд уурхайг түшсэн хот суурин газрын үүсэл хөгжлийг дагуулах төлөвтэй. Жишээ нь, Оюу Толгойн уурхайг тойрч Өмнөговь аймагт 14000 хүнтэй уурхайн хотхон байгуулагдах болно.

Уурхайнууд гол төлөв алслагдмал газар байрладаг тул тэдгээрийн шаарддаг дэд бүтцийн хөгжил ихэвчлэн туйлын өвөрмөц байдаг ба уурхайгүйгээр тэрхүү дэд бүтэц бараг үнэлэмж үгүй (Дэлхийн банк болон PPIAF 2007). Иймээс дараагийн арван жилд Монголд өрнөх дэд бүтцийн хөгжлийн үлэмж хэсгийн эдийн засгийн үндэслэлийг бүрдүүлэх, шаардлагатай хөрөнгө бүрдүүлэхэд уурхайнууд ихээхэн үүрэг гүйцэтгэх төлөвтэй. Уурхайтай холбоотой дэд бүтэц хүний хөл бараг хүрээгүй газар хүртэл тэлж, уурхайтай шууд холбоогүй дэд бүтцийн хөрөнгө оруулалт хот суурин газар төвлөрөх (хэдхэн тохиолдлоос бусад) нөхцөлд биологийн төрөл зүйлд нөлөөлж болзошгүй нөлөөллийн хувьд ч дээрх үйл явц өөрийн ул мөрөө үлдээх нь гарцаагүй.

Иймээс энэхүү судалгааны зорилгын дагуу байгалийн чухал нутгуудад дэд бүтцийн хөгжлийн болзошгүй нөлөөллийг судлахдаа уул уурхайн шууд бус нөлөөллийг голчлон анхаарав (зам харгуй, төмөр зам болон цахилгаан эрчим хүчний дэд бүтэц байгуулах, уурхайн суурин газрууд бүрэлдэх зэрэг). Байгалийн чухал нутгуудад байршиж буй биологийн төрөл зүйлд ноцтой нөлөөлж болзошгүй уурхайтай шууд бус холбоотой дэд бүтцийн томоохон төслүүдийн хувьд нөхцөл байдал тэс өөр ба тэрхүү шууд бус

нөлөөлөлд төмөр зам, туслах замууд, нисэх онгоцны буудал болон усан цахилгаан станц барих зэрэг орно.

Дэд бүтцийн салбарын өнөөгийн байдал

Эдийн засгийн хөгжлийн төвшинтэй нь харьцуулбалМонголүлэмжнүсэрдэдбүтэцтэй орон юм. Тухайн орны орлого ба газарзүйг харгалзвал зам харгуй, цахилгаан эрчим хүч болон хөдөлгөөнт харилцаа холбоо зэрэг дэд бүтцийн дөхөмтэй байдал төсөөлснөөс өндөр байна (Дэлхийн банк болон PPIAF 2007). Гэсэн хэдий ч дэд бүтцийг хөгжүүлэх хэрэгцээ шаардлага одоо ч асар их хэвээр байна. Монгол орны нийт өрхийн гуравны нэг нь өнөөгийн байдлаар зүй зохистой усан хангамжгүй ба хөдөө орон нутгийн хүн амын дөнгөж тэн хагас нь цахилгаан эрчим хүчний эх үүсвэртэй холбогджээ (Дэлхийн банк болон PPIAF, 2007).

Хэдийгээр Монгол орны замын нягтрал дэлхийд хамгийн багад ордог ч (1000 хавтгай дөрвөлжин км-т 0,009 зам) түүнийг тухайн орны орлогын нягтралтай харьцуулбал харьцангуй өндөр байна (Дэлхийн банк болон PPIAF, 2007). 2005 оны эцсийн байдлаар Монголын замын сүлжээний нийт урт 49250 км ба үүний 11219 км нь улсын чанартай зам (ЗТАЖЯ-аас зохицуулагддаг), 38031 км нь орон нутгийн чанартай зам байна (ЗТАЖЯ, 2007). Монголын нийт замын сүлжээний зөвхөн 1900 км нь хатуу хучилттай. Хайрган замын урт 1900 км бөгөөд байгалийн сайжруулсан замын урт 1800 км. Үлдсэн 43600 км нь байгалийн шороон зам болно (Дэлхийн банк, PPIAF, 2007).

Дотоодын ачаа тээврийн ихэнхийг замын авто тээвэр гүйцэтгэдэг. Авто тээвэртэй харьцуулбал ашигт малтмал тээвэрлэхийн хувьд төмөр зам харьцангүй давуу талтай тул олон улсын ачаа тээвэрт төмөр зам давамгайлдаг. Замын тээвэр гол төлөв Улаанбаатараас аймгууд руу урсгалтай бол нүүрс ачсан төмөр замын тээвэр Улаанбаатар хот руу чиглэдэг (Дэлхийн банк, PPIAF, 2007). Монголын төмөр зам нийт 1815 км өргөн зам бүхий сүлжээтэй ба үүний 1110 км нь Орос Хятадыг холбосон гол шугам, 238 км нь Монголын зүүн хэсгийг Оросын төмөр замтай холбосон тусдаа сүлжээ, 477 км нь гол шугамаас салбарласан шугамууд юм (Дэлхийн банк, PPIAF, 2007). Нэг чухал салбар шугам Орхон аймагт Эрдэнэтийн зэсийн үйлдвэрийг ажиллуулдаг цахилгаан станцыг гол гол нүүрсний уурхайтай холбодог (ЗТАЖЯ, 2007).

Агаарын тээврийн хувьд Монгол дотоодын нисэх онгоцны 17 буудалтайгаас зөвхөн хоёр нь олон улсын нисэх буудал юм. Үүний нэг нь олон улсын бүх нислэгийн 98 хувийг гүйцэтгэдэг Улаанбаатар хот дахь Чингис хаан нисэх онгоцны буудал юм (Дэлхийн банк, 2007).

Өнөөгийн байдлаар Монгол орон эрчим хүчний гурван бүсийн тогтолцоотой. Үүний хамгийн том нь Улаанбаатар, Эрдэнэт болон төвийн районы томоохон хот суурингуудыг хамарч улсын нийт эрчим хүчний хэрэглээний 96 хувийг бүрдүүлдэг Төвийн эрчим хүчний систем юм. Зүүн бүсийн эрчим хүчний систем нь Дорнод, Сүхбаатар аймгуудын хот, суурин газар, Баруун бүсийн эрчим хүчний систем нь Баян-Өлгийн, Увс болон Ховд аймгуудын төв, суурин газруудыг хамардаг (Дэлхийн банк болон PPIAF 2007). 2002 онд Монголын нийт эрчим хүчний үйлдвэрлэлийн 90 хувийг нүүрсээр бүрдүүлдэг байсан ба нэгээс илүү хувийг дизель, 0,3 хувийг бага оврын усан цахилгаан станцаар гаргадаг байжээ. Үлдсэн эрэлт хэрэгцээг Оросоос цахилгааны импорт хийж хангадаг байсан (Дэлхийн банк болон PPIAF, 2007). 2003 оны байдлаар Монголд зургаан дунд оврын усан цахилгаан станц байсан ба хамгийн том нь 20 МВ-ын хүчин чадалтай Завхан аймгийн Богд голын усан цахилгаан станц юм (ALAGC, 2003).

Дэд бүтцийн хөгжлийн төлөвлөгөө

Дараагийн 10 жилийн турш жилийн 7-8 хувийн ДНБ-ий өсөлтийг хадгалахад шаардлагатай сайн чанар бүхий дэд бүтцийг хөгжүүлэх хэрэгцээ байна (Дэлхийн банк, PPIAF, 2007). Дэд бүтцийг эдийн засгийн хөгжилд чөдөр болохоос хазаарлах үүднээс гурван гол талбарт хөрөнгө оруулалт хийх саналыг Дэлхийн банкнаас саяхан хийсэн судалгаанд дэвшүүлсэн ба үүнд: (i) одоогийн дэд бүтцийг тэтгэх хөрөнгө оруулалт, (ii) уул

уурхайн сүүлийн үеийн тогтоогдсон нөөцийг ашиглахад шаардлагатай хөрөнгө оруулалт ба (iii) цахилгаан эрчим хүчний хомсдолоос сэргийлж түгээлтийн төхөөрөмжийг сайжруулах үндэсний чадавхийг бэхжүүлэх хөрөнгө оруулалт (Дэлхийн банк, PPIAF, 2007) зэргийг хийх.

Дэд бүтцийн хэрэгцээ шаардлагыг хангах төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлбэл Монголын засгийн газар тогтвортой хөгжлийн зарчимд үнэнч байгаагаа харуулах болно. Дэд бүтцийн хөгжлөөс байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг зохицуулах хууль эрх зүйн үндэс суурийг тавьж, 1995 онд батлагдсан Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 1998 онд батлагдсан Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулиудад засгийн газар эдгээр чиглэлээр авсан үүрэг амлалтаа тусгасан байна. (6.1-р хэсгийг үзнэ үү). Засгийн газраас сүүлийн үед гаргасан бусад баримт бичгүүдэд ч тогтвортой хөгжлийн зарчмыг дурьдсан юм. Жишээ нь, 2007 онд батлагдсан Монголын Үндэсний тээврийн стратегид “засгийн газрын санхүүжилт бүхий хөрөнгө оруулалтын талаар гарах шийдвэр нь бусад альтернатив хувилбаруудын техник, эдийн засаг, санхүү болон байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний дүн шинжилгээн дээр суурилна” гэжээ (ЗТАЖЯ, 2007).

Монгол орны дэд бүтцийн хөгжлийн төлөвлөгөөг бүхэлд нь нэг дор тусгасан баримт бичиг одоогоор байхгүй байна. 2003 онд ГЗБГЗЗГ-аас тээвэр, эрчим хүч, ус, харилцаа холбоо болон аялал жуулчлалын дэд бүтцийн төлөвлөж буй хөгжлийн талаарх мэдээллийг агуулсан 2004-2023 он хүртэлх хугацааны газрын менежментийн үндэсний мастер төлөвлөгөө боловсруулжээ. Гэхдээ энэ төлөвлөгөөнд тусагдсан мэдээллийг ихэнхдээ өөрсдийн төлөвлөгөөг өөрсдөө хянаж, өөрчилсөн салбарын яамдуудаас нь авсан болно.

Дэлхийн банкнаас тээврийн салбарын үндэсний стратегийг 1999 онд боловсруулсан юм (1999). Харин шинэ стратегийн баримт бичгийг Азийн хөгжлийн банкны техник туслалцаатайгаар ЗТАЖЯ боловсруулсан байна (ЗТАЖЯ 2007). Тээврийн салбарын шинэ стратегид салбарын 14 ерөнхий чиглэлийг тодорхойлсон ба “байгаль орчны хувьд тогтвортой, экологийн тогтолцоог хүндэтгэсэн, нийгэм соёлын тогтвортой байдлыг хадгалж дэд бүтцийн чанартай аливаа ажил, тээврийн үйлчилгээний байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг багасгах чиглэлд тээврийн салбарын бүх төслүүдийг хэрэгжүүлэхэд засгийн газар анхаарна” гэж заасан нь байгаль орчны тогтвортой байдлын стратегийг тодорхойлсон явдал юм (ЗТАЖЯ, 2007). Тээврийн төхөөрөмж, үйлчилгээг төлөвлөж ашиглахад “байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон Засгийн газрын байгаль орчны бодлогын бусад шаардлагыг” хангах амлалт ч бас үүнд орно.

Тээврийн шинэ стратегид тусгагдсан зорилго, зорилтуудыг биелүүлэхэд нийтдээ 1275 сая ам. долларын хөрөнгө оруулалт 2006-2015 онуудад шаардлагатай ба үүнээс 926 сая ам. долларыг Монголын засгийн газар, 349 сая ам. долларыг бусад эх үүсвэрээс гаргах төлөвтэй (ЗТАЖЯ, 2007).

Эрчим хүчний салбарын бодлогыг Түлш, эрчим хүчний яам тодорхойлдог (ТЭХЯ). Салбарын өнөөгийн бүтэц, үйл ажиллагааны хууль эрх зүйн үндсийг 2001 онд батлагдсан Эрчим хүчний хуулинд тусгасан ба үүгээр засгийн газрын бодлого боловсруулахад гүйцэтгэх үүрэг ролийг хязгаарлаж, эрчим хүчний салбарын үйл ажиллагаа, өмчлөлийг улсын болон хувийн хэвшилд шилжүүлэхээр болсон юм (Дэлхийн банк болон PPIAF, 2007).

Монголын дэд бүтцийн үйлчилгээний талаар Дэлхийн банкнаас сүүлийн үед хийсэн судалгааны хүрээнд тээвэр, эрчим хүч болон харилцаа холбооны салбарын төлөвлөгдсөн хөгжлийг эргэн хянаж үр ашгийг дээшлүүлэх, төлөвлөлтийг сайжруулан, дэд бүтцийн хөрөнгө оруулалтыг нэн тэргүүний ач холбогдлоор нь жагсаах зэргийг зөвлөмж болгосон юм (Дэлхийн банк, PPIAF, 2007). Албан ёсны баримт бичиг бус ч энэхүү судалгаанд Монголын засгийн газраас санал болгосон дэд бүтцийн хөгжлийн төрөл бүрийн төслүүдийн үндэслэлийн талаар чухал мэдээлэл агуулагдсан байна.

Орон нутгийн төвшинд Монголын засгийн газар Дэлхийн банкны техник туслалцаа, Нидерланд-Монголын байгаль орчны шинэчлэл төслийн дэмжлэгээр өмнөд говийн бүс нутгийн хөгжлийн төлөвлөгөөг боловсруулж байна (Нидерланд-Монголын байгаль орчны шинэчлэлийн сан). Энэ төлөвлөгөө нь Өмнөд говийн бүсийн эдийн засгийн хөгжлийг дэмжих дэд бүтцийн төрөл бүрийн хувилбарын үр дагаврыг томьёолсон байна (Рехерт, 2008). Улс орны уул уурхайн үйл ажиллагааны гол цөм болсон бүс нутгийн дэд бүтцийн байгаль орчин, нийгмийн нөлөөллийг үнэлэх боломж уг төлөвлөлгөөг хэрэгжүүлснээр бүрдэх юм (Хэсэг 6.1, Хүснэгт 6, 7).

2015 он хүртэлх хугацаанд Монголын тээврийн тогтолцоо Улаанбаатар хотын өсөн нэмэгдэж буй тээврийн бөөгнөрөлийг шийдвэрлэн, уул уурхайн бүс нутгаас дэлхийн зах зээлд гарах гарцыг баталгаажуулж, Орос, Хятадын хил хүртэлх худалдааны найдвартай гарцыг буй болгон, Улаанбаатар хот болон бүс нутгийн хоорондын холбоог сайжруулах учиртай (Дэлхийн банк, PPIAF, 2007).

Замын дэд бүтцийн хувьд Үндэсний Тээврийн стратегийн баримт бичигт “Улаанбаатараар дамжсан хойд-өмнөд зүгийг холбосон замын гол коридорыг сайжруулах ” асуудлыг энэ тэргүүний хэмээн томьёолж “баруун-зүүнийг холбосон гол коридорыг (Мянганы зам) сайжруулж, улмаар Улаанбаатар болон эдгээр коридоруудын холбоог сайжруулах” асуудлыг үүний дараа төлөвлөв (ЗТАЖЯ, 2007).

Дэлхийн банкнаас сүүлийн үед хийсэн судалгааны тоо баримтаас үзвэл (Дэлхийн банз болон PPIAF, 2007) зам хөгжүүлэх засгийн газрын төлөвлөгөө нь дараах төслөөс бүрдэж байна. Үүнд:

- Мянганы замыг тавьж дуусгах (600 км),
- Монголын баруун хэсэгт Орос, Хятадыг холбох шинэ замыг тавих
- Мянганы замтай холбогдох хойд-өмнөд хэсгийн дөрвөн шинэ зам тавих (нийтдээ 1100 км),
- Улаанбаатараас Хятадын хил хүрэх Замын Үдийн замыг тавьж дуусгах (300 км)
- Урдууraa Алтай хүрэх зам (225 км).

Мянганы замын хэсгүүдийг тавьж дуусгах ажлыг Дэлхийн банк болон хоёр талын бусад хандивлагчдын хамтаар хийнэ. Мянганы замд холбогдох хойд-өмнөд зүгийг холбосон замын нэгийг барих төслийг (Цагаан нуураас Ярантай хүрэх зам) АХБ-ны санхүүжилтээр одоо боловсруулж байна (ЗТАЖЯ, 2007).

Төмөр замын дэд бүтцийн хувьд Үндэсний Тээврийн стратегийн баримт бичигт “Орос, Хятадыг холбох хойд-өмнөд хэсгийн төмөр замын коридорыг сайжруулах” болон “уул уурхайн салбарт холбох холбоосыг нөхцөлдүүлэх гол хувилбар болгож төмөр зам барих ” асуудлыг тэргүүлэгч болгон тодорхойлов (ЗТАЖЯ, 2007).

Дэлхийн банкны судалгааны дагуу (Дэлхийн банк, PPIAF, 2007) төмөр зам хөгжүүлэх засгийн газрын хөрөнгө оруулалтын төсөлд дараах төслүүд орно. Үүнд:

- Орос, Хятадыг холбох төмөр замын шинэ шугам (1100 км),
- Монголын өмнөд хэсэгт баруун-зүүнийг холбосон шинэ төмөр зам (500 км)
- Уул уурхайн шинэ төмөр зам (300 км)
- Засвар үйлчилгээний салбарын төмөр зам.

Хувийн хөрөнгө оруулалтын олдоцоос шинэ уурхайн төмөр зам ихээхэн хамаарч боломжийн хирээр уул уурхайн аж ахуйн нэгжүүдээр өөрсдөөр нь бариулж ажиллуулах хэрэгтэй гэдэг нь судалгаанаас харагдав (Дэлхийн банк болон PPIAF 2007). Одоогоор уул уурхайн аль ч төмөр замыг тавих шийдвэр гараагүй байна (Дэлхийн банк болон PPIAF 2007). Гэхдээ Хятадын хил болон Өмнөговийн уурхайнуудыг холбох төмөр замын шинэ үйлчилгээг нэвтрүүлэх бодит шаардлагыг Үндэсний Тээврийн стратегийн баримт бичигт тусгасан болно (ЗТАЖЯ, 2007).

Иргэний агаарын тээврийн хувьд Үндэсний тээврийн стратегийн баримт бичигт тус

улсын баруун хэсгийг Улаанбаатар хот болон бусад гол цэгүүдтэй холбосон дотоодын агаарын тээврийн үйлчилгээг сайжруулах, нэн тэргүүнд аялал жуулчлалын хэрэгцээ шаардлагад нийцүүлж дотоодын агаарын тээврийн үйлчилгээг сайжруулах асуудлыг тусгажээ (Дэлхийн банк болон PPIAF, 2007). Түүнчлэн Улаанбаатарт баригдах шинэ нисэх онгоцны буудлын үндэслэл болон цаг хугацааг тодорхойлох техник, эдийн засгийн үндэслэл боловсруулахыг стратегийн баримт бичгээс санал болгожээ.

Дэлхийн банкны хийсэн судалгааг үндэслэвэл (Дэлхийн банк болон PPIAF 2007) иргэний агаарын тээврийг хөгжүүлэх засгийн газрын хөрөнгө оруулалтын хөтөлбөрт дараах төсөл орно. Үүнд:

- Улаанбаатарт баригдах нисэх онгоцны шинэ буудал
- Орон нутгийн нисэх онгоцны 4 буудлыг сайжруулах (Өлгий, Улаангом, Улиастай, Алтай).

2008 оны 3 сарын 8-ны өдөр Япон Улсын засгийн газар болон Монгол Улсын засгийн газар Улаанбаатараас 40 км зайд орших Зуун мод хотод олон улсын нисэх онгоцны шинэ буудал барих гэрээнд гарын үсэг зуржээ. Нийт 28.8 тэрбум ьены (175 сая ам доллар) өртгөөр баригдах уг нисэх онгоцны буудлыг 2015 онд ашиглалтанд өгөхөөр төлөвлөж байна (Киодо мэдээллийн агентлаг, 2008).

Эрчим хүчний хувьд газрын менежментийн үндэсний мастер төлөвлөгөөнд 2004-2012 оны хооронд баригдах 8 усан цахилгаан станцын жагсаалтыг тусгажээ. Эдгээр цахилгаан станцын нийт суурилуулсан өртөг нь 266,7 МВ байх ба үүний 83 хувийг Булган аймгийн Эгийн голын станц үйлдвэрлэнэ (ГЗБГЗЗГ, 2003). Найман усан цахилгаан станцын далан нь нийтдээ 1,1 сая га газар эзлэх ба эндхийн усны болон хуурай газрын биологийн төрөл зүйлд ноцтой нөлөө үзүүлэх төлөвтэй байна.

Дэлхийн банкны хийсэн судалгаанаас үзвэл (Дэлхийн банк болон PPIAF, 2007) Монголын засгийн газрын санал болгож буй эрчим хүчний хөрөнгө оруулалтын хөтөлбөр нь дараах хэсгээс бүрдэнэ. Үүнд:

- Эгийн голын усан цахилгаан станцын хоёр үе шатны ажлыг зохион байгуулах,
- Улаанбаатарт нүүрсээр ажилладаг дулааны болон цахилгаан станц шинээр барих,
- Одоо ашиглагдаж буй дамжуулах хүчин чадлын хирээр ОХУ-аас нэмэлт эрчим хүч импортлох,
- Хувийн хэвшлийнхний туслалцаатайгаар Таван толгойд нүүрсээр ажилладаг цахилгаан станц бариулах

220 МВ хүчин чадал бүхий Эгийн голын усан цахилгаан станцын эхний үе шат 2012 онд эхлэх төлөвтэй (Дэлхийн банк болон PPIAF, 2007).

Усан цахилгаан станцаас бусад усан дэд бүтцийн асуудлыг уг судалгаагаар нарийвчлан судлаагүй болно. Гэхдээ зарим нэгэн төлөвлөж буй үйл ажиллагаа биологийн төрөл зүйлд ноцтойгоор нөлөөлнө гэдэг нь ойлгомжтой юм. Үүнийг нэг жишээ бол 70 хувь нь уул уурхайн хэрэгцээ шаардлагыг хангах Хэрлэн голоос зүүн өмнөд Говь руу ус татахыг санал болгож буй Хэрлэн-Говийн усны төсөл юм (Дэлхийн банк болон PPIAF, 2007).

2015 хүртэл дээр дурьдсан дэд бүтцийн хөгжлийн төслүүд нь хэрэгжинэ гэдэгт эргэлзэх хэд хэдхэн учир шалтгаан байна. **Нэгдүгээрт,** шаардлагатай хөрөнгө оруулалт олдохгүй байх төлөвтэй. Жишээ нь, Дэлхийн банкнаас сүүлийн үед зохион байгуулсан хөндлөнгийн үнэлгээгээр 2008-2015 хүртэл Монголд боловсруулсан тээврийн дэд бүтцийн төслийн өртөг нь тухайн улсын тээврийн дэд бүтцэд зарцуулдаг мөнгөнөөс даруй 3-4 дахин илүү тул хэрэгжүүлэхэд маш хүнд байх болно (Дэлхийн банк болон PPIAF, 2007) гэсэн дүгнэлт гарчээ.

Хоёрдугаарт, санал болгож буй олон төслүүд, нэн ялангуяа тээврийн салбарын төслүүд эдийн засгийн үндэслэлгүй болох нь тодорхой болов. Нэг жишээ дурьдахад Мянганы замын сүүлийн үеийн өргөтгөлд хойт өмнөд зүгийг холбосон таван замыг шинээр тавихаар тусгагджээ. Эдгээр чиглэлд урьдчилсан болон

өнөөгийн техник, эдийн засгийн үндэслэлийн судалгаа хийгдээгүй ба өөрийн өртгөө нөхөх хэмжээний ачаа тээврийн эргэлтийг энэ зам гүйцэтгэж чадахгүй байх эрсдэлтэй (Дэлхийн банк болон PPIAF, 2007).

Эдгээр хүндрэлтэй асуудлын хариу болгож 2008-2015 он хүртэлх засгийн газрын хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг олдох боломжтой санхүүгийн нөөц эх үүсвэртэй уялдуулах чиглэлд хэрхэн өөрчилж болох талаар Дэлхийн банкнаас урьдчилсан зөвлөмж гаргалаа (Дэлхийн банк болон PPIAF, 2007).

Эдгээр зөвлөмжинд улсын баруун зүүн хэсгийг холбох төмөр зам барих төлөвлөгөөнөөс татгалзах, ашиглагдаж буй хүчин чадлаа нэмэх замаар ОХУ, БНХАУ-ыг холбох шинэ төмөр зам барих хэрэгцээ шаардлагыг бууруулах, Мянганы замын хөтөлбөрийн хүрээнд баригдах хойт өмнөд хэсгийг холбох шинэ замын уртыг 1100 км-ээс 150 км болтол багасгах болон нисэх онгоцны шинэ буудал барихаас одоохондоо татгалзах зэрэг саналууд орж байна (Дэлхийн банк болон PPIAF, 2007).

5.4. Аялал жуулчлалын салбарын хөгжил

Товч түүх

Монголын аялал жуулчлалын салбар гол төлөв хөдөөгийн ард иргэд, тэдгээрийн нүүдлийн аж амьдрал дээр суурилдаг ба үүнд өргөн, уудам нутаг, сонирхол татахуйц өвөрмөц газар нутгууд ч нөлөөлдөг (Вингстэр, 2005). Байгалийн аялал жуулчлалын зэрэгцээ морин аялал, загасчлал, шувуу, эрвээхэй үзэх зэрэг сонирхол бүхий зохион байгуулалттай, бие даасан бүтээгдэхүүний төрөл, тоо бага ч болов өсөх хандлагатай байна. Ландшафт, соёлын болон зэрлэг ан амьтны үнэлэмж, аяллын бусад боломжийн хувьд Монгол орны тусгай хамгаалалттай газар л аялал жуулчлалын эрэлт хэрэгцээ ихтэй газар болжээ.

Тусгай хамгаалалттай газрын менежментийг санхүүжүүлэх эсвэл орон нутгийн эдийн засагт хувь нэмэр оруулах замаар тусгай хамгаалалттай газарт аялал жуулчлалын хөгжил ихээхэн хандив оруулж байгаа ба үүгээрээ ч байгаль хамгаалах үйлсдээ улс төр, орон нутгийн ард иргэдийн дэмжлэгийг хүлээж байна. Үүний зэрэгцээ аялал жуулчлалын салбар Монгол орны тогтвортой хөгжлийг дэмжих томоохон боломжийг нээж байна. Аялал жуулчлалын үйл ажиллагаа нь бусад салбартай харьцуулбал Улаанбаатар хотод төвлөрдөггүй тул эрчимтэй өсөж буй хотжилтоос тэс өөр нөлөө үзүүлдэг (Вигстен, 2008). Түүнчлэн нийслэл хотод шилжин ирж суурьшсан залуучуудад улирлын чанартайгаар эсвэл бүрмөсөн төрсөн нутаг усандаа эргэн очих боломжийг нээж, эмэгтэйчүүдэд хөдөлмөр эрхлэх өргөн боломж бүрдүүлж байгаараа аялал жуулчлал нь орон нутгийн ард иргэдийн жендерийн тэнцвэрийг хадгалахад ч нөлөөлж байна (Вингстен, 2008). Мөн хөрөнгө оруулалтын өртөг зардлын хувьд ч аялал жуулчлалын салбарт орон нутгийн ард иргэд татагдан оролцоход саад бэрхшээл харьцангуй бага байдаг (Вингстен, 2008).

Хүйтэн, урт өвлийн улмаас өвлийн аялал жуулчлал хөгжүүлэх боломж туйлын хязгаарлагдмал тул аялал жуулчлалын улирал 4-12-р сарын хооронд явагддаг ба хамгийн оргил үе нь 7, 8-р сарууд юм. Тээвэрлэлт болон буудаллах байр зэрэгтэй холбоотой дэд бүтцийн хязгаарлалт, хүндрэлийн улмаас жуулчид тур операторуудаас ихээхэн хамааралтай болж, тэдгээрээс урьдчилсан захиалгаар тээвэр, хоол хүнс, зочид буудал зэргийг оруулсан аялалын багц худалдан авдаг (Вингстен, 2005). Жуулчид Улаанбаатар хотоос гадуур, ихэвчлэн засгийн газраас олгосон тусгай зөвшөөрөл бүхий тур операторуудын ажиллуулдаг гэр баазуудаар байрладаг.

Бусдын амжилтаас үлгэр жишээ авч гэрээс гэрт гэсэн санаачлагыг даган аялагчдын хөл ихтэй газар малчин өрхүүд бие даасан тусдаа бааз байгуулан ажиллах нь олонтаа болсон ч тэдгээрийн зохицуулалт муу, бизнесийн ур чадвар дутмаг болон өөрийн бүтээгдэхүүн, үйлчилгээгээ бусдад сурталчлах арга барилаар дутмаг юм. Иймээс одоогоор дэлхийн зах зээлд борлуулалтын сүлжээгээр дамжуулан тэр болгон амархан борлуулагдах

нэгдсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг малчин өрхүүд боловсруулж чадаагүй байна (Вингстен, 2008).

Эдгээр жуулчны бааз нь орон нутгийн ард иргэдэд үзүүлж буй ач тус харилцан адилгүй байна. Жуулчны бааз нь орон нутгийн эзэмшилтэй буюу хөрөнгө оруулагч нь уг орон нутгаас гаралтай бол тухайн бааз хөдөлмөр эрхлэлт, адуу, тэмээгээ түрээслүүлэн унуулах, хүнсний ногоо, сүү, мах худалдах зэрэг хэлбэрээр орон нутагт ач тусаа үзүүлдэг (Вингстен, 2008). Гэвч ихэнх тохиолдолд тур операторууд өөрийн малаа ашиглаж, аюулгүй байдал, найдвартайг харгалзан хоол хүнсээ гаднаас авчирдаг. Иймээс орон нутгийн сонирхогч талуудад хүртээх ач тус ихээхэн хязгаарлагдмал байдаг.

Аялал жуулчлалын салбарын өргөжиж буй байдал

1990 оноос эхэлсэн эдийн засгийн шинэтгэл аялал жуулчлалын салбарыг хувьчилж, Монголд зорчих, дотооддоо аялахтай холбоотой аливаа хязгаарлалтыг халж, энэ салбарын эрчимтэй хөгжлийг бий болгосон билээ. Монголд ирэх зорчигчдын тоо эрс өсч 1999 онд 137000 байснаас 2006 онд 385000 болжээ (ЗТАЖЯ, 2007) (Зураг 7). Эдгээр зорчигчдын ихэнх нь амралт, зугаалгын зорилгоор ирэх жуулчид биш харин тусгай хамгаалалттай газарт байршдаг гэр баазуудаар хоноглодоггүй бизнесийн хэргээр зорчигсод байв (Вингстен, 2008).

Зураг 7. Монголд ирсэн зорчигчдын тооны өсөлт (ЗТАЖЯ, 2007)



Зорчигчдын өсөлт 1999 онд 63 байгаад 2006 онд 200 болсон нь зочид буудал, жуулчны баазын өсөлттэй уг өсөлт уялдаж байна (ЗТАЖЯ, 2007). (Зураг 8). Монголд ирсэн зорчигчдын 90 хувь нь дараах орны иргэд байжээ. Үүнд: БНХАУ, ОХУ, Солонгос, Япон, АНУ, Герман, Франц, Их Британи, Австрали, Нидерланд болон бусад орнууд. Аялал жуулчлалын салбараас 2006 онд 210 сая ам долларын орлого орж Монголын ДНБ-ний 10 хувийг бүрдүүлсэн байна.

Засгийн газраас аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэхийг нэн тэргүүний зорилт хэмээн тунхагласан билээ (Батжаргал). Олныг хамарсан гэхээсээ илүү тусгай сонирхлын аялал жуулчлалд салбарын хөгжлийг чиглүүлэх нь зүйтэй гэдгийг нийтээрээ хүлээн зөвшөөрсөн билээ. Монголын аялал жуулчлалын ихэнх хэсэг байгаль дээр суурилсан тул цаашид жуулчдын тоо нэмэгдэхийн хирээр тусгай хамгаалалттай газар нутгууд болон Монголын байгальд учрах дарамт өсөх төлөвтэй (Шлейхер ба Хотц, 2007).

ОдоогийнбайдлаарУлаанбаатарынойролцоо Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газраас бусад газар дотоодын жуулчлал маш бага хөгжсөн байна. Гэхдээ хүн амын орлого өсч, дэд бүтэц сайжрахын хирээр дотоодын жуулчлал өсөх байх. Энэ судалгааны багт дотоодын жуулчлалын төвшин болон аялал жуулчлалын гол газруудтай холбоотой тоо баримт хомс байлаа.

Зураг.8 Монголын жуулчны бааз болон зочид буудлуудын өсөлт, 1999-2006 (ЗТАЖЯ, 2007) (ногоон шугамаар зочид буудлуудын тоо, цэнхэр шугамаар жуулчны баазуудын тоог тус тус тэмдэглэв).



Монгол орны аялал жуулчлалын стратегийн баримт бичгийг боловсруулах ажил

Аялал жуулчлалын салбарын хөгжлийн стратегийн хамгийн сүүлийн үеийн баримт бичиг бол ЗТАЖЯ-аас гаргасан Монголын Аялал жуулчлалыг 2007-2011 он хүртэл хөгжүүлэх баримт бичиг юм. Төрийн бодлого, сургалт, мэдээлэл, олон нийтийн мэдлэг ойлголтыг сайжруулж судалгаа зэргийг хэрэгжүүлэх үүрэг бүхий бие даасан тусдаа бүтэц байгуулахыг уг баримт бичигт санал болгов. Стратегийн зорилт нь бусад асуудлын зэрэгцээ (1) Монголын байгаль орчин, нийгэм соёлын өвийн хамгаалал, (2) бага орлого бүхий айл өрхийн ядуурлыг бууруулж эмзэг бүлэгт тус нэмэр болох,(3) аялал жуулчлалын салбарын хүний нөөцийг бэхжүүлэх, (4) оролцогч талуудын хамтын ажиллагааг эрчимжүүлж хувийн хэвшлийн санал санаачлага, хөрөнгө оруулалтыг дэмжих, (5) орон нутгийн ард иргэдэд тулгуурласан аялал жуулчлалыг хөгжүүлэх, (6) хамгаалалттай газар нутгийн аялал жуулчлалын менежментийг сайжруулах ба (7) жуулчны улирлыг уртасгах зорилгоор өвлийн аялал жуулчлалыг хөгжүүлэх зэрэгт оршино. Тодорхой төслүүд хэрэгжүүлж халуун рашаан (Хужирт, Шаргалжуут, Цэнхэрийн рашаан) болон Улаанбаатар хот, Хөвсгөлд өвлийн аялал жуулчлалын цогцолборын асуудлыг шийдвэрлэнэ.

Үндэсний стратеги байгаа хэдий ч Монголын аялал жуулчлал ихэнхдээ эрэлт хэрэгцээгээр тодорхойлогдох тул стратегийн аливаа нэгэн удирдамжийн хүрээгээр хязгаарлагдахгүй юм. Иймээс тухайн салбар ерөнхийдөө хаана эрэгт хэрэгцээ байна тэнд хөгжих төлөвтэй байна. Хөвсгөл нуур, Горхи Тэрэлжийн байгалийн цогцолборт газар зэрэг онцгой газруудад аялал жуулчлалын хөгжил төвлөрч хурдацтай явагдах төлөвтэй (Вингсен, 2008).

Монгол орны тогтвортой аялал жуулчлалын хөгжил

Аялал жуулчлалын салбарт гарсан хамгийн онцлох санал санаачлага бол Тогтвортой аялал жуулчлалын хөгжлийн төв (ТАЖТ) байгуулсан явдал юм. ТАЖТ-ийн эрхэм зорилго нь Монгол оронд тогтвортой аялал жуулчлалын практик болон зарчмуудын дизайн, мониторинг, үнэлгээ болон сайжруулалтын механизмыг нэвтрүүлэхэд хувь нэмэр оруулах явдал юм. Түүний үүрэгт тусгай хамгаалалттай газруудад тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх бодлого, төлөвлөлт боловсруулах, тур операторуудын дүрэм журмыг бий болгож “Орон нутгийн ард иргэдэд тулгуурласан аялал жуулчлалын сүлжээний” бүрэлдэхүүн хэсэг болгон орон нутгийн ард иргэдтэй хамтран ажиллах, орон нутгийн засаг захиргаанд аялал жуулчлалын хөгжлийн талаар удирдамж өгөх зэрэг үйл ажиллагаа орж байна.

Олон улсын хандивлагч ямарч байгууллагын оролцоогүйгээр ТАЖТ үйл ажиллагаандаа амжилт гаргасан бөгөөд зорчих газрын менежментийн хувьд тодорхой зорилгоо тунхаглаж чадсан байна. ТАЖТ нь тодорхой эрхэм зорилго, харилцааны стратегитай тул уг төвийн оролцогч талууд анхнаасаа юу сонгон авч байгаагаа сайтар мэддэг. Тиймээс тухай байгууллагын бизнесийн зорьж буй үр дүнд чиглэсэн хамтын ажиллагааг өрнүүлэх бүрэн боломжтой юм. ТАЖТ үүсэн хөгжсөнөөр Монголын ДНБ-нд ихээхэн хувь нэмэр оруулахуйц уялдаа бүхий харилцаа холбоо аялал жуулчлалын салбар болон ирээдүйн хөгжлийн төлөвлөлтийн хэрэгцээ хоёрын хооронд бий болж байна (Вингстен, 2008).

6. Бүтэц, зохион байгуулалтын тогтолцооны дүн шинжилгээ

6.1 Байгаль хамгааллын бүтэц зохион байгуулалт, зохицуулалтын тогтолцоо

Байгаль хамгааллыг зохицуулах тогтолцоо

1990 оноос хойш Монголд байгаль орчны хамгаалалтай холбоотой дараах хэд хэдэн гол хууль тогтоомжийг батлан мөрдсөн юм. Үүнд:

- Монголын Үндсэн хууль (1992 он)
- Байгаль орчныг хамгаалах тухай хууль (1995 он)
- Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль (1998 он)
- Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль (1994 он)
- Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль (1997 он)
- Газрын тухай хууль (2002 он)
- Ойн тухай хууль (2007 он)

Эдгээр хууль, эрх зүйн баримт бичигт орхигдуулсан хэд хэдэн зүйл болон хязгаарлалт бий. Зарим ажигчлагчдын үзэж байгаагаар (IIED, WBCSD 2002) нийтийн тээврийн хувьд мөрдөж буй зохицуулалт маш сул байна. Тухайлбал, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний үйл явцад нийтийн хэлэлцүүлэг явуулах тухай заалт огт байхгүй байна. Бусад ажиглагчдын үзэж байгаагаар (Вингард ба Захлер, 2006) зэрлэг ан амьтны арилжаа, наймааны талаар ямар ч хууль тогтоомж байхгүй.

Байгаль орчны хамгааллыг зохицуулах ажлын тулгын чулууг 1995 оны Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 1998 оны Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулиуд тус тус тавьсан юм. Бусад асуудлыг зохицуулахын зэрэгцээ эдгээр хуульд бохирдуулагч этгээдээр төлбөр төлүүлэх зарчмыг нэвтрүүлсэн ба иргэдэд байгаль орчны холбогдолтой мэдээллийг хүртэх эрхийг эдгээр хуулиар олгосон байна.

1995 оны Байгаль орчны хамгааллын тухай хуулийн долдугаар зүйлд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний талаар дурьдсан нь улмаар 1998 оны Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай тусдаа хууль болон батлагдсан билээ. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулинд санхүүгийн болон эрүүгийн хариуцлагын тогтолцоог тусгаж, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тайлан гаргаагүй нөхцөлд төслийн хэрэгжилтийг зогсоох хүртэл арга хэмжээ авах тухай заажээ. Гэвч байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний үйл явцад олон нийтийн хэлэлцүүлэг явуулах тухай заагаагүй ба байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тайланг боловсруулж дууссаны дараа олон нийт танилцах боломж эдлэх байдлаар заажээ.

1994 оны ТХГН-ийн тухай хуулиар улсын болон орон нутгийн ТХГН байгуулах, улсын тусгай хамгаалалттай газрын менежментийн зохицуулалтыг тусгаж өгсөн байна. **Уг хуулийн 12,18,21 болон 24 дүгээр зүйлүүдэд Улсын ТХГН-т уул уурхайн хайгуул, олборлолтын ажил явуулахыг хатуу хориглож зарим газруудад аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулахыг ч хязгаарласан байна.** 28 дугаар зүйлийн дагуу холбогдох ИТХ-аас тодорхой газруудад аялал

жуулчлалын үйл ажиллагаа явуулах шийдвэр гаргаж болохыг заажээ. 2007 оны Ойн тухай хуулинд уул уурхайн хайгуул, олборлолтын үйл ажиллагааг байгалийн чухал нутгуудад явуулахыг хориглосныг “хамгаалалттай ойн бүс нутаг” гэж өргөжүүлсэнээр нилээд өргөн ангиллыг хамрах болжээ. Томоохон чухал хууль тогтоомж болох 2002 оны Газрын тухай хуулинд “Тусгай хэрэгцээний газар” гэсэн ойлголтыг томьёолж, түүнд улсын болон орон нутгийн ТХГН-ийг хамруулсан байна. Тусгай хэрэгцээний газар нь улсын өмч бөгөөд хувийн өмчлөлд олгогдохгүй болно.

Монгол дахь байгаль орчны хамгааллыг зохицуулах талаарх нарийвчилсан хэлэлцүүлгийг Хавсралт 6-д тусгасан болно.

Байгаль орчны хамгааллын бүтэц, зохион байгуулалт

Газрын удирдлага, кадастрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага бол Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар юм (ГЗБГЗЗГ). ГЗБГЗЗГ нь Газрын менежментийн үндэсний төлөвлөгөө болосруулах үүрэгтэй ба уг төлөвлөгөөг хамгийн сүүлчийн хувилбараар боловсруулж Засгийн газрын 264 дугаарын тогтоолоор 2003 оны 12 сарын 24-нд батлуулжээ.

Байгаль орчны болон байгалийн баялгийн бодлого боловсруулж, хэрэгжилтийг хангах төрийн захиргааны төв байгууллага бол Байгаль орчны яам юм. 1989 онд байгуулагдсан БОЯ нь таван газар, хоёр агентлагтай (Дэлхийн банк, 2006). БОЯ-нд хамгаалалттай газрын асуудлыг 1993 онд байгуулагдсан Тусгай хамгаалалттай газрын товчоо хариуцдаг. БОЯ хамгийн бага санхүүжилт бүхий яамдуудын нэг ба 2003 онд тус яам улсын төсвийн нэг ч хүрэхгүй хувийн санхүүжилттэй байжээ (Вингард ба Захлер, 2006).

Зэрлэг ан амьтны менежментийн хувьд БОЯ маш хязгаарлагдмал хүчин чадалтай. Тус яаманд зэрлэг ан амьтан хамгаалах төсөв байхгүй төдийгүй зэрлэг ан амьтны менежментийн зориулалтыг хариуцах нэгж байдаггүй (Вингард ба Захлер, 2006). Харин зэрлэг ан амьтны менежментийг орон нутгийн засаг захиргаа хариуцдаг ба тэдгээр нь Монголын өргөн уудам нутаг дэвсгэрт зүй зохистой хяналт тавих чадавхи бүрдүүлэх тодорхой сургалт, үр ашигтай менежмент явуулах санхүүгийн эх үүсвэрээр хомс юм (Вингард ба Захлер, 2006). Орон нутгийн засаг захиргааны газрууд мэргэжлийн боловсон хүч, хүн хүч муутай, цалин хөлс, тоног төхөөрөмжийн хангамж муу тул Монголын зэрлэг ан амьтныг үй олноор хорогдуулж байгаа хууль бус ангийн үйл ажиллагааг хянах чадваргүй юм (Вингард ба Захлер, 2006).

Урьд өмнө БОЯ-ны харьяа агентлаг байсан Байгаль орчныг хамгаалах газар нь 2003 оны 2 сард Мэргэжлийн хяналтын газартай нэгдсэн (Дэлхийн банк, 2006). Аймгуудад (нийслэл хотод) улсын хяналтын ахлах байцаагч томилогдон ажилладаг ба сумын төвшинд (дүүргийн) улсын байцаагч болон байгаль хамгаалагчийг ажиллуулдаг. Байгаль орчин хамгаалах тухай хуулиар сөрөг нөлөөллийг арилгахыг шаардах, сөрөг нөлөө бүхий үйл ажиллагааг зогсоож зөрчил гаргасан этгээдэд захиргааны хариуцлага тооцох эрх эдгээр байцаагчдад олгогдсон байдаг.

6.2. Уул уурхайн зохицуулалт, бүтэц зохион байгуулалтын тогтолцоо

Уул уурхайн зохицуулалт

2006 оноос өмнө Монголын уул уурхайн зохицуулалтын тогтолцоог 1988 онд батлагдсан Газрын хэвлийн тухай хууль, 1997 оны Ашигт малтмалын тухай хуулиуд болон энэ баримт бичгийн 6.1, 6-р хавсралтанд тус тус үзүүлсэн байгаль орчны чиглэлийн хэд хэдэн бие даасан хуулиудаар тодорхойлдог байжээ. Зарим ажиглагчид (IIED8 WBSCB 2002, Дэлхийн банк, 2006) энэ зохицуулалтын тогтолцооны сул талыг онцолсон ба ялангуяа, тусгай зөвшөөрөл олгох үйл явц, хариуцлага тооцох, нөхөн сэргээх санхүүжилт хийх, албан бус олборлолт, хамгаалалттай газар болон газар ашигласны нөхөн төлбөр зэрэг асуудлаар шийдвэр гаргахад олон нийтийн оролцоо байхгүй байгааг тэмдэглэсэн байдаг.

Эдгээр сул талуудыг 2006 онд шинээр

батлагдсан Ашигт малтмалын тухай хуулиар өөрчилсөн. Уг хуульд орсон нэмэлт өөрчлөлтүүд нь байгаль орчны хамгааллыг бэхжүүлж хайгуул, олборлолт болон холбогдох хөрөнгө оруулалтын процедурыг тодорхой болгосон байна (Азийн сан, 2007). Албан бус олборлолтын хувьд 2008 оны 2 сард түр журам батлаж гар аргаар болон бичил олборлолтыг зохицуулсан нь сүүлийн үед гарсан нэг томоохон дэвшил байлаа. Хэдийгээр уул уурхайн салбарын үйл ажиллагааг зохицуулах дорвитой алхмууд хийгдсэн хэдий ч уг салбарыг үр ашигтайгаар зохицуулах нарийвчилсан тогтолцоо өнөөг хүртэл үгүйлэгдсээр байна.

2006 оны Ашигт малтмалын тухай хуулинд томоохон хайгуул, олборлолтын үйл ажиллагаанд тусгай зөвшөөрөл олгох асуудлыг цэгцэлжээ. **Ашигт малтмалын тухай хуулийн 17, 24 дүгээр зүйлүүдэд улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газрыг хамарсан "Тусгай хэрэгцээний газар"-т хайгуул, олборлолтын үйл ажиллагаа явуулахыг хоригложээ.** Гэвч уг хуулинд холбогдох орон нутгийн ард иргэдтэй зөвшилцөх хэрэгцээ шаардлага зэрэг тусгай зөвшөөрөл олгохтой холбоотой асуудалд олон нийтийн үр дүнтэй хэлэлцүүлэг хийх талаар огт дурьдаагүй бөгөөд санал өгөх 30 хоног дуусгавар болсоны дараа хайгуулын тусгай зөвшөөрлийг автоматаар олгох тухай тусгажээ. Одоогийн хуулийн өөр нэг сул тал нь хайгуулын тусгай зөвшөөрөл олгох эрх бүхий байгууллага болох АМГТХЭГ нь улсын тусгай хамгаалалттай газрын сүлжээг хариуцаж буй БОЯ-нд тусгай зөвшөөрөл олгосны дараа зөвхөн энэ тухай мэдэгдэх тухай заасан ба энэ нь тухайн газрын тусгай хамгаалалт бүхий нутаг дэвсгэртэй давхцаж байгаа эсэхийг хянах боломжийг уг яаманд олгохгүй байна.

Монгол оронд олныг хамарсан, албан бус уул уурхайн олборлолтын үйл ажиллагааг зохицуулах зорилгоор тусдаа хууль батлагдтал мөрдөгдөх гар аргаар болон бичил уул уурхайн үйл ажиллагааг зохицуулах түр журмыг засгийн газраас саяхан баталсан юм. Энэхүү журмаар тусгай хамгаалалттай газар, 2002 оны Газрын тухай хуулиар тодорхойлсон Тусгай зориулалтын газарт гар аргаар болон бичил олборлолт хийхийг хоригложээ.

Монголын байгаль орчны хамгааллын зохицуулалтын тогтолцооны талаар дэлгэрэнгүй хэлэлцүүлгийг Хавсралт 7-д тусгасан болно.

Уул уурхайн салбарын бүтэц, зохион байгуулалт

Уул уурхайн салбарын хөгжлийн асуудлыг бүхэлд нь хариуцсан эрх бүхий байгууллага нь Үйлдвэр худалдааны яам юм. 1997 онд Ашигт малтмалын тухай хууль батлагдахад Геологи, уул уурхайн хяналтын алба гэсэн тусдаа тохируулагч агентлаг үйл ажиллагаа явуулж байсан ба улмаар бие даасан хэрэгжүүлэгч байгууллага АМГТХЭГ байгуулагджээ (Дэлхийн банк). Тус яамны уул уурхайтай холбоотой үүрэг нь өнөөгийн байдлаар зохицуулалтын тогтолцоог бүрдүүлэх, бүс нутгийн геологийн судалгааны үр дүнг нэгтгэх, үнэлэх зэрэг зөвхөн салбарыг дэмжих үүргээр хязгаарлагдаж байна.

ҮХЯ-аас тусгаарласнаас хойш Геологи, уул уурхайн хяналтын алба нь хяналтын нэгдсэн агентлаг болох Улсын мэргэжлийн хяналтын албанд харьяалагдах болжээ. Түүнд ажиллаж буй 12 байцаагч нь Ерөнхий сайдын шууд удирдлагад харьяалагддаг аймгийн уул уурхайн хяналтын албатай холбоотой ажилладаг (Дэлхийн банк, 2006).

Ашигт малтмалын хувьд АМГТХЭГ бол хөндлөнгийнголлоххэрэгжүүлэгчагентлагюм. Тэрээр ашигт малтмалын тусгай зөвшөөрөл олгох, салбарын мэдээллийг цуглуулах, геологийн тоо баримтыг архивлах болон геологийн судалгаа хийх үүрэгтэй. Агентлаг нь гурван хэлтэстэй. Үүнд: Геологи, уул уурхайн кадастрын газар, уул уурхайн газар, геологийн судалгааны албанд хуваагддаг. Геологи, уул уурхайн кадастрын газар нь 12 ажилтантай, хайгуул, олборлолтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг хүлээн авч боловсруулдаг (Дэлхийн банк, 2006).

Газар ашиглах зөвшөөрөл олгох, тусгай зөвшөөрлийн зөрчилд зохих хариуцлага

ногдуулж хүлээлгэх зэрэг асуудлаар орон нутгийг засаг захиргааны процедуртай холбоотой зохицуулалтыг цаг алдалгүй хэрэгжүүлэх боломж олгох зүй зохистой бүтэцгүй, мөн АМГТХЭГ болон БОЯ, Сангийн яам, Улсын мэргэжлийн хяналтын газар, орон нутгийн засаг захиргааны хооронд ажлын уялдаа холбоо сул зэрэг хэд хэдэн сул талууд уул уурхайн бүтэц, зохион байгуулалтын тогтолцоонд ажиглагдаж байна (Дэлхийн банк, 2006).

АМГТХЭГ-т хэд хэдэн асуудлаар, тухайлбал гар аргаар болон бичил олборлолтыг зохицуулах, зөвшөөрөл болон тусгай зөвшөөрөлд заагдсан нөхцлийн дагуу олборлолтын үйл ажиллагаанд техникийн хийгээд байгаль орчны үзүүлэлтийн аудитыг хийх нэмэлт хүчин чадавхи шаардагдаж байна. Уг асуудлыг шийдвэрлэх үүднээс ҮХЯ гар аргаар болон бичил олборлолтын үйл ажиллагааны нэгжийг Швейцарийн хамтын ажиллагааны байгууллагын тусламжтайгаар АМГТХЭГ-ын бүтцэд 2005 онд байгуулжээ (Дэлхийн банк).

АМГТХЭГ-ын хүчин чадавхийн дутмаг байдалтай холбоотой өргөн хүрээний асуудлыг шийдвэрлэх зорилгоор Монголын засгийн газар, Дэлхийн банктай хамтран АМГТХЭГ-ын Геологи, уул уурхайн кадастрын газрын хүчин чадавхийг бэхжүүлэх бүрэлдэхүүн хэсэг бүхий Монголын уул уурхайн салбарын техник туслалцааны төслийг боловсруулахаар зэхэж байна. Энэ төслийн хүрээнд уул уурхайн тоо баримтыг бүрэн компьютержуулж уг тогтолцоонд тусгай хамгаалалттай газрыг хамрах боломжийг бүрдүүлэн (мөн боломжоороо хүрээлэн буй орчны бусад онцгой ач холбогдол бүхий газруудыг хамрах), тэдгээр газар нутагтай давхцаж буй талбайн олборлолтын тусгай зөвшөөрлийг автоматаар зөвшөөрөхгүй байх зарчмыг баримтлана. Үүний зэрэгцээ байгууллага хоорондын хамтын ажиллагааг зохицуулах чиглэлээр холбогдох этгээд бүрт тодорхой үүрэг хариуцлага ногдуулах замаар салбарын яам хоорондын хамтын үр дүнтэй ажиллагааг Дэлхийн банкнаас санал болгож буй уг төслийг дэмжинэ (Ханкок, 2008).

6.3 Аялал жуулчлалын салбарын зохицуулалт, бүтэц зохион байгуулалтын тогтолцоо

Аялал жуулчлалын салбарын зохицуулалт

Монгол улс аялал жуулчлалын хөгжилтэй холбоотой хэд хэдэн хууль, журмыг 1990 оноос хойш батлан хэрэгжүүлжээ. Үүнд:

- Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль (1994 он),
- Аялал жуулчлалын салбарын хөгжлийн талаар төрөөс баримтлах бодлого (1995 он),
- Тусгай хамгаалалттай газрууд, аялал жуулчлалын үйл ажиллагааг зохицуулах тухай Сайдын тушаал (1996 оны 43),
- ЖАЙКА-ийн дэмжлэгтэйгээр боловсруулсан Монголын Аялал жуулчлалын салбарын хөгжлийн мастер төлөвлөгөө (2000 он),
- Аялал жуулчлалын хууль (2000 он),
- ЖАЙКА-ийн дэмжлэгтэйгээр боловсруулсан Монголын Аялал жуулчлалын салбарын хөгжлийн мастер төлөвлөгөөн дэх байгалийн аялал жуулчлалын удирдлага, зохион байгуулалтын тогтолцоо (2002 он),
- Монголын аялал жуулчлалыг 2007-2011 онд хөгжүүлэх стратегийн баримт бичиг (2007 он).

Аялал жуулчлалын салбарыг зохицуулах үндэссуурийгАялалжуулчлалынтухайМонгол Улсын хуулиар (2000 оны 5 сард батлагдсан) тавьсан бөгөөд тусгай хамгаалалттай газарт явуулах аялал жуулчлалын үйл ажиллагааг Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулиар (хуулийн заалт 2.3) зохицуулдаг.

Аялал жуулчлалын байгууллагуудад (тур операторууд болон тур агентлагууд) “Үндэсний, түүх, соёл болон байгалийн үнэт ховор эд зүйлсийг хамгаалж хадгалах талаар өөрийн эрх мэдлийн хүрээнд шаардлагатай арга хэмжээ авч хууль зөрчсөн тохиолдолд холбогдох байгууллагуудад мэдээлэх болон Монголын нийгэм, эдийн засгийн хөгжил, эрүүл мэнд, хүн ардын ёс заншил, уламжлалд хувь нэмрээ оруулахуйц байгальд ээлтэй

аялал жуулчлал хөгжүүлэхийг зорино” гэсэн шаардлага тавигддаг (Заалт 8.2).

ЗТАЖЯ-ны эрх мэдлийн талаар хуулийн 16-р зүйлд заасан ба үүнд аялал жуулчлалтай холбоотой төрийн нэгдсэн бодлогыг боловсруулж зохицуулан, тодорхой удирдлагаар хангах (16.1.1), аялал жуулчлалыг хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг хангах (16.1.3), аялал жуулчлалын байгууллага, дээд зэрэглэлийн зочид буудал болон жуулчны баазад зэрэглэл тогтоож тусгай зөвшөөрөл олгох дүрэм батлах (16.1.6), аялал жуулчлалын бүсэд үйл ажиллагаа явуулах жуулчны бааз, амралт, рашаан, сувиллын газруудын тоо, байршлыг тогтоох (16.1.7), аялал жуулчлалын бүсэд хүлээн авах жуулчдын тоог тогтоох (16.1.12), аялал жуулчлалын зам, маршрутыг тогтоох (16.1.13) болон аялал жуулчлалын салбарт сөргөөр нөлөөлж болохуйц аливаа үйл ажиллагаа явуулахыг хориглоно (16.1.14) гэж тус тус з аажээ.

Аялал жуулчлалын хуульд мөн аялал жуулчлалын салбарын нэгдсэн бодлого боловсруулж, хэрэгжүүлэх Монгол орны аялал жуулчлалын зөвлөл (Заалт 15) байгуулах ёстой. Аялал жуулчлалын зөвлөлд БОЯ болон аялал жулчлалын ТББ-ын төлөөлөгчид ордог (15.3).

Аймаг, сум болон багийн төвшинд ИТХ өөрийн эдийн засаг, нийгмийн хөгжил болон өөрийн холбогдох нутаг дэвсгэр дээр байгалийн баялгийг хэрхэн хуваарилах талаар шийдвэр гаргах эрхтэй юм. Аялал жуулчлалын хувьд өөрийн нутаг дэвсгэр дээр аялал жуулчлалын бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянах (18.1.1), аялал жуулчлалын хөгжлийн талаар хэрэгжүүлэх үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах (18.1.2), өөрийн мэдлийн нутаг дэвсгэрийн тодорхой хэсгийг аялал жуулчлалын нөөц бүс нутагт оруулах тухай саналаа ЗТАЖЯ-нд хүргүүлэх (18.1.3) болон өөрийн мэдлийн нутаг дэвсгэрийн аялал жуулчлалын хөгжлийн хөтөлбөрийг батлах (18.1.4) зэрэг эрх, үүрэгтэй болно.

Засаглалын бүтцийн гурван төвшний засаг дарга нар аялал жуулчлалын хувьд (Заалт 18.2) өөрийн газар нутаг дээр аялал жуулчлалын бодлого болон хууль, тогтоомжийг хэрэгжүүлэх (18.2.1), өөрийн эрх мэдлийн хүрээнд болон ЗТАЖЯ-аас баталсан тоо, байршлын дагуу холбогдох хууль тогтоомжийг баримтлан тус газарт байгуулагдах аялал жуулчлалын байгууллагад зөвшөөрөл олгож гэрээ байгуулна (18.2.2), өөрийн мэдлийн холбогдох газарт бүс нутгийн аялал жулчлалын хөгжлийн бодлоготой нийцүүлж хөтөлбөр, төслүүд боловсруулан, холбогдох ИТХ-д хүргүүлж батлагдсан хөтөлбөрийн дагуу аялал жуулчлалын төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлнэ (18.2.3).

1994 оны Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулинд: (i) Дархан цаазат газар, (ii) Байгалийн цогцолборт газар, (iii) Байгалийн нөөц газар болон (iv) Байгалийн түүх, соёлын дурсгалт газрууд зэрэг улсын тусгай хамгаалалттай газар нутгийн 4 төрөлд аялал жуулчлалыг зохион байгуулах талаар тодорхой заасан байдаг.

Дархан цаазат газар нь онгон бүс, хамгаалалтай бүс болон хязгаарлалтын бүс (8-р зүйл) гэж хуваагддаг ба зүй зохистой зөвшөөрлийг авч, “байгаль орчинд халгүй технологи ашигласан” нөхцөлд хязгаарлагдмал ашиглалт бүхий бүсэд байгалийн аялал жуулчлал болон бусад төрлийн аялал жуулчлалыг зохион байгуулах, түр байрлах жуулчны байр буюу баазыг байгуулж болно (11-р зүйл). Гэхдээ хөрс, ус, агаар бохирдуулах аливаа үйл ажиллагаа, нуур, гол, горхи, рашаан зэргийг арилжааны зорилгоор ашиглахыг хориглосон байдаг (12.1).

Байгалийн цогцолборт газрууд онцгой бүс, аялал жуулчлалын бүс болон хязгаарлалтын бүсэд хуваагддаг (14-р зүйл). Байгалийн цогцолборт газруудын менежментийн дүрэмд аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрсөн тохиолдолд Дархан цаазат газрын аялал жуулчлал болон хязгаарлагдмал ашиглалт бүхий бүсэд аялал жуулчлал эрхлэхтэй адилхан байна. (3үйл 16, 17).

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулинд Байгалийн нөөц газар явуулах

аялал жуулчлалын үйл ажиллагаа нь тухайн газар нутгийн унаган төрхийг өөрчлөх, байшин барилга барьж газар ухах зэрэг байгальд сөрөг нөлөө үзүүлээгүй нөхцөлд хариуцлагатай аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулахыг төдийлөн хориглоогүй байна (12-р зүйл). Хариуцлагатай аялал жуулчлалын үйл ажиллагааг мөн Байгалийн түүх, соёлын дурсгалт газруудад явуулахыг хориглоогүй ч сүр бараа, үзэмжийг нь дарах, газар сэндийчэн ухан, тэсрэх бодис ашиглан байшин барилга барих буюу байгалийн баялаг олборлох, Байгалийн эсвэл соёлын түүх дурсгалт хөшөө дурсгалыг хөндөх, сүйтгэх болон хөдөлгөх, тэдгээрт хор хөнөөлтэй аливаа үйл ажиллагаа явуулахыг хоригложээ (24-р зүйл).

Тусгай хамгаалалттай газрын дотор болон гадна аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулахыг байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн заалтуудаар зохицуулах ба шинэ төслийг шалгаруулах үйл явцыг тодорхойлж шаардлагатай нөхцөлд байгаль хамгааллын төлөвлөгөөний агуулгыг тогтооно.

Аялал жуулчлалын бүтэц, зохион байгуулалт

Өнгөрсөн 10 жилийн хугацаанд Монголын засгийн газар аялал жуулчлалын үйл ажиллагааг өмчилж явуулах практикаас хууль, эрх зүйн болон бодлогын цар хүрээг тодорхойлох практик руу шилжсэн цаг үе байлаа. Ихэнх нь аялал жуулчлалын томоохон бүс болох тусгай хамгаалалттай газар нутгийн менежерийн хувьд Засгийн газар нь эдгээр газруудад ирэх жуулчдад үйлчлэх байгууламж болон менежментийн хувьд хариуцлага хүлээнэ.

ЗТАЖЯ-ны үүрэг хариуцлагад зам, тээвэр, төмөр зам, усан тээвэр, иргэний агаарын тээвэр, шуудангийн үйлчилгээ болон аялал жуулчлалын салбарын бодлого боловсруулж хэрэгжүүлэх зэрэг ажлууд багтсан байдаг. ЗТАЖЯ зургаан газартай ба одоогоор аялал жуулчлалын салбарын ерөнхий бодлого, стратегийг боловсруулж зохицуулах, салбарт баримтлах стандарт, журмыг боловсруулж боловсронгүй болгох, маркетинг, сурталчилгаа, аялал жуулчлалын дэд бүтэц, хүний нөөцийг хөгжүүлж аялал жуулчлалын бүтээгдэхүүн боловсруулах үүрэг бүхий Аялал жуулчлалын бодлого, зохицуулалтын газартай. Харин БОЯ бол гадаадын жуулчдыг Монгол руу татах гол хүч болох тусгай хамгаалалттай газрын менежментийг хариуцдаг. Мөн аялал жуулчлалын салбарт хамаарал бүхий дүрэм журмыг оролцуулан байгаль хамгаалахтай холбоотой журам боловсруулж хэрэгжүүлэх ажлыг тус яам хариуцдаг. Харамсалтай нь ЗТАЖЯ болон БОЯ-ны хооронд үйл ажиллагааны нарийн чанд, нүдэнд харагдахуйц зохицуулалт байхгүй мэт санагдана (Вингстен, 2008). Аялал жуулчлал болон тусгай хамгаалалттай газрын менежментийг нэг газарт хариуцуулах нь зүйтэй гэсэн санал олон гарч байсан. Гэвч зарим орны туршлагаас харахад аялал жуулчлалын салбар нь өөрөө ихэхээн том үйлдвэрлэл бөгөөд олон тооны бага болон дунд оврын аж ахуйн нэгжүүдээс бүрддэг (Агаарын тээврийн компаниуд, зочид буудлууд, тур операторууд г.м.) тул аялал жуулчлалын бүхий л үйл ажиллагааг нэг байгууллагын харьяалал дор нэгтгэн явуулахад бэрхшээл ихтэй болох нь тогтоогдсон (Вингстен, 2008).

Монголын аялал жуулчлалыг хөгжүүлэхэд Японы хамтын ажиллагааны байгууллага маш чухал үүрэг гүйцэтгэсэн болно. Тэрээр 1999 онд Монголын аялал жуулчлалын салбарыг хөгжүүлэх мастер төлөвлөгөө боловсруулах үндэсний хэмжээний том судалгаа явуулах үйл ажиллагааг дэмжсэн юм. Судалгааны тайланд үндэслэн 2002 онд БОЯ, Дэд бүтцийн яамтай хамтран Монголын байгалийн аялал жуулчлалыг хөгжүүлэх үндэсний хэмжээний семинарыг ЖАЙКА байгууллага зохион байгуулав. Тус семинараас дүрэм, журам болон Монголын байгалийн аялал жуулчлал, түүний холбогдох байгууллагуудын шалгуур үзүүлэлт, тодорхойлт, дезайн, санхүүгийн үндэс суурь болон аюулгүйн стандартуудын талаар зөвлөмж гаргасан байна. Байгалийн аялал жуулчлалыг Монголын нийгэм, эдийн засгийн байдлыг сайжруулах арга зам хэмээн тодорхойлов. ЖАЙКА-тай хамтран гүйцэтгэсэн ажлын нэгдсэн дүнг Засгийн газрын хуралдаанаар оруулж улмаар

2000 оны 5 сард Монголын анхны Аялал жуулчлалын хууль батлагдсан билээ.

6.4. Газар нутгийг хамгаалахад чиглэсэн улс төрийн бодлого

Олон улсын хөгжлийн банкуудын бодлого

Дэлхийн банк болон олон улсын хөгжлийн бусад банкууд өөрийн санхүүгийн үйл ажиллагаанаас гарч болзошгүй сөрөг нөлөөллийг намжаах зүй зохистой арга хэмжээ авах нөхцлийг бүрдүүлэх үүднээс байгаль орчны хамгаалалтын бодлого нэвтрүүлжээ (Хавсралт 8). Эдгээр бодлогоор аливаа зохисгүй үйл ажиллагаанаас биологийн төрөл зүйлийн чухал газруудыг хамгаалах үндэс суурийг тавьжээ. Биологийн төрөл зүйлд учрах дээр дурьдсан аюул занал болон Монголд эдүгээ өрнөж буй эдийн засгийн хурдацтай үйл явцууд нь эдгээр бодлогыг бүрэн хэрэгжүүлэхийн чухлыг харуулж байна.

Байгалийн чухал газруудын тухай мэдээллийг аль болох хүртээмжтэй болгох нь байгаль хамгаалах бодлогыг үр ашигтай хэрэгжүүлэхэд тус дөхөм болно. Эдгээр мэдээлэл нь: (i) хандивлагч байгууллага болон зээлдэгчдийн хооронд байгаль хамгаалллын бодлогын хэрэгжилтийн талаар илүү тодорхой харилцан ойлголт төрүүлнэ, (ii) байгаль хамгаалллын бодлогын тууштай, ил тод байдлыг буй болгох ба (iii) байгаль хамгаалллын талаар харьцангуй сул шаардлага бүхий хандивлагчдыг “ангуучлах” боломжийг зээлдэгчдэд хаалттай болгож, хамгаалалтын бодлогод стандартчилал, уялдаа холбоог буй болгоход тус дэм болох юм. Хандивлагчдын үйл ажиллагааны бодлого, процедурт оршиж буй ялгааг зээл тусламжийг хүртэгч олонх орнууд гадаадын хөгжлийн тусламжийн үр шимийг чөдөрлөгч гол хүчин зүйл гэж үздэг.

Байгаль хамгааллын талаар хувийн хэвшлийн байр суурь

Олон улсын санхүүгийн корпорациас тогтоосон стандартууд олон улсын санхүүгийн бусад байгууллагуудад стандарт боловсруулахад нь ихээхэн тус дөхөм үзүүлжээ. 2003 онд ОУСК-тай хамтран ажилладаг олон жижиг банкууд “Экваторын зарчим” хэмээх үйл ажиллагааг нэвтрүүлжээ. Үүний гол зорилго нь дэлхийн хаана ч, бүхий л салбарт хэрэглэж болохуйц байгаль орчин, нийгмийн хамгааллын стандартуудын нэгдсэн багц боловсруулахад оршиж байв. Улмаар эдгээр стандартыг дэлхийн 50 оронд батлаад байна.

Экваторын зарчимд нэгдэн орсон орнууд 10 сая ам долларааас давсан бүхий л хөрөнгө оруулалтын хувьд Биологийн төрөл зүйл, байгаль орчны тогтвортой нөөцийн менежментэд (дээр дурьдсан буй) ОУСК-ийн гүйцэтгэлийн стандарт 6-г хэрэглэнэ гэжээ. Энэ арга хэмжээ нь биологийн төрөл зүйлд чухал газар нутгуудыг хамгаалах цар хүрээг ихээхэн өргөтгөсөн юм.

Өөрийн тогтвортой хөгжлийн стратегийн чухал бүрэлдэхүүн хэсэг болгож биологийн төрөл зүйлийг хамгаалах эрмэлзлэлтэй байгаагаа харуулах хэрэгтэйг уул уурхайн компаниуд улам бүр ухамсарлах боллоо. Тэр тусмаа ашигт малтмалын нөөцөөр арвин, ашигт малтмалын улам бүр өсөн нэмэгдэх үлэмж их эрэлт хэрэгцээ бүхий ОХУ, БНХАУ-ын хооронд орших стратегийн чухал байршилтай Монгол орны уул уурхайн өнөөгийн огцом хөгжлийн хувьд энэ нь чухал ач холбогдолтой.

Олон улсын тэргүүлэгч уул уурхай, металлын аж ахуйн нэгжүүдийг төлөөлөх зорилгоор Олон улсын уул уурхай, металлын зөвлөл (ОУУУМЗ) 2001 онд байгуулагджээ. ОУУУМЗ-ийн Тогтвортой хөгжлийн баримт бичигт “Биологийн төрөл зүйлийн хамгаалал болон газар ашиглалтын төлөвлөлтийн нэгдмэл хандлагад хувь хандив оруулах” гэж заасан байна. Энэ үүрэг амлалт дээр тулгуурлан 2006 онд ОУУУМЗ-өөс уул уурхай болон биологийн төрөл зүйлийг хамгаалах талаарх тэргүүн туршлагын удирдамж гаргажээ.

Биологийн төрөл зүйлийг хамгаалах эдгээр үүрэг амлалтыг ОУУУМЗ-ийн гишүүн зарим аж ахуйн нэгж улам бүр боловсронгүй болгосон ажээ. Жишээ нь Монголын уул уурхайд нилээд их ашиг сонирхол бүхий Рио

Тинто компани 2004 оны 11 сард Бангкок хотноо болсон Дэлхийн байгаль хамгаалах уулзалтын үеэр байгууллагыг бүхэлд нь хамарсан биологийн төрөл зүйлийг хамгаалах стратегээ танилцуулжээ. Энэ стратегид цэвэр эерэг нөлөөллийн дараах зарчмуудыг тусгасан байна. Үүнд:

“Өөрийн үйл ажиллагаанаас гарах сөрөг үр дагаварыг багасгаж үйл ажиллагаа явуулж буй бүс нутагт байгаль хамгаалах үйлст зүй зохистой хувь нэмэр оруулснаар биологийн төрөл зүйлд цэвэр эерэг нөлөөлөл үзүүлэхийг Рио Тинто зорино” хэмээжээ.

Биологийн төрөл зүйлд эерэг нөлөөлөл үзүүлэх Рио Тинтогийн хандлага хэд хэдэн алхмаас бүрдэх ба үүнд: (1) Биологийн төрөл зүйлд нөлөөлөх нөлөөллийн хэмжээ болон шинж чанарыг тодорхойлох, (2) боломжийн хирээр эдгээр нөлөөллийг арилгах буюу багасгах, (3) зайлсхийх боломжгүй нөлөөллийг багасгах арга хэмжээ авах болон (4) ойр орчмын газрыг дэмжих зэрэг нөхөн хамгаалах үйл ажиллагаагаар аливаа үлдэгдэл нөлөөллийг нөхөх асуудлууд орно. Эцэст нь хэлэхэд тус компани нь өөрийн хувьд нөхөн сэргээлтийн хэлбэртэй бус бөгөөд заавал уул уурхайн үр дагавартай холбоотой биш байгаль хамгааллын бусад үйл ажиллагаанд хөрөнгө оруулах сонирхолтой байгаагаа дурьдсан байна.

Байгалийн чухал нутгуудыг хамгаалахтай холбогдсон бусад механизмууд

Байгалийн чухал нутгуудын хамгааллын асуудал нь олон улсын байгаль орчны гэрээ хэлэлцээрийн хүрээнд Монгол Улсын авсан үүрэг амлалтыг биелүүлэхэд тус дөхөмтэй гэдгийг дурьдах хэрэгтэй юм.

Эдгээр гэрээ хэлэлцээрт Биологийн төрөл зүйлийн тухай конвенци, Олон улсын ач холбогдол бүхий ус намгархаг газрын тухай конвенци (Рамсарын конвенци), Нүүдлийн ан амьтны тухай конвенци (Бонны конвенци) болон Дэлхийн өвийн сангийн тухай конвенци зэргийг дурьдаж болох юм. Монгол Улс эдгээр бүх конвенцид нэгдэж орсон орны нэг.

7. Байгаль орчинд хөгжлийн төлөвлөлтийн үзүүлж буй нөлөө

7.1. Уул уурхайн хайгуулын тусгай зөвшөөрөл, байгалийн чухал нутгуудын хоорондын давхардал

Байгаль хамгаалалд чухал газар нутгуудад уул уурхайн үйл ажиллагаанаас үүдэх нөлөөллийн үнэлгээнд тулгуурлаж олгосон хайгуулын тусгай зөвшөөрөл (2008 оны 5 сарын байдлаарх), байгалийн чухал нутгуудын ((улсын хамгаалалттай газар нутаг, орон нутгийн хамгаалалттай газар нутаг, олон улсын хэмжээнд хамгаалагдсан газар болон тахилага шүтлэгтэй газар хийгээд шувуудад чухал газрууд г м) ангилал бүрд (хэсэг 4-д үзүүлсэн) давхардлыг тогтоох зорилгоор геологийн мэдээллийн тогтолцооны дүн шинжилгээг хийв. Үүний дараа хайгуулын тусгай зөвшөөрөлтэй газрууд, Монгол орны байгалийн чухал нутгуудын нэгдсэн дүн хоорондын давхардлыг тодорхойлох дүн шинжилгээ хийв. (4.7-оос үзнэ үү).

Монгол орны нийт газар нутгийн дөрөвний нэг буюу 40,3 сая га газарт хайгуулын тусгай зөвшөөрөл олгосон байна (5.2-р хэсгээс үзнэ үү). Үүний 3874886 га газар нь Монгол орны байгалийн чухал нутгуудын нийт талбайн 10 орчим хувьтай давхардаж байна (Хүснэгт 9, Газрын зураг 10).

Эдгээр тоо баримт хайгуулын тусгай зөвшөөрөлтэй газрууд болон байгалийн чухал нутгуудын хооронд ихээхэн ялгаа байгааг харуулж байна. Хайгуулын тусгай зөвшөөрөлтэй газруудын Улсын ТХГН-тай давхцаж буй талбайн хэмжээ улсын ТХГН-ийн нэгээс бага хувь буюу 141014 га газар байхад, олон улсын хэмжээнд хамгаалагдсан газар нутагтай давхцаж буй талбайн хэмжээ 72179 га газар буюу хоёр хувьтай тэнцүү байна.

Хүснэгт 9. Хайгуулын тусгай зөвшөөрөлтэй газрууд болон байгалийн чухал нутгуудын хоорондын давхардал

Байгалийн чухал нутгууд	Нийт талбай (га)	Хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий талбай (га)	Хайгуулын тусгай зөвшөөрлийн дунд эзлэх хувь
1. Улсын тусгай хамгаалалттай газар нутаг	22,413,136	141,014	0.6
2. Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг	16,531,505	3,083,781	18.7
3. Олон улсын хэмжээнд хамгаалагдсан газар	3,988,448	72,179	1.8
4. Тахилага шүтлэгтэй	[47 газар]	[2 sites]	4.3
5. Шувуудад чухал газар	8,358,313	724,512	8.7
Нэгдсэн дүн	**40,327,615**	**3,874,886**	**9.6**

Тэмдэглэл: Хайгуулын зөвшөөрөлтэй газрууд болон байгалийн чухал нутгуудын хоорондын давхардлын улмаас дээрх 5 ангиллын нийлбэр нь байгалийн чухал нутгуудын нэгдсэн дүнгээс илүү байна.

Хайгуулын тусгай зөвшөөрөлтэй газрууд нь байгалийн чухал нутгуудын бусад ангилалтай давхцах давхардлын төвшин үлэмж их байна. Тухайлбал, 3083781 га газар орон нутгийн ТХГН-тай (нийт дүнгийн 19 хувь), тахилага шүтлэгтэй газар хоёр (4 хувь) ба 724.512 га газар шувуудад чухал газруудтай (9 хувь) тус тус давхцаж байна. Эдгээр ангиллын ийм их хэмжээний давхардал нь хоёр хүчин зүйлээс хамааралтай байна. **Нэгдүгээрт**, тахилага шүтлэгтэй газар болон шувуудад чухал газрууд нь хамгаалалттай гэж тодорхойлсоноос хэтрэхгүй бөгөөд Монголын хууль тогтоомжоор хамгаалалтанд ороогүй байдаг. **Хоёрдугаарт**, Газар нутгийг орон нутгийн тусгай хамгаалалтанд авах ажил сүүлийн үед эхэлсэн нь (гуравны нэгийг нь 2000 оны 1 сарын 1-ээс хойш, Зураг 3) хайгуулын тусгай зөвшөөрлийг олгосон цаг хугацаанаас хожуу байгаатай холбоотой.

Монголд олгогдсон 3572 хайгуулын тусгай зөвшөөрлийн 878 нь (буюу 25 хувь) нэг ба түүнээс дээш тооны байгалийн чухал нутгуудтай давхцаж байна. Эдгээр зөвшөөрлийн ихэнх нь (826 нь) 2006 оны Ашигт малтмалын тухай хуулийн 17-р заалтаар хайгуулын ажил хориглосон талбайтай (Улсын болон орон нутгийн ТХГН, Тусгай хэрэгцээний газар зэрэг) давхцаж байна. Энэ давхардал хоёр янз байна. Тухайлбал, бага хэмжээний давхардал (энэ нь тусгай зөвшөөрлийн 10 хүрэхгүй хувь нь нэг буюу түүнээс дээш тооны тусгай хамгаалалттай газартай давхардаж байгаа), их хэмжээний давхардал (тусгай зөвшөөрлийн 10 буюу түүнээс дээш хувь нь нэг буюу түүнээс дээш тооны тусгай хамгаалалттай газартай давхардаж байгаа) гэсэн 2 янзын давхардал байна.

Тусгай хэрэгцээний газартай давхардаж буй хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий газрын гуравны нэг нь (296 тусгай зөвшөөрөл) бага хэмжээний давхардалтай байна (Хүснэгт 10). Харин ихэнх хэсэгт энэ давхардал хайгуулын тусгай зөвшөөрлийн талбайн хил хязгаарыг буруу тогтоосноос болон тусгай хэрэгцээний газартай давхардахаас зайлсхийх гэж хайгуулын талбайн хил хязгаарыг шулуун шугамаар хэмжинэ гэсэн Ашигт малтмалын тухай хуулийн 17-р зүйлийг зөрчиж байгаатай холбоотой. Нүдэн баримжаагаар уг давхардлыг шалгавал тоо баримт, эх сурвалжуудын зөрүүтэй байдлаас шалтгаалан газарзүйн мэдээллийн системийн алдаатай холбоотой болох нь тогтоогдов. Гэвч энэ нь бага хэмжээний давхардалд нөлөөлжээ.

Хүснэгт 10. Тусгай хэрэгцээний болон хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий газруудын давхардал

Давхардлын төрөл	Тусгай зөшөөрлийн тоо	Давхардлын нийт талбайн хэмжээ (га)	Давхардлын голч талбай (га)
Бага хэмжээний (<10%)	296	187,074	632
Үлэмж хэмжээний (≥10%)	530	2,989,441	5,640
Нийт	**826**	**3,176,515**	**3,846**

Дээр дурьдсанаас үлдсэн тусгай зөвшөөрөл бүхий 530 газар нь тусгай хэрэгцээний газруудтай мөн л их хэмжээгээр давхцаж байна. (Хүснэгт 10). Эндээс үзэхэд 283 тохиолдолд тусгай зөвшөөрөл (≥99.5 хувь) нь тусгай хэрэгцээний газар дотор байв. Гэхдээ хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий болон Тусгай хэрэгцээний газруудын хоорондын их хэмжээний давхардлын 29 тохиолдолд бүгдэд нь Орон нутгийн ТХГН багтжээ. Үүнийг хоёр хүчин зүйлээр тайлбарлаж болох юм. **Нэгдүгээрт**, Улсын ТХГН-ийн 90 гаруй хувийг 2004 оны 1 сарын 1-ээс өмнө тогтоосон байхад тусгай зөвшөөрлийн 80-аас илүү хувийг үүнээс хойш олгосон байна. Энэ нь тэн хагасаас илүү хувь нь 2004 оны 1 сарын 1-ээс хойш тогтоогдсон Орон нутгийн ТХГН-тай зөрчилдөж байгаа юм.

Иймээс ихэнх (бараг бүгдэд нь) тохиолдолд хайгуулын тусгай зөвшөөрлийг давхцаж буй Орон нутгийн ТХГН байгуулахаас өмнө олгосон холбоотой. **Хоёрдугаарт**, 2008 оноос өмнөх Орон нутгийн ТХГН-ийн талаарх тоо баримт нэгдсэн байдлаар олдоогүй болно. Тухайлбал, орон нутгийн ТХГН-ийн полигоны хил хязгаарын тухай мэдээлэл олдоогүй ба саяхнаас л ГЗБГЗЗГ, Монгол дахь ДБХС болон Байгаль хамгаалах байгууллагаас хамтран уг мэдээлийг бүрдүүлэх оролдлого хийжээ. (ГЗБГЗЗГ болон ДБХС-ийн Монгол дахь хөтөлбөрийн газар, 2008).

Иймээс өнөөг хүртэл хайгуулын тусгай зөвшөөрөл олгохдоо Орон нутгийн ТХГН-ийг хамруулахгүйн тулд Ашигт малтмалын тухай хуулийн 19-р зүйлийн дагуу АМГТХЭГ-аас тусгай зөвшөөрлийн өргөдлийг хянаж олгохоос өмнө аймгийн засаг даргын тамгын газраар хянуулсан байх ёстой юм.

7.2. Уул уурхайн хайгуулын тусгай зөвшөөрөл олгогдсон болон байгалийн чухал нутгуудын хоорондын давхардлын үр дагавар

Монгол орны тусгай хамгаалалттай газрын тогтолцооны бараг 3,2 сая га газар нь улсын болон орон нутгийн төвшинд хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий талбайтай давхцаж байна. Эдгээр давхардлын ихэнх нь (асуудалтай байгаа хайгуулын талбайн 10 буюу түүнээс дээш хувь нь) Орон нутгийн ТХГН-ийг хамарчээ. Хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий болон шувуудад чухал газруудын хооронд 700000 га газрыг хамарсан томоохон давхардал байгаа бөгөөд шувуудад чухал газруудын сүлжээний дөрөвний нэгээс илүү хэсэг нь тусгай хамгаалалтгүй буюу эсвэл Орон нутгийн ТХГН гэж тогтоогдсонтой (саяхныг хүртэл уул уурхайн үйл ажиллагааны эсрэг зохистой хамгаалалттай газар болж чадаагүй) холбоотой юм.

Орон нутгийн ТХГН, шувуудад чухал газруудын хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий газартай давхардаж байгаагийн үр дагаварыг (болон зарим тохиолдолд хүрээлэн буй орчны онцгой ач холбогдолтой бусад ангиллууд) доорхи 4 төрөлд ангилан үзэж болох юм. Үүнд:

- Хайгуулын үйл ажиллагаанаас биологийн төрөл зүйлд учрах шууд нөлөө
- Хайгуулын үйл ажиллагаанаас үүдэн биологийн төрөл зүйлд учрах шууд бус нөлөө
- Хамгаалалттай газрыг байгуулахад учрах бэрхшээлүүд
- Хамгаалалттай газрыг хамгаалалтгүй болгоход чиглэсэн дарамт

зэрэг орно.

Эдгээр нөлөөллийг доор нэг бүрчлэн тайлбарласан болно. Түүнчлэн хайгуулын тусгай зөвшөөрөл олгогдсоор байгаа нь ирээдүйд байгалийн чухал нутгууд олборлолтын үйл ажиллагаанд хамрагдах эрсдэлтэйг илтгэж байна. Гэхдээ олгогдсон хайгуулын тусгай зөвшөөрлийн ихэнх нь ирээдүйд олборлолтын зөвшөөрөл болохгүй бөгөөд олборлолтын зөвшөөрөл болсон ч тэдгээр тусгай зөвшөөрлийн болон уул уурхайн шууд ул мөр зэрэг нь хайгуулын тусгай зөвшөөрлийн багахан хувийг эзлэх (Монголын олборлолтын талбайн голч 374 га байхад хайгуулын талбайн голч 11206 га байх жишээтэй) тул эрсдэл багатай юм.

Уул уурхайн хайгуулын үйл ажиллагаа байгалийн чухал нутгуудад шууд нөлөөлөх нь

Уул уурхайн үйл ажиллагаа нь биологийн төрөл зүйлд ямагт шууд болон шууд бус байдлаар нөлөөлдөг. Хамгийн хүчтэй нөлөө нь голдуу уул уурхайн үйл ажиллагааны үе шатанд илэрдэг боловч хайгуулын үеийн нөлөө томоохон газар нутгийг хамардаг учраас төдийлөн мэдрэгдэхгүй. Гэхдээ ашигт малтмалын хайгуулын үйл ажиллагаа нь эцсийн үе шатандаа хайгуулын бааз байгуулах, хайгуулын өрөмдлөгө хийх, боловсруулалтын үйлдвэр байгуулж зам харгуй тавихтай холбоотой байдаг тул томоохон хэмжээний дэд бүтэц бий болгохыг аяндаа шаарддаг. Эдгээр дэд бүтцийн биет ул мөр нь байгаль дахь амьдрах орчин сүйрч үгүй болоход нөлөөлдөг байхад дэд бүтцийн обьектуудыг барьж байгуулах явц, тэдгээрийн үйл ажиллагаа зэрэг нь амьтны аймагт муугаар нөлөөлдөг.

Тиймээс хайгуулын эцсийн үе шат хүртэл

биологийн төрөл зүйлд нөлөөлөх шууд нөлөөлөл тодийлөн мэдрэгдэхгүй. Урьд өмнө нь хүний үйл ажиллагаа огт нөлөөлөөгүй, хүн амын тархай бутархай суурьшил бүхий харьцангуй унаган төрхөөрөө байгаа газруудад хайгуулын судалгаа-туршилтын өрөмдлөгийн үе шатанд хайгуулын баг ажиллаж байгаа нь тэдгээр эмзэг газруудын экологийн тогтолцоонд дарамт учруулж эхэлдэг. Эдгээр дарамт нь газрын хөрсний ургамлан бүрхэвчийг машин техникээр талхлах зэргээр энгийн байдлаар илэрнэ. Түүнчлэн, хайгуулын багийг менежерүүд нь сайтар хянахгүй бол зэрлэг ан амьтны хулгайн агнуур нилээд газар авдаг бодит эрсдэл бий. Сибирийн тарвага *Marmota sibirica*, хар-сүүлт зээр *Gazella subgutturosa*, цагаан зээр *Procapra gutturosa,* саарал чоно *Canus lupus* зэрэг нь хулгайн анчдад олноор өртдөг амьтад. Байгаль хамгааллын менежментийн ажилтангүй газруудад эдгээр биологийн төрөл зүйлүүдэд аюул занал учрах нь олонтаа тохиолддог. Иймээс байгалийн нутгууд болон хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий газрууд давхардаж, түүнд Улсын болон Орон нутгийн ТХГН-ууд хамрагдсан тохиолдолд тухайн газрууд дээр үр ашигтай хамгааллын менежмент үгүйлэгдэж буйг харуулж байна.

Монголд уул уурхайн хайгуулын тусгай зөвшөөрөл олгох тогтолцооны нэг сул тал нь хайгуул хийсний дараа тухайн газрыг нөхөн сэргээх шаардлага тавьдаггүйд оршино. Үүний улмаас зарим аж ахуйн нэгжүүд замын ажил гүйцэтгээд, ландшафтыг сүйтгэсэн тохиолдлууд бий (Ханкок, 2008). Иймээс хууль, журмын хэрэгжилтийг хянан чангатгаж аж ахуйн нэгжүүд тухайн газрыг орхиж явсан ч уг газрын нөхөн сэргээлтийг хийх зардлыг хангалттай нөхөхүйц хэмжээний байгаль орчны барьцаат хөрөнгө байршуулахыг тэдгээрээс шаардах хэрэгтэй.

Уул уурхайн хайгуулын үйл ажиллагаа биологийн төрөл зүйлд дам нөлөөлөх нь

Энэ үйл ажиллагаа нь хайгуулын үйл ажиллаагаа явуулж буй аж ахуйн нэгжийн шууд бус ажилбартай холбоотой. Тухайлбал, уг компани тухайн газар нутаг дээр байрлаж байгаа нь л тэндхийн биологийн төрөл зүйлд шууд бус байдлаар нөлөөлөөд эхэлдэг. Хайгуулын ажлын явцад геологичид, тэдгээрийн туслах ажилтнууд зэрлэг ан амьтны гаралтай бүтээгдэхүүний /Жишээ нь ангийн мах/ зах зээлийн эрэлт хэрэгцээг хөөрөгдүүлсэнээр орон нутгийн ард иргэдийн ан агнуурын үйл ажиллагааг улам нэмэгдүүлдэг.

Гар аргаар олборлогчид нь бусад аж ахуйн нэгжүүдийн хайгуулын талбайг онцлон сонирхдог тул гар аргаар олборлолтын үйл ажиллагаа арилжааны уул уурхайн үйл ажиллагаатай шууд холбоотой байдаг тухай баримт олон байдаг. (Наутон, 2008). Тиймээс тухайн газарт хайгуулын үйл ажиллагаа явуулах, тэр газарт зөвхөн хайгуулын тусгай зөвшөөрөл олгосон зэрэг нь алт мэтийн ашигт малтмалын хойноос яваа гар аргаар олборлогчдыг тухайн газар руу олнооруу татагдах нөхцлийг бүрдүүлдэг. Гар аргаар олборлогч ард иргэдийн хоорондын мэдээллийн солилцоо маш сайн байдаг нь тэдгээр хүмүүсийг төрийн хяналтаас гадуур байж, шинэ нөхцөл боломжийг түргэн ашиглах нөхцлийг бүрдүүлдэг. Шороон ордын алтны олдворууд тухайн улсын өнцөг булан бүрээс ирэх гар аргаар олборлогчдыг ихээхэн татдаг (Наутон, 2008). Дараах хоёр нөхцөл бүрдсэн тохиолдолд гар аргаар ашигт малтмал олборлох үйл ажиллагаа газар авдаг. Үүнд:

Нэгдүгээрт: Товлож буй ашигт малтмал нь алт байх, Хоёрдугаарт: нөөц тогтоогдсон ч олборлолтын үйл ажиллагаа нь эдийн засгийн үр ашиггүйн улмаас тухайн компани уг газрыг орхиж явах тохиолдол.

Газар нутгийг Тусгай хамгаалалттай болгоход учрах бэрхшээл

Газар нутгийг орон нутгийн тусгай хамгаалалттай болгох нь Орон нутгийн / аймаг эсвэл сумын/ төвшинд албан ёсоор тогтоогддог хэдий ч ихэнх тохиолдолд тэдгээрийг хамгаалах орон нутгийн ард иргэдийн үр ашигтай менежмент байдаггүй ба тусгай хамгаалалттай газрын менежментийн тогтолцоо ч бүрдээгүй байдаг. Өнөөгийн байдлаар ихэнх Орон нутгийн ТХГН зөвхөн “цаасан дээр” орших бөгөөд бодит байдлаар байдаггүй. Өөр нэг чухал асуудал бол Орон нутгийн ТХГН-ийг тогтоохдоо биологийн ямар нэгэн цэгцтэй шалгуур баримтлаагүйн улмаас

тэдгээрийн зарим нь олон улсын, улсын, орон нутгийн ач холбогдол бүхий биологийн төрөл зүйлийг хамгаалахад дорвитой хувь нэмэр болдоггүй байна.

Хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий газрууд нь Орон нутгийн ТХГН-тай нийтдээ 3 сая га газар бүхий талбайгаар давхцаж байна. Эдгээр тохиолдлын тэн хагаст буюу 1436323 га газарт (нийт давхардлын 47 хувь) Орон нутгийн ТХГН-ийг хайгуулын тусгай зөвшөөрөл олгохоос өмнө тогтоожээ. Энэ тохиолдолд хайгуулын тусгай зөвшөөрөлд Орон нутгийн ТХГН-ийг оруулах нь 2006 оны Ашигт малтмалын тухай хуулийн 17-р зүйлийг зөрчиж байгаа бөгөөд хайгуулын тусгай хамгаалалт бүхий талбайн хил хязгаарыг Орон нутгийн ТХГН-тай давхардуулах явдлыг өөрчлөх шаардлагатай. Бусад тохиолдлуудад хайгуулын тусгай зөвшөөрлийн олголт нь орон нутгийн ТХНГ-ийг тогтоохоос өмнө хийгдсэн эсвэл, орон нутгийн ТХГН-ийг тогтоосон хугацаа нь тодорхойгүй (зарим тохиолдолд аймаг, сумын засаг захиргаа зориудаар хайгуулын тусгай зөвшөөрөл олгогдсоны дараа нэг буюу түүнээс дээш хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий талбайг хамран орон нутгийн ТХГН-ийг тогтоосон) байгаатай холбоотой. Хайгуулын тусгай зөвшөөрлийн олголт нь орон нутгийн ТХГН-ийг тогтоохоос өмнө болсон тохиолдолд хамгаалалттай газрын статус хэвээр байгаа ч Ашигт малтмалын тухай хуулийн 14-р зүйлийн дагуу орон нутгийн ТХГН байгуулах шийдвэр гаргасан эрх бүхий байгууллага тусгай зөвшөөрөл эзэмшигчид нөхөн төлбөр хийх учиртай юм.

Тусгай хамгаалалттай газрын дотор уул уурхайн аливаа гомдол нэхэмжлэл гарахаас сэрэмжлэн хөгжингүй орнуудад түгээмэл хэрэглэдэг арга бол тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд олгох шууд нөхөн төлбөр юм (Фарингтон, 2005). Гэвч эдгээр суурингуудын өртөг зардлыг нөхөх төсвийн хөрөнгө хомс тул аймаг, сумдын төсвийн хувьд Ашигт малтмалын тухай хуулийн 14-р зүйлийг амьдрал дээр хэрэгжүүлэхэд маш хүндрэлтэй. Иймээс орон нутгийн ТХГН-ийн 1,6 сая га газарт урьд өмнө олгогдсон хайгуулын тусгай зөвшөөрөл байгаа нь эдгээр газруудыг бодит байдлаар хамгаалахад үлэмж их саад бэрхшээл учруулж байна. Хайгуулын тусгай зөвшөөрөл тусгай хамгаалалттай газрын зөвхөн зарим хэсгийг хамарч байсан ч тусгай хамгаалалттай газрын байгууламжинд саад бэрхшээл учруулсаар байх болно. Иймээс сөрөг нөлөөнд өртсөн орон нутгийн ТХГН-ийн талбайн хэмжээ нь давхардсан хэмжээнээс ч илүү байж болзошгүй юм.

Тусгай хамгаалалттай газар болгох санал бүхий газрууд нь хайгуулын тусгай зөвшөөрөл хүсэгчдийн сонирхолыг ихээхэн татдаг байж магадгүй. (Фарингтон, 2005). Учир нь 6.2-р хэсэгт дурьдсан хуулийн цоорхойгоор тусгай хамгаалалтанд авах санал бүхий газруудад хайгуулын тусгай зөвшөөрөл олгохыг хориглоогүй байгаа юм.

Газар нутгийг Тусгай хамгаалалтаас чөлөөлөхөд чиглэсэн дарамт шахалт

Хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий болон тусгай хамгаалалттай газруудын давхардлын эцсийн үр дагавар бол газар нутгийг тусгай хамгаалалтаас чөлөөлөх дарам шахалт ихэсч, ашиглалтыг зөвшөөрөх үүднээс талбайн хэмжээг багасгахад нөлөөлдөг. 2002 оны дундуур АМГТХЭГ-аас хайгуул, олборлолтын ажилд хөрөнгө оруулалт татах зорилгоор Улсын Тусгай хамгаалалт бүхий 18 газрыг хамарсан 1,9 сая га газрын хамгаалалтын статусыг халах тухай санал оруулжээ. Харин БОЯ-аас 10 газрыг хамарсан 434000 га газрыг улсын тусгай хамгаалалтын статустай болгохыг санал болгожээ. Эдгээр хоёр саналыг Монголын Парламент дэмжээгүй (Дэлхийн банк, 2006). Үүний дараа 2003 онд уул уурхайн албан ёсны хайгуул, олборлолтыг зөвшөөрөх үүднээс Улсын ТХ-тай 4 газрыг хамарсан 3.1 сая га бүхий илүү их хэмжээний газрын хамгаалалттай статусыг халах саналыг засгийн газраас гаргажээ. Уг санал мөн л дэмжигдээгүй (Фарингтон, Дэлхийн банк, 2006) юм.

7.3. Олборлолтын тусгай зөвшөөрөл олгогдсон газрууд, байгалийн чухал нутгуудын хоорондын давхардлын дүн шинжилгээ

Газарзүйн мэдээллийн системийн дараагийн үе шатанд олборлолтын тусгай зөвшөөрөл бүхий (2008 оны 5 сарын байдлаар) болон байгалийн чухал нутгуудын хоорондын

давхардлыг судлах хэрэгтэй юм. Бид иймэрхүү давхардах хандлагыг 7.1-р хэсэгт үзүүлсэн бөгөөд байгалийн чухал нутгуудын ангилал бүрээр болон нэгдсэн байдлаар судалж үзэв.

Олборлолтын тусгай зөвшөөрөл бүхий 400000 га газрын 18006 га газар нь байгалийн чухал нутгуудтай давхцаж байна. Энэхүү судалгаагаар тогтоосон байгалийн чухал нутгуудын нэгдсэн багцын нэгээс ч бага хувийг дээрх давхардал төлөөлж байна (Хүснэгт 11, Газрын зураг 11). Хайгуулын тусгай зөвшөөрлийн нэгэн адил олборлолтын тусгай зөвшөөрлийн хувьд эдгээр тоо баримт нь байгалийн чухал нутгуудын төрөл бүрийн ангиллын ялгааг харуулж байна. Улсын ТХГН-тай 891 га газраар давхцаж байгаа ба 428 га газар нь Хангайн нурууны байгалийн цогцолборт газартай (1996 онд тогтоогдсон), 413 га газар нь Тосон хулстай байгалийн нөөц газартай (1998 онд тогтоогдсон) тус тус давхардсан байхад зарим нь газрын зургийн тэмдэглэлийн алдаатай холбоотой олон тооны бага хэмжээний давхардлууд ч байна. Улсын ТХГН-ийн нийт талбайтай харьцуулбал олборлолтын тусгай зөвшөөрөлтэй давхцах давхардлын хэмжээ бага байгаа нь Улсын ТХГН-ийн статус нь өнөөг хүртэл албан ёсны олборлолтын үйл ажиллагаанаас хамгаалах үр ашигтай арга хэрэгсэл болохыг харуулж байна. Зөвхөн Улсын ТХГН л олборлолтын тусгай зөвшөөрөлтэй нутгуудтай бага хэмжээгээр давхардаад байгаа хэрэг биш. Олон улсын хэмжээнд хамгаалагдсан газрын 18 га газар нь (газрын зургийн тэмдэглэлийн алдаа ч байж болох талтай), шувуудад чухал газрын 175 га газар, тахилага шүтлэгтэй газрууд хүртэл олборлолтын тусгай зөвшөөрөл бүхий талбайтай давхардаж байна.

Байгалийн чухал нутгуудын бусад ангилалтай харьцуулбал орон нутгийн ТХГН-тай давхцах давхардал харьцангуй их байгаа (Орон нутгийн ТХГ-ын сүлжээний зөвхөн нэг орчим хувь) юм. Олборлолтын тусгай зөвшөөрөл бүхий талбайд орон нутгийн ТХГН-ийн 157799 га газар хамрагдсан нь олборлолтын тусгай зөвшөөрөл бүхий болон байгалийн чухал нутгуудын давхардлын 99,9 хувьтай тэнцэж байна. Хайгуулын тусгай зөвшөөрлийн нэгэн адил орон нутгийн ТХГН-тай хамгийн их давхцаж байгаа нь саяхныг хүртэл АМГТХЭГ-ын Геологи, уул уурхайн кадастрын албанд Орон нутгийн ТХГН-ийн статус, байршлын тухай мэдээлэл байгаагүй, мөн Орон нутгийн ТХГН-ийн олонхи нь давхцаж буй олборлолтын тусгай зөвшөөрлийн олголтоос хойш тогтоогдсон зэрэг шалтгаантай холбоотой. Тухайлбал, Өмнөговь аймгийн Таван Толгойн орон нутгийн ТХГН нь 100609 га талбай бүхий зургаан нүүрсний ордтой давхцаж байна. Энэхүү талбай болон орон нутгийн ТХГН-тай давхцаж буй бусад газрыг тэдгээрийг тогтоосон орон нутгийн засаг захиргаа зориудаар олборлолтын газартай давхцуулсан гэж ойлгогдож байна.

Хүснэгт 11. Уул уурхайн олборлолтын тусгай зөвшөөрөл бүхий газрууд, байгалийн чухал нутгуудын давхардал

Байгалийн чухал нутгууд	Нийт талбай (га)	Хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий талбай (га)	Хайгуулын тусгай зөвшөөрлийн дунд эзлэх хувь
1. Улсын тусгай хамгаалалттай газар нутаг	22,413,136	891	0.004
2. Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг	16,531,505	157,799	0.955
3. Олон улсын хэмжээнд хамгаалагдсан газар	3,988,448	18	0.000
4. тахилага шүтлэгтэй газар	[47 газар]	[0 газар]	0.000
5. Шувуудад чухал газар	8,358,313	175	0.002
Нэгдсэн дүн	**40,327,615**	**158,006**	**0.392**

Тэмдэглэл: байгалийн чухал нутгуудын хоорондын давхардлын улмаас дээрх 5 ангиллын нийлбэр нь хүрээлэн буй орчны онцгой ач холбогдол бүхий газруудын нэгдсэн дүнгээс илүү байна.

Монгол орны хэмжээнд олборлолтын тусгай зөвшөөрөл нийтдээ 1066 байгаагийн 307 нь (29 хувь нь) байгалийн чухал нутгуудын нэг буюу түүнээс дээш нутагтай нь давхцаж байна. Эдгээр тусгай зөвшөөрлийн бараг ихэнхи нь (305 нь) орон нутгийн ТХГН (бараг бүх тохиолдолд) буюу Улсын ТХГН-тай (хэдхэн тохиолдолд) давхцаж байна. Тэдгээр нь тусгай хэрэгцээний газар тул Ашигт малтмалын тухай хуулийн 24-р зүйлийн дагуу тэнд олборлолт явуулахыг хориглосон байв. Энэ давхардал нь хоёр ангилалд хуваагдана. Үүнд: 1. бага хэмжээний давхардал (тусгай зөвшөөрөл бүхий газрын 10 хүрэхгүй хувь нэг буюу түүнээс дээш хамгаалалттай газартай давхардаж байгаа), 2. Их хэмжээний давхардал (тусгай зөвшөөрөл бүхий газрын 10 буюу түүнээс дээш хувь нэг буюу түүнээс дээш хамгаалалттай газартай давхардаж байгаа) юм.

Олборлолтын тусгай зөвшөөрөл бүхий газрууд, тусгай хэрэгцээний газрын хоорондын давхардлын 11 хувь (33 тусгай зөвшөөрөл) нь бага хэмжээтэй байна (Хүснэгт 12).

Харин ихэнх хэсэгт олборлолтын үйл ажиллагааг тусгай хэрэгцээний газарт явуулахыг хориглосон Ашигт малтмалын тухай хуулийн 24-р зүйлийг зөрчсөн тул бодит давхардал гэж тооцох үндэстэй. Тусгай хэрэгцээний газартай давхардаж буй үлдсэн 272 олборлолтын тусгай зөвшөөрөл бүхий газрын хувьд ихээхэн давхардал байгаа ба 222 тохиолдолд тусгай зөвшөөрөл бүхэлдээ (≥99.5 percent) тусгай хэрэгцээний газрын дотор байна.

Хүснэгт 12. Уул уурхайн олборлолтын тусгай зөвшөөрөл бүхий газар, тусгай хэрэгцээний газруудын давхардал

Давхардлын төрөл	Тусгай зөшөөрлийн тоо	Давхардлын нийт талбайн хэмжээ (га)	Давхардлын голч талбай (га)
Бага хэмжээнийl (<10%)	33	2,328	68
Үлэмж хэмжээний (≥10%)	272	155,523	570
Нийт	**305**	**157,850**	**514**

Олборлолтын тусгай зөвшөөрлийг чухалчилдаг хоёр төрлийн ашигт малтмалын хувьд (алт болон нүүрс) олборлолтын тусгай зөвшөөрөл бүхий болон байгалийн чухал нутгуудын давхардал нийт давхардлын 90-ээс дээш хувийг эзэлдэг (Зураг 9). Байгалийн чухал нутгуудтай давхцаж буй тохиолдлын хамгийн их нь алт (148) ба эзэлж буй талбайн хувьд нүүрс тэргүүлж (117873 га) байна. Үүний учир нь нүүрс олборлолтын газрын талбай нь алтныхаас тав дахин их байдагтай холбоотой (Хүснэгт 8) ба эдгээр металлыг хамарсан давхардлын хэмжээний ялгаанд энэ нь илэрхий харагдаж байна. (нүүрсний голч нь 1684 га байхад алтных 183 га байна).

Байгалийн чухал нутгуудтай давхардаж буй олборлолтын бусад тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн товлож буй ашигт малтмалын тоонд хүдэр, холимог металл, барилгын материал, цагаан тугалаг, цахиур болон жонш орно. (Хүснэгт 13). Хүснэгт 13-аас үзэхэд эдгээр металл бүрт улсын хэмжээний нийт давхардал нэг буюу хоёр мянган га газар байна. Олборлолтын тусгай зөвшөөрөлд хамрагдсан Монгол орны газар нутгийн ихээхэн хэсгийг зэс болон вольфрамын талбай байгалийн чухал нутгуудтай огт давхцаагүй байгаа нь тэмдэглүүштэй. Зэсийн тохиолдол бол бүр ч сонирхолтой бөгөөд зэс нь алт, нүүрсний дараа Монголын уул уурхайд хамгийн том хувь нэмэр оруулдаг

ашигт малтмал юм (Хүснэгт 8). Үүний учир нь хоёр жижиг хэмжээний газраас (Дорноговь болон Хэнтий аймгууд) бусдад нь зэсийн олборлолтын талбай харьцангуй том ба байгалийн чухал нутгуудын гадна хоёр өөр газарт байршилтай юм. (Орхон аймгийн Эрдэнэт болон Өмнөговь аймгийн Оюу Толгой).

Зураг 9. Уул уурхайн олборлолтын тусгай зөвшөөрөл газрууд, байгалийн чухал нутгуудын хоорондын давхардал (Товлож буй ашигт малтмалын төрлөөр)



Хүснэгт 13. Уул уурхайн олборлолтын тусгай зөвшөөрөл бүхий газрууд, байгалийн чухал нутгуудын давхардал (Товлож буй ашигт малтмалын төрлөөр)

Товлож буй ашигт малтмал	Тусгай зөвшөөр-лийн дугаар	Давхардлын талбай (га)	Нийт талбайд давхардсан талбайн эзлэх хувь	Олборлолтын талбайн голч (га)
Нүүрс	70	117,873	74.6	1,684
Алт	148	27,116	17.2	183
Төмрийн хүдэр	8	2,795	1.8	349
Холимог метал	3	1,747	1.1	582
Барилгын материал	36	1,323	0.8	37
Цагаан тугалаг	1	1,280	0.8	1,280
Цинк	4	1,124	0.7	281
Жонш	17	1,014	0.6	60
Фосфат	4	745	0.5	186
Уран	1	264	0.2	264
Молибден	2	202	0.1	101
Давс	4	151	0.1	38
Алабастер	1	40	0.0	40
Бусад	5	2,036	1.3	407
Үл мэдэгдэх	3	296	0.2	99
Нийт	307	158,006	100	515

7.4. Уул уурхайн олборлолтын тусгай зөвшөөрөл бүхий газрууд байгалийн чухал нутгуудтай давхардсаны үр дагавар

Олборлолтын тусгай зөвшөөрөл бүхий газрууд болон байгалийн чухал нутгуудын давхардлын үр дагаврын талаар зайлшгүй дурьдах нэг зүйл бол олборлолтын тусгай зөвшөөрөл нь олборлох үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл авсан аж ахуйн нэгжийн тоог илтгэж байгаа явдал юм. Гэвч тэдгээрийн зөвхөн хэдхэн нь л өнөөгийн байдлаар идэвхитэй олборлолтын үйл ажиллагаа явуулж байна. Үлдсэн хэсэг нь хэд хэдэн учир шалтгааны улмаас одоогоор олборлолт явуулахгүй байгаа юм. Тэдгээр аж ахуйн нэгжийн зарим нь засгийн газартай хөрөнгөоруулалтынгэрээбайгуулахшатандаа явж байна. Зарим нь шаардлагатай хөрөнгө оруулалтад шаардагдах санхүүжилтээ баталгаажуулж байна. Түүгээрч барахгүй зарим нэг нь дампуурсан байна. 2008 оны 1 сарын 28-нд Улаанбаатарт зохиогдсон “Уул уурхайн ашиглалтын тусгай зөвшөөрөл олгоход иргэдийн оролцоо” сэдэвт уулзалтын үеэр явагдсан “хариуцлагатай уул уурхай, нөөц ашиглалтын цуврал хэлэлцүүлэг”-ийн явцад одоогоор тусгай зөвшөөрөл авсан 300 аж ахуйн нэгжийн зөвхөн 70 нь идэвхитэй олборлолт явуулж байгаа нь тогтоогджээ. Иймээс өнөөгийн байдлаар тодорхой байршлын хувьд уул уурхай ихээхэн нөлөөтэй ч байгалийн чухал нутгуудад хараахан нөлөөлөөгүй ч цаашид нөлөөлөх магадлал өндөр байна. Гэхдээ зүй зохистой хамгаалалт, үр нөлөөллийг намжаах болон нөхөн сэргээх арга хэмжээг авахгүй бол уул уурхайн салбарын өсөлт нь байгалийн чухал нутгуудад нөлөөлөх эрсдэл өндөр байгаа юм.

Байгалийн чухал нутгууд дахь олборлолтын үйл ажиллагааны нөлөөлөлд өртөх талбайн хэмжээ нь хайгуулын үйл ажиллагаатай харьцуулбал бага байдаг боловч үзүүлэх нөлөө нь их байдаг. Бага хэмжээний давхардлыг эс тооцвол олборлолтын тусгай зөвшөөрөл бүхий газрууд болон байгалийн чухал нутгуудын давхардлын хэмжээ нь (570га), хайгуулын тусгай зөвшөөрөлтэй талбай болон байгалийн чухал нутгуудын давхардлын хэмжээний (5640га) аравны нэгтэй тэнцэж байна. Гэвч олборлолтын талбайн биологийн төрөл зүйлд нөлөөлөх нөлөө нь хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий талбайтай харьцуулбал үлэмж их. Олборлолтын үйл ажиллагаатай холбоотой шууд нөлөөлөлд усны бохирдол (хаягдлаа голын усанд хаях, хүчлийн чулуун өрөмдөлт хийх, мөнгөн ус хэрэглэх зэрэг), агаарын бохирдол (тоос, хайлуулах үйлдвэрийн хийн ялгаралт г м) болон амьдрах орчны сүйрэл (жишээ нь хайгуулын өрөмдөлт, хөрс талхлалтын зурвас үүсэх болон бохирдсон үлдэц үлдэх) зэрэг нөлөөнүүд багтана. Гэхдээ олборлолтын үйл ажиллагаанаас үүдэх амьдрах орчны сүйрэл нь гол төлөв орон нутгийн түвшинд ул мөрөө үлдээдэг тул бусад салбарын (хөдөө аж ахуй болон ойн аж ахуй) хөгжлийн чанартай үйл ажиллагааны улмаас цаашдаа багасах хандлагатай байдаг. Монгол орны хувьд гүнийн болон гадаргын усанд орж буй өөрчлөлт (уурхайн хэрэгцээнд ус ашиглах, ашигт малтмалын баяжуулалт болон нүүрс угаах зэрэг) нь шууд ноцтой нөлөөлдөг ба ялангуяа ургамлын хувьд гүнийн ус, зэрлэг ан амьтны хувьд орон нутгийн эфемерал гадаргын усны нөөцөөс хамаарах үзэгдэл хуурай болон хуурайдуу орчинд ихээхэн ажиглагддаг. Эдгээр өөрчлөлт нь уур амьсгалын өөрчлөлтөөр дамжин гидрологийн өөрчлөлтийг ч бий болгосон нь ойрын ирээдүйд экосистемд ихээхэн дарамт үзүүлэх болно. Газрын хөрс талхлалт болон ан агнуур зэрэг бусад аюул хөнөөлөөс хамгаалах хамгааллын аргуудыг хослуулсан нөхцөлд байгалийн чухал нутгуудын бүрэн бүтэн байдлыг хадгалах зорилгод харшлахгүй, зохистой байдлаар явагдах олборлолтын үйл ажиллагаа ч бас бий. Газар доорх олборлолтын үйл ажиллагаа нь хөрсөнд бага нөлөөлдөг. Ялангуяа ашигт малтмалын баяжуулалтын болон бохирдсон нуур цөөрмийн төхөөрөмжүүд, ажилчдын байрлах байр зэрэг нь нөлөөлдөг. Эдгээр нөлөөг багасгахын тулд байгалийн чухал нутгуудийг бий болгохоос гадна газрын гадаргын дэд бүтэц байгуулах шаардлагатай байдаг.

Байгалийн чухал нутгуудыг ихээхэн өөрчлөх буюу доройтуулахад төдийлөн

нөлөөлөхөөргүй олборлолтын үйл ажиллагаа нь /YAX 4.04-ийн дагуу/ Дэлхийн банкны зүгээс амьдрах орчны талаар баримтлах бодлогод ницэж байгаа юм.

Байгалийн чухал нутгууд болон олборлолтын тусгай зөвшөөрөл бүхий газруудын давхардлын үр дагавар нь 3 гол хүчин зүйлээр тодорхойлогдоно. Үүнд:

(I) Тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгжийн байгаль орчны үйл ажиллагаа

(II) Товлож буй ашигт малтмалын шинж чанар

(III) Нөлөөлөлд өртсөн экосистемийн мэдрэмтгий байдал

Энэ судалгаагаар эхний хүчин зүйлийг нарийвчлан тайлбарлахыг зорьсонгүй. Гэхдээ уурхайн үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгжүүд нь байгалийн чухал нутгуудад нөхөн сэргээх, биологийн төрөл зүйлийг нөхөн сэргээх, болзошгүй сөрөг нөлөөллөөс хэрхэн зайлсхийх, түүнийг багасгах талаар сайн ажилласан байх нь чухал. Дэлхийн банкны сүүлийн үед гаргасан тайланд (2006 он, хуудас 1) “Монголын уул уурхайн салбарын байгаль орчны нөлөөллийн үнэлгээний байдал маш бүрхэг дүр зурагтай байна. Тэдгээрийн байгаль орчны ихэнх үйл ажиллагаа нь байгаль орчныг ихээхэн доройтуулах, үйлдвэрлэлийн алдагдлыг бий болгохуйц менежменттэй байна” гэж тэмдэглэжээ. Санхүүгийн боломж хязгаарлагдмал, хуучирсан технологи ашигладаг уурхайнуудын үйл ажиллагаа нь ихээхэн хэмжээний үнэтэй бүтээгдэхүүнийг ашиглаж чадахгүй орхидогийн зэрэгцээ тухайн газарт олборлох ажлыг дахин дахин хийхэд хүргэж, байгаль орчны нөхөн сэргээлтийг орхигдуулах, үлдэгдэл хэсэгт гар аргаар олборлогчдыг олноор татахад нөлөөлдөг (Азийн сан, 2007) талтай. Иймэрхүү бүрхэг дүр зургаас гадна Монголд олноор ирж буй гадаадын хөрөнгө оруулалт бүхий компаниудын тоо нэмэгдэж байгаа нь тухайн салбарын стандарт сайжрах нөхцлийг бүрдүүлж байна. Эдгээр компаний зарим нь ОУУУМЗ-ийн гишүүн бөгөөд компани бүрийн үйл ажиллагааг тоон үзүүлэлтүүдээр үнэлж дүгнэдэг, уул уурхай болон биологийн төрөл зүйлийн чиглэлээр хамгийн сайн хөтөч байхаар (ОУУУМЗ, 2006) гарын үсгээ хүртэл зурсан байна.

Зарим тохиолдолд товлож буй металлыг ашигласны үр дагавар нь уг уурхайн байгуулагдан ажиллаж байгаа экологийн тодорхой нөхцөлтэй холбоотой болох нь уул уурхайн биологийн төрөл зүйлд шууд нөлөөлөх байдлаас харагдаж байдаг. Жишээ нь, Усыг ихээр хэрэглэж (нүүрс угаах) олборлолтын үйл ажиллагаа явуулдаг уурхайн хувьд усны нөөц арвинтай тайгын экосистемийг бодвол усны нөөц багатай цөлийн экосистемд ихээхэн нөлөөлнө. Монгол орны ашигт малтмалын төрлүүдийг ашигласны улмаас үүдэн гарсан гол үр дагаврын тухай доор өгүүлэв.

Алт, зэс, молибден, төмрийн хүдэр, цайр, мөнгө, уран, тугалга болон “холимог металл”

- Эдгээр металлуудыг гарган авдаг чулуу нь хүчлийн чулуун өрөмдлөгийн нөлөөлөлтэй байж болзошгүй. Иймээс эрчимтэй, урт хугацааны усан сэргээлтийн менежмент шаардагдана. Сүүлийн үеийн судалгаагаар Эрдэнэт мэтийн ус цөөрөм нь бохирдож буй газруудад хүчлийн чулуун өрөмдлөгө нилээд анхаарал татах зүйл болж байна (Дэлхийн банк, 2006). Томоохон гол, нууранд хаягдал ялгаруулдаг уурхайнууд тул загас (*Hucho taimen)* болон усанд амьдардаг бусад төрөл зүйлийн амьтдад аюул учруулж байна.
- Металлургийн боловсруулалтын улмаас дээр дурьдсан ихэнх металлууд бохирдуулах нөлөө ихтэй. Тухайлбал, Зэс нь алт болон бусад металлтай харьцангуйгаар их бохирдуулах нөлөөтэй металл юм. Дэлхийн бусад оронд их хэмжээний хаягдлыг усанд хаядаг практикийг ихээхэн шүүмжилж байна. Монголын хувьд ч голын ус бохирдож байгаа нь усны нөөцийн ашиглалтад сөргөөр нөлөөлж байгаа юм.
- Зэс болон бусад үндсэн металлын хатуу хаягдал ч ихээхэн нөлөө үзүүлдэг. Монголд арилжааны олборлолтын үйл ажиллагааны улмаас гарч буй хатуу хаягдал гол төлөв тогтворгүй тул идэмхий чанартай (Дэлхийн банк 2006). Хур

тунадас ихээр буусан нөхцөлд хайрга, хөрсийг ихээр урсган голын хөндийн болон хуурай газрын гадаргын биологийн төрөл зүйлд сөргөөр нөлөөлдөг.

- Алтны уурхайн хувьд гар аргаар олборлохтой холбоотой олон төрлийн байгаль орчны хүндрэл бэрхшээлүүд үүсдэг. Эдгээрийн хамгийн эхнийх нь гэхэд л Монголын чулуун ордыг гар аргаар олборлох явдал түгээмэл байхад, шороон орд олборлогчид нь мөнгөн ус ашиглаж байгаа практикийг дурьдаж болох юм. (Дэлхийн банк. 2006). Судалгаанаас үзэхэд гар аргаар олборлогчид мөнгөн усаар бохирдсон шороогоо цианитаар боловсруулдагбайна(Наутон,2008).Харин арилжааны алт олборлолтын тохиолдолд шороон ордод хайрганы аргыг гол төлөв хэрэглэдэг байна. Цианит ашигласан нөхцөлд уг үйл явцыг зохицуулах шаардлагатай ба зохицуулж ч болдог. Алтны хүдрийн чанараас шалтгаалан хуримтлагдах хаягдал мэдэгдэхүйц их хэмжээтэй байж ч болзошгүй.
- Зэсийн уурхайтай холбоотой хайлуулах төхөөрөмж болон төмрийн хүдрийн уурхайтай холбоотой төмрийн үйлдвэрээс ялгаруулж буй агаарын хийн стандарт сул байгаагаас холбогдох газруудад хүчлийн бороо буюу ойн доройтол явагдаж болзошгүй.
- Ураны хувьд цацраг идэвхт бодис ялгарахын зэрэгцээ ураны хатуу хүдэр боловсруулах үйл явц мөн л ихээхэн хэмжээний бохирдлыг буй болгодог.
- Молибденийг ихэвчлэн зэсийн олборлолттой хамт хийдэг ба цөөн тохиолдолд тусад нь боловсруулдаг.
- Дээрх металлын боловруулалт нь бүгдээрээ усыг ихээр хэрэглэдэг. Усыг металлург, хаягдлыг устгаж баяжуулсан металлыг тээвэрлэхэд ашигладаг. Уул уурхайн өнөөгийн практик нь усны хувьд үр ашиг муутай, хэт их хэрэглээ бүхий үйл явц болох нь тогтоогдсон ба иймээс хөрсний болон гадаргын усанд муугаар нөлөөлж байгаа юм. Жишээ нь Эрдэнэтийн зэсийн үйлдвэрт цаг тутам 80 куб метр цэнгэг усыг зэсийн концентрат угаахад хэрэглэдэг байна (Дэлхийн банк, 2006). Тиймээс хуурай болон хуурайсаг газруудад усны зүй зохистой менежмент явуулах, усыг дахин хэрэглэх нэн шаардлагатай байна.

Нүүрс

- Нүүрсний олборлолтын талбай нь байгалийн чухал нутгуудтай давхцах явдал хамгийн түгээмэл байна /7.3-аас үзнэ үү/.
- Удаан хугацаагаар ашиглагдаж буй нүүрсний уурхайнуудад хүчлийн хатуу өрөмдлөгө нилээд асуудал үүсгэдэг. Гэвч нүүрсийг үечлэн авах, мөн цаг тухайд хийх нөхөн сэлгэлт хийх зэрэг нь богино хугацаанд сульфид ялгаруулалтыг багасгаж шинээр исэлдэлт явагдахаас нь өмнө хуучин исэлдсэн чулууг булах нөхцлийг бүрдүүлдэг. Олборлолтыг өрөмдлөгийн дэргэд явуулж буй нөхцөлд хүчлийн хатуу өрөмдлөгийг бодууштай юм.
- Нөхөн сэргээх хамгийн сайн практикийг хэрэглээгүй тохиолдолд нүүрсний олборлолт нь томоохон ул мөр үлдээх магадлал өндөр. Энэ судалгааны явцад цуглуулсан тоо баримтаас үзвэл Монголд зэсээс бусад металлтай харьцуулахад нүүрсний уурхайн хэмжээ нилээд томд тооцогдоно.
- Нүүрс олборлогчид тээвэрлэхээс өмнө нүүрсээ угаахад маш их хэмжээний ус зарцуулдаг. Хуурай болон хуурайсаг бүс нутагт энэ нь газрын гадаргын усны нөөцөд сөргөөр нөлөөлдөг.

Фосфат

- Фосфат олборлолтын биологийн төрөл зүйлд үзүүлэх нөлөө нь фосфатаар бохирдсоны улмаас өрөмдсөн цооногт үүсэх эутрофикацийн үзэгдлээр илэрнэ.

Барилгын материал, хайрга, шохой болон алабастер

- Ерөнхийдөө эдгээр ашигт малтмал бол идэвхгүй бөгөөд хатуу хаягдлын хувьд химийн хортой бодисыг бага зэрэг ялгаруулна. Эдгээр ашигт малтмалын биологийн төрөл зүйлд нөлөөлөх нөлөө

нь гол төлөв уурхайн ул мөр, дэд бүтэцтэй холбоотой юм.

Жонш

- Жоншийг ихэвчлэн бусад металлын хүдрээс гаралтай дайвар бүтээгдэхүүн гэдэг. Гэхдээ Монголд түүнийг тусад нь олборлодог. Ихээхэн хэмжээгээр олборлосон нөхцөлд жоншны уурхайнууд орон нутгийн хүчлийн хатуу өрөмдлөгийн нөлөөллийг ихэсгэнэ.

Монгол орны биологийн төрөл зүйлд устай холбоотой шууд нөлөөлөл томоохон байр эзэлдэг. Хуурай болон хуурайдуу экосистемд хөрсний ус ашиглах асуудал нилээд хүндрэлтэй бөгөөд энэ нь ялангуяа өнөөгийн уур амьсгалын өөрчлөлтөөс үүдсэн хуурайшлын нөхцөлд зэрлэг ан амьтны ундаалах усны нөөцөд ихээхэн нөлөөлнө. Ер нь гидрологийн нөөцийг сайтар судалж, тэдгээрийн тогтвортой ашиглалтын төвшинг тогтоож үнэлгээ өгөх шаардлагатай. Усны нөөц арвинтай хойд хэсгийн нутгуудад усны бохирдол сэтгэл зовоож болзошгүй юм. Иймээс хүчлийн хатуу өрөмдлөгө болон хаягдлын менежментийг сайжруулах шаардлагатай байна.

7.5 Уул уурхайтай холбоотой дэд бүтэц, байгалийн чухал нутгуудын давхардлын дүн шинжилгээ

Энэ судалгааны явцад газарзүйн мэдээллийн системийн 3 дахь үе шатанд төлөвлөж буй дэд бүтцийн төслүүд болон байгалийн чухал нутгуудын давхардлыг судлах зорилготой байв. Дэд бүтцийн төслүүд нь суурин байгуулах газруудыг тэр болгон тодорхой дурьддаггүй ба зам харгуй тавих газрыг төдийлөн нарийн заадаггүй тул үндэсний төвшинд дэд бүтцийн төлөвлөсөн төслүүдийн байгалийн чухал нутгуудад үзүүлэх болзошгүй нөлөөллийг судлахад амаргүй. Монголын дэд бүтцийг хөгжүүлэх үндэсний хэмжээний ихэнх төлөвлөгөөнд тодорхой асуудлыг тэр болгон тусгадаггүй ба эсвэл маш ерөнхий байдлаар тусгадаг. Иймээс энэхүү судалгааны явцад байгалийн чухал нутгуудтай дэд бүтцийн давхардлыг тогтоох чанартай төслүүдийг тодорхой ойлголт өгөхүйц төвшинд дурьдах боломжгүй байлаа.

Ийм учраас энд дурьдсан дүн шинжилгээнд зөвхөн олборлолттой холбоотой дэд бүтцийг хамруулсан болно. Өөрөөр хэлбэл нарийвчлан тогтоох боломжтой олборлолтын тусгай зөвшөөрөл бүхий газруудын байршил үүнд нөлөөлсөн болно. Уул уурхайн салбарын огцом өсөлт, шинээр байгуулагдах уурхайнуудад шаардагдах дэд бүтцийн хэрэгцээ, онгон зэлүүд газруудад уурхай байгуулах зэргээс үүдэн байгалийн чухал нутгуудад ихээхэн сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай.

Ирэх 10 жилд биологийн төрөл зүйлд хамгийн их нөлөөлөх магадлал бүхий дэд бүтцийн хөгжлийн төслүүдийн ихэнх хувийг олборлолттой холбоотой дэд бүтэц эзлэх төлөвтэй бөгөөд тодорхой хэд хэдэн хэрэгцээ шаардлагыг тодорхойлсон хэдий ч дэд бүтцийн гол төслүүдийн (зам харгуй, төмөр зам г.м.) байршлыг тогтох талаар шийдвэр гараагүй байна. Иймээс уул уурхайтай холбоотой дэд бүтэц болон байгалийн чухал нутгуудын давхардах магадлалыг үнэлж дүгнэхдээ дам аргуудыг хэрэглэв. Тухайлбал, доорх дурьдсан нөхцлүүдэд байгалийн чухал нутгууд уул уурхайтай холбоотой дэд бүтцийн нөлөөнд шууд ба дам байдлаар өртөгдөх эрсдэл өндөр гэж тооцогдоно. Үүнд:

Нэгдүгээрт, нэг буюу түүнээс дээш олборлолтын тусгай зөвшөөрөл бүхий газартай давхардах **Хоёрдугаарт**, олборлолтын нэг ч тусгай зөвшөөрөл бүхий газартай давхцаагүй атлаа тусгай зөвшөөрөл бүхий нэг буюу түүнээс дээш тооны газраас 20 км зайд орших[2].

Энэхүү судалгаагаар хайгуулын тусгай зөвшөөрөлтэй давхардах буюу ойролцоо орших байгалnay чухал нутгуудыг тодорхойлоогүй болно. Үүний учир нь хайгуулын тусгай зөвшөөрөл олборлолтын үе шатанд хамаагүй (ихэвчлэн эдийн засгийн

[2] *20 км зайг босго болгон сонгосны учир нь байгалийн чухал нутгуудын (12,3 км диаметртэй тойрогт орших 474 хавтгай дөрвөлжин км талбай) 20 км-ын зайнд (радиусаар 126 км тайлбай бүхий тойрогтой огтолцох талбай) орших шулуун шугамын дэд бүтцийн нэгж обьектэй огтолцох магадлал 20 хувь юм.*

хувьд үр ашиг бүхий ашигт малтмалыг тогтоож чадаагүй зэрэг хэд хэдэн учир шалтгааны улмаас) бөгөөд байгалийн чухал нутгуудыг хамрах буюу тэдгээртэй ойролцоо газруудад уурхайтай холбоотой дэд бүтэц баригдах эрсдэлийг илтгэдэггүйтэй холбоотой юм.

Байгалийн чухал нутгуудын зөвхөн 158006 га газарт нь олборлолтын тусгай зөвшөөрөл бүхий газрууд байршиж байгаа бөгөөд эдгээрийн ихэнх нь орон нутгийн ТХГН-т байдаг юм /7.3-аас үзнэ үү/. Гэхдээ 6521266 га газар нь нэг буюу түүнээс дээш тооны олборлолтын газрын ойр орчмын 20 км-т оршиж, энэ нь нийтдээ 6679272 га газрыг уурхайтай холбоотой дэд бүтцийн нөлөөнд өртөгдөх эрсдэлийг бүрдүүлжээ. (Хүснэгт 14, Газрын зураг 12).

Энэ нь Монгол орны байгалийн чухал нутгуудын нэгдсэн дүнгийн 16 хувьтай тэнцэнэ. Түүнчлэн тахилага шүтлэгтэй 11 газар нь нэг буюу түүнээс дээш олборлолтын тусгай зөвшөөрөлтэй талбайн ойр орчмын 20 км зайд оршиж байна.

Хүснэгт 14-т харуулсан дүн шинжилгээнд уурхайн улмаас ихээхэн хэмжээний нөлөөлөлд автах магадлал багатай байгалийн чухал нутгууд байхад (тухайлбал Улсын ТХГН, Олон улсын хэмжээнд хамгаалагдсан газар ба шувуудад чухал газрууд), ангилал бүрт уурхайн холбоотой дэд бүтцийн сөрөг нөлөөнд автах эрсдэл бүхий тодорхой газрууд байна. Нөлөөлөлд автах эрсдэл гэдэг нь бодит нөлөөлөл гэсэн үг биш ба учир нь эрсдлээс зайлсхийж болдог (дэд бүтцийн төслийг нарийн төлөвлөж байршуулсан нөхцөлд) буюу зайлшгүй эрсдэлийг намжаах замаар багасгаж болдог юм.

Хүснэгт 14. Уул уурхайтай холбоотой дэд бүтцийн сөрөг нөлөөнд өртөгдөх эрсдэл бүхий байгалийн чухал нутгууд

Байгалийн чухал нутгууд	Нийт талбай (га)	Хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий талбай (га)	Хайгуулын тусгай зөвшөөрлийн дунд эзлэх хувь
1. Улсын тусгай хамгаалалттай газар нутаг	891	1,479,779	1,480,670
2. Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг	157,799	4,731,877	4,889,676
3. Олон улсын хэмжээнд хамгаалагдсан газар	18	295,306	295,324
4. тахилага шүтлэгтэй газар	[0 газар]	[11 газар]	[11 газар]
5. Шувуудад чухал газрууд	175	874,330	874,505
Нийт багц	**158,006**	**6,521,266**	**6,679,272**

Тэмдэглэл:Байгалийн чухал нутгуудын хоорондын давхардлын улмаас дээрх 5 ангиллын нийлбэр нь байгалийн чухал нутгуудын нэгдсэн дүнгээс илүү байна.

7.6 Уул уурхайтай холбоотой дэд бүтэц, байгалийн чухал нутгуудын давхардлын үр дагавар

Монголын хувьд байгалийн чухал нутгуудад уул уурхайн салбарын өсөлтөөс үүдэлтэй дэд бүтцийн хөгжлийн нөлөө хамгийн ихээр нөлөөлөх магадлалтай. Өмнөговь аймгийн Таван Толгойн ордын жишээнээс үзвэл: уг орд 5 тэрбум орчим тонн коксжсон нүүрстэй боловч түүнтэй хамгийн ойрхон төмөр зам 400км зайд оршдог. Таван толгой шиг ордыг ашиглахад урьд өмнө хүний хөл хүрээгүй газруудад томоохон дэд бүтцийн хөрөнгө оруулалт хийх шаардлагатай. Шууд болон дам нөлөөллийн магадлал аль ч тохиолдолд их байна.

Байгалийн чухал нутгуудтай давхацсан нөхцөлд шулуун шугаман дэд бүтэц нь байгалийн чухал нутгуудын доройтлыг бий болгодог. Жишээ нь: Газрын менежментийн

үндэсний мастер төлөвлөгөөнд хамааралтай газар нутагтай огтолцох санал болгож буй төмөр замын барилгын ажил явагдах 4 аймгийг тодорхойлжээ. Үүнд: Баян-Өлгийд 7.5 км, Ховдод 25 км, Булганд 0,6 км ба Өмнөговьд 125,8 км (ГЗБГЗЗГ, 2003). Шулуун шугаман дэд бүтэц, нэн ялангуяа зам харгуй болон төмөр зам зэрлэг ан амьтны шилжилт хөдөлгөөнд саад болдог. Томоохон өргөн уудам газар нутагт тархай бутархай байршсан хүн, мал бүхий Монгол шиг орны хувьд зүй зохистой бус байдлаар байршуулсан шулуун шугаман бүтэц нь зэрлэг ан амьтны орчныг сүйтгэх нөлөөтэй. Жишээ нь, Ито (2005) сансарын хиймэл дагуулын мэдээг ашиглан Монгол орны цагаан зээр (*Procapra gutturosa)*–д олон улсын төмөр замын болзошгүй нөлөөг судалсан байна. Ажиглалтад байсан хар-сүүлт зээр төмөр замын нөгөө хэсэгт илүү үржил шим бүхий орчин байсан ч төмөр замын дагуу л шилжих хөдөлгөөн хийж, харин төмөр замыг давж гарахгүй байгааг судалгаагаар тогтоожээ. Төмөр зам нь байгалийн чухал нутгуудыг хуваж байгаа тул хар-сүүлт зээрийн шилжин байршихад төмөр зам хаалт саад болж байгааг тэд тогтоожээ. Мал сүрэг нэвтрэхээс сэргийлж барьсан төмөр утсан хашаа нь зэрлэг ан амьтны чөлөөтэй шилжин байрших нөхцлийг саатуулах хүчин зүйл болж байна. Шулуун шугаман дэд бүтэц нь түүнчлэн зэрлэг ан амьтны тайван бус байдлыг нэмэгдүүлж нөхөн үржихүйд сөргөөр нөлөөлөн улмаар эндэгдлийг ихэсгэдэг байна. Жишээ нь, цахилгаан дамжуулах шугам байгуулсан нь үржлийн шувуудад муугаар нөлөөлдөг тул дэлхий даяар устах аюулд өртсөн жороо тоодог (*Chlamydotis undulata)*-т онцгой аюул учруулж байна. Дэд бүтцийн барилга байгууламжаас болж зарим мөн ан амьтад хоорондоо мөргөлдөх явдал ч гардаг. Цахилгаан дамжуулах шугам болон салхин сэнстэй мөргөлдсөн тохиолдол тогоруу (Grus spp.,), махчин шувууд, хонин тоодог (*Otis tarda*) зэрэгт удаа дараа гарч байжээ.

Байгалийн чухал нутгуудын сүйрэл, өөрчлөлт болон тайван байдал алдагдах зэрэг нь урт хугацаанд гарах ихээхэн сөрөг нөлөө юм. Ер нь уул уурхайтай холбоотой дэд бүтцийн барилга байгууламжийн биологийн төрөл зүйлд үзүүлэх дам нөлөө нь хамгийн ноцтой байх төлөвтэй. Олборлолтоос гарах дам нөлөөлөлд зам харгуй, төмөр зам болон боомтууд барих, уул уурхайн болон үйлчилгээний салбарт ажиллах хүмүүсийн шилшилт хөдөлгөөн болон хяналтын гадуурх бүс нутгийн хөгжил зэрэг орно. Эдгээр чиг хандлага ургамлын болон амьтны популяцид (ноос, түлшний мод зэрэг) сөргөөр нөлөөлж улмаар амьдрах орчныг сүйрэл буюу зүйлийн хомсдолыг бий болгоно.

Урьд өмнө хүний хөл хүрээгүй газарт уул уурхайтай холбоотой дэд бүтэц байгуулсанаас сүүлийн үед зэрлэг ан амьтны ан агнуур, арилжаа наймаа дэлгэрч улмаар байгалийн баялгийг их хэмжээгээр шингээх чадвартай Хятад улстай хиллэх урд хилээ нээлттэй болгосон нь үүнийг бүрч гааруулсан байна. Тухайлбал, монгол бөхөн (*Saiga tatarica mongolica*), халиун буга (*Cervus elaphus*), Аргаль (*Ovis ammon*), монгол тарвага (*Marmota sibirica*) болон идлэг шонхор (*Falco cherrug*) зэрэгт эдийн засгийн ач холбогдол бүхий зэрлэг ан амьтны зүйлд эрс хорогдол гарсан байна (Вингард, Захлер нар, 2006). Одоогийн хийж буй ан агнуур цаашид тогтвортой бус гэдгийг анчид, наймаачид болон биологчид санал нэгтэй зөвшөөрдөг. Хятадад шинээр үүсэн гарч буй зах зээлтэй Монголын шинэ уурхайнуудыг холбох тээврийн дэд бүтцийг барих асуудал хил дамнасан зэрлэг ан амьтны наймаа өсч буй өнөө үед санаа зовоосон асуудал болж байна. Хуулийн хэрэгжилтийг хангах чиглэлээр ажилладаг Монголын эрх бүхий байгууллагууд алслагдсан хилийн худалдааны цэгүүдэд хүн хүч дутмагаас болж үр ашигтай хяналтыг тогтоож чадаагүй байна (Вингард, Захлер нар, 2006).

Энд дурьдвал зохих уул уурхайн хөгжлийн шууд бус нөлөөлөл бол уурхайн ойр орчмын газар гарч буй эдийн засгийн өсөлт, дэд бүтцийн хөгжлийн улмаас уурхайн шинэ суурин газрууд байгуулагдаж, хуучин газрууд нь өргөжин тэлж байгаа явдал байна. Нэг жишээг дурьдахад Өмнөговь аймгийн Оюу Толгойн төсөл уг уурхайн зүүн хойд хэсэгт байгуулагдах хотхоныг буй болгох төлөвтэй. Олборлолтын үйл ажиллагаа эхэлсэн нөхцөлд уг уурхайд хамгийн ихээр бодоход 1850 хүн ажиллах болно (IMMI, 2007). 2006

онд Монголын уул уурхайн сургуулийн хийсэн эдийн засгийн судалгаанаас үзэхэд Оюу Толгойд шинээр бий болгох нэг ажлын байрны хариуд холбогдох бусад салбарт дөрвөн ажлын байр шинээр бий болно (IMMI 2007). Үүнээс гадна аймаг болон сумын захиргаад уул уурхайн орлогын ихэнхийг орон нутагтаа хадгалж дахин хөрөнгө оруулалт хийх, ажил хайж буй иргэдийг уурхайд бараа, үйлчилгээ нийлүүлдэг аж ахуйн нэгжтэй холбох, улмаар олон нийтэд чиглэсэн чанартай үйлчилгээ бий болгон үр өгөөжийг нийтэд хүртээх боломж бүрдэнэ. Энэ хүрээнд хотын хөгжил хөдөө орон нутгийн эдийн засгийг үндсээр нь өөрчилж гүний усны хомсдол, хууль бус ан, модны хулгай зэрэг шинэ бөгөөд урьдчилан таамаглаж болохгүй дарамтуудыг байгаль дахь амьдрах орчин ба зэрлэг ан амьтны популяцид учруулна.

7.7. Хайгуул болон олборлолтоос үүдэлтэй сөрөг нөлөөнд өртөж буй зарим чухал нутгууд

Улсын тусгай хамгаалалттай газар нутаг

Улсын ТХ-тай 38 газар хайгуулын болон олборлолтын тусгай зөвшөөрөлтэй талбайтай давхцаж байна (Хавсралт 9). Гэвч, зөвхөн тусгай хамгаалалтай 3 газрын хувьд нийлбэр давхардал тухайн талбайн 10-аас илүү хувийг эзлэж байна Үүнд: Их газрын чулуу ба Нагалханы байгалийн нөөц газар; Сүйхэнт уулын байгалийн түүх, соёлын дурсгалт газар юм (Хүснэгт 15). Нагалхан болон Сүйхэнт Уулын хувьд тусгай хамгаалалттай газрыг түүнтэй давхардаж буй хайгуулын тусгай зөвшөөрлүүд олгохоос өмнө байгуулжээ. Харин Их газрын чулууны хувьд хамгаалалтай газар (2003 онд байгуулсан) ба давхардаж буй хайгуулын тусгай зөвшөөрлүүдийн нэгийг олгохоос өмнө (2007 оны 1 сард олгогдож 1067 га талбайгаар давхардаж буй), нөгөөгөөс хойш (1998 оны 2 сард олгогдож 20233 га талбай эзлэх) байгуулагджээ. Эдгээр гурван тохиолдлыг Газрын зураг 15-17-д харуулсан болно. Улсын тусгай хамгаалалттай газар нутагтай давхардсан бүхий л тохиолдолд хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий газар хамааралтай байна. Улсын ТХ-тай 6 газар олборлолтын тусгай зөвшөөрөл бүхий газар давхардсан бөгөөд түүний хоёр нь 50 га-аас их газрууд юм. Улсын тусгай хамгаалалттай газар нутаг болон хайгуул, олборлолтын тусгай зөвшөөрөл бүхий газруудын хоорондын давхардлын нийт талбайн хэмжээ 141905 га бөгөөд энэ нь Улсын ТХГН-ийн сүлжээний 1-ээс бага хувьтай тэнцэх юм.

Хүснэгт 15. Хайгуулын болон олборлолтын тусгай зөвшөөрөл бүхий газруудтай ихээхэн давхацсан улсын тусгай хамгаалалттай газрууд

Зэрэг-лэл	Газрын нэр	Нийт талбай (га)	Хайгуулын давхардал (га)	Олбор-лолтын давхардал (га)	Нийт давхар-дал (га)	Давхард-лын хувь
1	Их газрын чулуу	34,096	21,301	0	21,301	62.5
2	Нагалхан	4,806	1,455	0	1,455	30.3
3	Сүйхэнт уул	7,717	2,112	0	2,112	27.4

Уурхайтай холбоотой дэд бүтцээс үүдэж болохуйц нөлөөллийн хувьд Улсын ТХГН-ын 35 нь олборлолтын газрын ойр орчмын 20 км зайд бүхэлдээ болон хэсэгчлэн оршиж байна. Талбайн хувьд Улсын ТХГН-ийн 7 хувь буюу 1480705 га газар нь нэг буюу түүнээс дээш тооны олборлолтын газраас 20км зайд оршдог байна. Давхардлын хувь хэмжээг үзвэл Улсын ТХ-тай 25 газрын 10 хувь нь олборлолтын тусгай зөвшөөрөл бүхий газрын 20 км зайтай давхцаж байгаа ба үүний найман талбайн тэн хагас нь давхцаж байна (Хүснэгт 16).

Хүснэгт 16. Талбайн тэн хагас нь олборлолтын тусгай зөвшөөрөл бүхий газартай давхардаж буй улсын тусгай хамгаалалттай газрууд

Зэрэг-лэл	Газрын нэр	Нийт талбай (га)	Олборлолтын тусгай зөвшөөрөл бүхий газрын 20 km-т орших талбай (га)	Давхардлын хувь хэмжээ
1	Дэвэлийн арал	10,022	10,022	100.0
2	Богд хаан уул	41,383	41,383	100.0
3	Нагалхан	4,806	4,806	100.0
4	Булган гол	11,892	11,892	100.0
5	Хар ямаат	51,274	40,653	79.3
6	Түргэн	133,810	84,183	62.9
7	Их нартын чулуу	70,088	42,287	60.3
8	Сийлхэм “В”	76,647	46,035	60.1

Орон нутгийн тусгай хамгаалалттай газрууд

Орон нутгийн ТХГН-ийн 357 нь хайгуулын болон олборлолтын тусгай зөвшөөрөл бүхий газартай давхцаж байна. Эдгээрээс 341 нь нэг буюу түүнээс дээш олборлолтын тусгай зөвшөөрөл бүхий, 75 нь нэг буюу түүнээс дээш хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий газартай давхцаж байна. Орон нутгийн ТХГН ба хайгуулын болон олборлолтын тусгай зөвшөөрөл бүхий газартай давхцаж буй нийт талбайн хэмжээ 3241579 га газар байна. Энэ нь Улсын ТХГН-ийн сүлжээний 20 хувьтай тэнцэж байгаа юм. Энэ нь байгалийн чухал нутгуудын бусад ангиллын газруудтай харьцуулбал ихээхэн хэмжээний давхардал болж байна.

Давхардлыг хувь хэмжээгээр гаргавал орон нутгийн ТХГН-ийн 277 нь хайгуулын болон олборлолтын тусгай зөвшөөрөл бүхий газартай давхцдаг (нийт талбайн арав буюу түүнээс дээш хувийг эзлэх давхардал). Орон нутгийн ТХ-тай 187 газрын хувьд тусгай зөвшөөрөл нийт талбайн тэн хагасыг хамарсан байхад 100 тохиолдолд нийт талбайг хамарсан байна. Харин талбайн хэмжээний хувьд орон нутгийн ТХГН-ийн 16 нь талбайн хэмжээгээр 50 мянган га газраас их хэмжээ бүхий талбайтай хайгуулын болон олборлолтын тусгай зөвшөөрөл бүхий газартай давхцаж байна (хүснэгт 17). Орон нутгийн ТХГН ба хайгуулын болон олборлолтын тусгай зөвшөөрөл бүхий газруудын хоорондын давхардлын 45 хувийг эдгээр орон нутгийн ТХГН-ууд эзлэж байна.

Хүснэгт 17. Тавин мянган га-гаас дээш талбайд нь хайгуулын болон олборлолтын тусгай зөвшөөрөл олгогдсон орон нутгийн тусгай хамгаалалттай газрууд

Зэрэг-лэл	Газрын нэр	Аймаг	Нийт талбай (га)	Хайгуулын давхардал (га)	Олбор-лолтын давхардал (га)	Нийт давхар-дал (га)	Давхард-лын хувь хэмжээ
1	Хил орчмын газар	Өмнөговь	863,271	179,035	0	179,035	20.7
2	Таван Толгой	Өмнөговь	184,466	66,029	100,609	166,638	90.3
3	Их Чингис уул	Говь Алтай	217,874	151,223	45	151,269	69.4
4	Хангайн бүс	Баянхонгор	989,126	120,469	4,069	124,538	12.6
5	Нарийн сухайт	Өмнөговь	117,393	102,385	10,547	112,932	96.2

6	Бүдүүн уул	Сүхбаатар	87,011	87,009	0	87,009	100.0
7	Зотол хаан уул	Сүхбаатар	530,942	81,568	283	81,851	15.4
8	Улаан уул сум	Хөвсгөл	404,781	76,554	0	76,554	18.9
9	Чойбалсан, Гурван загал сум	Дорнод	86,685	71,951	91	72,042	83.1
10	Хоёр мелхийт	Дорнод	115,941	63,819	0	63,819	55.0
11	Галийн гол	Дорнод	70,638	62,280	0	62,280	88.2
12	Говь гурван сайхан	Өмнөговь	66,126	61,769	0	61,769	93.4
13	Ханбогд сумтай ойролцоо хил орчмын газар	Өмнөговь	157,028	57,973	144	58,118	37.0
14	Эрдэнэ-хайрхан	Өмнөговь	129,112	55,410	0	55,410	42.9
15	Сүхбаатар сумын баруун хэсэг	Сүхбаатар	71,380	53,530	39	53,569	75.0
16	Баруун Ол	Дорнод	64,407	51,872	97	51,969	80.7

Тэмдэглэл: Газрын нэр нь мэдэгдэхгүй байгаа талбайг хаалтанд бичсэн ба тэдгээрийн зөвхөн байршлыг нь заасан болно.

2003 оны 1 сарын 23-ны өдөр аймгийн засаг захиргаанаас тогтоосон Таван Толгойн Орон нутгийн ТХГН онцгой анхаарал татаж байгаа юм. Таван Толгойн Орон нутгийн ТХГН нүүрсний зургаан тусгай зөвшөөрөл бүхий газартай давхцаж байна. Эдгээр давхардал нийт 100609 га газрыг хамардаг бөгөөд Монголын олборлолтын тусгай зөвшөөрөл бүхий газар болон байгалийн чухал нутгуудын хоорондын давхардлын гуравны хоёрыг эзэлдэг. Аймгийн засаг захиргаанаас үйл ажиллагаа явуулж буй олборлолтын талбайтай зориуд давхцуулж санаатайгаар Таван толгойн ТХГН-ийг байгуулсан мэт харагдаж байгаа юм. Таван Толгойн Орон нутгийн ТХГН-ийг Газрын зураг 18-д харуулсан болно.

Орон нутгийн ТХГН, хайгуулын болон олборлолтын тусгай зөвшөөрөл бүхий газруудын давхардал Монголын нийт нутагт түгээмэл биш бөгөөд энэ нь цөөн тооны аймгуудад төвлөрсөн байна. Давхардаж буй талбайн 80 хувь нь зөвхөн таван аймагт төвлөрсөн бөгөөд нэг бүр нь 300 мянган га газар бүхий давхардалтай байна. Тухайлбал, Дорнод, Өмнөговь, Сүхбаатар, Говь-Алтай, Баянхонгор (Хүснэгт 18, Газрын зураг 13-14) аймгуудыг дурьдаж болох юм. Орон нутгийн ТХГН-ийн хамгийн их талбай бүхий дөрвөн аймаг үүнд орж байгаа нь санамсаргүй зүйл биш. Харин гайхал төрүүлэхүйц нэг зүйл бол бараг тэн хагас нь хайгуулын болон олборлолтын тусгай зөвшөөрөлтэй давхцаж буй Орон нутгийн ТХГН-ийн 760 мянга орчим га газартай Говь-Алтай аймгийг үүнд оруулсан явдал юм. Хайгуулын болон олборлолтын тусгай зөвшөөрөл бүхий газрууд, хамгаалалттай газруудын хоорондын давхардлын асуудлыг шийдвэрлэхэд дээрх 5 аймагт анхаарлаа төвлөрүүлэх хэрэгтэй юм.

Хүснэгт 18. Орон нутгийн ТХГН, хайгуулын болон олборлолтын тусгай зөвшөөрөл бүхий газруудын давхардал

Аймаг	Орон нутгийн ТХГ-ын талбай (га)	Орон нутгийн ТХГ-тай давхардаж буй тоо	Нийт давхардал (га)	Давхардлын хувь
Архангай	552,375	12	93,991	17.0
Баянхонгор	2,817,750	18	310,528	11.0
Баян-Өлгий	126,632	3	31,839	25.1
Булган	49,173	2	20,218	41.1
Дархан-Уул	56,830	7	11,020	19.4
Дорнод	3,211,381	40	813,868	25.3
Дорноговь	49,870	71	28,117	56.4
Дундговь	470,785	34	77,350	16.4
Говь-Алтай	759,360	14	326,609	43.0
Говь-Сүмбэр	0	0	0	n/a
Хэнтий	680,742	8	25,476	3.7
Ховд	257,499	5	21,057	8.2
Хөвсгөл	530,492	8	84,084	15.9
Өмнөговь	2,149,805	13	699,412	32.5
Орхон	3,544	1	2	0.0
Өвөрхангай	104,888	4	2,178	2.1
Сэлэнгэ	277,222	22	66,310	23.9
Сүхбаатар	2,461,656	35	430,866	17.5
Төв	1,413,616	39	90,792	6.4
Улаанбаатар	41,054	8	13,545	33.0
Увс	379,686	8	80,978	21.3
Завхан	137,145	5	13,341	9.7
Нийт	**16,531,505**	**357**	**3,241,579**	**19.6**

Шувуудад чухал газрууд

Шувуудад чухал гэж тооцогдох 29 газар нь хайгуулын болон олборлолтын тусгай зөвшөөрөл бүхий газруудтай давхардаж байна (Хавсралт 10). Түүний 28 тохиолдолд олборлолтын тусгай зөвшөөрөл бүхий газартай давхардаж байгаа бөгөөд тэдгээрийн нэг нь ч 138га-гаас хэтрэхгүй талбай бүхий 4 тохиолдолд л хайгуулын тусгай зөвшөөрөлтэй газруудтай давхарджээ. Давхардлын нийт талбайн хэмжээ 724687 га бөгөөд энэ нь Монголын ШЧГ-ын сүлжээний бараг 9 хувьтай тэнцүү юм. Давхардлын гуравны нэг нь /нийтдээ 497627 га талбай/ хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий 26 газартай давхцах Галбын говийн ШЧГ-т ноогдож байна. Ер нь нийтдээ ШЧГ гэж тооцогдох 11 газар нь хайгуулын болон олборлолтын тусгай зөвшөөрөл бүхий томоохон газруудтай давхардаж байна. Шувуудад чухал эдгээр газруудын 5 нь нийт талбайн тэн хагасаас илүү нь тусгай зөвшөөрөл бүхий газартай давхардаж байна (Хүснэгт 19). Эдгээр давхардлыг газрын зураг 19-23-д үзүүлсэн болно.

Хүснэгт 19. Хайгуулын болон олборлолтын тусгай зөвшөөрөл бүхий газруудтай их хэмжээгээр давхацсан шувуудад чухал газрууд

Зэрэг-лэл	Газрын нэр	Нийт талбай (га)	Хайгуулын давхардал (га)	Олборлол-тын дав-хардал (га)	Нийт давхар-дал (га)	Давхард-лын хувь
1	Дашинчилэн баян нуур	1,598	1,598	0	1,598	100.0
2	Ташгайн таван нуур	53,304	53,304	0	53,304	100.0
3	Цэнгэл хайрхан уул	52,726	49,663	0	49,663	94.2
4	Шаазан нуур	5,485	3,752	0	3,752	68.4
5	Галбын говь	828,328	497,627	0	497,627	60.1
6	Увсын хар ус нуур	13,601	4,239	0	4,239	31.2
7	Ойгон нуур	20,189	4,758	0	4,758	23.6
8	Булган гол	32,700	7,212	0	7,212	22.1
9	Толбо нуур	16,334	2,761	0	2,761	16.9
10	Улаагчны хар нуур	13,439	1,584	0	1,584	11.8
11	Борзонгийн говь	399,467	43,487	0	43,487	10.9

Уурхайтай холбоотой дэд бүтцээс үүдэлтэй нөлөөлөлд өртөх хамгийн өндөр эрсдэл бүхий, шувуудад чухал гэж тооцогдох 31 газар нь олборлолтын газраас 20 км зайд бүхэлдээ буюу хэсэгчлэн байрласан байна. Шувуудад чухалд тооцогдох 24 газрын талбайн 10-аас дээш хувь нь хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий газраас 20км зайд оршиж байна. Түүнчлэн шувуудад чухалд тооцогдох 10 газрынх нь талбайн тэн хагас нь хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий газраас 20 км зайд оршиж байгаа юм. (Хүснэгт 20). Мөн Эрхэл нуур, Тэшигийн олон нуур болон Хар ямаатын байгалийн нөөц газар зэрэг тусгай зөвшөөрөл бүхий газартай огт давхацдаггүй хэд хэдэн ШЧГ-ууд уурхайтай холбоотой дэд бүтцээс улбаатай нөлөөлөлд өртөх эрсдэл ихтэй байна. Ийм учраас уул уурхайн аж ахуйн нэгжүүд уурхайн хил хязгаараас гадна илүү өргөн газар нутгийг хамран байгалийн чухал нутгуудад нөлөөлж болзошгүй нөлөөллийг сайтар үнэлж удирдан зохицуулах шаардлагатай байгааг харуулж байна.

Хүснэгт 20. Талбайн тэн хагасаас илүү хувь нь олборлолтын тусгай зөвшөөрөл бүхий газруудад байршиж буй ШЧГ

Зэрэг-лэл	Газрын нэр	Нийт талбай (га)	Олборлолтын газраас 20 км зайд орших талбай (га)	Давхардлын хувь
1	Дашинчилэн баян нуур	1,598	1,598	100.0
2	Шаазан нуур	5,485	5,485	100.0
3	Майхант уул	42,015	42,015	100.0
4	Эрхэл нуур	3,537	3,355	94.9
5	Тэшигийн олон нуур	5,774	4,947	85.7
6	Хар ямаат байгалийн нөөц газар	51,404	41,521	80.8

7	Орхон, Сэлэнгэ голын эх	21,405	15,758	73.6
8	Увсын хар ус нуур	13,601	8,773	64.5
9	Түргэн цагаан, Зэгст, Туулайтын Бур	35,282	22,023	62.4
10	Их нартын чулуу байгалийн нөөц газар	66,601	40,709	61.1

7.8. Аялал жуулчлалын салбарын хөгжлийн төлөвлөгөө болон байгалийн чухал нутгуудын давхардлын дүн шинжилгээ

Жуулчны баазууд болон байгалийн чухал нутгуудын хоорондын давхардлын газарзүйн мэдээллийн системийн дүн шинжилгээ

Газарзүйн мэдээллийн системд хамрагдсан 140 жуулчны баазаас 84 нь улсын ТХ-тай 10 газрын ойр орчмын нутагт байрлаж байна. Жуулчны баазуудын нэр болон нутаг дэвсгэр дээрээ жуулчны баазтай Улсын ТХГН-ийн нэрсийг Хавсралт 11-т үзүүлэв. Хамгийн олон тооны жуулчны баазтай Улсын ТХГНутгуудад Горхи Тэрэлж (38), Богдхан уул (13), Хөвсгөл нуур (11), Хангайн нуруу (9) зэрэг орно (Хүснэгт 21). Богдхан уул, Горхи Тэрэлжийн аманд жуулчны хамгийн олон бааз байдгийг Улаанбаатар хоттой ойролцоо байдгаар нь тайлбарлаж болох ба төмөр замаар Монголд ирдэг голдуу амралтын зорилго бүхий зорчигчид нь Хятад, Оросоос ирэх галт тэргэнд суух зорилгоор 3-4 хоног нийслэлд хотод саатдаг байна (Вингстен, 2008).

Хүснэгт 21. Жуулчны бааз болон Улсын ТХГН-ийн хоорондын давхардал

Улсын ТХГН-ын нэр	Ангилал	Баазын тоо	Улсын ТХГН-ын талбай (га)	Нягтрал (100,000 га-д ногдох талбай)
Горхи Тэрэлж	БЦГ	38	292,010	13.0
Богд хаан уул	ТХГ	13	41,383	31.4
Хөвсгөл нуур	БЦГ	11	848,828	1.3
Хангайн нуруу	БЦГ	9	889,986	1.0
Орхоны хөндий	БЦГ	4	92,955	4.3
Хөгнө тарна	БЦГ	3	78,798	3.8
Хорго Тэрхийн цагаан нуур	БЦГ	3	85,007	3.5
Молцог элс	БЦГ	1	488	204.8
Угтам	БЦГ	1	42,595	2.3
Хяргас нуур	БЦГ	1	374,746	0.3
Нийт		84		

Газарзүйн мэдээллийн системд хамрагдсан загвар 140 жуулчны баазаас гадна 17 бааз орон нутгийн хамгаалалт бүхий 11 газарт байршдаг буюу ойр орчмын газарт нь оршдог байна. (Хүснэгт 22). Түүнчлэн нэгээс дээш тооны бааз бүхий орон тусгай хамгаалалттай 3 газар байдаг. Тухайлбал, Хархорин (хоёр баазтай), Говь гурван сайхан (гурван баазтай), Өгий нуур болон түүний орчмын газрууд (дөрвөн баазтай)-ыг тус тус дурьдаж болох юм. Жуулчны баазуудын нэр болон нутаг дэзрээ жуулчны баазтай орон нутгийн ТХГН-уудын нэрийг Хавсралт 12-т харуулсан болно.

Хүснэгт 22. Жуулчны бааз, орон нутгийн ТХГН-ийн хоорондын давхардал

Орон нутгийн ТХГН-ын нэр	Баазын тоо	Орон нутгийн ТХГН-ын талбай (га)	Нягтрал (100,000 га-д ногдох бааз)
Өгий нуур, түүний орчмын газар	4	3,649	109.6
Говь гурван сайхан	3	66,126	4.5
Хархорин	2	45,146	4.4
Молцог элс	1	1,133	88.3
Булган хангайн уул	1	2,740	36.5
Баянзаг	1	3,404	29.4
Онгийн хийд	1	6,677	15.0
Бага газрын чулуу	1	11,354	8.8
Нарийн хамар	1	27,391	3.7
Баруун ол	1	64,407	1.6
Туйн голын хөндийн	1	150,694	0.7
Нийт	**17**		

Газарзүйн мэдээллийн системийн дүн шинжилгээнд хамрагдсан загвар 140 жуулчны баазаас 65 нь ШЧГ болон түүний ойр орчмын газарт оршдог (Хүснэгт 23). Дээр дурьдсан хүрээлэн буй орчны онцгой ач холбогдол бүхий нэмэлт газруудад Тэрхийн цагаан нуур, Шаазан нуур, Айраг нуур зэрэг орно. Жуулчны баазын нэрийг Хавсралт 13-т харуулав.

Хүснэгт 23. Жуулчны бааз, ШЧГ-ын хоорондын давхардал

ШЧГ-ын нэр	Баазын тоо	ШЧГ-ын талбай (га)	Нягтрал (100,000 га-д ногдох баазын тоо)
Горхи Тэрэлжийн БЦГ	39	293,937	13.3
Хөвсгөл нуур	10	380,212	2.6
Хангайн нуруу БЦГ	9	897,840	1.0
Өгий нуур	2	10,189	19.6
Тэрхийн цагаан нуур	2	21,072	9.5
Шаазан нуур	1	5,485	18.2
Угтам БНГ	1	46,162	2.2
Айраг нуур	1	73,348	1.4
Нийт	**65**		

Байгалийн чухал нутгуудад жуулчны бааз төвлөрсөн нөхцөлд уг төвлөрөл тодорхой талбайд байдаг. Жишээ нь Хөвсгөл нуурын баруун урд хэсэг бүхэлдээ жуулчны баазаар дүүрэн байхад Горхи тэрэлжийн аманд өөр хоорондоо маш ойрхон олон тооны баазтай тул уг БЦГ-ыг амралтын газар болгон хувиргажээ (Вингстен, 2008). Талбайд жуулчны цөөн тооны бааз байсан ч тэдгээр нь зүй зохисгүй байдлаар байрласан байдаг. Жишээ нь Баянзагдын Орон нутгийн ТХГ-т гэр баазуудыг хадны эгц доор барихыг зөвшөөрчээ (Вингстен, 2008). Эдгээр сөрөг үйл явц аялал жуулчлалын стратегийн төлөвлөлт байхгүй, мөн байгаль орчныг хамгаалах зохицуулалт сул байгааг илтгэж байна.

Практик үйл ажиллагаа явуулагчийн дүгнэлт

Монголын аялал жуулчлалын 4 гол багцад доорх газрууд орно (Вингстен 2005). Үүнд:

1. Монголын эзэнт гүрний эртний нийслэлийн суурь болон Эрдэнэзуу хийд байдгаараа алдаршсан Хархорин (Өвөрхангай), Хөгнө хаан уул (Булган);
2. Нийслэл хоттой ойр байдгийн хувьд Улаанбаатарын оршин суугчдад салхинд гарч амрах гол газар болох уул, ой, хээр хосолсон Горхи Тэрэлжийн байгалийн цогцолбор газар (Төв аймаг);
3. Ёлын аманд гол төлөв аялал жуулчлал төвлөрсөн Говь гурван сайханы байгалийн цогцолборт газар (Өмнөговь), 1920-иод онд анх үлэг гүрвэлийн чулуужсан өндөг олдсон "Сэнжийн цохио" хадтай Баянзагд дахь Гурвансайхан уул, 180 км элсэн манхан бүхий Хонгорын элс зэрэг;
4. Сүүлийн 10 жилд аялал жуулчлалын гол бүс нутаг болж хөгжиж буй Оросын хил дээр далайн төвшнөөс 1635 м өндөрт орших Хөвсгөл нуурын баруун урд хэсэг болон Хатгал тосгон

Аялал жуулчлал эрчимтэй хөгжиж буй бөгөөд зохион байгуулалттай аялагчид болон ганц нэгээрээ аялж буй хүмүүст зориулсан улирлын чанартай олон тооны гэр баазууд, буудлууд бүхий төвүүдийг энд дурьдав. Говь гурван сайханаас бусад эдгээрийн ихэнх нь хэт их хөгжилд автсан ба даацын хэмжээнээсээ хэдийнээ давсан ажээ (Вингстен, 2005). Гэр баазын хэт төвлөрөлт хэт их өрсөлдөөнийг дагуулж орон нутгийн ашигт сөргөөр нөлөөлж байна. Нөгөө нэг санаа зовууштай асуудал бол аялал жуулчлалаас гарах эдийн засгийн үр ашиг зөвхөн хэдхэн газар төвлөрч нийт нутаг дэвсгэрт түгээмэл бус байна. (Вингстен, 2008). Жишээ нь баруун аймгуудын ихэнхэд нь болон зүүн аймгуудад бүхэлдээ ирэх хэдэн жилд аялал жуулчлал хөгжих ямар ч төлөв байдал ажиглагдахгүй байна (Вингстен, 2005). Тусгай хамгаалалттай газрын захиргаад өөрт оруулах нэмэлт орлогоо бодолцож нутаг дэвсгэр дээрээ гэр баазуудыг бариулдаг байна. Тухайлбал, Говь Гурван Сайханы байгалийн цогцолборт газар тусгай хамгаалалттай газрын менежментийн төслийг гадны хандивлагчийн санхүүжилтээр хийж байгаа учраас л нутаг дэвсгэр дээрээ гэр бааз барихыг ганц удаа хориглосон байна (Вингстен, 2008). Гэхдээ аялал жуулчлалын хөгжлийг байгалийн чухал нутгуудад аюул хөнөөл учруулж буй үйл явц гэж үзэхийн зэрэгцээ тогтвортой хөгжлийн боломж хэмээн үзэх нь зүйтэй юм. Байгаль орчинд нөлөө багатай гэр баазууд барих, морь унах, морин аялал хийх, шувуу харах, загасчлал /загасыг барьж буцааж усанд нь тавих/ зэрэг аялал жуулчлалын төрлүүдийг хөгжүүлэх нь Монголын байгалийн өвийг хадгалж хамгаалах зорилготой бүрэн нийцэх болно. Эдгээр төрлүүдийг хөгжүүлэх явцад орон нутгийн эдийн засаг хөгжиж, хүмүүсийн харилцааны болон хэлний ур чадвараа дээшлүүлэх боломжийг залуучуудад олгохоос гадна хөдөлмөрийн чадвартай хүмүүст улирлын чанартай ажлын байрыг бий болгодог. Монголд жуулчдын тоог тодорхой хязгаарт барьж, тогтвортой байдал болон ашигт ажиллагааны зүй зохистой тэнцвэрийг нөхцөлдүүлэх төрөлжсөн зах зээл, бүтээгдэхүүн бүхий аялал жуулчлалыг хөгжүүлэх боломжтой. Харин ийм төрлийн аялал жуулчлалын хөгжлийг буй болгох боломжтой газруудын ихэнх нь тусгай хамгаалалттай газар, байгалийн чухал нутгуудтай давхцаж байна (Вингстен, 2008).

ДБХС-ийн Монгол дахь хөтөлбөрийн газраас тусгай хамгаалалттай газар нутгуудын талаар баримтлах байр суурь

Сүүлийн үед ДБХС-аас Монголын тусгай хамгаалалттай газрын тогтолцооны менежментийн үр ашгийг судлах судалгаа явуулжээ (Батсүх, Белокуров, 2005). Тухайлбал, ДБХС-ийн Тусгай хамгаалалттай газрын менежментийг түргэн үнэлгээ болон ач холбогдлоор нь жагсаах аргачлалыг хэрэглэсэн ажээ. (ХГМТҮАХЖА)(Эрвин, 2003). Уг судалгаанд 31 тусгай хамгаалалттай газар хамрагдсаны дотор Дархан цаазат газар 12, Байгалийн цогцолборт газар 19 байжээ. Судалгаанаас үзэхэд үүнд хамрагдсан 12 дархан цаазат газрын 10-д нь аялал жуулчлалын үйл ажиллагаа явагдаж, 6-д нь аюул нүүрлээд байгааг тогтоожээ.

(Зураг 10). Судалгаанд хамрагдсан Байгалийн цогцолборт 19 газрын 18-д нь аялал жуулчлалын үйл ажиллагаа явагдаж, 12-т нь аюул нүүрлэж байгааг тогтоогджээ (Зураг 11).

Зураг 10. ДБХС-ийн ХГМТҮАХЖА-г ашиглан Дархан цаазат газарт дарамт, аюул занал байгааг тогтоох нь



Зураг 11. ДБХС-ийн ХГМТҮАХЖА-г ашиглан Байгалийн цогцолбор газарт дарамт, аюул занал байгааг тогтоох нь



Жуулчны баазын операторуудын хувьд

Олон улсын аялал жуулчлалын үзэсгэлэн яармагийн үеэр явуулсан санал асуулгын дүнгээс үзэхэд (5.1 хэсгээс үзнэ үү) жуулчны баазын операторууд доорх баазуудыг хүлээн авах гадаадын жуулчдын тооны хувьд тодорхой дарамтанд байдаг гэж нэрлэжээ. Үүнд: Эрдэнэ сумын Горхи тэрэлж байгалийн цогцолбор газар, Архангай аймгийн Өгий нуур, Цэнхэрийн халуун рашаан, Хорго Тэрхийн цагаан нуур; Хөвсгөл аймгийн Хатгал, Хөвсгөл нуур, Жаргалантын халуун рашаан; Өмнөговь аймгийн Хонгорын гол, Хонгорын элс, Ёлын ам; Өвөрхангай аймгийн Элсэн тасархай, Хар Хорин; Булган аймгийн Хөгнөхаан уул.

Түүнчлэн жуулчны баазын операторууд дотоодын жуулчдын тооны улмаас тодорхой дарамтанд буй дараах газруудыг нэрлэжээ. Үүнд: Архангай аймгийн Цэнхэрийн халуун рашаан, Тайхар чулуу, Тэрхийн цагаан нуур; Улаанбаатарын ойролцох Горхи тэрэлжийн Байгалийн цогцолбор газар; Өмнөговь аймгийн Булган, Сэврэй сум, Ёлын ам; Сэлэнгэ аймгийн Амарбаясгалант хийд; Өвөрхангай аймгийн Хар Хорин.

Мөн жуулчны баазын операторууд Байгаль орчинд жуулчны баазуудын нөлөөлөх гол нөлөөг дараах байдлаар үнэлсэн байна. Үүнд: хог хаягдал, газрын доройтол, зохицуулалтгүй зам харгуй гаргах, усны бохирдол гэжээ. Түүнчлэн нэмэлт нөлөөлөл гэдэгт ойр орчмын уул уурхайн үйл ажиллагаа, хяналтгүй кэмпинг болон мод, бусад байгалийн нөөц баялгийг тогтвортой бус байдлаар ашиглах зэргийг оруулжээ.

Одоогоор авч буй арга хэмжээ болон байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг багасгах чиглэлээр ирээдүйд авах арга хэмжээний талаар жуулчны баазын операторуудаас авсан санал асуулгын судалгааны дүнг зураг 12-т тусгасан болно.

Зураг 12. Байгаль орчинд жуулчны баазуудын нөлөөллийг багасгах чиглэлээр авч буй болон авах арга хэмжээний харьцуулал



Мөн санал болгох арга хэмжээнд жуулчны баазын операторууд засгийн газраас авч хэрэгжүүлэх болон өөрсдийн хийх ажлыг нэрлэжээ. Эдгээр саналыг Хүснэгт 24, 25-т тусгасан болно.

Хүснэгт 24. Засгийн газраас авах арга хэмжээ /Жуулчны баазуудын санал болгосноор/

Арга хэмжээний төрөл	Тоо	%
Жуулчны баазуудын хяналтыг бэхжүүлж, стандарчлах	18	23.7
Байгаль орчны хамгаалалыг бэхжүүлэх	18	23.7
Байгаль орчинд ээлтэй технологид хөрөнгө оруулахад санхүүгийн дэмжлэг үзүүлэх	16	21.1
Дэд бүтцийг сайжруулах	12	15.8
Уурхайн менежмент, хяналтыг сайжруулах	6	7.9
Аялал жуулчлалын салбар дахь гадаад хамтын ажиллагааг дэмжих	4	5.3
Хүчин чадавхийг бэхжүүлэх	1	1.3
Жуулчны баазуудын хоорондын хамтын ажиллагааг дэмжих	1	1.3

Хүснэгт 25. Жуулчны баазын өөрсдийн авах арга хэмжээ /Жуулчны баазуудын санал болгосноор/

Арга хэмжээний төрөл	**Тоо**	**%**
Ландшафт болон хүрээлэн буй орчны сайжруулалт	16	28.1
Нөөцийн ухамсартай болон тогтвортой ашиглалт	11	19.3
Байгаль орчны хамгааллын сурталчилгаа	9	15.8
Хаягдлыг багасгах	7	12.3
Байгаль орчны хяналтыг сайжруулах	5	8.8
Зэрлэг ан амьтныг хамгаалах	4	7.0
Байгалийн гамшгаас урьдчилан сэргийлэх	2	3.5
Ногоон хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих	2	3.5
Хамгаалалтыг нөхцөлдүүлэх	1	1.8

Байгалийн чухал нутгуудад аялал жуулчлалын үзүүлэх нөлөөллийг шинжлэх ажил

Байгаль хамгааллын үүднээс болон 2007 онд зохиогдсон ШЧГ-ын тухай семинараас гарсан мэдээлэл, жуулчны баазаас авсан санал асуулга, ном хэвлэлийн мэдээ зэрэгт үндэслэн доорх аюул хөнөөлийг одоогоор тодорхойлоод байгаа юм. Эдгээр нь орон нутгийн чанартай боловч зарим тохиолдолд ихээхэн нөлөөтэй юм. Өнөөгийн байдлаар аялал жуулчлалын улмаас үүсэх нөлөөллөөс уул уурхай, дэд бүтцийн хөгжлөөс үүдэлтэй аюул хөнөөл харьцангүй бага байна. Түүнчлэн үүрэг амлалт авч шилдэг туршлага нэвтрүүлсэнээр байгаль орчинд ээлтэй аялал жуулчлал хөгжүүлэх бүрэн боломж ч байна. Үнэхээр Монголын аялал жуулчлалын салбарын хөгжлийн амжилт нь байгаль орчин, соёл, эдийн засгийн харилцан уялдаанаас хамаарч байгаа нь аялал жуулчлалыг татах гол зарчим билээ.

Зэрлэг ан амьтанд учрах бэрхшээл

Жуулчны хэд хэдэн бааз нуур цөөрмийн эрэг газруудад жуулчдыг ямар ч хязгаарлалтгүй нэвтрүүлж хамгаалвал зохих өндөр ач холбогдол бүхий ус намгархаг газруудад ойрхон байрладаг (Жишээ нь Тэрхийн цагаан нуур, Конрад Шлейчер). Завиар аялах болон загасчлах зэрэг үйл ажиллагаа нь жижиг арлуудын үржлийн шувуудад бэрхшээл учруулдаг. Жуулчны улирлын оргил үе шувууд өндгөө дардаг үржлийн болон үржлийн дараах үетэй давхцдаг (Жишээ нь галуу болон нугас нисдэггүй үетэй) байна. Ийм тавгүй байдал нь тэдэнд тохиолдох эндэгдлийг нэмэгдүүлдэг. Монгол орны ус намгархаг газрууд нь олон улсын байгаль хамгааллын холбооны Улаан номонд орсон

хар тогоруу *(Grus monacha)*, цэн тогоруу (*G. vipio)*, хошуу галуу (*Anser cygnoides)* зэрэг маш эмзэг хэд хэдэн амьтны хувьд онцгой чухал.

Түүнчлэн Монгол орны аргаль (*Ovis ammon)*, монгол хулан (*Equus hemionus)*, хар сүүлт зээр (*Gazella subgutturosa*), монгол бөхөн (*Saiga tatarica mongolica*) зэрэг томоохон хөхтөн амьтдын хувьд ч ийм тавгүй байдал маш хор хөнөөлтэй ба бартааг туулах зориулалттай зарим машин техникүүд нь хээр тал, элсэн цөлд хүртэл мэдэгдэхүйц нөлөө учруулах талтай.

Тусгай хамгаалалттай газрыг бүсчлэх, эмзэг газруудад нэвтрэхийг хязгаарлах, Байгалийн цогцолборт газруудын менежер, тур операторуудад болон жуулчдад зориулсан удирдамж зэргээр дамжуулан эдгээр бэрхшээлийг сааруулж болох юм.

Хээр, цөлийн доройтол

Монгол орны хээр тал болон цөлийн амьдрах орчин маш эмзэг байдаг. Хатуу хучилттай зам дутмаг Монголын өргөн уудам талд хөдөө орон нутгаар чөлөөтэй зорчиж, үндсэн хуулиар олгогдсон эрхээ эдлэх зэрэг нь жуулчны машин тусгай хамгаалттай газрын нутаг дэвсгэрээр холхих нөхцлийг бүрдүүлж байна. Үнэндээ хөдөө орон нутгаар чөлөөтэй аялж өргөн уудам тал нутгийг машинаар туулах нь чухамдаа олон жуулчдыг татах гол зүйл билээ. Байгалийн шороон замыг цаашид ашиглах боломжгүй болсон нөхцөлд төрөл бүрийн чиглэлд үргэлжлэх олон зуун километр замыг шинээр гаргаж эхэлдэг. Энэ нь ургамлыг сүйтгэн доройтуулж, зэрлэг ан амьтны популяцид төдийлөн нөлөөлөхгүй ч ландшафтыг эвддэг хортой үр дагавартай.

Тур операторууд өөрсдийн мал (унуулах зорилгоор эсвэл хоол хүнсэнд хэрэглэхээр) авчирсан тохиолдолд зуны цагт жуулчны баазын орчимд бэлчээрийн талхлалт ихэсдэг. Иймээс гэр баазуудын тогтмол ажиллагаа нь яваандаа бэлчээрийг ихээхэн талхалж хөрсний доройтлыг үүсгэн улмаар цөлжилтийг бий болгох аюултай.

Хамгаалалттай газрыг машинаар нэвтрэн зорчихыг байгалийн цогцолборт газрын төлөвлөлт, нэвтэрч орохыг хязгаарлах, хучилттай замыг засах, барилгажуулах, аянчин жуулчдад удирдамж гаргаж мөрдүүлэх зэргээр зохицуулж болно. Харин бэлчээрийн улам бүр өсөн нэмэгдэх талхлалтыг орон нутгийн эзэмшлийн мал сүргийг түлхүү анхаарах, шаардлагатай бол гэр баазуудыг сэлгэн нүүлгэх зэрэг аргаар зохицуулж болно.

Гол, нууруудын бохирдол

Гол, нууруудын ойролцоо гэр баазуудыг барих явдал улмаар орон нутгийн чанартай бохирдлыг бий болгодог. Юуны түрүүнд жуулчны баазуудын бохир усны хаягдал, жуулчдын хэрэглэдэг саван, шампунь зэрэг нь үүнд сөргөөр нөлөөлдөг. Энэ нь жуулчин аянчин олноор хүлээн авдаг хамгаалалттай газруудад нилээд том асуудал болж байна. Жуулчны машиныг угаах асуудал мөн л бохирдолд нэмэр болдог. Усанд сэлэх явдлыг орон нутгийн иргэд мөн л бохирдлын хүчин зүйлийн нэг хэлбэр гэж үздэг.

Бохирдлын улмаас давсжилт, эутрофикаци үүсэж хүн, малын эрүүл мэндэд сөрөг нөлөө учруулна. Түүнчлэн үүнийг жуулчид анзаарч, үүний улмаас тэдгээрийн тав тух алдагдан тухайн газар нутгийн нэр хүндэд сөргөөр нөлөөлнө. Гэхдээ байгальд нөлөөлөх нөлөөлөл нь орон нутгийн чанартай юм.

Бохир усны асуудлыг жуулчдад дүрэм журмыг мөрдүүлэх, тэргүүн туршлагыг нэвтрүүлэх, шинээр жуулчны бааз барих ажлыг төлөвлөх үе шатанд нөлөөллийг сайтар үнэлэх зэрэг арга хэмжээгээр шийдэж болно.

Түлшний мод бэлтгэл

Хоол унд хийх, дулаацах зорилгоор мод бэлтгэх явдал олон газруудад сөрөг нөлөө үзүүлж байна (Жишэ нь, Горхи Тэрэлжийн байгалийн цогцолбор газар). Бусад газруудын хувьд ургаа бус унасан модны олдоц нилээд элбэг, хүлээн авдаг жуулчдын тоо бага тул уг асуудал томоохон хэмжээний хүндрэл учруулдаггүй байна. Харин анхаарвал зохих газруудад тур операторууд бэлэн түлшээ авчирч түлшний мод бэлтгэх үйл ажиллагааг

зогсоох шаардлагатай. Жуулчдын тоо нэмэгдэх тусам алслагдсан газруудад уг асуудал нилээд хүндрэл учруулж болзошгүй.

Усны нөөцийн хомсдол

Байгалийн чухал нөөцүүдийн нэг болох ус, тэр тусмаа цэвэр усны нөөц тус орны хуурай бүс нутагт нэн хомс байдаг. Аялал жуулчлалын салбар гол төлөв зочид буудал, баазууд болон жуулчдын хувийн хэрэглээнд их хэмжээний ус зарцуулдаг байна. Энэ нь улмаар усны хомсдлыг буй болгож усны нөөцийг доройтуулан их хэмжээний бохир усны хуримтлалыг буй болгодог.

Хатуу хаягдал

Жуулчны үйл ажиллагаа ихээхэн төвлөрсөн газруудад хог хаягдлын асуудал хурцаар тавигддаг. Хатуу хог хаягдал нь гол, ус, газар орон, жуулчны баазад сөргөөр нөлөөлж тухайн газар нутгийн үзэсгэлэнг гутаадаг.

Хатуу хог хаягдлыг цуглуулж хаях төхөөрөмжгүй хөдөө орон нутгийн газруудад жуулчид ихэнх тохиолдолд хог болон хэрэгцээгүй төхөөрөмж зэргээ орхиод явдаг. Хуванцар мэтийн хатуу хаягдлыг шатаах оролдлого хийдэг ч төдийлөн амжилттай болдоггүй ба шатаагүй үлдсэн материал нь хожим салхинд хөврөн тархдаг. Тэдгээр нь байгаль орчинд хэрхэн нөлөөлдгийг хэлэхэд хэцүү бөгөөд зарим амьтанд өвлийн улиралд уг хаягдлын үлдэц хэрэг болдог ч байж магадгүй. Гэхдээ л энэ нь аялал жуулчлалын агуулгад харш тул Байгалийн цогцолборт газруудад сөргөөр нөлөөлдөг. Иймээс Монголын тусгай хамгаалалттай олон газруудад уг асуудлыг нэн даруй шийдвэрлэх шаардлагатай.

Үүнийг тусгай хамгаалалттай газар тус бүрээр хатуу хог хаягдлыг зохицуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх замаар зохицуулж болох юм. (одоогоор олон жуулчин хүлээн авахгүй байгаа газруудыг ч хамрах хэрэгтэй). Уг зохицуулалтын журамд хатуу хог хаягдлыг ангилж хаях, хуванцарыг бусад хогноос тусгаарлах, тур операторуудад өөрийн хогоо буцаан авч явах, байгалийн цогцолбор газрын захиргаад хог хаягдлыг хуримтлуулж тээвэрлэлтийг зохион байгуулах зэргийг тусгаж болно. Хөвсгөл нуурын байгалийн цогцолборт газар хатуу хог хаягдлыг цуглуулж тээвэрлэхэд зориулсан биологийн задралд ордог сав баглаа нэвтрүүлсэн нь эерэг жишээ болж байна (Шлейчер, Хотц, 2007).

Аялал жуулчлалын дэд бүтэц

Гэр баазууд нь аялал жуулчлалыг татах нэг хүчин зүйл болохын хувьд тусгай хамгаалалттай газрын байгаль, түүх соёлын агуулгад нийцдэг байна. Ихэнх тохиолдолд тэдгээр нь тухайн газрын байгалийн гоо үзэсгэлэнд харш бус байдлаар байршлаа мэдрэмжтэй сонгосон байдаг. Энэ асуудлын хувьд бусад оронтой харьцуулбал Монгол орон тусгай хамгаалалттай газартаа дэд бүтцийн хөгжлийн нөлөөг багасгах чиглэлд багагүй амжилт олжээ. Харин тухайн газрын байгалийн гоо үзэсгэлэнд бетонон байшин барилга (ажилчдын байр, хүлээн авах болон зоогийн газрын байшин барилга), машины зогсоолын байршил, үйлчилгээ хийгээд хог хаягдлыг хуримтлуулах газар зэрэг нь сөргөөр нөлөөлдөг. Зарим баазуудын байршил төдийлөн тохиромжтой бус бөгөөд ландшафтыг сүйтгэж эргэн тойрны орчны тав тухыг алдагдуулдаг. Ийм төрлийн бохирдол ихэвчлэн байгаль орчинд төдийлөн нөлөөлдөггүй. Харин хун, тогоруу зэрэг шувуудад ноцтой хор хөнөөл учруулдаг цахилгаан, харилцаа холбооны дамжуулах шугамуудын байршлыг сонгоход анхаарах хэрэгтэй юм. Гэхдээ л энэ нь аялал жуулчлалд сөргөөр нөлөөлдөг тул урт хугацаанд аялал жуулчлалын болон байгалийн цогцолборт газрын төлөвлөлт, зохион байгуулалтыг сайтар бодож боловсруулан хэрэгжүүлэх шаардлага тулгарч байна.

Тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн асуудал

Байгаль хамгааллын асуудлыг хөндөж 2007 онд зохиогдсон ШЧГ-ын тухай семинар, жуулчны баазын санал асуулга болон ном хэвлэл зэргээс авсан мэдээллийг харгалзан үзээд менежментийн дараах асуудлуудыг тодорхойлов. Үүнд:

Бүсчлэл ба менежментийн төлөвлөлт

Тусгай хамгаалалттай газрын тухай хуулинд тусгай хамгаалалттай газрыг бүсчлэх тухай заасан байдаг. Жишээ нь дархан цаазат газруудыг онгон бүс, хамгаалах бүс, хязгаарлалтын бүс гэж хуваадаг бол Байгалийн цогцолбор газруудыг онцгой бүс, аялал жуулчлалын бүс, хязгаарлалтын бүс гэж хуваадаг. Харин практик амьдрал дээр бүсчлэл нь зэрлэг ан амьтдын үнэлэмжийг тодийлөн сайтар тусгахгүйн зэрэгцээ менежментийн хэрэгцээ шаардлагыг зөв тусгаагүй байдаг. Яг газар дээрээ бүсчлэл төдийлөн мэдрэгддэггүй бөгөөд тур операторууд болон цогцолборт газрын менежерүүд үүний байршлын талаарх тодорхой ойлголтгүй шахам байдаг. Аливаа бүсчлэлийг харуулсан газрын зураг ихэвчлэн байдаггүй. Тусгай хамгаалалттай газрын доторх бүсчлэлийн өөрчлөлтийн асуудлыг засгийн газар шийддэг ба одоогоор энэ талаар нэг ч шийдвэр гарч байгаагүй байна. Жишээ нь анхаарвал зохих нуурын эрэг орчмыг байгалийн цогцолборт газрын бүсчлэлд харгалзан үзээгүй бололтой (Вингстен, 2005).

Байгалийн цогцолборт газрын менежмент

Тусгай хамгаалалттай газрын менежмент болон аялал жуулчлалын салбар засгийн газраас их хамааралтай юм. Дархан цаазат газрууд болон Байгалийн цогцолборт газруудыг засгийн газраас удирддаг ба улсын төсвийн санхүүжилтээр бараг бүх үйл ажиллагаа нь явагддаг. Хөгжиж буй бүхий л орны нэгэн адил Монголын хувьд төсөв санхүүгийн дутмаг байдал хурц асуудал байдгийн зэрэгцээ хүн хүчний болон санхүүгийн нөөцөөр нэн хязгаарлагдмал байдаг юм.

ДБХС-ийн Монгол дахь Хөтөлбөрийн газрын Тусгай хамгаалалттай газрын менежментийн түргэн үнэлгээ болон нэн тэргүүний асуудлын жагсаалтад (Батсүх, Белокуров, 2005) боловсон хүчин, харилцаа холбоо, дэд бүтэц, тоног төхөөрөмж болон санхүүгийн эх үүсвэр зэргийг шинжилж “цалингийн төвшин бага, ажил эрхлэлтийн бусад нөхцөл байдлын улмаас зөвхөн цөөн тооны ур чадварын хувьд шаардлага хангахгүй боловсон хүчин авч ажиллуулах” нөхцөл бүхий “менежментийн бүхий л төвшинд байнга нөөцөөр дутмаг” хэмээн уг тогтолцоог тодорхойлжээ.

Иймээс Монголын тусгай хамгаалалттай газрууд хангалтгүй санхүүжилттэйгээс гадна хүчин чадавхиар дорой тул “хувийн хэвшилд чадавхигүй түнш” болдог. (Вингстен, 2005). Аялал жуулчлалын салбарыг эдийн засгийн хөгжлийн тэргүүлэгч чиглэл хэмээх аваас засгийн газраас байгалийн цогцолборт газрын менежментэд зориулж улсын төсөвт хөрөнгө оруулалтын зардал тусгах шаардлагатай.

Жуулчдад байгаль орчин хамгаалах талаар сурталчлах

Ихэнх жуулчид тусгай хамгаалалттай газрын зорилго, ач холбогдол хийгээд хамгаалалтын ерөнхий хэрэгцээг ойлгодог. Гэвч тэдгээрт тодорхой газрыг хамгаалах үнэлэмж, хурцаар тавигдах асуудлуудын талаарх мэдээллийг хангалттай өгдөггүй, ямархуу үйл ажиллагаа зүй зохисгүй болохыг ч сайн тайлбарлаагүй байдаг. Жишээ нь, Хүйсийн найман нуурын байгалийн түүх, соёлын дурсгалт газарт хийсэн ярилцлагаас үзвэл жуулчид уг газар хэрхэн бие авч явах талаар ойлголтгүй байсны зэрэгцээ тухайн газрын талаар ямар ч анхан шатны мэдээлэлгүй бөгөөд ихэнх нь товхимол, газрын зураг болон мэдээллийн самбар зэргээс мэдээлэл авах хүсэлтэй байгаагаа илэрхийллээ (Шлейчер, Хотц, 2007) гэжээ.

8. Зөвлөмж

8.1. Уул уурхай, дэд бүтцийн үйл ажиллагаатай холбоотой байгалийн чухал нутгуудын хамгааллын талаарх зөвлөмж

Уул уурхайн тусгай зөвшөөрөл олгох үйл явцад байгаль хамгаалах асуудлыг тусгах талаарх зөвлөмж

1. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай 1998 оны хуулийн 5 дугаар зүйл болон Ашигт малтмалын тухай 2006 оны хуулийн 24, 26 дугаар зүйлүүдийг Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ болон уул уурхайн тусгай зөвшөөрөл олгох үйл явцад олон нийттэй зөвлөлдөх асуудлыг заавал биелүүлэх шаардлага болгон тус тус өөрчлөх.
2. Ашигт малтмалын тухай 2006 оны хуулийн 19 дүгээр зүйлд тусгагдсан хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдлийг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор аймгийн засаг даргаас саналаа өгөх гэснийг наандаж 90 хоног болгон, орон нутгийн холбогдох ард иргэдтэй (зөвхөн орон нутгийн ИТХ биш) зөвлөлдөх асуудлыг албан ёсны заавал биелүүлэх шаардлага болгон өөрчлөх.
3. Ашигт малтмалын тухай 2006 оны хуулийн 19 дүгээр зүйлийг АМГТХЭГ-аас хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл бүрийг БОЯ-нд хянуулахаар хүргүүлж олгохоос өмнө тус яамны зөвшөөрлийг авах гэж өөрчлөх. Уг алхмыг холбогдох өргөдлийг аймаг (буюу нийслэл хотын) засаг даргад хүргүүлэх аваас өргөдлийн үйл явцын хугацаа сунжрахгүй юм.
4. Газарзүйн мэдээллийн системийн мэдээллийг боловсруулдаг байгууллагаас (Монгол дахь ДБХС, Байгаль хамгаалал болон зэрлэг амьтан судлан хамгаалах төв) АМГТХЭГ-ын Геологи, уул уурхайн кадастрын газар байгалийн чухал нутгуудын (Ялангуяа орон нутгийн ТХГН болон ШЧГ-ын тухай) тухай сүүлийн үеийн ГМТ-ны мэдээллийг өгч байх. Мөн Ашигт малмталын тухай 2006 оны хуулийн 19, 24 дүгээр зүйлүүдийн дагуу эдгээр тусгай зөвшөөрлийн өргөдөлд уг мэдээлэл хэрхэн холбогдол бүхий болохыг холбогдох ажилтнуудад мэдээлэх.

Хайгуул, олборлолтын тусгай зөвшөөрөл бүхий болон байгалийн чухал нутгуудын хооронд оршиж буй давхардлыг шийдвэрлэх зөвлөмж

5. Газрын тухай 2002 оны хуулийн 16 дугаар заалтын дагуу Тусгай хэрэгцээний газар гэгдэх нэг буюу түүнээс дээш байгалийн чухал нутгуудтай бага зэрэг давхардаж буй хайгуулын тусгай зөвшөөрлийг шинэчлэх үед хайгуулын талбайн хил хязгаарыг дахин хянах.
6. Хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий газар нэг буюу түүнээс дээш Улсын ТХНГ болон /буюу орон нутгийн ТХГН-тай үлэмж хэмжээгээр давхардсан, мөн асуудалтай байгаа хамгаалалттай газар буюу газруудыг байгуулсан хугацаа хайгуулын тусгай зөвшөөрлөөс өмнөх бол Ашигт малтмалын тухай 2006 оны

хуулийн 17 дугаар зүйлийг зөрчсөн тул нөхөн олговор огт төлөхгүйгээр тухайн тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож байх

7. Хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий газар нэг буюу түүнээс дээш Улсын ТХГН, орон нутгийн ТХГН-тай бага хэжээгээр давхардаж тусгай зөвшөөрөл асуудалтай байгаа хамгаалалттай газраас өмнө олгогдсон бол уг тусгай зөвшөөрлийг заагдсан хугацаанд хүчинтэй хэмээн тооцно. Харин эдгээр тусгай зөвшөөрлийн хугацааг сунгаж шинэчлэх асуудал давхардлыг арилгах оролдлогын хүрээнд тухайн хайгуулын талбайн хил хязгаарт гарах өөрчлөлтөөс хамаарна.

8. Олборлолтын тусгай зөвшөөрөл бүхий газар нэг буюу түүнээс дээш Улсын ТХГН, орон нутгийн ТХГН-тай давхардсан, мөн асуудалтай байгаа хамгаалалттай газрыг олборлолтын тусгай зөвшөөрөл олгохоос өмнө байгуулсан бол Ашигт малтмалын тухай 2006 оны хуулийн 24 дүгээр заалтыг зөрчсөнд тооцно. Гэхдээ тусгай зөвшөөрөл эзэмшигч тухайн тусгай хамгаалалтай газар мэдэлгүй үйл ажиллагаа явуулсан бол аливаа нөхөн олговор олголгүйгээр тусгай зөвшөөрлийг цуцлах нь томоохон шийтгэл болно. Тусгай хамгаалалттай газрыг тогтоосон эрх бүхий байгууллага (ихэнх тохиолдолд орон нутгийн ТХГН-ууд хамрагддаг тул аймаг, сумдын засаг захиргаа) тусгай зөвшөөрөл эзэмшигчтэй яриа хэлэлцээ явуулж одоогийн тусгай зөвшөөрлийг байгалийн чухал нутгуудтай давхацдаггүй талбайн тусгай зөвшөөрлөөр солих асуудал тавина. Солилцоогоор шинээр олгогдохоор санал болгох уг тусгай зөвшөөрлийг үйл ажиллагаа идэвхтэй явуулдаггүй, дампуурсан эсвэл татвараа төлдөггүй болон байгаль орчны хамгааллын дүрэм журмыг баримталдаггүй аж ахуйн нэгжүүдээс шилжүүлнэ. Энэ тохиолдолд ашигт малтмалын тусгай зөвшөөрлийг арилжаалах буюу шилжүүлэхийг хориглох

9. Олборлолтын тусгай зөвшөөрөл бүхий газар нэг буюу түүнээс дээш Улсын ТХГН, орон нутгийн ТХГН-тай давхардаж олборлолтын тусгай зөвшөөрлийг асуудалтай байгаа тусгай хамгаалалттай газрыг байгуулахаас өмнө олгосон бол уг тусгай зөвшөөрөл хүчинтэй байна. Цөөн тохиолдолд (жишээ нь биологийн нэн чухал төрөл зүйл бүхий газрын хамгаалалттай уг уурхай харшилж байвал) тусгай хамгаалалттай газрыг тогтоосон эрх бүхий байгууллага (ихэнх тохиолдолд аймаг, сумдын засаг захиргаа) Ашигт малтмалын тухай 2006 оны хуулийн 14,56 дугаар зүйлүүдийн дагуу уг тусгай зөвшөөрлийг цуцлаж эзэмшигчид нь нөхөн олговор төлөх

10. Талбайд хамрагдах олборлолтын тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан эсэхийг үл харгалзан АМГТХЭГ-аас Улсын болон орон нутгийн ТХГН-т шинээр нэг ч тусгай зөвшөөрөл олгохгүй байх

11. Тусгай хамгаалалттай газрын тухай 1994 оны хуулийн 3,28 дугаар зүйлүүдийн дагуу аймаг, сумын засаг захиргаанаас орон нутгийн ТХГН-ийг байгуулахдаа бодитой байдалд нийцсэн, шинжлэх ухааны үндэслэлтэй удирдамж, шалгуурыг боловсруулж мөрдөх. Эдгээр шалгуурыг холбогдох орон нутгийн засаг захиргаадаар дамжуулан орон нутгийн бүхий л ТХГН-т мөрдүүлэх. Эдгээр шалгуурт нийцэхгүй газруудыг хамгаалалтын бүсээс гаргах. Түүнчлэн орон нутгийн ТХГН-ийн менежментийн стандарт журмыг боловсруулж мөрдүүлэх.

Монгол орны хамгаалалттай газрын тогтолцооноос гадуурх байгалийн чухал нутгуудын хамгааллыг бэхжүүлэх тухай зөвлөмж

12. Газрын тухай 2002 оны хуулийн 16 дугаар зүйлийн дагуу Тусгай зориулалтын газрын тодорхойлтыг байгаль орчны олон улсын гэрээ хэлэлцээрийн хүрээнд хамгаалалтанд багтах учиртай газрууд (Рамсарт бүртгэгдсэн газар, шим мандлын гол газрууд болон Дэлхийн өвийн санд бүртгэгдсэн газрууд) болон

тахилага шүтлэгтэй газруудыг хамран өргөтгөх замаар эдгээр газруудыг хайгуул, олборлолтын тусгай зөвшөөрлөөс хамгаалах.

13. Улсын болон орон нутгийн тусгай хамгаалалттай газрын хүрээнд бүрэн хамгаалагдсан Рамсарт бүртгэгдсэн газар болон ШЧГ-ыг Улсын ТХГН, орон нутгийн ТХГН гэж тогтоох асуудлыг харгалзах, ялангуяа эдгээрийг хамгаалалттай бүсээс гаргах нь Монголын тусгай хамгаалалттай газрын тогтолцооны хамрах хүрээнд оршиж буй доголдлыг арилгахад дөхөм болно.

14. Одоогоор албан ёсоор тусгай хамгаалалтанд ороогүй боловч засгийн газраас тусгай хамгаалалтанд авахаар санал болгосон газруудад тогтоогдсон хамгаалалттай газруудад (Улсын ТХГН болон орон нутгийн ТХГН) хамрагдах хайгуул, олборлолтын хоригийг хэрэглэх. Тухайн орны томоохон хэмжээний газрыг тусгай хамгаалалттай газрын саналын улмаас хайгуул, олборлолтын үйл ажиллагаанаас ангид байлгахаас сэргийлэх үүднээс санал дэвшүүлсэн цагаас хойших тодорхой хугацаанд (магадгүй хоёр жил) хайгуул, олборлолтын тусгай зөвшөөрлийн уг мораториумыг хүчинтэй байлгах. Энэ хугацаанд уг газрыг албан ёсоор тусгай хамгаалалттай хэмээн зарлаагүй бол уг мораториумыг цуцална.

15. 2007 оны Ойн тухай хуулийн 8 дугаар зүйлийг хамгаалалттай ойн бүсэд хайгуул, олборлолт явуулахыг хориглосон гэж ойлговол эдгээр газрыг тэмдэглэж үүнд тооллого явуулах ёстой ба АМГТХЭГ-ын Геологи, уул уурхайн кадастрын газар холбогдох Газарзүйн мэдээллийн системийн мэдээллийг хүргүүлнэ. Ашигт малтмалын тухай 2006 оны хуулийн 17, 24 дүгээр зүйлүүдийг дахин хянаж хайгуул, олборлолтын тусгай зөвшөөрөл олгогдохгүй газрын ангилалд хамгаалалттай ойг оруулах

16. Хамгаалалттай нуур, зэрлэг ан амьтны коридорыг хамгаалдаг ой зэрэг тусгай хамгаалалттай газрын экологийн нөхцөл байдлыг хадгалахад ач холбогдол бүхий газруудыг тогтоох үндэсний хэмжээний судалгаа хийх.

17. Дэлхийн банкнаас байгалийн чухал нутгуудын нэмэлт жагсаалт бий болгож Монголын ШЧГ-ын жагсаалтыг (Азийн бусад орныхыг ч мөн адил) албан ёсоор батлах.

Байгалийн чухал нутгуудын хамгааллыг бэхжүүлэх зөвлөмж

18. Монголын тусгай хамгаалалттай газрын тогтолцооны менежментийн үр ашгийн талаар сүүлийн үед ДБХС-аас хийсэн судалгааны зөвлөмжийг (Батсүх, Белокуров, 2005) хэрэгжүүлэх.

19. Гар аргаар олборлолт ихээхэн төвлөрсөн газруудад байгаль орчны хамгаллын дүрэм журмыг чанд мөрдүүлэх. Ялангуяа гар аргаар болон бичил уул уурхайн үйл ажиллагааны тухай түр журмын 10 дугаар зүйлд заасны дагуу тусгай хамгаалалттай газар болон Тусгай зориулалтын газар гар аргаар олборлолт явуулахыг хориглосныг чанд мөрдүүлэх.

20. Олон улсын хандивлагчдын оролцоотойгоор үндэсний болон сум орон нутгийн төвшинд Улсын мэргэжлийн хяналтын газрын үйл ажиллагааг дэмжих хөтөлбөр боловсруулах. Энэхүү хөтөлбөрт газар дээрх үр ашигтай мониторинг, байгаль орчны хамгаалалтын дүрэм журмыг сахиулахад учрах хүн хүч, мэдлэг чадвар, тээвэр, харилцаа холбооны төхөөрөмж, байгууллага хоорондын уялдаа холбоо зэрэгтэй холбоотой саад бэрхшээлийг арилгах.

Уул уурхайн аж ахуйн нэгжүүдийн байгаль хамгаалах үйл ажиллагааг сайжруулах талаарх зөвлөмж

21. Аж ахуйн нэгж уул уурхай нь тухайн газрыг орхин явсан, тусгай зөвшөөрлийн дагуу хүлээсэн үүрэг амлалтаа биелүүлээгүй нөхцөлд уг газрыг нөхөн сэргээх ажлын өртөг зардлыг нөхөх хэмжээний байгаль орчны хамгаалалтад зарцуулагдаж, буцаан олгогдох баталгаат хөрөнгө

байршуулахыг хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдээс Ашигт малтмалын тухай 2006 оны хуулийн 39 дүгээр зүйлийн дагуу шаардах.

22. Монголын уул уурхайн салбарын байгаль орчин, нийгмийн үр нөлөөллийг тодорхойлох зорилгоор Дэлхийн банкнаас сүүлийн үед хийсэн судалгааны зөвлөмжинд тусгагдсаны дагуу (Дэлхийн банк, 2006) шороон ордуудад хамгийн тэргүүний технологи нэвтрүүлэхийг засгийн газраас дэмжиж, гар аргаар болон бичил уул уурхайн үйл ажиллагааг тодорхой газруудад явуулахыг хориглох тухай хууль батлан мөрдүүлэх.

23. Монголд холбогдол бүхий уул уурхайн үйл ажиллагаанд хамруулах тэргүүн туршлагыг сонгохдоо Монголын засгийн газар нилээд хянуур хандлага баримтлах. Ялангуяа нөлөөллийг багасгах эрэмбэ дарааллыг баримтлан, биологийн төрөл зүйлд үзүүлэх нөлөөллийг удирдан зохицуулахыг засгийн газар уул уурхайн аж ахуйн нэгжээс шаардах

24. Тусгай хамгаалалттай газрын дотор буюу ойролцоо явагдах уул уурхайн үйл ажиллагааны орлогыг тогтоох техник, эдийн засгийн судалгаа явуулах. Энэхүү судалгаагаар эдгээр тусгай хамгаалалттай газрын хамгаалалтын менежмент, эдгээрийн орчмын бүсэд аж төрж буй ард иргэдийн тогтвортой хөгжлийг дэмжих.

25. Энэхүү техник, эдийн засгийн судалгаа, бизнес, биологийн төрөл зүйлийн хөтөлбөр зэрэг санал санаачлагын дадлага туршлага дээрээ тулгуурлан биологийн төрөл зүйлийн нөхөн тэнцвэржүүлэлтэд хөрөнгө оруулах замаар үр дагаврыг багасгах. Үүний дараа биологийн төрөл зүйлд нөлөөлөх нөлөөллийг нөхөн төлөхийг уул уурхайн аж ахуйн нэгжүүдээс шаарддаг журмыг Монголын засгийн газар батлан нэвтрүүлэх.

8.2. Аялал жуулчлалын үйл ажиллагаатай холбоотой байгалийн чухал нутгуудын хамгааллын талаарх зөвлөмж

Тогтвортой аялал жуулчлалын хөгжлийн төлөвлөлтийг сайжруулах тухай зөвлөмж

1. Монголын засгийн газраас хувийн хэвшлийн сонирхогч талууд, иргэний нийгэм болон хандивлагчдын хамтын нийгэмлэгийн оролцоотой үндэсний тогтвортой аялал жуулчлалын стратегийг боловсруулах шаардлагатай байна. Уг стратеги нь тус улсын тогтвортой аялал жуулчлалын хөгжлийг тусгасан, Монголын аялал жуулчлалын салбарыг 2007-2011 онуудад хөгжүүлэх баримт бичиг байх учиртай.

2. Аймгийн төвшинд аялал жуулчлалыг хөгжүүлэх хэсэгчилсэн төлөвлөгөө боловсруулах хэрэгтэй байна. Үндэсний аялал жуулчлалын тогтвортой хөгжлийн стратеги болон энэ судалгааны үр дүнгээс хамаарах эдгээр төлөвлөгөөнд аялал жуулчлалын үйл ажиллагаанд зохимжгүй газруудыг тусгаж, тогтвортой аялал жуулчлалын боломж бүхий газруудыг тодорхойлох юм. Орон нутгийн засаг захиргааны хувьд аялал жуулчлалын үйл ажиллагаанаас орох орлого эдгээр газрыг хөгжлийн буруу гольдрилоос хамгаалах хөшүүрэг болж үйлчлэх учиртай.

3. Аймгийн төвшний эдгээр төлөвлөгөөг боловсруулах ажлыг зохион байгуулах үүднээс мэргэжлийн хүмүүс болон орон нутгийн ард иргэдийн зөвшилцлийн үндсэн дээр БОЯ-аас тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх хамгаалалттай газруудын дараачийн багцыг тодорхойлно. Зүй зохистой газар нутгийг тодорхойлж, Байгаль орчны нөлөөллийн үнэлгээг хийж зөвшилцөн, тогтвортой аялал жуулчлалыг хөгжүүлэх төлөвлөгөөг боловсруулах хүртэл аялал жуулчлалыг шинээр өөр газруудад явуулахгүй байх.

4. Олон улсын байгаль хамгаалах холбооны Зүүн Азийн байгалийн цогцолборт газар болон хамгаалалттай газар нутгуудад

аялалжуулчлалынүйлажиллагааявуулах удирдамжийг (Иглз 2001 он) мөрдлөг болгож, одоогоор аялал жуулчлал идэвхитэй хөгжиж буй хамгаалалттай газар тус бүрээр тогтвортой аялал жуулчлалын төлөвлөгөөг боловсруулах шаардлагтай (Бүлэг 9.2). Эдгээр төлөвлөгөөг ЗТАЖЯ, БОЯ, орон нутгийн засаг захиргаа зэрэг холбогдох эрх бүхий байгууллагын оролцоотой боловсруулах ба ингэхдээ байгаль хамгаалах болон аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлд тухайн орны хуримтлуулсан туршлага дээр тулгуурлах

5. Одоогоор аялал жуулчлалын үйл ажиллагаа хурц асуудал болоод байгаа тусгай хамгаалалттай газар нутагт тогтвортой аялал жуулчлал хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулсны дараа ирээдүйд аялал жуулчлал хөгжих боломжтой бусад тусгай хамгаалалттай газруудыг хамран уг төлөвлөгөөг боловсруулах

Тогтвортой аялал жуулчлалын хөгжлийг дэмжих зөвлөмж

6. Аялал жуулчлалын төвлөрсөн веб-д тулгуурласан тодорхой удирдамжийг боловсруулж, олон нийтэд хүртээжтэй болгох. Эдгээр мэдээллийг тогтвортой аялал жуулчлал хөгжүүлэх төв дээр төвлөрүүлж орон нутагт тулгуурласан аялал жуулчлалын сүлжээгээр түгээх боломжтой. Эдгээр баримт бичигт тогтвортой аялал жуулчлалын төлөвлөлт, гэр баазуудын хөгжил, зочдын менежмент, жуулчдын мэдлэг мэдээлэл, хатуу хог хаягдлын болон бохир усны менежмент зэрэг сэдвийг тусгах.

7. Аялал жуулчлалын аж ахуйн нэгжүүд, байгаль хамгаалах байгууллагууд, үндэсний тогтвортой аялал жуулчлалын стратегийн зорилгыг биелүүлэх тусгай хамгаалалттай газрын захиргаадын хамтарсан санал санаачлагыг дэмжих үүднээс нэг буюу түүнээс дээш тооны сонирхогч хандивлагчдын хөрөнгөөр салбар дундын сан байгуулах.

Тусгай хамгаалалттай газар нутгийн санхүүжилтэд хувь хандив оруулах аялал жуулчлалын боломжийг хэрэгжүүлэх зөвлөмж

8. Аялал жуулчлалын ихээхэн боломж бүхий зарим тусгай хамгаалалттай газруудад санхүүжилт, захиргааны шинэлэг загварыг туршилтын журмаар нэвтрүүлэх. Эдгээр загварт тусгай хамгаалалттай газрын бизнес төлөвлөгөө, удирдлагын зөвлөл дэх хувийн хэвшлийн төлөөлөл, орон нутгийн мэдлийн төвлөрсөн бус орлогын урсгал зэргийг хамрах. Эдгээр туршилтаас хуримтлагдах дадлага туршлагыг баримтжуулж үндэсний бодлого боловсруулахад хэрэглэх.

9. Тусгай хамгаалалттай газар болон тэдгээрийн орчны бүсэд явагдаж буй аялал жуулчлалын үйл ажиллагааны орлогын урсгалын судалгаа хийх. Энэ судалгаанд эдгээр газрын хамгаалалтын менежментийг сайжруулах, орчны бүсэд аж төрж буй орон нутгийн ард иргэдийн тогтвортой хөгжлийг дэмжих арга хэмжээнд уг орлогыг ашиглах боломжийг тусгах. Ийнхүү санхүүжилтийн тогтвортой механизмууд нь аялал жуулчлал эрхлэгчдийн хувьд өөрийн хэрэглэгчдийн ирж үзэх сонирхол бүхий газруудыг хамгаалахад хувь нэмэр оруулах боломжийг тусгах болно.

9. Байгалийн чухал нутгуудын хамгааллыг сайжруулж, сөрөг үр дагаврыг багасгахад чиглэсэн тэргүүн туршлагууд

9.1. Уул уурхай, дэд бүтцийн үйл ажиллагаатай холбоотой тэргүүн туршлага

Энэ баримт бичгийн 6.1, 6.2-р бүлгүүдэд үзүүлсэний дагуу Монгол оронд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх боломж олгосноор хайгуул, олборлолтын тусгай зөвшөөрлийг хэрэглэх тухай хууль батлагдсан хэдий ч уг үнэлгээнд БОЯ, уул уурхайн үйл ажиллагаанд холбогдох орон нутгийн ард иргэдийн оролцоог хангах талаар уг хуульд сул талууд ажиглагдаж байна.

Энэ бүлэгт Монголын хууль эрх зүй болон бодлогын цар хүрээнээс хальж байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг багасгах зорилгоор уурхайг хөгжүүлэх төлөвлөгөөг хэрхэн үр ашигтай болгох зэргээр бусад орны тэргүүн туршлагаас суралцахыг чухалчлан авч үзлээ. Бусад орны холбогдох тэргүүн туршлагыг байгалийн чухал нутгууд, тэдгээрт оршин амьдрах зүйлүүдтэй уялдуулсан ба Монголын биологийн төрөл зүйлийг хамгаалахад уул уурхайн хөгжил зүй зохистой байдлаар хувь нэмэр оруулах учиртайг харгалзан судалгаа явуулав. Энэ бүлэгт байгаль орчин, уул уурхайн хууль эрх зүйн актуудын тэргүүн туршлага болох хэд хэдэн жишээг дурьдсан бөгөөд уул уурхайн салбарын практик дүрэм зааврууд, сөрөг нөлөөллийг багасгах эрэмбэ дараалыг баримталсан байгаль орчны зорилго бүхий уул уурхайн төлөвлөлтийг харгалзан үзлээ. Энэ сэдэвт уул уурхайн салбарын байгаль орчны хамгаалалттай холбоотой үзүүлэлтийг сайжруулах үүднээс биологийн төрөл зүйлийн нөхөн тэнцвэржүүлэлтийг зүй зохистой хэрэглэх шаардлагын талаар ч дурьдсан болно.

Уул уурхай, байгаль орчинтой холбоотой үр дүнгээ өгсөн хууль эрх зүйн баримт бичгүүдийн зарим жишээ

Энэ бүлэгт дэлхий нийтэд хэрэглэж буй байгаль орчны хууль тогтоомжийг нэг бүрчлэн судлан томьёолох зорилгыг агуулаагүй бөгөөд Монголын хууль тогтоомжийг илүү үр дүнтэй болгох боломж бүхий байгаль орчны холбогдолтой зарим хууль эрх зүйн актуудыг дурьдав. Биологийн төрөл зүйл болон газрын хамгаалалт, уул уурхайн үйл ажиллагааны менежментийн талаар хоёуланг нь хамарсан бусад орны хууль эрх зүйн зарим актыг дурьдсан болно. Хариуцлагатай уул уурхайг хэрэгжүүлэхэд биологийн төрөл зүйлийг хамгаалах, байгаль орчныг хөгжлийн олон хэлбэрээс хамгаалах, уул уурхайн тусгай зөвшөөрөл олгож хэрэгжүүлэх тухай хууль тогтоомжийн хооронд нягт уялдаа байх учиртай (газарт нэвтрэх, уул уурхайн эрх, уурхайг хаах болон олборлолт хийсэн газрыг нөхөн сэргээх зэрэг).

Европын холбоо ба түүний гишүүн орнуудын туршлага

Биологийн төрөл зүйл, тэдгээрийн амьдрах орчны хамгаалал: Амьдрах орчны талаарх удирдамж болон шувуудын талаарх удирдамж зэрэг баримт бичгүүд нь Европын

холбооны гишүүн орнуудын байгаль орчны хамгааллын бодлогыг тодорхойлж байдаг. Байгалийн чухал нутгуудын хоёр гол арга хэмжээний хүрээнд үүнийг хэрэглэдэг: хамгаалалттай газрын Natura 2000 сүлжээ болон төрөл зүйлийн хамгааллын харийн нягт тогтолцоо. Амьдрах орчны талаарх удирдамжинд[3] Европын хувьд ач холбогдол бүхий амьтан, ургамлын зүйл (Хавсралт II) хийгээд "амьдрах орчны төрөл" (Хавсралт I) хэмээх 200 гаруй тодорхой томьёологдсон нэр төрлийг хамгаалжээ. Нэн тэргүүний ач холбогдол бүхий зүйл болон амьдрах орчныг хамгаалалтын статусыг нь үндэслэн тодорхойлсон юм. Европын холбоо биологи газар зүйн 9 бүстэй. Гишүүн орнуудын санал болгосон жагсаалтыг үндэслэн Natura 2000 газруудыг сонгов. Биологи, газар зүйн бүс болгонд зориулж комиссоос улмаар сүлжээний бүрэлдэхүүн хэсэг болох орон нутгийн чухал газруудыг (ОНАХБГ) сонгодог. Эцэст нь үндэсний төвшинд ОНАХБГ-уудыг Хамгаалалтын тусгай бүс хэмээн (ХТБ) тогтоодог. Европын холбооны олон янзын амьдрах орчин болон тэдгээртэй холбоотой төрөл зүйлийн биологи, газар зүйн дүн шинжилгээнд тулгуурласан тусгай хамгаалалттай газрын сүлжээг Natura-2000 гэж тодорхойлдог.

Шувуудын чиг баримжаанд[4] нь байгаль орчны талаарх Европын холбооны баталсан хамгийн эртний хууль тогтоомж ба холбооны хүрээнд байгальд орших зэрлэг шувуудын төрөл зүйлийг хамгаалах иж бүрэн загварыг буй болгох хамгийн чухал баримт бичиг. Ихэнх нь нүүдлийн шинжтэй байдаг зэрлэг шувууд нь гишүүн орнуудын дундын өмч, өв болох тул тэдгээрийг үр ашигтай байдлаар хамгаалах нь олон улсын хамтын ажиллагааны зүй ёсны асуудал мөн. Уг баримт бичигт амьдрах орчны доройтол болон сүйрэл нь зэрлэг шувуудын хувьд хамгийн ноцтой аюул гэдгийг хүлээн зөвшөөрчээ. Иймээс уг баримт бичигт зэрлэг шувуудын популяцийн хувьд онцгой ач холбогдолтой газруудыг тодорхойлохын зэрэгцээ устах аюул бүхий төрөл зүйл болон нүүдлийн шувуудын төрөл зүйлийн аль алины амьдрах орчныг хамгаалах хэрэгцээ шаардлагыг тод томруун тусгажээ (Хавсралт 1-т тусгагдсан). Эдгээр төрөл зүйлд хамгийн тохиромжтой бүхий л газруудыг хамарсан тусгай хамгаалалттай газрын сүлжээг байгуулсанаар дээрх зорилгод хүрэх юм. 1994 оноос хойш бүх ТХГН нь Natura 2000 экологийн сүлжээний бүрэлдэхүүн хэсэг болсон юм. BirdLife International-ын ШЧГ-ын глобал шалгуур Европын Холбооны ТХГН-ийг давтсан ч Европын Холбооны ШЧГ (уг шалгуурыг хангах) заавал ТХГН-ийн статусаар хамгаалагдаагүйг анхаарах хэрэгтэй юм.

Байгаль хамгаалах хууль тогтоомж нь бүтцийн, тээврийн буюу хөдөө аж ахуйн гэх зэрэг Европын Холбооны бусад бодлогыг хэрэгжүүлэхэд заавал харгалзан үзвэл зохих хууль тогтоомжууд юм. Дотоодын хөгжлийн төлөвлөлтийн болон байгаль орчны хууль тогтоомжууд нь Европын Холбооноос гаргасан амьдрах орчны ба шувуудын талаарх удирдамжтай уялдаатай байх ёстой. Жишээ нь, Нэгдсэн Вант Улсад хөгжлийн чанартай төлөвлөлтийн бүхий л хууль тогтоомж Европын Холбооноос гаргасан амьдрах орчны ба шувуудын талаарх удирдамжтай уялдаатай байх шаардлага тавигддаг. Орон нутгийн эрх баригчид болон хөгжлийн төлөвлөгч нарын санал болгосон аливаа уялдаа холбоогүй асуудлыг засгийн газар анхааралтай судлаж нягталдаг байна.

Томоохон хэмжээний болон төрөлжсөн газарзүйн бүсийг хамарч хамгаалалтад авах төрөл зүйл ба газар нутгуудыг аюул занал, биологи, газарзүйн ач холбогдлоор нь сонгодогт энэ хууль тогтоомжийн гол ач холбогдол оршдог. Түүнчлэн уг хууль тогтоомж нь хэвтээ бүтэцтэй тул салбарууд дундаа сахин мөрдөх статустай байдаг.

Америкийн Нэгдсэн Улсын жишээ

Устах аюул бүхий төрөл зүйлийн тухай хууль (УАБТЗТХ, 1973) нь амьдрах орчин, экологийн тогтолцооны хамгаллын төрөл зүйлд төвлөрсөн хандлагыг баримталсан маш чухал хууль тогтоомж юм. Энэхүү хууль тогтоомжийг Байгаль хамгаллын хүрээний

[3] Амьдрах *орчин, зэрлэг ан амьтан, ургамлын хамгаллын тухай 1992 оны 5 сарын 2№-ий өдрийн 92/43/EEC дугаартай Зөвлөлийн удирдамж*

[4] *Зэрлэг шувуудыг хамгаалах 79/409/EEC дугаартай Зөвлөлийн удирдамж*

болон хөгжлийн салбарын аль алины төлөөллийн зүгээс ихээхэн шүүмжилдэг. УАБТЗТХуулийн зорилго нь төрөл зүйл болон тэдгээрийг хамааралдаа байлгадаг экосистемийг хамгаалахад оршино. Үүнийг засгийн газрын хоёр эрх бүхий байгууллага болох АНУ-ын Загас, зэрлэг ан амьтны алба (АНУЗЗААА) ба Үндэсний далайн загасчлалын үйлчилгээг өөртөө багтаасан Үндэсний тэнгис агаар мандлын захиргаа (ҮТАМЗ) хэмээх хоёр албанаас захиран зохицуулдаг. Хамгийн сонирхолтой нь уг хуулийг мөрдүүлэх чиглэлээр засгийн газраас дорвитой алхам хийгээгүй нөхцөлд иргэд засгийн газраа шүүхэд өгөх эрхийг уг хуулиар олгосон байдаг. Ийм ч учраас уг хуулийг 1973 онд мөрдөж эхэлснээс хойш АНУ-д байгаль хамгаалах чиглэлээр ихээхэн ахиц гарчээ. Засгийн газрын анхаарлын төвд байгаль хамгаалах асуудлыг тавин, засгийн газрын байгууллагуудын хариуцлагыг үүнд чиглүүлэхэд гол үүргийг иргэний нийгэм гүйцэтгэжээ.

Албан ёсоор “аюулд өртсөн” буюу “устах аюулд өртсөн” гэж тодорхойлогдох төрөл зүйлийг УАБТЗТ хуулиар хамгаална. Нэгдүгээрх нь төв засгийн газрын байгууллагууд санаачлага гарган тухайн төрөл зүйлийг шууд жагсаалд оруулах асуудал. Харин хоёрдугаарх нь холбогдох байгууллагуудыг шинжлэх ухааны судалгаа шинжилгээ хийхийг шаардсан хувь хүн буюу байгууллагын шаардлагаар хийгдэнэ. Сүүлийн жилүүдэд хоёр дахь хандлагыг гүйнзгийрүүлэн хэрэглэхэд иргэний нийгэм чухал үүрэг гүйцэтгэж байна.

Жагсаалтанд багтсан ихэнх төрөл зүйлийн хувьд амьдрах орчны тогтцын алдагдал хамгийн анхдагч аюул болох тул уг хуулинд холбогдох төв засгийн газрын эрх бүхий байгууллагуудыг зарим газрыг “байгалийн чухал нутгууд” хэмээн тунхаглахыг зөвшөөрчээ. 1978 онд аюулд өртсөн буюу устах аюулд өртсөн бүхий л төрөл зүйлийн хувьд байгалийн чухал нутгуудыг тодорхойлох байдлаар хуулинд нэмэлт өөрчлөлт оржээ. Төрөл зүйлийг хамгаалахад нэн шаардлагатай бүхий л газар нутгийг уг амьдрах орчны чухал газарт багтаасан байх учиртай юм (Хэсэг 3(5)(А)). Эдгээр газар нь хувийн эсвэл улсын ч байж болох юм. Байгалийн чухал нутгуудыг “сүйтгэх буюу буруугаар өөрчлөх” үйл ажиллагааг зөвшөөрөх, санхүүжүүлэх явдлыг засгийн газраас хориглодог байна (Хэсэг 7(а)(2)). Байгалийн чухал нутгуудын зохицуулалтын хүрээ хувийн болон засгийн газрын бус газрын эзэмшигчдэд хамаарахгүй ч хувийн ба улсын газарт томоохон хэмжээний хөгжлийн чанартай ажил явуулах, орон сууц барьж уул уурхайн төсөл хэрэгжүүлэхэд төв засгийн газрын зөвшөөрөл шаардагддаг тул байгалийн чухал нутгуудын дүрэм журамд захирагддаг.

1973 оноос хойш хэд хэдэн удаа улс төрийн засаг захиргаа өөрчлөгдсөнтэй холбогдуулж уг хуульд хэд хэдэн нэмэлт өөрчлөлт оруулжээ. Байгалийн чухал нутгуудад явуулах хөгжлийн чанартай үйл ажиллагааг хязгаарлах замаар жагсаалтанд орсон төрөл зүйлийг хамгаалах хүчтэй хэрэгсэл болсон хэдий ч нөгөө талаас байгаль хамгаалах үйл ажиллагаанд оролцох санал санаачлага дутмаг байжээ. Иймээс байгаль хамгаалах санал санаачлагыг өрнүүлэх хамгийн сайн арга бол төрөл зүйлийг заавал жагсаалтанд оруулах хэрэгцээ шаардлагыг болиулах асуудал байв. Төрөл зүйлийг жагсаалтанд оруулах нь газрын менежментэд ихээхэн нөлөөлдөг байсан тул зарим тохиолдолд ямар ч үнэ өртгөөр хамаагүй, төрөл зүйл болон тэдгээрийг тэтгэх амьдрах орчныг дэнчинд тавих үнээр уг жагсаалтаас зайлсхийх оролдлого хийдэг байжээ. Иймд өнөөг хүртэл уг хуульд улс төрчдийн зүгээс оролцож нэмэлт өөрчлөлт хийсээр иржээ.

АНУ-д Тусгай хамгаалалттай газрын талбайн ихэнхийг улсын газар эзэлдэг. Ийнхүү улсын газарт Байгалийн цогцолборт газар, АНУЗЗААА, Ойн алба болон Газрын менежментийн товчооны газрууд багтдаг. Эдгээр газрын доторх гол талбайг зэлүүд газар гэж тодорхойлжээ (Онгон байгалийн тухай 1964 оны хууль). Эдгээр газрыг Монголын Дархан цаазат газрын доторх онгон бүстэй адилтгаж болох юм.

Уул уурхай болон нөхөн сэргээлтийн хувьд АНУ-д мөрддөг үр дүнтэй хууль бол Газрын гадаргын олборлолтын хяналт, нөхөн сэргээлтийн тухай 1977 оны хууль

(ГГОХНСХ) юм. АНУ-ын Газрын гадаргын нөхөн сэргээлт болон хууль сахиулах албанаас захиран зохицуулагддаг уг хуулиар далд болон ил уурхайнуудад байгаль орчны зүй зохистой стандарт нэвтрүүлэхийг зорьдог. ГГОХНСХуулиар олборлолтын өмнөх байгаль орчны нөхцөл байдал болон газар ашиглалтыг танилцуулж санал болгож буй олборлолт, нөхөн сэргээлтийн агуулгыг хянан, уг уурхай ГГОХНСХ-ийн стандартад хэрхэн нийцэх болон олборлолтын дараа нөхөн сэргээлт явуулсаны эцэст газар ашиглалт ямар байх зэргийг зохицуулдаг байна. Ийм мэдээлэл засгийн газарт уг уурхайн олборлолтыг зөвшөөрөх эсэх, мөн байгаль орчны зүй зохистой хамгааллыг буй болгох нөхцөл шаардлагыг тогтооход тус дөхөм болдог. ГГОХНСХ-иар компаниудыг нөхөн сэргээлт явуулахад хангалттай хөрөнгийн баталгаа гаргахыг шаарддаг ба компани уг газрыг орхин явсан, эсвэл тусгай зөвшөөрлөөр авсан үүрэг амлалтаасаа няцсан ч нөхөн сэргээлтийн ажлыг баталгаатай хийх нөхцлийг бүрдүүлдэг. Уг баталгаат хөрөнгийг олборлолтын тухайн газрыг бүрэн нөхөн сэргээж, засгийн газраас уг нөхөн сэргээлтийн ажлыг (тодорхой хугацаа өнгөрсний дараа) хангалттай гэж үзсэний дараа эргүүлэн олгодог. ГГОХНСХ-иар хяналт шалгалт, хууль сахиулах протоколыг тогтоосон ба Байгалийн цогцолборт газар, зэлүүд газруудад уул уурхайн үйл ажиллагаа явуулахыг хориглодог. Түүнчлэн тусгай зөвшөөрөл олгох үйл явцад олон нийтийн оролцоог хангах замаар газрын гадаргын олборлолтын үйл ажиллагаанд иргэдийн зүгээс саад хориг тавихыг зөвшөөрдөг. ГГОХНСХ нь Монголын ашигт малтмалын 2006 оны хуультай нэгэн адил үйлчилгээтэй механизмтай ч ирээдүйд Монголын ашигт малтмалын хуулийг сайжруулах зорилгоор нэмэлт өөрчлөлт оруулах аваас ГГОХНСХ-ийн зарим заалтуудаас санаа авч болох юм.

Хууль эрх зүйн өөр нэг чухал баримт бичиг бол Цэвэр усны хууль (Хөтөлбөрийн 404 хэсэг) бөгөөд АНУ-ын инженерүүдийн корпус эсвэл Байгаль орчны хамгааллын агентлагийн баталсан улсын хөтөлбөр нь ус намгархаг амьдрах орчинд нөлөөлөх тусгай зөвшөөрлийг олгож үүнд тодорхой нөхцөл заах эсэхийг шийдвэрлэдэг. Уг хэрэгсэл нь хэдийгээр ус намгархаг амьдрах орчинд хамааралтай ч биологийн төрөл зүйлийн нөхөн тэнцвэржүүлэлтийн зарчмыг тодорхойлж байгаа тул чухал юм. Хөтөлбөрийн 404-р хэсгийн хүрээнд ус намгархаг газрыг алдагдалгүй байлгахын тулд эхлээд зөвшөөрөл эзэмшигч нь усанд санаатайгаар аливаа материал ялгаруулахыг хориглох, хориглох боломжгүй нөхцөлд уг хаягдлыг багасгах тухай заалт байдаг. Хог хаягдал зайлшгүй гарах тохиолдолд инженерүүдийн зөвлөлөөс /корпусаас/ тусгай зөвшөөрлийн нөхцөл болгож зөвшөөрөл эзэмшигчид багасгах шаардлага тавьдаг байна. Ус намгархаг газрууд болон бусад газрын усны нөөцөд нөлөөлөхөөс зайлсхийх боломжгүй, сөрөг нөлөөллийн улмаас гарч болох үр дагаврыг нөхөх хэд хэдэн аргын нэг нь нөхөн намжаах банк байгуулах явдал юм. Намжаах банк гэдэг нь ус намгархаг газрын нөөцийг сэргээн байгуулж баяжуулах ба хөгжлийн үйл явцын дунд байгалийн чийглэг газруудад нөлөөлөх корпусаас зөвшөөрсөн нөлөөллийг нөхөн намжаах зорилгоор байгуулах газруудыг хэлнэ.

Сөрөг нөлөөллийг намжаах банкны үйл ажиллагааг нөлөөллийг намжаах банкийг байгуулах, ажиллуулах болон ашиглахад баримтлах хууль эрх зүйн баримт бичиг болох сөрөг нөлөөллийг намжаах банкны хэрэгслээр зохицуулагдана. Сөрөг нөлөөллийг намжаах банкийг байгуулж удирдах асуудлаар корпусын дүүргийн инженерүүдэд зөвлөлгөө өгөх төв, омог, муж болон орон нутгийн зохицуулалтын болон нөөцийн агентлагийн төлөөлөлгчдийн бүлэг болох Байгууллага дундын хяналтын баг сөрөг нөлөөллийг намжаах банкны хэрэгслийг батлах ёстой. Зөвшөөрлөөс зөвшөөрлийн зарчмаар буюу нэг хэрэглэгч бүхий сөрөг нөлөөллийг намжаах банкны хүрээнд зөвшөөрлийг хүлээн авагч нь сөрөг нөлөөллийг намжаах арга хэмжээ авна. Сөрөг нөлөөллийг намжаах гуравдагч талын банк байгуулах боломж байдаг ба (сөрөг нөлөөллийг намжаах арилжаааны банк) энэ тохиолдолд зөвшөөрөл эзэмшигчээс гурав дахь этгээд төлбөр авч түүний үүрэг амлалтыг биелүүлдэг. Гэхдээ гуравдагч этгээд гэхээсээ илүү ихэнхи сөрөг нөлөөллийг намжаах арга

хэмжээг зөвшөөрөл эзэмшигч өөрөө авдаг байна.

Бохир усны хуримтлал болон олборлолтын бусад үр дагавар байгаль дахь амьдрах орчинд нөлөөлсөн тохиолдол бүхий олонхи АНУ-ын компаниуд уг механизмыг ашигласан бөлгөө. Газар зүйн хувьд ба уурхайтай холбоотой биологийн төрөл зүйлийн алдагдлыг нөхөх зорилгоор үүнийг загвар болгож хаа ч ашиглаж болно.

Бразилийн жишээ

Бразилийн засгийн газар 9985 тоот хууль дээр үндэслэн 2006 онд Байгаль хамгаалах нэгжийн үндэсний тогтолцооны талаар 371 тоот тогтоол гаргасан юм. Энэ тогтоолоор томоохон төсөл хэрэгжүүлэгчид төслийн төсвийн наанадаж 0,5 хувийг биологийн төрөл зүйлийн хамгаалалтад оруулах шаардлага тавигдсан юм. Энэхүү хөрөнгийг техникийн зөвлөлийн сонгосон Дархан цаазат газрын хэвийн байдлыг хангахад зарцуулдаг. Нөхөн төлөх энэхүү нөхөн тэгцвэржүүлэлтийн шаардлага хангах газруудад дараах газрууд ордог Үүнд:

- Орон зай, талбай, эмзэг байдал болон дэд бүтцийн шалгууруар сонгогдсон төслүүдийн нөлөөлөлд шууд өртөх одоогоор хамгаалалттай газрууд болон тэдгээрийн орчны бүс;
- Дээр дурьдсан газрууд байхгүй нөхцөлд нэг биомд буюу болж өгвөл нэг ус цуглуулах талбайд орших Дархан цаазат газрыг байгуулах, хэрэгжүүлж засвар үйлчилгээ явуулах асуудал нэн тэргүүнд тооцогдох учиртай. Тэргүүний ач холбогдол бүхий асуудлыг тодорхойлох ажилбарын үр дүнг харгалзана;
- Засгийн газрын байгаль орчны асуудал эрхэлсэн байгууллагад бичгээр санал болгосон бусад газрууд.

371 дүгээр тогтоолыг биелүүлэх үүднээс уул уурхайн компаниудад хайлуулах төхөөрөмж болон тээврийн дэд бүтэц зэрэг уул уурхайтай холбоотой аливаа төсөлтэй холбоотой биологийн төрөл зүйлийн нөхөн тэнцвэржүүлэлтэд хөрөнгө оруулах шаардлага тавигдана. Уурхайн хөгжилтэй холбоотой нөхөн тэнцвэржүүлэлтийг төв засгийн газрын төвшний байгаль орчны тусгай зөвшөөрөл олгодог байгууллага батлах ба туслах дэд бүтэцтэй холбоотойг мужийн төвшинд шийдвэрлэдэг.

Тусгай зөвшөөрөл олгох үйл явцад аливаа хөгжлийн үйл явцын улмаас биологийн төрөл зүйлд гарах нөлөөллийн нөхөн тэнцэржүүлэлтийг ашиглах механизмыг ийнхүү нэвтрүүлжээ. Бразилийн хувьд ийм механизм Бразилийн байгаль орчин, сэргээгдэх эх үүсвэрийн хүрээлэнд маш үнэтэй нөөцийг бүрдүүлдэг ч энэхүү нөхөн тэнцвэржүүлэлтийг тодорхойлох нь эдгээр хөгжлийн үйл явцын улмаас биологийн төрөл зүйлд нөлөөлөх нөлөөллийг үр ашигтай байдлаар нөхөж байгаа эсэх нь тодорхойгүй юм. Төв байгууллагаас тодорхойлсон нэн тэргүүний гэгдэх арга хэмжээг авах нөөц хөрөнгийг уг механизм гаргаж өгдөг. Ийм механизм Монголын хувьд нэвтрүүлж болох зүйлийн нэг бөгөөд хуримтлуулсан нөөц хөрөнгийг санхүүжилт багатай БОЯ нь хамгаалалттай газрын менежментийг сайжруулж хамгаалалттай газрын сүлжээг өргөтгөхөд ашиглаж болох юм.

Австралийн жишээ

Австралийн төрөл бүрийн хуулиар Монголын уул уурхайн хөгжилтэй холбоотой биологийн төрөл зүйлийн нөхөн тэнцвэржүүлэлтийг загвар болохуйц механизмыг хэрэгжүүлсэн байна. 1999 онд батлагдсан Нэгдсэн баялгийн байгаль хамгаалах болон биологийн төрөл зүйлийн хамгааллын хуульд төрөл зүйлд нөлөөлж болзошгүй боловч төрөл зүйлийн нөхөн тэнцвэржүүлэлт хэлбэрээр гарах хор хохирлыг нөхөх нөхцлийн шаардлагыг бүхий хөгжлийн чанартай үйл явцыг батлах тухай заалттай.

Ижил төстэй бодлогыг Виктория, Нью Соуф Уэлс болон бусад мужийн төвшинд нэвтрүүлж байна. Баруун Австралид Байгаль орчин хамгаалах хуулинд уугуул ургамлын аймгийг цэвэршүүлэхтэй холбоотой байгаль орчны нөхөн тэнцвэржүүлэлтийн талаар тодорхой заалт байдаг. Бүлэг 51Н(1)-т цэвэршүүлж буй ургамлыг байгалийн хор хөнөөлөөс

зайлсхийх, багасгах буюу алдагдлыг нөхөн тэнцвэржүүлэлтээр нөхөх зорилгоор шаардлагатай хэмээн тооцогдох нөхцлийн дагуу цэвэршүүлэх зөвшөөрлийг олгох тухай заажээ. Цэвэршүүлсэн ургамлын алдагдлыг нөхөх буюу уугуул ургамлын аймгийг хамгаалах зориулалт бүхий санд мөнгөн хандив оруулах зорилгоор цэвэршүүлснээс өөр ургамлыг газар дээр ургуулж арчлах тодорхой арга хэмжээ авахыг зөвшөөрөл эзэмшигчээс шаардана. Өмнөд Австралид 1991 онд батлагдсан Ургамлын тухай хуулинд Ургамлын зөвлөлөөс ургамал цэвэршүүлэхийг зөвшөөрөхдөө тодорхой нөхцөл тавьж болно гэж заажээ. Цэвэршүүлсэн нэг га газар бүрт 10 га газрын нөхөн тэнцвэржүүлэлт хийх тодорхой томьёог тогтоожээ.

Нью Соуф Уэлсэд засгийн газраас үйл явцын улмаас гарах үр дагавраас байгаль орчинд эерэг нөлөөл гарахыг баталгаажуулах Ногоон нөхөн тэнцвэржүүлэлтийн хөтөлбөр хэрэгжүүлсэн ба нөлөөллөөс залсхийх, намжаах угтвар нөхлийг харгалзсан нөхөн тэнцвэржүүлэлтийн зарчмыг баримталсан, засгийн газрын бусад хөтөлбөрийг харилцан нөхөх, урамшуулалын сайн тогтолцоотой бөгөөд байгаль орчинд нөлөөлөх цэвэр нөлөөлөл нь эерэг байх зарчмыг баримталжээ. Эдгээр нөхөн тэнцвэржүүлэлт нь тоолж болохуйц, зорилтот (“ижлийн оронд ижлийг буюу түүнээс сайн”), зүй зохистой байршил бүхий (нөлөөллийг хувьд орон нутгийн байх), нэмэлт бөгөөд мөрдөж болохуйц байх шаардлагатай.

Куинзлэндэд байгаль орчны хуулиудад гарсан өөрчлөлт болон оршиж байсан санаа санаачлагыг нэгтгэснээр Австралийн анхны ногоон сан болох шинэлэг Eco Fund Queensland-ийг 2008 оны 3 дугаар сард байгуулав. Энэхүү ногоон сан засгийн газар, хувийн хэвшил болон Австралиас гадуур үйл ажиллагаа явуулж буй түншүүдийг хөрөнгө оруулах нөхцлийг бүрдүүлнэ. Үүний зорилго нь Куинзлэндийн хамгаалалттай бүст хувь нэмэр оруулах бөгөөд уг сан дараах байдлаар ажиллана. Үүнд:

Байгаль орчны нөлөөллийг багасгах өнөөгийн хэрэгцээ шаардлагад үндэслэн санд санхүүгийн хувь хандив оруулснаар зайлсхийх боломжгүй нөлөөллийг нөхөх. Куизлэндийн байгалийн цогцолбор газар болон хамгаалалтай газрын сүлжээнд нэвтрэн орох хөгжлийн үйл ажиллагаа явуулагчийн нэрийн өмнөөс зүй зохистой нөхөн тэнцвэржүүлэлтийг мэрэгжлийн хувьд Сан тодорхойлж хадгална. Нэгэнт нөхөн тэнцвэржүүлэлтийн процедурыг сайтар байгуулсан нөхцөлд засгийн газар, салбар, мужууд болон гадаадын аж хауйн нэгжүүд уг Ногоон санд хандаж өөрсдийн хүлэмжийн хийн ялгаралтын нөхөн тэнцвэржүүлэлтийг хийх болно. Энэхүү механизм 2009 оны 1 сараас хүчин төгөлдөр болох ба үүгээр дамжуулж куинзлэнд өөрийн Байгалийн цогцолбор газрын эзэмшлээ 2020 он гэхэд 50 хувиар нэмэгдүүлэх санал гаргасан ба үүнд хоёр Тасмания арлын газар нутагтай тэнцүү хэмжээгээр буюу тусгай хамгаалалттай талбайн хэмжээ 7,6 сая га газраас 12 сая га газар хүртэл нэмэгдэх юм. Тусгай хамгаалалттай газрын хамрах талбай болон сүлжээгээ 30 хувь хүртэл нэмэгдүүлэх зоримог бодлого хэрэгжүүлэх Монголын засгийн газар уг механизмыг судлаж үзэх нь зүйтэй юм.

Монголд холбогдол бүхий зарим жишээ-зохицуулалтын хүрээнээс хальсан уул уурхайн үйл ажиллагааны байгаль орчны удирдамж

Монголын ихэнх нутаг хагас хуурайшилтай буюу хуурай газрын ангилалд ордог. Тйимээс уул уурхайн үйл явцыг харгалзахдаа засгийн газар, хувийн хэвшлийн анхаарвал зохих биологийн төрөл зүйлийн сөрөг нөлөөллийг багасгах, байгаль дахь амьдрах орчны нөхөн сэргээлтийн хувь хэмжээ болон усны менежменттэй холбоотой асуудлууд гарч ирнэ.

Түүнчлэн энэхүү тайланд тусгагдсан дүн шинжилгээгээр нийт нутгийн 90 хувь нь зөвхөн гурван төрлийн ашигт малтмал болох нүүрс, алт зэсийн олборлолтын тусгай зөвшөөрөлд хамрагдсан байна. Иймээс эдгээр ашигт малтмалын бүтээгдэхүүнтэй холбоотой байгаль орчны асуудлыг удирдан чиглүүлэх тэргүүн туршлагыг энэ тайланд дурьдах нь зүйтэй билээ.

Хуурай болон хуурайсаг орчинд уул уурхайн үйл ажиллагаа явуулах тэргүүн туршлага

Хагас хуурай болон хуурай орчинд ашигт малтмалын хайгуул хийж үндсэн үйл ажиллагаа явуулан нөхөн сэргээх арга хэмжээ авахад анхаарвал зохих хэд хэдэн асуудал бий. Хуурай болон хуурайсаг газрыг ихэвчлэн амьдрахад бэрх, бэлчээр ихээхэн хэмжээгээр ашиглахаас бусад тохиолдолд газар ашиглалтын хувьд тодийлөн үнэ цэнэтэй биш хэмээн тооцогддог. Иймээс уул уурхайн үйл ажиллагааг уламжлалт ёсоор ихэвчлэн цөлийн байгаль орчинтой холбоотой бага ч болов үлэмж ач холбогдол бүхий биологийн төрөл зүйлийг бараг харгалзахгүйгээр явуулж иржээ. Уул уурхайн үйл ажиллагааны биет ул мөр гол төлөв цөлийн амьдрах орчинд үл мэдэгдэх, орон нутгийн байгаль орчинд бага дарамттай, машин төхөөрөмж, өрөмдлөгийн хэрэгсэл, хөрс хуулалт, хаягдал хайрга чулуу болон бохир усны хуримтлал зэргээр илэрдэг. Түүнчлэн бохир ус цэвэршүүлэх төхөөрөмж үлэмж усыг ууршилтаар алдаж ийм орчинд биологийн төрөл зүйлийн хувьд амин чухал ач холбогдолтой усны коридор болон булаг шандад хөрсний усны резервуаруудыг ашигладаг уг орчинд усны хэрэглээ ихэнхдээ хариуцлагагүй бөгөөд тогтворгүй байв.

Олзуурхууштай нь хуурай болон хуурайсаг газар явагддаг томоохон оврын уул уурхайн үйл ажиллагааг тэргүүн туршлагын удирдамжийг боловсруулах замаар тодорхойлон шийдвэрлэж байна. Цөлийн орчинд уул уурхайн үйл ажиллагаа явуулах эдгээр удирдамжинд дараах асуудлыг тусгана. Үүнд:

- Машины чиргүүл, хайгуулын үйл ажиллагаа, хаягдал хайрга чулуу, хөрс хуулалтын үлдэгдэл болон ус цэвэршүүлэх төхөөрөмж зэргээр төлөөлүүлэх биет ул мөрийг багасгах;
- Металургийн боловсруулалт, ус цэвэршүүлэх менежмент, тоос багасгах болон дотоодын хэрэглээнд зориулж ус дахин боловсруулах схемүүдийг нэвтрүүлэх замаар хөрсний ус ашиглалтыг бууруулах;
- Хагас хуурай болон хуурай орчинд зэрлэг ан амьтан болон малыг бохирдсон усаар услах явдлыг багасгах;
- Хог хаягдлын тухайд дараах үр ашигтай менежментийг хэрэгжүүлэх. Үүнд:
    - Зориуд бий болгосон уст цэгийн хүртээмжийг багасгах;
    - Хөрсний ус, ус сорох системийн бохирдлоос зайлсхийх;
    - Зэрлэг ан амьтанд зориуд бэлдсэн хоол хүнс өгөхөөс зайлсхийх (энэхүү хоол хүнс махчин амьтдын популяцид нөлөөлж улмаар биологийн бусад төрөл зүйлд нөлөөлнө).
- Доройтсон амьдрах орчныг үр ашигтайгаар нөхөн сэргээх үйл явцыг дэмжих
- Салхи, усны элэгдлийн менежмент;
- Тоосны нөлөөг багасгах үр ашигтай менежмент;
- Сөрөг нөлөөллийг багасгахад амаргүй орчинд хөгжлийн чанартай үйл ажиллагаа явуулахдаа ландшафтын зүй зохистой үнэлгээ, төлөвлөлт хийх.

Олон улсын байгаль хамгаалах холбооноос хагас хуурай, хуурай орчинд олборлох үйл ажиллагаа явуулахтай холбоотой тэргүүн туршлагын хүндрэл, хандлагуудыг тусгасан экосистемийн менежментийн цуврал 2003 онд хэвлэгджээ. (Гратцфелд, 2003). Энэ баримт бичиг чухал ач холбогдолтой ба уг бүсэд уул уурхайн үйл ажиллагаа явуулахад оролцоо бүхий сонирхогч талуудад хүртээмжтэй байх учиртай.

Нүүрсний далд болон ил уурхайн удирдамжийн тэргүүн туршлага

Дэлхийн төвшинд газар доорх нүүрсний олборлолтыг өргөнөөр явуулдаг ч сүүлийн үед нүүрсний далд уурхай болон ил уурхайн арга техникийг нэвтрүүлжээ. Хэдийгээр ийнхүү арга техник анхдагч нөлөөлөлтэй ч нүүрсний геологийн хувьд уурхай үйл ажиллагаа явуулж байхад ч нөхөн сэргээлтийн ажил хийж болох нөхцлийг хангадаг юм. Ийм нөхцөлд үйлдвэрлэл явагдаж байх үед

амьдрах орчны нөхөн сэргээлт хийгдэж улмаар байгаль дахь амьдрах орчин болон бусад газрын ашиглалтад нөлөөлөх анхдагч нөлөөллийн цар хүрээ, цаг хугацааг багасгах ач холбогдолтой.

Биологийн төрөл зүйлийг хамгаалах чиглэлээр нөхөн сэргээлтийг төрөл бүрийн төвшинд явуулж ирсэн ч нүүрсний аж үйлдвэрлэлд зүй зохистой стандарт нэвтрүүлэх талаар ГГОХНС хууль хамгийн оновчтой хэрэгсэл болсон тухай энэ бүлэгт өмнө дурьдсан билээ. Аппалачийн уулархаг зүүн хэсгээр гарсан сөрөг нөлөөлөл их байсан бөгөөд үүнийг багасгах, нөхөн сэргээхэд туйлын амаргүй байлаа. Харин баруун хэсэгт ГГОХНС хуулийн хэрэгжилт илүү үр дүнтэй байв. Улмаар уг салбарын төлөөлөл Газрын гадаргын уурхайн албатай хамтран уул уурхайн бүхий л үе шатны явцад амьдрах орчныг нөхөн сэргээх өндөр стандартуудыг хэрэгжүүлэхэд ач холбогдол бүхий Баруун хэсэгт нөхөн сэргээлт явуулах арга техникийн талаарх гарын авлага боловсруулжээ.

Уг гарын авлагад үйл ажиллагааны менежмент, нөхөн сэргээлтийн арга техникийг тусган дараах асуудлыг нарийвчлан судалжээ. Үүнд:

- Өнгөн хөрсний менежмент: нөхөн сэргээх үйл ажиллагаа ба орлуулалт
- Гидрологи: хяналтын бүтэц, тундасын хяналт, гидрологийн онцлог, бүтцийн өөрчлөлт
- Топографи: уул толгодын шинжилгээ, топографийн зураглал болон арга техник
- Олборлолтын үйл явцад зэрлэг амьтан хамгаалах арга техник: хаших, цахилгаан дамжуулах шугамын нөлөөллийг багасгах, замын ачаалал болон зам харгуй, завсрын амьдрах орчин бүрдүүлэх, махчин шувуудын үүрийг сэлгэн байршуулах
- Ургамал: нөхөн ургамалжуулах хөтөлбөр хэрэгжүүлэх, үр тарих, ухалт болон гидро аргаар үр тарих, нөхөн ургамалжуулах аж ахуйн болон мониторинг
- Уурхайн дараах газар ашиглалт: төлөвлөлт, бэлчээрийн шинэ горим тогтоон удирдах, малын өнөөгийн менежмент.

Хойд Колорадо болон Вайоминг зэрэг нүүрсний уурхай олонтой АНУ-ын баруун хэсэгт Монголын байгальтай ижил төстэй хээр тал, уулархаг ландшафттай. Иймээс энэ баримт бичигт тусгагдсан эдгээр арга техникийг Монголд судлан үзэж, өөрийн онцлогт нийцүүлэн ашиглаж болох талтай.

Зэс, алтны олборлолт: Хүчлийн чулуун өрөмдлөгийн менежмент

Хүчлийн чулуун өрөмдлөгө (буюу Хүчлийн уурхайн өрөмдлөгө) гэдэг нь чулуун хүдрийн олборлолтоос ус болон агаарт ялгарах сульфидын минерал бодис хүчилтэй урвалд орох үйл явц юм. Үүний улмаас буй болох хүчлийн бодис зэрлэг амьтад болон хүний хэрэглээний усны чанарт үлэмж нөлөөлдөг. Зэсийн баяжмал зэрэг сульфидын орц ихтэй хүдрийн олборлолтод Хүчлийн чулуун өрөмдлөгийг өргөнөөр ашигладаг. Шинээр нээх уурхайн хувьд үнэлгээ нь заавал хийгдэх ёстой бөгөөд түүхэн хийгээд орхигдсон уурхайнуудад өнөөг хүртэл хүндрэл учруулдаг тул Хүчлийн чулуун өрөмдлөгө байгаль орчинд үлэмж их эрсдэл буй болгодог. Түүхийн хувьд анхнаас Хүчлийн чулуун өрөмдлөгө зохицуулалтын хүрээнд хамрагддаггүй байсан ба өдгөө байгаль орчинд урт удаан хугацаанд сөргөөр нөлөөлж өртөг зардал ихтэй нэгэн бөлгөө. Асуудал үүсгэж болзошгүй нөхцөлд Хүчлийн чулуун өрөмдлөгийг менежментээр зохицуулж болдог. Тэгсэнч менежментийн үгхөтөлбөрийг уурхай хаагдсаны урт удаан хугацааны дараа хэрэгжүүлэх шаардлагатай байдаг. Уул уурхай, олборлолтын үнэлгээний сүүлийн үеийн практикт Хүчлийн чулуун өрөмдлөгийн нөлөөлийг эрт тодорхойлж Байгаль орчны нөлөөллийн үнэлгээнд тусгадаг болжээ. Уг үнэлгээнд үйл ажиллагааны эхний үеий шатанд Хүчлийн чулуун өрөмдлөгийг хянан удирдах стратегийг тусгасан байх учиртай. Хүчлийн чулуун өрөмдлөгө хийж болзошгүй бөгөөд бохирдолтын үр дагавар буй болголгүйгээр ажиллуулж амжилттай хаах боломж бүхий хэд хэдэн уурхай байна. Байгальд хүчлээс ангид ус ялгаруулах үүднээс үүнд ашигладаг

хэвшмэл арга бол ус хуримтлуулж цуглуулан хүдрийг цэвэрлэх арга юм. Гэхдээ уг аргыг уурхайг хаасан ч удаан хугацаанд хэрэглэх хэрэгтэй. Хүчлийн чулуун өрөмдлөгийн шаардлага болон өртөг зардлыг Урхайг хаах төлөвлөгөө, санхүүгийн төлөвлөгөө эсхүл удаан хугацааны үүрэг амлалтаа уул уурхайн компаниуд биелүүлэхийг баталгаажуулах барьцаат хөрөнгөөр дамжуулж тусгана. Хүчлийн чулуун өрөмдлөгийн ноцтой бөгөөд удаан хугацаанд үргэлжлэх шинж чанарыг зохицуулах зорилгоор Хүчлээс урьдчилан сэргийлэх олон улсын сүлжээ (ХУОУС) байгуулагджээ. Хүчлийн өрөмлөгийн талаархи мэдээлэл, дадлага туршлагыг дайчлан олон улсын байгууллагын үүргийг 1998 онд байгуулагдсан ХУСОУС гүйцэтгэдэг. Байгуулагдсан цагаас хойш уг асуудлаар ХУСОУС тэргүүлэгч байгууллага болсон юм. Олонхи нь Олон улсын уул уурхай, металлын зөвлөлийн гишүүн уул уурхайн дэлхийн тэргүүлэч компаниудаас уг сүлжээ бүрддэг (www.inap.com.au).

Хүчлийн чулуун өрөмдлөгийн хувьд шилдэг дадлага туршлага бүхий компаниудад дараах орно. Үүнд:

- Уурхайн байгаль орчинд сөрөг нөлөөлөлгүй өрөмдлөгийн хөтөлбөр (www.nrcan.gc.ca/ms/canmet-mtb/mmsl-lmsm/mend/);
- Хүчлийн өрөмдлөгийн технологийн санаачлага (www.unr.edu/mines/adti/);
- Австралийн ашигт малтмалын судлагааны төв (www.acmer.uq.edu.au/);
- Хүчлийн чулуун өрөмдлөгийг зохицуулах Европын түншлэл (www.padre.imwa.info/index.html).

Алт олборлолт ба мөнгөн усны бохирдол

Монголд гар аргаар болон бичил оврын алт олборлолт өргөн дэлгэрсэн ба мөнгөн усны хэрэглээгээ багасгасан алт олборлох бусад салбартай харьцуулбал бага оврын алт олборлогчид алт угаахдаа мөнгөн ус ихээр хэрэглэдэг гар аргын олборлолт ноцтой хүндрэл буй болгож байна. Мөнгөн ус бол гол бохирдуулагчдын нэг бөгөөд экологийн систем болон хүний эрүүл мэндэд урт хугацаанд сөргөөр нөлөөлдөг тул үлэмж ноцтой асуудал бөлгөө. Дэлхийн нийт алтны олборлолтын 25 хувийг гар аргаар олборлодог. Үүнтэй холбоотой бохирдолт, хүнсний сүлжээнд нэвтэрсэн мөнгөн ус байгаль орчин, уурхайчдын эрүүл мэнд болон гар аргын олборлолт бүхий газар нутгийн ойролцоо аж төрөх хүн ардын амь насанд хор хөнөөлтэй нөлөөлдөг.

Уг нөхцөл байдлыг засч залруулах үүднээс гар аргаар олборлогчдын мөнгөн усны хэрэглээг болиулах оролдлого нилээд хийгдлээ. Уг асуудлыг зохицуулдаг байгууллагын нэг бол НҮ байгууллагын Аж үйлдвэрийн хөгжлийн байгууллага юм (UNIDO). Global Environment Facility (http://www.gefweb.org) болон оролцогч бусад орнуудын хамтын санхүүжилтээр UNIDO-оос Гар аргын олборлолтод мөнгөн усны хэрэглээг халах глобал хөтөлбөр хэрэгжүүлсэн билээ.

UNIDO-оос гар аргаар алт олборлох цэвэр технологийг нэвтрүүлэх хөтөлбөр боловсруулжээ (http://www.natural-resources.org/minerals/cd/unido.htm). Үүний зэрэгцээ UNIDO-оос байгаль орчны хамгаалал, шинэ технологи нэвтрүүлэх, зүй зохистой тоног төхөөрөмж үйлдвэрлэн, сургалтын хөтөлбөр хэрэгжүүлэх олон талт үйл ажиллагаа явуулдаг.

Биологийн төрөлзүйлийн хариуцлагатай хамгаалал болон менежментийн талаар зарим уул уурхайн компаний баримталдаг зарчим

Дэлхий нийтэд нэр хүнд нь унаж байгааг 1990-ээд онд дэлхийн уул уурхайн салбар нийдтээ хүлээн зөвшөөрчээ. “Үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл ” авахад амаргүй болсныг уг салбар мэдэрч, уг салбарын баримталдаг стандарт, нэр хүндийг сайжруулахад ямарваа нэгэн арга хэмжээ авах хэрэгтэйг ойлгож эхэлжээ. Үүнд салбарын нэгдсэн дуу хоолой дуулгах шаардлагатай болсон ба салбарт базаахгүй үйл ажиллагаа явуулдаг компаниуд улмаар сайн компаниудын нэр хүндэд харш байгааг ухамсарлаж эхэлсэн байна.

Салбарын шинэтгэл, салбарын хяналт шинжилгээ явуулж уг салбарт нүүрлэсэн

нийгмийн чанарын асуудлуудыг бүхэлд нь судлах зорилгоор дэлхийн тэргүүлэгч есөн компаний бүрэлдэхүүнтэйгээр Уул уурхайн глобал санаачлага байгууллага 1998 онд байгуулагджээ. Йоханесбургэд 2002 онд зохиогдсон Тогтвортой хөгжлийн дэлхийн дээд хэмжээний чуулга уулзалтад анхны тайлангаа хүргүүлэн танилцуулсан Уул уурхай, ашигт малтмал болон тогтвортой хөгжлийн төсөл хэрэгжүүлсэн нь Уул уурхайн глобал санаачлага байгууллагын хөтөлбөрийн оргил байлаа. Уг салбарт тэргүүлэгч олон компаний тодорхой бодлого боловсруулвал зохих асуудлаар биологийн төрөл зүйл, байгаль орчны асуудлуудыг уг баримт бичигт тодорхой тусгажээ. Салбарын ийнхүү хамтын ажиллагааны үр дүнд өдгөө салбарын манлайлагч арван зургаан уул уурхайн компани болон салбарын хорин долоон нийгэмлэгийн гишүүнээрээ багтаасан Уул уурхай, металын олон улсын зөвлөл (ICMM) байгуулагджээ. Уг байгууллага биологийн төрөл зүйл болон нийгмийн чанартай асуудлуудыг зохицуулах шилдэг туршлагыг хуримтлуулах чиглэлээр ажиллах үлэмж ач холбогдол бүхий хөдөлгөх хүч болжээ.

Одоогоор ICMM-ийн гишүүн зарим компаниуд өөрсдийн нүүрлэж буй биологийн төрөл зүйлийн эрсдлийн стратегийн хийгээд үр ашигтай менежментийг нөхцөлдүүлэх бодлого, практикийг боловсруулж байна. Үүний хэд хэдэн жишээг дор дурдав. Үүнд:

BHP-Billiton

Хүн ард, хүлээн авагч орон нутаг болон байгаль орчинд огт хор хөнөөлгүй байхыг тунхагласан 2007 онд батлагдсан BHP-Billiton-ны Тогтвортой хөгжлийн бодлогын хүрээнд биологийн төрөл зүйл, байгаль орчны талаар явуулах бодлогод дараах орно. Үүнд:

- Ажилтан, гэрээт ажилчид, байгаль орчин болон хүлээн авагч орон нутагт тулгарах эрсдлийг тодорхойлох, үнэлэн удирдах;
- Нөөцийг үр ашигтай ашиглах, бохирдлыг багасган болиулахыг хөхиүлэн дэмжих зорилгыг тодорхойлж хэрэгжүүлэх;
- Хөрөнгө оруулалт, үйл ажиллагаа болон уурхайг хаах үйл явцад экологийн үнэлэмж, газар ашиглалтын асуудлыг үнэлж, харгалзах замаар биологийн төрөл зүйлийн хамгааллыг бэхжүүлэх.

BHP-Billiton-ны компани нийтдээ эдгээр хэтийг зорьсон бодлогыг тунхаглан бүтээгдэхүүний бүлэг бүрээр биологийн төрөл зүйлийн менежментийг шийдвэрлэх дотоодын сорилтыг даван туулж байна. Жишээ нь BHP-Billiton-ны Төмрийн хүдэрийн салбараас Австралийн баруун хэсгийн Пилбара бүст хэрэгжүүлэхээр Биологийн төрөл зүйлийн стратегийг боловсруулж байна. Уг стратегийг боловсруулах үйл явцад холбогдох сонирхогч талууд (засгийн газар, эрдэмтэн судлаачид, ТББ-ууд), зөвлөхүүд оролцсон болно. Үүгээр дараах үр дүнг зорино. Үүнд:

- Биологийн төрөл зүйлд нөлөөлөх нөлөөллөөс хамгаалж, түүнийг бууруулах;
- Төрөл зүйлийг алдагдалгүй байлгах;
- Бүсийн ландшафтад нийцэх тогтвортой, бүрэн ажиллагаатай экологийн системийг үлдээх.

Холыг зорьсон глобал хандлага гэхээсээ илүү эдгээр стратегийг боловсруулах санаа санаачлага нь бизнесийн нэгж эсхүл бүтээгдэхүүний бүлэгээс гардаг. Тиймээс энэхүү хандлага биологийн төрөл зүйлийн нэн тэргүүний ач холбогдлыг тогтоож үйл ажиллагааг төлөвлөхөд глобал стратегийн жинхэнэ үнэлэмжийг буй болгох эсэх нь одоогоор тодорхойгүй байна.

Newmont

Үйл ажиллагаа явуулж буй газарт уул уурхайн үйл ажиллагаа илт нөлөөлж буй талаар уг компани мэдээлдэг. Уг компани хайгуулаас барилга багууламж, үйл ажиллагаанаас хаах хүртэлх бүхий л үе шатанд биологийн төрөл зүйлийг хамгаалах хүсэл эрмэлзлэл бүхий юм. Үйл ажиллагаа явуулахаар төлөвлөж буй газруудад экологийн эмзэг асуудлыг тодорхойлох нарийвчилсан суурь судалгаа хийхэд уг хандлага оршино. Байгаль орчинд нөлөөлж болзошгүй нөлөөллийг үнэлж, уурхайн амьдралын бүхий л хугацаанд сөрөг нөлөөллийг багасгах арга замыг төлөвлөхөд эдгээр судлагаа дөхөм болох учиртай.

2005 онд Newmont глобал биологийн төрөл зүйл хамгаалах ТББ-тай хамтран өөрийн нөлөөллийг илүүтэй ойлгон, глобал биологийн төрөл зүйлийн стратегийг боловсруулахаар Conservation International-тай хамтран ажиллаж эхлэв. Newmont-ын Conservation International-тай өрнүүлсэн ийнхүү хамтын ажиллагаа биологийн төрөл зүйлийн асуудлуудыг байгаль орчны бодлого, үйл ажиллагааны стандарт болон менежментийн тогтолцоонд тусгахад дөхөмтэй болно.

Newmont тухайн газарт онцлон чиглэсэн биологийн төрөл зүйлийн эрсдлийн үнэлгээг явуулах зорилгоор 2006 оныг хамран глобал биологийн төрөл зүйлийн бодлого боловсруулах төлөвлөгөөтэй байсан бөлгөө. 2007 оны байдлаар биологийн төрөл зүйлийн эрсдлийн үнэлгээг олборлолтын хоёр, хайгуулын нэг талбайд явуулжээ. Гэвч 2007 онд цаг агаарын өөрчлөлтийн асуудал нэн тэргүүний ач холбогдолтой байсан тул глобал биологийн төрөл зүйлийн бодлого болон стратегийн зорилтыг гүйцэт боловсруулж дуусаагүй билээ.

Rio Tinto

2004 онд Rio Tinto компаний Биологийн Төрөл зүйлийн стратеги боловсруулж дууссан юм. ICMM-д Rio Tinto-ийн тэргүүлэгч оролцоо болон BirdLife International, Conservation International, Fauna and Flora International болон Smithsonian Institution зэрэг дэлхийн тэргүүлэгч байгаль хамгаалагч ТББ-тай явуулдаг биологийн төрөл зүйлийн талаарх түншлэл уг стратеги боловсруулахад нэмэр болсон юм. Уг стратегийг боловсруулахад Rio Tinto-ийн удирдах зөвлөл удирдан чиглүүлж, BirdLife International-ын тэргүүлсэн байгаль хамгаалах, орон нутгийг хөгжүүлэх байгууллагын төлөөлөл болох зургаан мэргэжилтний хөндлөнгийн зөвлөл дэмжсэн бөлгөө.

Rio Tinto өөрийн биологийн төрөл зүйлийн стратегиа 2004 онд хэвлүүлж, Бангкокод болсон IUCN-ий Дэлхийн байгаль хамгаалах их хурлын үеэр танилцуулсан билээ. Тэрээр биологийн төрөл зүйлийн талаар баримтлах стратегиа дараах байдлаар томьёолов. Үүнд:

“Биологийн төрөл зүйлийн хамгаалал болон хариуцлагатай менежментийг бизнес ба нийгмийн асуудал болохын ач холбогдлыг Rio Tinto хүлээн зөвшөөрч байна. Бид биологийн төрөл зүйлд Цэвэр Эерэг нөлөөлөл үлдээхийг зорьж буй. Бид тогтвортой хөгжлийн үр дүнд хүрэх зорилгоор байгаль орчин, нийгмийн чанартай шийдвэр гаргахад биологийн төрөл зүйлийг хамгаалах асуудлыг чухалчлах эрмэлзлэл бүхий байна. Энэ нь зарим талбайд үйл ажиллагаа явуулахаас бид татгалзах ёстой гэсэн үг юм.

Биологийн төрөл зүйлийн талаар уул уурхайн салбарт Rio Tinto тэргүүлэх байр суурьтай нөлөө бүхий байхыг зорьж байна. Энэ байр суурийг хүлээн зөвшөөрч, биологийн төрөл зүйлийн талаар бидний явуулах үйл ажиллагаа манай бизнест үр ашигтай байна гэдэгт итгэж буй. Иймээс бид дараахийг зорино. Үүнд:

- *Бизнесийн бүхий л мөчлөгийн явцад биологийн төрөл зүйлд учрах эрсдлээс урьчилсан сэргийлэх, багасган, үр дагаврыг намжаана;*
- *Удирдан зохицуулж буй газартаа хариуцлагатай байна;*
- *Биологийн төрөл зүйлийн хамгааллын боломжийг нээн тодруулж, ашиглана;*
- *Биологийн төрөл зүйлийг удирдан зохицуулах үйл ажиллагаандаа орон нутгийн төлөөлөл болон бусад эрх мэдлийн хүрээг татан оролцуулна ” гэжээ.*

Энэхүү стратегийг Rio Tinto груп олон жилийн турш хэрэгжүүлжээ. Сөрөг нөлөөллийг нахмжаах эрэмбэ дарааллыг баримтлахыг Цэвэр эерэг нөлөөллийн зарчим шаарддаг ба биологийн төрөл зүйлд нөлөөлөх нөлөөллийг багасгахдаа: эхлээд сөрөг нөлөөллөөс залсхийх, залсхийх боломжгүй нөхцөлд түүнийг багасгах, үйл ажиллагаа явгдаж дууссаны дараа (эсхүл боломжоороо үйл ажиллагаа явгдаж байх үед) байгалийн эко тогтолцоог сэргээнэ. Хэрэв нөлөөллийг багасгах бүхий л арга хэмжээ авгдсаны эцэст биологийн төрөл зүйлд алдагдал гарсаар хэвээр байвал уг алдагдлыг нөхөн буюу зарим тохиолдолд бүр алдагдлыг

нөхөхөөс илүү хэмжээний “биологийн төрөл зүйлийн нөхөн тэнцвэржүүлэлт” хэлбэрийн нөхөн төлбөрийг төлнө. Шинээр уурхай төлөвлөж, тусгай зөвшөөрөл авах үйл явцын эхний үед намжаах эрэмбэ дарааллыг баримтлахын зэрэгцээ нөхөн төлбөрийн хэмжээг үнэлж тогтоон, биологийн төрөл зүйлийн зүй зохистой офсетийг тодорхойлох боломжтой. Түүнчлэн BirdLife болон бусад ТББ-ын зөвлөмжтэйгээр биологийн төрөл зүйлийн офсетийг тодорхойлох аргачлалыг Rio Tinto боловсруулж байна.

Rio Tinto-оос *Байгалийн тэнцвэрийг хадгалах нь: Rio Tinto-ийн үйл ажиллагаанд биологийн төрөл зүйлийг хамрах практик удирдамж* хэмээх үйл ажиллагааны удирдамжийн баримт бичиг боловсруулжээ. Rio Tinto-ийн ажилтан нарт өөрийн талбайд биологийн төрөл зүйлийг үнэлж, менежмент явуулах удирдамаар хангахад уг удирдамжийн зорилго оршино. Түүнчлэн үйл ажиллагааны нэн тэргүүний чиглэл тогтоох зорилгоор хөрш зэргэлдээ орон нутгийн төлөөлөлтэй болон сонирхогч бүлгүүдтэй хамтран ажиллахад уг удирдамж тус нэмэр болдог. Бразил, Гвиней, Мадагаскар болон Намиби зэрэг орнуудад хэрэгжиж буй уул уурхайн төслүүдэд (шинэ төслүүдэд) Биологийн төрөл зүйлийн үйл ажиллагааны төлөвлөлт болон биологийн төрөл зүйлийн үнэлэмжийн үнэлгээ ашиглагддаг. Түүнчлэн төрөл бүрийн биологийн төрөл зүйлийн ТББ-тай хамтран Rio Tinto Цэвэр эрэг нөлөөлөл буй болгоход түүний оруулж буй хувь нэмрийг үнэлэхэд тус дөхөм болох газруудад байгаль хамгаалах үйл ажиллагааг дэмжиж байна.

Xstrata

Xstrata-ийэ Эрүүл мэндийн аюулгүй байдал, байгаль орчны стандартууд биологийн төрөл зүйлээр баялаг, эмзэг газруудыг тогтмол тодорхойлохыг бүхий л төсөл, үйл ажиллагаанаас шаарддаг. Эдгээр төсөл, үйл ажиллагаанаас биологийг төрөл зүйлийн үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэхийг шаарддаг билээ. Тусгай хамгаалалтай газар болон биологийн төрөл зүйлийн үнэлэмжийн хувьд хүлээн зөвшөөрөгддөг тусгай хамгаалалттай бус гаруудтай холбоотой газрыг биологийн төрөл зүйлээр баялаг гэх ба зүйлийн эдемизм болон глобал төвшинд аюулд өртсөн зүйлтэй үлэмж холбоотой газрыг эмзэг газар гэнэ. Тусгай хамгаалалттай газар болон биологийн төрөл зүйлийн өндөр үнэлэмж бүхий газруудын хувьд глобал менежменттэй үйл ажиллагааны байршил болон ач холбогдлыг үнэлэх тодорхой бөгөөд баримтжуулсан үнэлэмжтэй бөлгөө.

Өөрсдийн тогтвортой байлын бодлогын хүрээнд “өөрийн үйл ажиллагаанд өртсөн амьдрах орчны урт хугацаан дахь эрүүл мэнд, чадавхи болон чадамжийг хадгалах зорилгоор байгаль орчин, биологийн төрөл зүйл болон ландшафтад нөлөөлөх үйл ажиллагааны болзошгүй хийгээд бодит үлэмж их нөлөөллийг тодорхойлох, дүн шинжилгээ хийх, үнэлэх болон арилгах эсхүл засан залруулах. Үйл ажиллагаанд өртсөн талбайд биологийн төрөл зүйл, ландшафтын ажиллагааг хамгаалж, үр ашигтай менежмент явуулах шинжлэх ухааны үндэслэлтэй технологи болон процедурыг боловсруулж хэрэгжүүлнэ ” гэжээ.

Xstrata байгаль орчинд нөлөөлөх газар болон төслийн үйл ажиллагааг иж бүрнээр нь шийдвэрлэж, төслийн буюу үйл ажиллагааны үе шатанд суурь судалгаа болон Байгал орчны нөлөөллийн үнэлгээ явуулах эрмэлзлэл бүхий байна. Xstrata өөрийн явуулж буй уул уурхайн бүхий л үйл ажиллагаатай холбогдуулж биологийн төрөл зүйлийн сонирхол татахуйц онцлогийг үнэлэх, нэн тэргүүний ач холбогдлыг тодорхойлох болон болзошгүй нөлөөллийг тодорхойлж зохицуулах тогтмол хандлагадаа нөлөөллийг намжаах эрэмбэ дарааллыг баримтлаж буй бололтой.

Ус, цахилгаан эрчим хүч, түүхий эдийн ашиглалт зэрэг байгалийн нөөц хадгалах үлэмж чухал асуудлыг тодорхойлж баримтжуулах тогтолцоо болон процедурыг бүрдүүлж хэрэгжүүлсэн болно. Экологийн тогтолцооны функцийг зөвөөр үнэлэх хандлагыг баримтлан хамгийн эхнээс нь суурь биологийн төрөл зүйл болон ландшафтын функцийн талаар сайн ойлголттой болоход анхаарлаа төвлөрүүлж байна.

Зүйл болон амьдрах орчны сүйрэл эсхүл ололт, биологийн төрөл зүйлд нөлөөлөх хүчин зүйл, тусгай хамгаалалттай газрын аюулгүй байдал, биологийн нөөцийн менежмент болон экологийн тогтолцооны нөхөн сэргээлт болон сэргээлт зэргээр уурхайг хаасны дараах төслийн үе шатанд мониторинг хэрэгжүүлнэ. Өөрийн зарим үйл ажиллагаанд биологийн төрөл зүйлийн офсетийг тодорхойлж хадгалах хандлага баримтлахын зэрэгцээ Xstrata хэн хэндээ ашигтай байдлаар нөхөн тэнцвэржүүлэх үр дүнд хүрэхийг чармайж байна.

Уул уурхай, металын олон улсын зөвлөл

Уул уурхай, металын олон улсын зөвлөл буюу ICMM нь биологийн төрөл зүйлийн хамгааллын салбар болон уул уурхайн глобал хамтын нийгэмлэгийн хооронд илүү үр ашигтай үнэлэмж бүхий солилцоо хийх зорилгоор анх 2002 онд IUCN-тэй яриа хэлэлцээ явуулж улмаар Йоханесбургэд болсон Тогтвортой хөгжлийн дээд хэмжээний уулзалтаар уг яриа хэлэлцээг үргэжлүүлсэн билээ. Түнээс хойш ICMM-ийн байр суурийг тодотгож түүний шилдэг практик нэвтрүүлэх эрмэлзлэлийг харуулсан хэд хэдэн амжилттай үр дүн ажиглагдав. Тэдгээрээс дурдвал:

- Уул уурхай болон хамгаалалттай газруудын байр суурийн талаарх мэдэгдэл (2003 оны 8 сар).
- Уул уурхай болон биологин төрөл зүйлийн хамгааллыг нэгтгэх нь: газар бүрийн тодорхой жишээн дннр үндэслэв (2004 он)
- Уул уурхай болон уугуул иргэдийн асуудал (2006 оны 3 сар)
- WCPA-ийн менежментийн ангилалын ажлын хэсэг- IUCN-д өгөх хариулт (2007 он).

Уул уурхай болон биологийн төрөл зүйлийн шилдэг туршлага (2006 он)-ын боловсруулсан нь IUCN болон ICMM-ын хоорондын яриа хэлэлцээний гол үр дүн болж 2005 оны турш ТББ-ууд ба ICMM-ий гишүүн байгууллагуудад зориулж хийсэн бүс нутгийн сонирхогч талуудын семинарын үеэр олон нийтийн зөвшилцлийн үр дүнд гарсан гол баримт бичиг бөлгөө. Уул уурхайн төслийн үйл явц болон хайгуулаас уурхайг хаах хүртэлх төслийн үе шатыг бүхэлд нь хамарсан биологийн төрөл зүйлийн эрсдэл хийгээд менежментийг зохицуулах үр ашиг бүхий арга хэрэгсэл уг барим бичиг болсон юм.

Ур баримт бичигт хайгуул, урьчилсан техник эдийн засгийн үнэлгээ, барилга байгууламж, холбогдох дэд бүтцийг буй болгох, олборлолт болон металын боловсруулалт, хаалтын төлөвлөлв болон хэрэгжүүлэх зэрэг уул уурхайн бүхий л үе шатыг хамарсан болно.

Төслийн боловсуулалт, уурхайн үйл ажиллагаа, хаалтын төлөвлөлт , хэрэгжүүлэлт зэрэгтэй холбоотой төрөл бүрийн үйл ажиллагаагаар дамжуулан биологийн төрөл зүйл ба байгаль орчны онцлогт нөлөөлөлх нөлөөллийг тодорхойлох маш практик ач холбогдолтой хандлагыг санал болгож байна. Үүний зэрэгцээ эдгээр үйл ажиллагаа болон нөлөөлөлд нь өртөж болзошгүй байгаль орчны онцлогыг хоорондын харьцааг ч мөн харуулдаг.

Уг баримт бичигт урьдчилан тодорхйолох, тогтоох, биологийн төрөл зүйлийн ач холбогдлыг үнэлэх, биологийн төрөл зүйлийн ач холбогдолтой талуудыг тодорхойлох болон энэхүү үйл явц зорьж буй биологийн төрөл зүйлийн үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулахад хэрхэхийг харуулах менежментийн тогтолцоо болон үнэлгээний арга хэрэгслийг Байгаль орчин болоод Нийгмийн нөлөөллийн үнэлгээний хувьд тусгадаг (биологийн төрөл зүйлийн үнэлгээг Байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээнд нэгтгэх үр ашиг бүхий хэлбэр) болно. Товчхондоо арга хэрэгсэл болохын хувьд энэ нь маш ач холбогдолтой баримт бичиг болсон ба уул уурхайн салбар, засгийн газар аль аль нь ашиглах аваас уул уурхайн бүхий л йүл явцын турш биологийн төрөл зүйлийн менежментийг хийж, хамгаалах үр ашигтай шилдэг туршлагыг буй болгох учиртай бөлгөө.

ICMM нь уг салбартай холбоотой төрөл бүрийн шилдэг туршлагын талаар мэтгэлцэж , шинэ санаа бодол төрүүлэх бусадтай хуваалцах бололцоо олгох глобал болон үндэсний

хэмжээний төлөөллийг нөхцөлдүүлэх үр ашиг бүхий форум юм. Монголын үндэсний уул уурхайн ассоциаци ICMM-тэй хамтран ажиллах үр ашгийн талаар бодолцож, Монголын бүхий л салбарт (хувийн, улсын болон иргэний нийгэм) хөгжил дэвшлийн өнөөгийн чухал цаг үед Монголын олборлох салбарт байгаль орчин, нийгмийн төгс төгөлдөр стандартыг нэвтрүүлэхэд оруулах ICMM болон түүний гишүүдийн хүчин чадавхийг харгалзахыг санал болгож байна.

“Цэвэр алдагдалгүй” байх зарчмыг тунхаглан, сөрөг нөлөөллийг намжаах эрэмбэ дарааллыг бариментлах замаар биологийн төрөл зүйлд нөлөөлөх сөрөг нөлөөлөл болон байгаль хамгааллын асуудлыг шийдвэрлэх нь

Сөрөг нөлөөллийг намжаахад тодорхой эрэмбэ дараалал баримтлах талаар урьд өмнө нилээд дурдсан билээ. Уг үзэл баримтлалыг биологийн төрөл зүйлийн (болон бусдын) сөрөг нөлөөлийн хувьд хүлээх үүрэг хариуцлагыг тодруулж, эдгээр сөрөг нөлөөллийг багасгах үйл явцыг уул уурхайн төслийн бүхий л үе шатанд өрнүүлэх шаардлагыг ойлгох тогтолцоог буй болгох зорилгоор уул уурхайн салбарын олон аж ахуйн нэгж хүлээн зөвшөөрсөн юм. Үүний зэрэгцээ байгаль орчин, биологийн төрөл зүйлд нөлөөлөх сөрөг нөлөөллийг аль болох эрт багасгах үүднээс аливаа хүчин чармайлтыг төслийн хамгийн эхний үе шатанд гаргах шаардлагын тухай уг үзэл баримтлал өгүүлж байна.

BHP-Billiton болон Rio Tinto зэрэг компаниуд “цэвэр алдагдалгүй”, “хор хөнөөлгүй” буюу “Цэвэр эерэг нөлөөлөл” зэргийг тунхагласныг бид урьд өмнө харсан. Эдгээр нь биологийн төрөл зүйлийн талаар тодорхой мэдээлэл буй, мөн төслийн талбайн ихэнхи хэсэг хамгаалалттай нөхцөлд биелэх тоон чанарын үүрэг амлалт юм.Зүй зохистой суурь үзүүлэлтэд хүрээгүй нөхцөлд “хор хөнөөлгүй” буюу “цэвэр эерэг нөлөөлөл”-д хүрч чадахгүй ба уурхайн үүсэл хөгжлийн үе шат бүрийн үйл ажиллагаанд гарах нөлөөллийг намжаах хүчин чармайлт биологийн төрөл зүйлийн тодорхойлсон зорилтот хүргэж чадахгүй. Олонхи нь олон арван жилийн турш үйл ажиллагаа явуулж буй уурхайнуудын хувьд байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний үе шатанд зүй зохистой суурь мэдээлэл байхгүй явдал нь “цэвэр алдагдалгүй” буюу “цэвэр эерэг нөлөөлөл”-ийг буй болгоход саад учруулдаг. Харин төслүүдийн хувьд хайгуул буюу урьдчилсан техник, эдийн засгийн үндэслэлийн үе шатанд уг зорилт илүү хялбар биелнэ. Ямартаа ч зүй зохистой суурь мэдээлэл байх явдлыг засгийн газар тусгай зөвшөөрөл олгох нэг стандарт шаардлага болгож, компаниуд сөрөг нөлөөлийг намжаах эрэмбэ дарааллыг баримтлахад заавал байлгах ёстой юм.

Төслийн хувьд үр ашигтай, зүй зохистой суурь мэдээллийн багцтай болоход юү хэрэгтэй вэ? Үүнд биологийн төрөл зүйлийн шалгаруулалт чухал үүрэгтэй. Олонхи газар биологийн төрөл зүйлийн талаар бэлэн мэдээлгүй олдоцтой байх нь ойлгомжтой тул үүнийг нарийн судлагаа шинжилгээ, тухайн талбарт хийгдсэн урьд өмнөх болон өнөөгийн судалгааны үйл ажиллагааны үр дүнд түшиглэх байдлаар бүрдүүлж болно. Энэ аргаар орхигдож буй мэдээлэллийг тодорхойлж ямар судалгаа шаардлага хангахуйц байдлаар хийгдсэнийг тогтооно. Тусгай хамгаалалттай газар болон түүний орон нутаг, бүс нутаг, үндэсний болон олон улсын ач холбогдлыг нөлөөллийн үнэлгээ болон ирээдүйнд нөхөн тэнцвэржүүлэлтийн хувилбаруудын хувьд тодорхойлох хэрэгтэй. Уг газар албан ёсоор хамгаалалтанд ороогүй ч үүнийг биологийн төрөл зүйлийн нэн чухал ач холбогдолтой газар гэж тодорхойлсон уу? Засгийн газрын буюу бусад сонирхогч талын уг газар нутгын талаарх үнэлгээ нь ямар вэ? Уг газар нутаг глобал эсхүл үндэсний хэмжээнд аюулд өртсөн зүйлийг тэтгэдэг үү?

Суурь мэдээллийн нарийн нягт дүн шинжилгээ нь байгаль орчинд нөлөөлөх байдлын үр ашигтай үнэлгээний угтвар нөхцөл юм. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний бүрэлдэхүүн хэсэг болгож эсхүл байгаль орчны тусгай зөвшөөрөл авсны дараа компани Биологийн төрөл зүйлийн үнэлэмжийн үнэлгээ хийж болно. Үүнд: төслийн үйл явц болон үйл ажиллагааны хүрээнд менежментийн зорилтот үйл ажиллагааны зүй зохистой газар нутгийг

тодорхойлно. Ингэснээр тухайн компаний сөрөг нөлөөллийг намжаах эрэмбэ дарааллыг баримтлаж буйг тодорхойлж дараахийг хийж гүйцэтгэхэд дөхөм болно. Үүнд:

- Төслийг анхдагч дизайны дагуу боловсруулахдаа хэрэгцээ шаардлагагүй нөлөөллөөс зайлсхийх;
- Өргөн цар хүрээ бүхий байгаль орчин, төлөвлөгөөнд нөлөөлж болзошгүй төслийн шууд бус нөлөөллийг ойлгох замаар хэрэгцээ шаардлагагүй нөлөөллөөс зайлсхийх;
- Төслийг боловсруулах, барилга байгууламж барих болон үйл ажиллагааны менежментээр дамжуулж сөрөг нөлөөллийг багасгах;
- Уурхайг өргөтгөх үе шатыг боловсруулахдаа төслийн дезайнаар дамжуулж хэрэгцээ шаардлагагүй нөлөөллөөс зайлсхийх;
- Биологийн үнэлэмжийн үнэлгээнд тусгагдсан үр дүнд нийцэх нөхөн сэргээх арга техникийн шилдэг практикт тулгуурлан нөхөн сэргээлтийн хамгийн сайн үр дүнд хүрэх.

Боломжтой үед залсхийсэн, уул уурхайн бүхий л үйл явцын турш бууруулсан болон сөрөг нөлөөллийг нь намжаасан биологийн төрөл зүйлийн нөлөөллийн үндсэн дээр уурхайг хаах хүртэл сэргээх ажил явуулсны дараа нөхөн тэнцвэржүүлэлтийг тодорхойлно. Практик дээр биологийн нөхөн тэнцвэржүүлэлтийг заавал уурхайг хаах үе шатанд тодорхойлох албагүй. Хэтийг харсан үр ашиг бүхий төлөвлөлтөөр уул уурхайн бүхий үйл явцын туршид биологийн төрөл зүйлийн цэвэр алдагдал ямар байхыг тодорхойлж болдог ба үүний нөхөн тэнцвэржүүлэлтийн хийх биологийн төрөл зүйлийн ямар ажилбар, ямар цар хүрээнд хийгдэх шаардлагатайг тодорхойлох урьчилсан шийдвэрийг дүр зургыг тусгадаг. Тусгай зөвшөөрөл олгох үе шатанд биологийн төрөл зүйлийн нөхөн тэнцвэржүүлэлтийг хамрах талаар нилээд их анхаарал татаж буй практик бол энэ. Бразил болон Австралид урьд өмнө дурдсанчлан биологийн төрөл зүйлийн нөхөн тэнцвэржүүлэлтийг тусгай зөвшөөрөл олгох үйл явцтай уялдуулдаг. Гэхдээ биологийн төрөл зүйлийг хадгалж хамгаалах үзэл баримтлалыг хууль ёсны болохыг нотлох зарчмын багц дээл үндэслэн биологийн төрөл зүйлийг тодорхойлж зөвшөөрөх үйл явцыг уялдуулах нь чухал. Эдгээр зарчмууд уг үйл явцыг ил тод болгож улмаар зүй зохистой сонирхогч талуудын оролцоо болон дэмжлэгэ хүлээхэд тус дөхөм болдог.

Биологийн төрөл зүйлийн нөхөн тэнцвэржүүлэлт

Биологийн төрөл зүйл болон хөгжлийн хэрэгслийн хувьд биологийн төрөл зүйлийн нөхөн тэнцвэржүүлэлтийн үзэл баримтлал үүсч хөгжих үе шатандаа байна. Төгс төгөлдөр боловсроогүй үзэл баримтлалын хувьд төрөл бүрийн орон төрөл бүрийн хэлбэрээр (АНУ-д нөлөөллийг намжаах банк, Бразилд хөгжлийн нөхөн төлөх арга хэрэгсэл г.м.) ашиглагдаж ирсэн ч уул уурхай, барилга байгууламж, хөдөө аж ахуй, ойн аж ахуй зэрэг салбарын хөгжлийн биологийн төрөл зүйлд нөлөөлөх нөлөөллийн үлдэцийн нөхөн тэнцвэржүүлэлтийг хийх гол хэрэгсэл болохын хувьд салбар дундын үлэмж анхаарал татаж байна. Гэхдээ удаан хугацаанд үргэлжлэх үлэмж их хэмжээний алдагдлын улмаас хөгжлийн үйл явцыг өрнүүлэх нь зүй бус, эсхүл ийнхүү алдагдлыг нөхөх хэн хэндээ хэлбэрийн ашигтай нөхөн тэнцвэржүүлэлтийг тодорхойлох боломжгүй нөхцөлд биологийн төрөл зүйлийн үнэлэмж туйлын чухал байхад зөвшөөрөл авах

зорилгоор ашигладаг тул “биологийн төрөл зүйлийг” буруу ашиглах хандлага байдаг. Түүнчлэн, хараа хяналтгүй, сахилга батгүй уг үзэл баримтлалыг хэрэглэвэл байгаль орчны ч бай, эсхүл нийгмийн чанартай нөлөөлөл ч бай зүй бус нөхцөл байдалд тусгай зөвшөөрөл авч болох хэрэгсэл болж хувирдаг. Иймээс уг үзэл баримтлалыг шүүмжлэх хандлага нилээд дэлгэрч байгаа болно.

Биологийн төрөл зүйлийг үзүүлэлтийг сайжруулах чиглэлээр уг салбартай хамтран ажилладаг байгууллагууд нөхөн тэнцвэржүүлэлтийг зөвхөн зүй зохистой нөхцөл байдалд ашиглах тухай ойлголттой болж байна. Уул уурхайн тодорхой төслүүдийн хувьд биологийн төрөл зүйлийн төлөвлөлтийг хийдэг сонирхогч талуудын төлөөлөл бүхий биологийн төрөл зүйлийн ажлын зарим хэсгүүд сөрөг нөлөөллийг намжаах эрэмбэ дарааллыг баримтлан, биологийн төрөл зүйлийн хүрэхэд амаргүй үлэмж хэмжээний эерэг үр дүнд хүрэх хэрэгцээ шаардлагын улмаас биологийн төрөл зүйлийн нөхөн тэнцвэржүүлэхийг тодорхойлохыг хүлээн зөвшөөрдөг.

Компаниуд, засгийн газар болон байгаль хамгаалах мэргэжлийн хүрээнийхний хооронд харьцангүй шинэлэг хэлбэрийн түншлэл болох Бизнес, биологийн төрөл зүйлийн нөхөн тэнцвэржүүлэлтийн хөтөлбөр буюу BBOP-оос уг үзэл баримтлалын агуулга баяжин, биологийн төрөл зүйлийн нөхөн тэнцвэржүүлэлтийг буй болгох, биологийн төрөл зүйлийн хувьд “цэвэр алдагдалгүй” төвшинд хүрэхэд түүнийг хэрхэн ашиглах талаар судлагаа хийгдсэн болно. Уг байгууллагын Нарийн бичгийн дарга нарын газар Forest Trends, Conservation International болон Зэрлэг ан амьтныг хамгаалах нийгэмлэгийн төлөөлөлөөс бүрддэг. Техникийн удирдамжийг засгийн газар (Австралийн Виктория мужийн засгийн газар болон АНУ-ын Загас, амьтны алба), иргэний нийгэм (Байгаль хамгаалал, ДБХС, BirdLife International болон Байгаль орчин хамгаалах олон улсын холбоо) болон төрөл бүрийн салбарын аж ахуйн нэгжүүд (Rio Tinto, Anglo American, Newmont, Shell болон Insight Investment)-ын төлөөлөл бүхий Олон улсын зөвлөх хорооноос гаргана.

Хөгжлийн чанартай томоохон төслүүдтэй харьцуулбал илүү их үрашигтай, өртөгзардлын хэмнэлттэй үр дүнд хүрэхэд биологийн төрөл зүйлийн нөхөн тэнцвэржүүлэлт тус дөхөмтэй гэдгийн BBOP шилдэг туршлага болон туршилтын төслүүдээр дамжуулан харуулах оролдлого хийж байна. Биологийн төрөл зүйлд үлэмж их нөлөөлдөг компаниудын хувьд биологийн төрөл зүйлийн нөхөн тэнцвэржүүлэлт бизнес практикийн салшгүй нэг стандарт бүрэлдэхүүн хэсэг болно гэж BBOP найдаж байна. Хөгжлийн үйл явцын өдөр тутмын практикт биологийн төрөл зүйлийн нөхөн тэнцвэржүүлэлтийг нэтрүүлэх нь удаан хугацаанд глобал төвшний хамгаалалын үр дүнд хүргэнэ. Үүний зэрэгцээ биологийн төрөл зүйлийн “цэвэр алдагдалгүй” зарчим компаниудад өөрийн тусгай зөвшөөрлийг хадгалж өртөг зардал, өр авлагаа зохицуулахад тус дөхөм болно.

Аль болох боломжийн хирээр байгаль орчинд учирсан хор хохирлыг бууруулсны дараа сөрөг нөлөөллийг намжаах эрэмбэ дарааллын дагуу хамгийн сүүлд биологийн төрөл зүйлийн нөхөн тэнцвэржүүлэлтийг хийх ёстой гэж BBOP үздэг. Нөхөн тэнцвэржүүлэлтийн үйл ажиллагаа байгаль хамгаалалын нэмэлт, хэмжиж болохуйц үр дүнд хүргэх ёстой. Зүй зохистой нөхөн тэнцвэржүүлэлтийн үйл ажиллагаа газар нутаг бүрт өөр өөр байх бөгөөд газрын менежмент биологийн төрөл зүйлийн нөхөн тэнцвэржүүлэлтэд дараах байдлаар оролцоно. Үүнд:

- Үр ашиг муутай хамгаалалттай газруудыг бэхжүүлж дэмжих;
- Тусгай хамгаалалтгүй газруудыг хамгаалалтанд авч дэмжих;
- Тусгай хамгаалалттай газруудыг бусад гол газар нутагтай холбосон коридор буй болгох;
- Тусгай хамгаалалттай газар нутгийг хүрээлж орчны бүс байгуулах;
- Нэн ховор амьтдыг устгах;
- Биологийн төрөл зүйлийн алдагдлын сэдрээж буй учир шалтгааныг арилгах;
- Орон нутгийн ард иргэд болон биологийн төрөл зүйлд үр шимээ хүртээх тогтвортой амьжиргааг дэмжин хөгжүүлэх.

Биологийн төрөл зүйлийн нөхөн тэнцвэржүүлэлтийг өдөр тутмын үйл ажиллагаанд хэрэглэхтэй холбоотой эрсдлийг бууруулах зорилгоор дараах асуудлыг ВВОР-аас компаниудад санал болгож байна. Үүнд:

- Бүхий л компаниуд холбогдох олон улсын, үндэсний болон бусад хууль тогтоомжийг чанд биелүүлэх;
- Хуулиар зөвшөөрсөн ч биологийн төрөл зүйлд учруулж болзошгүй хор хөнөөл, түүнтэй холбоотой эрсдлийн улмаас зарим төслийг хэрэгжүүлж болохгүй;
- Биологийн төрөл зүйлд учрах хохирлоос зайлсхийх, бууруулан, намжаах зэрэг эрэмбэ дарааллыг үлдэц нөлөөллийг нөхөн тэнцвэржүүлэлтийн аргаар арилгахаас өмнө заавал баримтлан хэрэгжүүлэх. Үүнийг гол зорилго бол биологийн төрөл зүйлийг "цэвэр алдагдлаас ангид" байлгахад оршино.

Мөн түүнчлэн үйл ажиллагаа явуулж буй газар нутгийн биологийн төрөл зүйлийн гол үнэлэмжийг тодорхойлж, ач холбогдлыг нь ухамсарлах замаар биологийн төрөл зүйлийн нөхөн тэнцвэржүүлэлтийг хэрэгжүүлнэ. Шаардлагатай нөхөн тэнцвэржүүлэлтийн хэмжээг тодорхойлох үүднээс үлдэц нөлөөллийг тооцоолсон байх хэрэгтэй. Үүнд хэд хэдэн боломжийн хувилбаруудыг судлаж, засгийн газар, ТББ болон орон нутгийн ард иргэд зэрэг сонирхогч бүлгүүдийн хооронднөхөн тэнцвэржүүлэлтийг тодорхойлох зөвшилцөл явагдаж учиртай.

Өнөөгийн байдлаар нөхөн тэнцвэржүүлэлтийн үйл ажиллагаа сайн дурын үндсэн дээр явагддаг тул гаргаж буй нөхөн тэнцвэржүүлэлтийн хүчин чармайлт шинжлэх ухааны үндэслэлтэй бөгөөд нийгмийн хувьд хүлээн зөвшөөрөхүйц байгааг хувийн хэвшил нотлох эрмэлзлэл бүхий байна. Иймээс уг хандлагад итгэл төрүүлж, практик болон улс төрийн дэмжлэг хүлээн авах үүднээс ВВОР-г стандарт аргачлал боловруулахад туслалцаа үзүүлэх хүсэлт байнга гардаг. Тйим учраас ВВОР-аас салбар, бодлого боловсруулагчид, санхүүгийн байгууллага болон иргэний нийгмийн байгууллагад зориулж биологийн төрөл зүйлийн дезайн боловсруулж, хэрэгжүүлэх удирдамжаар хангах арга хэрэгсэл болосруулж байна. Уг удирдамжийн төслөө ВВОР 2008 оны 5 сард Германы Бонн хотод болсон Биологийн төрөл зүйлийн тухай конвенцийн COP 9 дээр танилцуулсан билээ.

Биологийн төрөл зүйлийг тогтоож хэрэглэхэд нарийн чанд хандлага баримтлах учиртай ч ийнхүү механизм нь хууль тогтоомжоор баталгаажсан нөхцөлд (Австралийн Куинзлэндийн Эко- Сан-д боловсруулж хэрэгжүүлсний нэгэн адил) улсын хамгаалалттай газрын сүлжээд бодит үр шимээ өгч, биологийн төрөл зүйл болон тогтвортой хөгжлийн ашиг сонирхолд нийцүүлэх талаар бүтээлч саналыг огтхон ч хязгаарладаггүй бөлгөө. Уул уурхай, аялал жуулчлалын салбарын хөгжлийг урагшлуулах эрмэлзлэл бүхий Монгол орны хувьд улсын хамгаалалттай газар нутгийн сүлжээг өргөтгөж, дэмжлэг үзүүлэх явдал харгалзаж үзвэл зохих асуудал байж болзошгүй.

Уул уурхайн хөгжилтэй холбоотой шууд бус нөлөөллийг тогтоох ба Байгаль орчны стратегийн нөлөөллийн үнэлгээний хэрэгцээ шаардлага (БОСНҮ)

Уул уурхайн үйл ажиллагааг үнэлэхдээ ихэнхи анхаарлаа уг уурхайн үлдээх "ул мөр"-тэй холбоотой анхдагч нөлөөлөлтэй холбож үздэг. Их хэмээний чулуу зайлуулах, зарим тохиолдолд бүр уул нураах, их хэмжээний талбайг хог хаягдлаар дүүргэх зэрэг байдлаар анхадагч нөлөөлөл үлэмж их байх тохиолдолд ч бий. Гэхдээ компани болон засгийн газар хамтран хариуцлага хүлээх уурхайн "шууд бус (хоёрдогч) ул мөр"-ийг ихэнхи тохиолдолд үл тооцоож, хор хөнөөлийг нь дутуу үнэлдэг. Харин энэхүү шууд бус нөлөөллийн үр дагавар орон нутгийн болон бүр бүс нутгийн популяцид хэд дахин өсөн хуримтлагдсан байдлаар нөлөөлөхөөс нааш илэрдэггүй юм. Бодит байдал дээр ууг уурхайгаас үлэмж алслагдсан газар нутагт биологийн төрөл зүйлд нөлөөлөл учирдаг. Анхдагч нөлөөллөөс гадна уурхай нь ойролцоо талбайдаа нийгэм, эдийн засгийн бусад үйл явцыг буй болгож улмаар газар ашиглалтын чиг хандлага болон холбогдох дарамтын нөлөөллийг өөрчлөх талтай.

Хөгжлийн өргөн агуулга бүхий сонголтуудын нэгд нь уурхай үйл ажиллагаа явуулдаг. Нийгмийн болон байгаль орчинтой холбоотой эрсдлийг бууруулах аваас компани, засгийн газрын хамтаар нотлон харуулах үүрэг хариуцлагын мөн чанарыг ойлгоход тухай агуулгыг ойлгох явдал чухал бөлгөө. Дараах асуулт эрсдлийн шинж чанарыг үнэлэхэд тус дөхөтэй байдаг. Үүнд:

- Дэд бүтцээр хомс газар нутагт уурхай байрших уу?
- Сайтар зохион байгуулалттай суурин газрын хүрээнд уг уурхай байрших уу?
- Уг уурхайн хөгжиж буй эдийн засагтай бүс нутагт байгаа юу?
- Бүтэц, зохион байгуулалтын хувьд энэ нь сайтар хөгжсөн газар уу?
- Хөгжлийн төлөвлөлтийг зүй зохистой зохицуулалттай юү?
- Санал болгож буй уг уурхай тус бүс нутагт одоо байгаагаас нь илүү олон ажлын байр болон бусад үр шим авчрах уу?
- Уг уурхайтай холбоотой хөгжил тусдаа явагдах уу эсхшл үндэсний болон бүс нутгийн хөгжлийн үйл явцын бүрэлдэхүүн хэсэг болох уу?
- Цахилгаан эрчим хүч, ус (усны хоолой, резервуар), тээврийн томоохон хэрэгсэл (зам харгуй, төмөр зам, боомт) зэрэг бусад нөөцөөс уг уурхай хамааралтай юу?
- Эдгээр нөөц эх үүсвэрийг дан ганцаараа бүрдүүлж менежментийн хяналтыг тавих уу эсхүл үүнийг бүс нутгийн/үндэсний төв засгийн газар болон бусад байгууллагуудын хамтаар хийх үү?
- Тус бүс нутагт одоогоор оршиж буй бөгөөд ирээдүйд шууд холбоотой болж болзошгүй хөгжлийн чанартай тулгамдсан асуудлууд байна уу?
- Уг уурхайн үйл ажиллагаа хуримтлагдсан асуудлыг шийдвэрлэхэд хувь нэмэр оруулах уу?
- Уг уурхай тус бүс нутаг дахь нэн ховор амьтдын тархалтад нөлөөлөх үү?
- Уурхайг зэрлэг амьтдын орших газар нутгат эсхүл тусгай хамгаалалттай газар нутагт ойрхон байрлах уу?
- Тус бүс нутагт дэлхийн төвшинд аюулд өртсөн амьтдын хамгааллын асуудал асуудал хурцаар тавигддаг уу?

Төрөл бүрийн дараах бадлаар уул уурхайн үйл ажиллагаа хүсээгүй сөрөг нөлөөллийг буй болгодог. Үүнд:

- Урьд өмнө хүний хөл хүрээгүй газар нутгийг малчин, газар тариалан эрхлэгч болон мод, түлээ бэлтгэгч нарт шинээр гаргасан байгалийн зам харгуй нээж өгдөг;
- Шинэ ажлын байрны сургаар, мөн төрөл бүрийн үйлчилгээг шинээр шаардах хот суурин газар байгуулагдсанаар урьд өмнө уг газар нутгатай огт холбоогүй байсан хүмүүсийн сэлгэн суурьшилт явагдана;
- Өргөжин тэлж буй хүн ам орон нутгийн төвшинд түлээний мод, нүүрс, зэрлэг ан амьтны мах, арилжааны зорилгоор хийх зэрлэн ан амьтны ан агнуур зэрэг нөөцийг ашиглан дарамт үүсгэж болзошгүй;
- Байгалийн бусад баялгийн нөөцийн хөгжлөөс ихээхэн хамааралтай нөхцөлд тус уурхай зам, боомтын барилгы эсхүл усан цахилгаан станц болон цахилгааны бусад эх үүсвэр зэрэг үндэсний хэмжээний томоохон хөгжлийн үйл ажиллагаатай холбоотой болдог;
- Орон нутгийн буюу бүсийн амьдрах орчныг доройтуулж, биологийн төрөл зүйлийн сайн чанарын нөөцийг өндөр хөгжилтэй ландшафтад шилжүүлэх зэрэг орон нутгийн нөөц эх үүсвэрт уг үйл явц нэмэлт дарамт учруулдаг;
- Түүнчлэн ихийн хүсэн хүлээж нүүдэл хийн суурьших болсон хүн ам уг хүлээлт нь биелээгүй нөхцөлд тулгамдаж болзошгүй;
- Нийгэм эдийн засгийн төлөвлөлтийг хийгээгүй нөхцөлд бүс нутгийн хөгжлийн төвшинд гарах өөрчлөлт орон нутгийн ард иргэдийн аж байдалд эерэг болон сөргөөр нөлөөлж болзошгүй;
- Харин хүн амд учрах дарамт нөлөөлөл нь эргээд биологийн төрөл зүйлд нэмэлт дарамт учруулж болзошгүй (ядуурлыг улам бүр ихэсгэх).

Өнөөг хүртэл олон улс оронд дэд бүтцийн болон бусад хөгжлийн үйл явцыг тусд нь үнэлж явуулдаг. Гэхдээ нэгж уурхайн төслүүд тусдаа хэрэгждэггүй, ялангуяа дэлхийн бараа, бүтээгдэхүүн, цахилгаа эрчим хүчний өсөн тэлж буй зах зээлийн эрэлт хэрэгцээнд нийцэж бүс нутгийн хөгжил явагддаг тул тэдгээрийн байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийг ч нэгэн адил өргөн цар хүрээнд авч үзэх нь зүйтэй юм. Өнөөгийн улам бүр даяарших орчинд дэлхийн хөгжиж буй болон хөгжингүй бүс нутгуудын бараа, бүтээгдэхүүн, эрчим хүчний эрэлт хэрэгцээ хамгийн алслагдмал газар нутгийг ч хамарч байгаа нөхцөлд бүс нутгийн төлөвлөлтийн санаа санаачлагт тус дөхөм болох байгаль орчны стратегийн үнэлгээг хийх тодорхой хэрэгцээ шаардлага байна. Нэг жишээ дурдахад BirdLife International дэлхийн ураны эрэлт хэрэгцээ үндэсний хэмжээнд “ураны төлөөх тулаан”-ыг өдөөж буй Намибийн төсөлтэй холбоотой ажиллаж байна. Ураны эрэлд яаран хошуурсан уг үйл явц нийгэм, эдийн засгийн орчин хийгээд төв Намибийн цөл нутгийн биологийн өвөрмөц төрөл зүйл болон ландшафтад үлэмж нөлөөлж байна (Намибийн аялал жуулчлалын салбарт сөргөөр нөлөөлөх). Одоогоор Намибийн Уул уурхайн танхимын удирдлага дор уг газар нутагт уул уурхайн үйл ажиллагаа явуулах өсөн нэмэгдэх тооны хэд хэдэн компани болон сонирхогч хамтын нийгэмлэгийн дэмжлэгтэйгээр тус бүс нутгийн байгаль орчны стратегийн үнэлгээ явуулах санал галсан бөлгөө.

Үүнтэй холбогдуулж уг бүлэгт хөгжлийн боломжийг бүрэн ашиглаж, түүнтэй холбоотой биологийн төрөл зүйл болон соёлд учрах эрсдлээс зайлсхийж бууруулж чадах аваас Монгол орны бүс нутгийн болон үндэсний төвшинд байгаль орчны стратегийн үнэлгээ хийх зөвлөмжийг гаргав. Ийнхүү байгаль орчны стратегийн үнэлгээнд дараах арга хэмжээнээс тус дөхөм болно. Үүнд:

- Биологийн төрөл зүйлийг тодорхойлж тэмдэглэх: ач холбогдлоор нь жагсаах;
- Экологийн тогтолцооны үйлчилгээг тодорхойлж тэмдэглэх;
- Аж үйлдвэрийн хөгжлийн үйл явцын уялдаа холбоо- цахилгаан эрчим хүч, ус г.м.;
- Хот суурин газрын үйлчилгээ-цахилгаан, эрчим хүч, ус, хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн;
- Бүтэц, зохион байгуулалтын тэмдэглэгээ болон сонирхогч талуудын дүг шинжилгээ;
- Сонирхогч өргөн хүрээ бүхий талуудын оролцоо;
- Хувилбарын дүн шинжилгээ- тогтвортой хөгжлийн альтернатив хувилбаруудболон байршлын альтернатив хувилбарууд;
- Салбар дундын нэгдсэн төлөвлөлтийн цар хүрээг боловсруулах- шийдвэр гаргагч байгуулага болон асуудлууд (“хамтарсан бодлого” боловсруулалт);
- Эцэст нь цаг агаарын болзошгүй өөрчлөлтийг харгалзан үзэхэд илүүдэхгүй.

9.2. Аялал жуулчлалын салбартай холбоотой тэргүүн туршлага

Тусгай Хамгаалалттай газарт аялал жуулчлал эрхлэх талаар Олон Улсын байгаль хамгаалах холбооны удирдамж

Бүс нутгийн тусгай хамгаалалттай газар нутгуудад тогтвортой аялал жуулчлал хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулахад IUCN-ны *Зүүн азийн байгалийн цогцолборт газар болон тусгай хамгаалалттай газар нутгуудад аялал жуулчлал явуулах удирдамж* (Eagles 2001 он) маш сайн үндэс суурь болох учиртай. Ийнхүү төлөвлөгөө боловсруулахад IUCN-ны санал болгосноор хийх гол алхмууд болон Монголын нөхцөлд тохируулж уг саналыг хэрхэн ашиглах талаар Хүснэгт 26-аад тусгасан болно. Удирдамжинд цохон тэмдэглэснээр “байгаль, соёл, аялал жуулчлалын нөөцийн тооллого явуулж бүртгэлтэй болх явдал төлөвлөлтийн эхний үе шатанд хийгдэх ёстой зүйл. Хэрэв аялал жуулчлалыг ямарваа нэгэн төлөвлөгөөгүй хэдийнээ хөгжүүлж эхэлсэн бол ирээдүйн хөгжил, түүнтэй холбоодой үүдэн гарах сөрөг нөлөөллийг сайтар төлөвлөх үүднээс хийх ажлын жагсаалтын дагуу арга хэмжээ авахад хэзээ ч оройтохгүй” билээ.

Хүснэгт 26: IUCN-ны санал болгосноор хамгаалалттай газар нутагт тогтвортой аялал жуулчлал хөгжүүлэх төлөвлөгөө боловсруулах алхам ба Монголын нөхцөлд уг төлөвлөгөөг хэрэгжүүлэх нь

Санал болгож буй алхмууд	Монголын нөхцөлд үүнийг хэрэгжүүлэх нь
Байгалийн цогцолбор газар бүрийн хувьд тогтвортой аялал жуулчлал хөгжүүлэх тодорхой зорилтыг тодорхойлох	Эдгээр зорилтын хамрах хүрээний тухайд IUCN-ээс Монголд нэн ач холбогдол бүхий удирдамжийг (FNNPE-ээс 1993 онд баталсан) санал болгож буй. Байгаль орчны зорилтод дараах орж болох ба үүнд: (1) биологийн төрөл зүйлийг хамгаалах зэргийг оролцуулан экологийн хамгаалал; (2) газрын хамгаалал; (3) усан хагалбарын менежмент; (4) агаарын чанарын хадгалалт. Соёлын зорилтод: (1) орон нутгийн ард иргэд болон аялагч жуулчдын байгаль хамгааллын талаарх мэдлэг, ойлголтыг сайжруулах; (2) орон нутгийн байгалийн болон соёлын өвийг үнэлэх; (3) тогтвортой аялал жуулчлалыг орон нутгийн болон үндэсний соёлын бүрэлдэхүүн хэсэг болгох орно. Нийгмийн зорилтод: (1) аялагч жуулчдын сэтгэл ханамж; (2) орон нутгийн ард иргэдийн амьжиргааны төвшин болон ур чадварын ахиц; (3) масс болон багц аялал жуучлалын альтернатив хувилбарыг тодруулж, газар бүр тогтвортой аялал жуулчлалыг сурталчлах; (4) нийгмийн бүхий л салбарт хамгаалалттай газар нутагтай танилцах болмж олгох орно. Эдийн засгийн зорилтод: (1) орон нутгийн болон үндэсний эдийн засагт гарах дэвшил; (2) орон нутгийн бизнес болон ажил эрхлэлтийн боломжоор хангах; (3) хамгаалалттай газар нутгийг сахин хадгалах нэмэлт орлого хуримтлуулах.
Байгаль орчин, соёлын онцлог хийгээд аялал жуулчлалын өнөөгийн байгаа болон ирээдүйн боломжийн бүртгэлийг бүрдүүлэх. Мэдээллийг тэмдэглэж, дүн шинжилгээ хийх.	Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгааллын ач холбогдол газар бүр янз янз байх ба аялал жуулчлалын салбарын хөгжлийн хувьд энэхүү нөөц эмзэг байх нь ч янз бүр байдаг. Жишээ нь үржлийн болон нүүдлийн шувуудыг баримтжуулж, туруутан амьтдын хэрэгцээ шаардлагыг бүртгэх. Энэхүү мэдээлэл хамгаалалттай газрын төлөвлөлт болон нөлөөллийн үнэлгээнд хэрэгтэй. Бүртгэлийг заавал нарийвчлан хийх шаардлагагүй, мэдээллийг хадгалж нөхөн ашиглах тогтолцоо бүрдтэл яваандаа нэгдсэн бүртгэл буй болно. Хамгийн шилдэг хурдан гарааны цэг бол орон нутгийн мэдлэг байдаг.
Орон нугийн ард иргэдийн оролцуулах	Зүүн азийн аль оронтой харьцуулбал Монголд ирэх жуулчдид болон аялал жуулчлалын үйлчилгээ орон нутгийн ард иргэдийн оролцооноос ихээхэн хамаардаг. Тэдгээр нь тогтвортой аялал жуулчлалын төлөвлөлт хэрэгжилтэд оролцож, тур оператор болон засгийн газар тэдгээрт аялал жуулчлалаас гарах бодит үр шимийг хүртэх хүртээмжийг баталгаажуулах хэрэгтэй. Орон нутгийн ард иргэдээс бараа, бүтээгдэхүүн, үйлчилгээ худалдан авч, орон нутгийн ард иргэд өөрсдөө жуулчдын байх гэрт хөрөнгө оруулсан бэлтгэн нийлүүлэлтийн сүлжээтэй тэдгээрийг холбох хэрэгтэй.

Санал болгож буй алхмууд	Монголын нөхцөлд үүнийг хэрэгжүүлэх нь
Орон нутгийн иргэд, аялал жуулчлалын салбар болон бусад бүс нутгийн ба орон нутгийн байгууллагуудтай түншлэлийн зарчмаар хамтран ажиллах.	Тусгай хамгаалалттай газар нутгийн захиргаа, тур операторууд болон орон нутгийн ард иргэдийн түншлэл маш чухал ач холбогдолтой. Монголын тусгай хамгаалалттай газар нутагт ирж буй жуулчдын ихэнхи нь зохион байгуулалттай аялалд хамрагддаг тул тэдгээрийн үйл ажиллагаа уг газар нутгийн байгаль орчин, соёлын онцлогийг хүндэтгэсэн, хамгаалалттай газар нутгийн дүрэм журмыг чанд сахисан байх учиртай ба жуулчдад нарийн нягт сүүлийн үеийн мэдээллийг өгөх тал дээр анхаарах хэрэгтэй. Тур операторуудын удирдамжийг Австралийн Аялал жуулчлалын зөвлөл (1999 он) болон Байгалийн аялал жуулчлалын нийгэмлэг (1993 он) боловсруулжээ. Уг удирдамжинд аялалын өмнөх хөтөлбөр, хөтөчийн хөтөлбөр, мониторингийн хөтөлбөр, менежментийн хөтөлбөр болон орон нутгийн байр зэргийн талаар тусгажээ. Дараах асуудлыг онцлох зорилгоор IUCN-ээс Байгалийн аялал жуулчлалын нийгэмлэгийн удирдамжийг хэрэгжүүлж байна. Үүнд: (1) Сөрөг нөлөөллийг хэрхэн багасгах, орон нутгийн ард иргэдтэй хэрхэн харьцах талаар жуулчдад аялалын өмнө урьдчилан зөвлөгөө өгөх; (2) холбогдох ном, бүтээлүүд танилцуулж, жишээ татан, засч залруулах арга хэмжээ авч, аль болох жижиг бүлэгт жуулчдыг хуваан, менежмент муутай болон хэт талхлагдсан газруудаас залсхийх зэрэг арга замаар сөрөг нөлөөллийг багасгах; (3) сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх талаар компаний баримталдаг бодлогыг менежер болон нийт ажиллагсад танилцуулж ойлгуулах; (4) байгаль, соёлын хувьд эмзэг тогтоц бүхий газар нутагт үйлчлүүлэгчидтнй харьцаж, зохицуулалт хийх ур чадвар дээшлүүлэх сургалтыг менежер болон ажиллагсадын дунд явуулах; (5) жуулчид аялагчдыг хүлээн авсан газар нутгийн хамгаалалтанд хувь хандив оруулах; (6) бизнесийн үйл ажиллагааны бүхий л талбарт өрсөлдөх чадавхи бүхий орон нутгийн ажил эрхлэлтийг буй болгох; (7) орон нутгийн нөөцийг тарамдуулж, байгаль орчинд хор хөнөөлгүй бөгөөд байгаль орчны талаар танин мэдэхүйн ойлголт өгч, орон нутгийн ард иргэдтэй зохистой байдлаар харьцах боломж олгох газар нутгийн онцлогийн мэдрэмжтэй байраар хангах. Боловсруулсан удирдамж бүр эзэмшил, зүй зохистой ашиглалт болон өөрийн зохицуулалтын боломжийг нөхцөлдүүлэх оролцооны аргыг өргөн хэрэглэх явдал чухал.

Санал болгож буй алхмууд	Монголын нөхцөлд үүнийг хэрэгжүүлэх нь
Экологийн ач холбогдол бүхий газар нутагт хор хөнөөл учруулахгүйгээр аялал жуулчлалын нөлөө их газруудыг тодорхойлж, төлөвлөхөд бүсчлэлийн аргын хэрэглэх	Аялал жуулчлалын салбарын хөгжилд тус дөхөм болох үүднээс бүсчлэх явдал маш чухал гэдгийг урьд өмнө дурдаж байсан билээ. Тухайн газар нутагт хэрхэн очих, ямар машин унаа хэрэглэх, гэр баазын байршил, кэмпинг хихй тохиромжтой газрууд болон ус болон жуулчны сонирхол татахуйц газруудад хэрхэн очихыг тусгахдаа бүсчлэлийг тун тодорхой хийх хэрэгтэй. Бүсчлэлд зэрлэг ан амьтан, хөрс болон усны хангамжийн хувьд туйлын эмзэг газар нутагт анхдагч анхаарлаа төвлөрүүлнэ. Бүсчлэлийг аль болох хялбар хийж, менежментийн үйл ажиллагаанд тусган, ойлгож биелүүлэхэд хялбар байдлаар танилцуулах материалд тусган аянчин жуулчдад тараах явдал чухал. Баруун Монголын аялал жуулчлалын асуудлаар зөвлөгөө өгсөн Вингстен (2005 он) гэр баазуудыг хамгаалалттай газар нутгийн хил хязгаарын дотор байгуулах аваас дараах стандартыг баримтлах хэрэгтэйн гэжээ. Үүнд: (1) цементен шал хийж болохгүй- малчдын өрх гэрийх шиг шууд газар дээр гэр барих; (2) гэр баазаас зайтай газар машины зогсоол хийж, замын асуудлыг шийдвэрлэр; (3) цахилгаан эрчим хүч гаргахдаа дизель генератор бус салхин сэнс болон нарны элчийг ашиглах; (4) уг газрын менежментийг зүй зохистой явуулж, шаардлага хагахуйц бие засах газартай, шүршүүр болон хөлдөөгч ажиллуулах салхи, нарны цахилгаан үүсгүүр бүхий дээд тал нь 14 гэр зочдод зориулж барих; (5) Аялал жуулчлалын компани орон нутгийн ард иргэдээс мах, сүү худалдан авч, мал түрээслэн, ажлын байраар тэднийг хангах эрмэлзлэл бүхийгээ илэрхийлэх; (6) ус татдаг бие засах газруудыг хориглон усны ундрагаас 60 км зайнд хуурай бодис бүхий жорлон суурилуулах; (7) ажиллагсадад (гол төлөв хотын залуучууд) рок хөгжим чангаар тоглохыг хориглох; (8) гэр баазыг аялал жуулчлалын сонирхол татах гол цэг дээр байрлуулж болохгүй. Харин жуулчид ихэнхи цагаа гэр бааздаа өнгөрүүлж, тэндээсээ бусад газруудруу аялах учиртай. Вингстены санал болгосноор дээрх саналууд Монголын зарим газар хэдийнээ хэрэгжиж эхэлсэн байна (Төв аймгийн Жалман нуга, Арбүрдийн элс, Өмнөговийн Дүнгэнээ болон Булганы Дэлгэрийн гэр баазууд). Вингстены өөрийн компани болон Номадик Жонейз гэр баазын эздэд байгаль орчинд бага нөлөө бүхий үйлчилгээ үзүүлсэнд нэг жуулчны нэг хоногийн нэмэлт таван ам. доллар өгдөг юм. Харамсалтай нь усны нөөцийн хамгаалалын менежмент болон дээр дурдсанчлан бага нөлөө бүхий гэр баазуудын саналыг аймгийн байгаль орчны байцаагчдын хийдэг Байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр төдийлөн дэмждэггүй. Өөрийн гэр баазуудын нэр хаягийг байрлуулаагүй, ус татдаг бие засах газар болон барууны маягийн усанд орох шүршүүр зэрэг төхөөрөмжгүй эзэд “цэцэг” гэгдэх үнэмлэх авдаггүй ба жил тутам дээрх шаардлага хангаагүйн торгууль төлдөг. Түүнчлэн дизель цахилгаан үүсгэгч ашиглахаас илүү өртөг зардал бүхий нар, салхины эх үүсвэрт хөрөнгө оруулж ашиглах эрмэлзлэл огт үгүй болно.

Санал болгож буй алхмууд	Монголын нөхцөлд үүнийг хэрэгжүүлэх нь
Тусгай хамгаалалттай газар нутгийн ихэнхи хэсгийг ашиглах зөвшөөрөгдсөн лимит тогтоож, байгаль орчны стандартууд нэвтрүүлэн, хэрэгжилтийг хангах	Тусгай хамгаалалттай газар нутаг бүрт зөвшөөрөгдсөн ашиглалтын лимит тогтоох шаардлагатай ба үүнийг тухай газрын менежментийн төлөвлөгөөнд тусгана. Үүнийг хамгийн олдоц сайтай мэдээлэл, тухайн газар нутгийн талаар хамгийн сайн мэдлэгтэй нэгний саналыг үндэслэн хийнэ. Зөвшөөрөгдсөн ашиглалтын төвшинг тогтоосны дараа байгаль орчны стандартуудыг нэвтрүүлж, хэрэгжилтийг хянана.
Тусгай хамгаалалттай газар нутагтай аялал жуулчлалын ямар үйл ажиллагаа нийцэж буй эсхүл нийцэхгүй байгааг тогтоож холбогдох бодлого боловсруулах	Алхам 6-тай холбогдуулж алхам 2-той уялдуулан хамгаалалттай газар нутаг бүр тухайн газрын байгалийн үнэт зүйлстэй аялал жуулчлалын ямар үйл ажиллагаа нийцэж, эсхүл нийцэхгүй байгааг тогтооно. Алхам 6-тай нэгэн адил үүнийг хамгийн олдоц сайтай мэдээлэл болон тухайн газар нутгийн талаар хамгийн сайн мэддэг нэгний саналыг үндэслэн хийнэ.
Аялал жуулчлалын хөгжлийн саналуудын байгаль орчин, эдийн засаг, нийгэм болон соёлын нөлөөллийн үнэлгээг хийх	Тусгай хамгаалалттай газар нутгийн дотор ба гадна аялал жуулчлалын дэд бүтцийг хөгжүүлэх нь шинэ төслийн үнэлгээний үйл явц болон шаардлагатай нөхцөлд байгаль орчин хамгаалах төлөвлөгөөний агуулгыг тусгасан Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний хууль эрх зүйн баримт бичгийн шаардлагад тусгалаа олсон байдаг. Харин хөгжлийн томоохон үйл ажиллагааг төлөвлөж буй нөхцөлд үүнийг олон нийтийн өргөн хэлэлцүүлгийн зарчмаар шийдвэрлэх хэрэгтэй. Байгаль орчны нөлөөллийн үнэлгээг Алхам 2-т тусгасан үнэт зүйлд дээр тулгуурлан хийнэ.
Тухайн газар нутгийн байгаль орчин, соёл, өв болон чухал газруудын талаарх ойлголтыг сайжруулах боловсрол, танин мэдэхүйн хөтөлбөрүүдийг зочид болон орон нутгийн ард иргэдийн дунд явуулах	Зочид болон орон нутгийн ард иргэдэд зориулж боловсрол, танин мэдэхүйн чанартай хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх нь хамгаалалтай газар нутгийн амжилтын гол эх сурвалжуудын нэг бөлгөө. Үүний гол зорилго бол тухайн газар нутгийн байгаль, соёлын үнэт зүйлсийн талаарх ойлголтыг сайжруулж, аливаа сөрөг нөлөөллийг багасгах үүднээс аялагч жуулчдын зан авирт нөлөөлөх, хамгаалалттай газрын менежментийн зорилгыг тайлбарлан, тухайн газрын сонирхол татахуйц гол зүйлүүд, тэдгээрийг хэрхэн хүртэж үзэж сонирхох талаар аянчин жуулчдад анхааруулахад оршино. Менежментийн хүчин чадавхи огт үгүй эсхүл хомс газруудад зочдын ёс зүйн дүрэм боловсруулж товхимол материал болон тэмдэг тэмдэглэлийг ашиглан нэвтрүүлнэ. Эдгээр ёс зүйн дүрмэнд зочдоос чухам юүг хүсэн хүлээж буйг тодорхой дурдана. Дэлхийд нэн ховор буюу устах аюулд өртсөн амьтадтай зарим эмзэг газруудад мэргэжлийн хөтөч нар жуулчдыг уг газар аваачиж, үүнд төлбөр хураамж ногдуулан, хамгаалалттай газар төлөгдөж байх хэрэгтэй.

Санал болгож буй алхмууд	Монголын нөхцөлд үүнийг хэрэгжүүлэх нь
Хамгийн бага сөрөг үр дагавартайгаар жуулчдыг зорьсон газар нутагт хүргэх аргачлалыг боловсруулах	Гол хүндрэлийн талаар дээр дурдсан ба үүнийг жуулчдыг уг газар нутагт хүргэх зохистой аргачлал хэрэглэх замаар зохицуулж болх юм. Үүнд төрөл бүрийн аялал зохион байгуулах, зэрлэг ан амьтан нуугдаж ажиглах, эсхүл байгалийн ажиглалтын цэгүүдээс ажиглалт хийх зэргийг сонгож болно. Үүнийг маш болгоомжтой бөгөөд тэргүлэх ач холбогдол өгч буй амьтдын ашиг сонрхолд нийцүүлж хийнэ. Аль болох хялбар бүтэц үүнд ашиглах хэрэгтэй. IUCN-ны удирдамжинд аялал зохион байгуулах маршрутыг тогтооход төдийлөн хүндрэлтэй биш, аялагчдын сонирхолтой болон олонд танигдсан онцлогтой танилцуулах, богино болон урт хугацааны аялал зохион байгуулах маршрут боловсруулах, ойр орчмын газар алхахад хялбар байхыг харгалзах, уул толгодоор аялал болгоомжтой зохион байгуулах, уулзварыг тодорхой тэмдэглэж маш эмзэг орчин болон амьтдаас залсхийх. Шаардлагатай нөхцөлд аялалын хөтөч болон газрын зургаар хангах.
Аялал жуулчлалын зах зээл, жуулчдын хэрэгцээ болон хүлээлтийн талаар сайтар судлаж, дүн шинжилгээ хийх. Аялал жуулчлалын шинэ бүтээгдэхүүн боловсруулахын өмнө буюу дараа уг үйл ажиллагааг явуулах нь илүү тохиромжтой.	Тур операторууд болон хамгаалалттай газрын захиргаа хамтран ажиллаж жуулчдын хэрэгцээ, шаардлага болон хүлээлтийн талаарх судалгааг ЗТАЖЯ-ны удирдамжаар явуулах нь зүйтэй.
Ирээдүйд боловсруулах аялал жуулчлалын бүтээгдэхүүний талаар иж бүрэн судлаж, ирэх жуулчдын төрөлд хэрхэн нөлөөлөх талаар дүгнэлт гаргах. Тогтвортой аялал жуулчлал хөгжүүлэх газар нутгийн үнэт зүйл болон имидж болон түүнд тохирсон сурталчилгааны стратегийг тодорхойлох.	Тусгай хамгаалалттай газрын үнэт зүйлс, аялал жуулчлалын боломжийн талаар харилцан санал солилцох үүднээс хамгаалалттай газрын захиргаа тур операторуудыг хүлээн авч хамгаалалтанд байлгах ач холбогдлын хувьд тус газрыг хэрхэн сурталчлах талаар харилцан ярилцах. Сурталчилгааны стратеги болон материал боловсруулахад хөндлөнгийн туслалцаа шаардагдах магадлалтай.

Санал болгож буй алхмууд	Монголын нөхцөлд үүнийг хэрэгжүүлэх нь
Тусгай хамгаалалттай газар нутаг, жуулчид түүнийг хэрхэн ашиглаж буй байдлын мониторингийг хийх. Тодорхой цаг хугацааны давтамжтайгаар аялал жуулчлалын зориулалтаар уг газар нутгийг ашиглахдаа байгаль орчны стандарт баримтлаж буйг баталгаажуулах төлөвлөгөөнд гарсан ахицыг үнэлэх. Хэрэгцээтэй бол төлөвлөгөөг дахин хянах.	Тусгай хамгаалалтай газар нутгийн захиргааны төлөөлөл болон орон нутгийн ард иргэдийн оролцоотой мониторингийн хялбар тогтолцоог бүрдүүлж болно. Мониторингийн схемд чухал амьтад, амьдрах орчин, менежментийн үйл ажиллагаа болон уг газар нутгийг жуулчид хэрхэн ашиглаж буй байдлыг хамарна (хүрэлцэн ирэх цаг хугацаа, байх хугацаа, жуулчдын тоо, харьяалал, тур операторын нэр болон тус газар нутагт үзүүлэх нөлөөлөл зэрэг).
Сургалт хийгээд бусад ямар хэрэгцээ шаардлага байгаа, ямар эх үүсвэр ашиглах талаар хамтаар судлах.	Тусгай хамгаалалттай газар нутгийн тогтвортой менежментийг хэрэгжүүлэхэд тулгарах гол хязгаарлагч хүчин зүйл бол хүчин чадавхи болон санхүүгийн эх үүсвэрийн дутмаг байдал гэж урьд өмнө тодорхойлсон билээ. Аялал жуулчлалтай холбоотой хэрэгцээ шаардлагаас гадуур хэрэгцээг тодорхойлсноор менежерүүд эх үүсвэрийг илүүтэй хуваарилах нөхцлийг бүрдүүлнэ. Тусгай хамгаалалттай газар нутаг, аялал жуулчлалын салбарын өсөлт, нийт эдийн засгийн хөгжлийн хоорондын уялдаа холбоог тогтоох нь ахиухан хөрөнгө, нөөцийн хүсэлт тавих үндэслэл болдог.
Төлөвлөгөөг хэрэгжүүлэх	Бараг ихэнхи тохиолдолд бүх төлөвлөгөө цаг, хөрөнгө, нөөц ихээр зарцуулсан ч хэрэгжилгүй тавиур бөглөдөг. Төлөвлөлтийн үйл ажиллагаа, төсөв боловсруулах, хүний нөөцийг хуваарилж гарч буй ахиц амжилтын талаар мэдээлэхэд төлөвлөлтийг ашигладаг. Тиймээс тэдгээрийн хэрэгжилтийн мониторингийг байнга хийж байх шаардлагатай.

Үндэсний байгалийн аялал жуулчлалын стратегийг тэтгэн дэмжих санхүүжилтийн механизмын Австралийн жишээ

1994 онд Австралийн аялал жуулчлалын салбар Үндэсний байгалийн аялал жуулчлалын стратеги боловсруулжээ. Энэхүү стратегийн баримт бичиг хөтөлбөрийн 12 талбар, нутгийн уугуул иргэдийг аялал жуулчлалын үйл ажиллагаанд татан оролцуулах, жуулчны маршрут боловсруулах зэрэг байгалийн аялал жуулчлалын гол гэгдэх 12 асуудлыг хамарчээ. Энэ стратегийг бүхэлд нь хувийн хэвшил боловсруулсан юм. Гэхдээ Австралийн засгийн газар уг салбарын төлөөлөгчдийн дунд зөвшилцөл байгааг нэгэнт мэдэрсэн тул Үндэсний байгалийн аялал жуулчлалын стратегийн уг баримт бичгийн хэрэгжилтэнд зориулж

дөрвөн жилийн турш 10 сая австрали доллар гаргах болжээ. Уг стратегид тодорхойлсон асуудлын алийг ч шийдвэрлэх сонирхолтой компаниуд, иргэний нийгмийн байгууллагууд болон бусад сонирхогч талууд салбар дотроо холбоо байгуулж санхүүгийн эх үүсвэрээс хүртэх боломжийг уг механизм бүрдүүлсэн юм. Өөрийн давуу тал болон сонирхолын дагуу төрөл бүрийн талуудыг уг стратегийг хэрэгжүүлэх боломжоор санхүүжилтийн уг механизм хангасан бөлгөө.

Хувийн хэвшлийн аялал жуулчлалын компаниуд, байгаль хамгаалах байгууллагууд болон тусгай хамгаалалттай газар нутгийн захиргааны хооронд стратегийн түншлэл байгуулах бүрэн боломж бүхий тул ийнхүү санг Монголд байгуулж болох талтай. Ингэснээр байгаль хамгаалах, иж бүрэн төлөвлөлтийн асуудлыг орхигдуулж гол төлөв гадаад сурталчилгаа, орон нутаг дээр суурилсан аялал жуулчлалын асуудалд анхаарлаа төвлөрүүлдэг хандивлагчдын аялал жуулчлалын салбарт зориулдаг санхүүжилтийн эх үүсвэрийн дутмаг байдлыг нөхөж болно.

Ишлэл авсан бүтээлүүд

ACS Publications- Байгаль орчны шинжлэх ухаан ба технологийн онлайн бодлогын мэдээ-2005 оны 11 сарын 23 http://pubs.acs.org/subscribe/journals/esthag-w/2005/nov/policy/cc_wetlands.html 2008 оны 6 сарын 20-д дахин үнэлгээ хийгдсэн.

Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар (ГЗБГЗЗГ) (2003 он) *Монголын газар нутгийн хөгжлийн иж бүрэн төлөвлөгөө: 2004-2023 он.* Улаанбаатар: Газрын алба, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газар.

ГЗБГЗЗГ ба Монгол дахь ДБХС (2008 он) *Орон нутгийн хамгаалалттай газрын тухай мэдээллийг газар зүйн мэдээллийн тогтолцоонд нэгтгэн тайлагнах нь.* Улаанбаатар: ГЗБГЗЗГ ба Монгол дахь ДБХС.

Anglo-American. Компани хариуцлага- Тогтвортой хөгжил- Биологийн төрөл зүйл (2008 он) http://www.angloamerican.co.uk/cr/sustainabledevelopment/biodiversity/ 2008 оны 6 сарын 22-д дахин үнэлгээ хийгдсэн.

Батсүх, Н. Ба Белокуров, А. (2005 он) *ДБХС-ийн RAPPAM аргачлалын дагуу Монголын тусгай хамгаалалттай газар нутгийн тогтолцооны менежментийн үр ашгийн үнэлгээ.* Улаанбаатар: Монгол дахь ДБХС.

BHP-Billiton. Тогтвортой хөгжил- Байгаль орчны үүрэг амлалтууд- Биологин төрөл зүйл (2007 он) http://bhpbilliton.com/bbContentRepository/docs/SustainableDevelopment/policiesAndKeyDocuments/HSECPolicy.pdf 2008 оны 3 сарын 10-д дахин үнэлгээ хийгдсэн.

BirdLife International (2004 он) *Азийн шувуудад чухал газар: тусгай хамгаалалттай гол газар нутгууд.* Кэмбридж, Их Британи: BirdLife International.

Булгаамаа, Б. (2004 он) Сөрөг хүчний шаардлагаар хамгаалалттай газар нутгийг чөлөөлөх засгийн газрын тендер, *UB Post,* 2004 оны 1 сарын 8.

Биологийн төрөл зүйлийн нөхөн тэнцвэржүүлэлтийн боломжийг эрэлхийлэхэд компани, засгийн газар болон байгаль хамгаалах мэргэжилтнүүдийн шинэ түншлэл болох Бизнес болон биологийн төрөл зүйлийн офсетийн хөтөлбөрүүд (BBOP) (2008 он) http://www.forest-trends.org/biodiversityoffsetprogram/ 2008 оны 6 сарын 20-д дахин үнэлгээ хийгдсэн.

Clayton, B. (2006 он) Монголын засгийн газар ба Парламентын гишүүдэд хандаж хэлсэн үгний товчоон. Улаанбаатар, 2006 оны 12 сарын 13.

АНУ-ын загас, зэрлэг ан амьтны албанд зориулж болосруулсан төв засгийн газрын нөөцийн хууль тогтоомжийн дээжис. Аюулд өртсөн амьтдын тухай 1973 оны хууль. http://www.fws.gov/laws

Eagles,P.F.J., Bowman, M.E., ба Tao, T.C.-H. (2001 он) *Зүүн Азийн байгалийн цогцолборт газар болон тусгай хамгаалалттай газар нутаг аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулах*

удирдамж. Gland, Швейцари ба Кэмбридж, Их Британи: UINC.

Eberherr, T. (2000 он) *Баруун Монголын тусгай хамгаалалттай газар нутагт байгалийн аялал жуулчлал хөгжүүлэх зөвлөмж.* ДБХС-ийн хөтөлбөр.

Энэбиш, Д. ба Мягмарсүрэн, Д. (2000 он) *Монгол орны тусгай хамгаалалттай газар нутгууд.* Улаанбаатар: Байгаль хамгаалах газар.

Ervin, J. (2003 он) Тусгай х*амгаалалттай газрын менежментийн түргэвчилсэн үнэлгээ болон ач холбогдлын дэс дарааллын аргачлал (RAPPAM).* Glad. WWF International.

Европын Комис>Байгаль орчин>Байгаль ба биологийн төрөл зүйл>Амьдрах орчны чиглэл. 92/43/EEC тоот Зөвлөлийн чиглэл, 1992 оны 5 сарын 21-ий өдөр, газар нутаг, амьтан, ургамлын аймгийн хамгаалал http://ec.europa.eu/environment/nature/legislation/habitatsdirective/index_en.htm 2008 оны 6 сарын 22-д дахин үнэлгээ хийгдсэн.

Европын комис > Байгаль орчин > байгаль ба биологийн төрөл зүйл> Шувуудын талаарх удирдамж, 79/409/EEC тоот Зөвлөлийн чиглэл, Зэрлэг шувуудыг хамгаалах талаар http://ec.europa.eu/environment/nature/legislation/birdsdirective/index_en.htm 2008 оны 6 сарын 22-д дахин үнэлгээ хийгдсэн.

Farrington, J. (2000 он) Заамрын алтны уурхай дахь байгаль орчны тулгамдсан асуудлууд, Монгол. *World Placer Journal* 1(1): 107–128.

Farrington, J. (2001a) *Зөрчилтэй асуудлыг шийдвэрлэх АНУ, Канад ба Австралийн загвар болон Монгол орны уул уурхайн салбар ба тусгай хамгаалалттай газар нутгийн зөрчлийн талаарх тайлан.*Улаанбаатар: Монголын Ашигт малтмалын газар.

Farrington, J. ed. (2001b) *Монгол: Чингис Хааны өлгий нутагт шинэ малталын шинэ боломжийг нээх нь.* Улаанбаатар: Монголын Ашигт малтмалын газар.

Farrington, J. D. (2005) Монгол орны тусгай хамгаалалттай газар нутагт уул уурхайн үйл ажиллагааны нөлөөлөх сөрөг нөлөөлөл: нөхцөл байдлын талаарх тайлан ба бодлогын чанартай зөвлөмж. *Байгаль орчны нэгдсэн үнэлгээ ба менежмент* 1(3): 283-289.

FNNPE [Европын Байгаль орчин, байгалийн цогцолбор газруудын хороо] (1993). *Үхтлээ хайрлаж байна уу? Европын байгалийн болон үндэсний цогцолботр газрууд дахь тогтвортой аялал жуулчлал.* Eupen, Бельги: Европын Байгаль болон байгалийн цогцолборт газруудын хороо.

Gratzfeld, J. ed. (2003 он) *Хуурай болон хагас хуурайшилтай бүс дэхь олборлолтын үйлдвэрлэл: байгаль орчны төлөвлөлт болон менежмент*. Gland and Cambridge: IUCN.

Hansen, M. ed. (1996 он) *Барууны нөхөн сэргээх арга техникийн гарын авлага*. Денвер: Газрын гадаргуйн нөхөн сэргээлт болон хууль сахиулах алба.

Hockings, M., Stolton, S. ба Dudley, N. (2000 он) *Үр ашгийг үнэлэх нь: хамгаалалттай газар нутгийн менежментийг үнэлэх цар хүрээ*. WCPA Шилдэг хамгаалалттай газрын туршлагын удирдамжийн цуврал. дугаар 6. Gland: IUCN.

ICMM [Уул уурхай, металын олон улсын зөвлөл] (2006 он) *Уул уурхай ба биологийн төрөл зүйлийн сайн туршлага*. Лондон: Уул уурхай, металын олон улсын зөвлөл.

IIED [Байгаль орчин, хөгжлийн олон улсын хүрээлэн] ба WBCSD [Тогтвортой хөгжлийн дэлхийн бизнесийн зөвлөл] (2002 он) *Уул уурхай, эрдэс баялаг болон тогтвортой хөгжил*. Тогтвортой хөгжлийн дэлхийн бизнесийн зөвлөлд хүргүүлэх төслийн тайлангийн төсөл.

IIED ба WBCSD (2002 он) *Уул уурхай, эрдэс*

баялаг ба тогтвортой хөгжил. MMSD-ын тайлан. Earthscan Publications Ltd, London ба Sterling, VA.

IMMI [Монгол дахь Ivanhoe Mines Inc.] (2007 он) *Лавлагааны баримт: Оюу Толгойн төсөл*. 2007 оны 12 сарын 11-ий өдрийн хэвлэгдээгүй хүснэгт.

Хүчлээс урьдчилан сэргийлэх олон улсын сүлжээ. Уурхайн сульфидын хэрэглээг бууруулах эхмэлзлэл бүхий уул уурхайн олон улсын аж ауйн нэгжийн байгууллага. http://www.inap.com.au 2008 оны 5 сарын 20-д дахин үнэлгээ хийгдсэн.

Ito, T. Y., Miura, N., Лхагвасүрэн, Б., Энхбилэг, Д., Takatsuki, S., Tsunekawa, A. ба Jiang, Z. (2005 он) Монголын хар сүүлтийн нүүдэлд төмөр зам саад тотгор учруулдаг тухай урьчилсан нотлох баримт. *Conservation Biology* 19(3): 945-948.

Жаргалсайхан, Д. (2004 он) Монголын эрдэс баялгийн салбарт хөрөнгө оруулах нь. Монголын хөрөнгө оруулагч, бизнесийн чуулган дээр тавьсан илтгэл. 2004 оны 10 сарын 24. www.mram.mn/english.htm 2005 оны 1 сарын 17-д дахин үнэлгээ хийгдсэн.

Johnstad, M. D. ба Reading, R. P. (2003 он) Монгол орны тусгай хамгаалалттай газар нутгийн тогтолцоо. *Хойт Евроазийн биологийн төрөл зүйлийн талаарх мэдээлэл, Оросын байгаль хамгаалах сонины нэмэлт дугаар* 2(1): 8-11.

Khamaganova, E. (2001 он) Тогтвортой хөгжлийн өнцгөөс Их Засгийг харах нь. *Монгол судлалын олон улсын холбооны товхимол*.

Kyodo News Agency (2008 он) Япон Улс Монголд нисэх онгоцны шинэ буудалд зориулж ₮28.81 тэр бум йен (17.46 сая ам. доллар орчим)-ны зээл олгов.Kyodo Мэдээллийн агентлагийн мэдээ, 2008 оны 3 сарын 3.

БОЯ [Байгаль орчны яам] (1997 он) *Биологийн төрөл зүйлийн хамгаалалын төлөвлөгөө*. Улаанбаатар: Байгаль орчны яам.

БОЯ (2007 он) *Биологийн төрөл зүйлийн конвенцийн биелэлтийн талаар Монголын гаргасан үндэсний гурав дахь тайлан*. Улаанбаатар: Байгаль орчны яам.

Mongol Messenger Редактор (2004 он) Тусгай хамгаалалттай газар уул уурхайн үйл ажиллагааг зогсоов. *Mongol Messenger* 15: 2004 оны 4 сарын 15. www.mongolm-essenger.mn/issue/040415.php 2005 оны 1 сарын 2-д дахин үнэлгээ хийгдсэн.

Монголын уул уурхайн үндэсний ассоциаци http://www.miningmongolia.mn/ 2008 оны 6 сарын 22-д дахин үнэлгээ хийгдсэн.

ЗТАЖЯ [Зам, тээвэр, аялал жуулчлалын яам] (2007 он) *Монгол орны тээврийн үндэсний стратеги*. Улаанбаатар: Зам, тээвэр, аялал жуулчлалын яам ба Азийн хөгжлийн банк.

ЗТАЖЯ [Зам, тээвэр, аялал жуулчлалын яам] (2007 он). *Монголын аялал жуулчлалын салбарыг 2007-2011 онуудад хөгжлүүлэх стратеги.* Улаанбаатар: Зам, тээвэр, аялал жуулчлалын яам.

Үндэсний чийглэг газар нутгийг бууруулах үйл ажиллагааны төлөвлөгөө (2008 он) http://www.mitigationactionplan.gov/ 2008 оны 5 сарын 21-д үнэлэгдэв.

Newmont уул уурхайн компани, уул уурхайгаас тогтвортой хөгжил хүрэх замнал 2007 http://www.beyondthemine.com/2007 2008 оны 6 сарын 23-д үнэлэв.

Newmont уул уурхайн компани. Newmont компаний тогтвортой байдлын тайлан – өдгөө бө 2005 оноос хйош / Байгаль орчин. http://www.newmont.com/csr05/environment_2.html 2008 оны 6 сарын 23-д үнэлэв.

Нямбаяр, Б. ба Цэвээнмядаг, Н. (2008 он) *Монгол орны шувуудад чухал газрын жагсаалт: хамгаалалтанд авах гол газар нутаг*. Улаанбаатар: Зэрлэг амьтан судлан хамгаалах төв, Биологийн

хүрээлэн ба BirdLife International.

Оюунбаяр, Н. (2000 он) Гадаад өрийн өсөн нэмэгдэх аюул. *UB Post*. No. 24(213). 6 сарын 16.

Rio Tinto (2004 он) *Rio Tinto-ийн биологийн төрөл зүйлийн стратеги*. Лондон: Rio Tinto.

Rio Tinto (2008 он) Онцлог – Tom Price-ийн уурхайд хүчлийн чулуун өрөмдлөгийг зохицуулах нь http://www.riotinto.com/whatweproduce/517_6716.asp оны 6 сарын 22-д үнэлэв.

Schleicher, K. (2007 он) *Ноён хангайн байгалийн цогцолборт газар дахь аялал жуулчлал: аюул, зөрчил ба боломж.* GTZ-ийн хөтөлбөрт хүргүүлэх тайлан: Байгалийн нөөцийн хамгаалал ба тогтвортой менежмент. Цэцэрлэг, Архангай аймаг, Монгол: GTZ.

Schleicher, K. and Hotz, H. (2007 он). *Хүйсийн найман нуурын байгалийн дурсгалт газар явагддаг аялал жуулчлалын үйл ажиллагаа: аюул, зөрчил ба боломж*. GTZ-ийн хөтөлбөрт хүргүүлэх тайлан: Байгалийн нөөцийн хамгаалал ба тогтвортой менежмент. Цэцэрлэг, Архангай аймаг, Монгол: GTZ.

ten Kate, K., Bishop J., ба Bayon, R. (2004 он). *Биологийн төрөл зүйлийн нөхөн тэнцвэржүүлэлт: санал бодол, дадлага туршлага ба бизнесийн жишээ.* IUCN, Gland, Швейцари ба Кэмбридж, Их Британи ба Insight Investment, Лондон, Их Британи.

Азийн сан (2007a) *Уул уурхайн тусгай зөвшөөрөл олголт: Монголын иргэдийн хөтөч.* Улаанбаатар: Азийн сан.

Азийн сан (2007b) Хариуцлагатай уул уурхайн асуудлаархи олон талт чуулга уулзалт: хамтарсан шийдвэр гаргах цар хүрээ. Хэвлэгдээгүй хүснэгт.

Байгалийн аялал жуулчлалын нийгэмлэг (1993 он) *Байгалийн аялал жуулчлалын тур операторуудад зориулсан байгалийн аялал жуулчлалын удирдамж.* North Bennington, Vermont: Байгалийн аялал жуулчллаын нийгэмлэг.

Австралийн аялал жуулчлалын зөвлөл (1999 он) *Байгальд ээлтэй байх нь таны үүрэг.* Woolloomooloon, New South Wales, Australia: Австралийн аялал жуулчлалын зөвлөл.

UNDP [НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр] (2001 он) Монгол орны хамгаалалттай газар нутагт аюул нүүрлэв. *UNDP Мэдээлэл*. 2001 оны 11 сарын 21. www.un-mongolia.mn/index.php?name=News&fi_le=article&sid=79 2005 оны 1 сарын 17-д үнлэгэдэв.

UNESCO [НҮБ-ын боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага] (2008 он) *Шим мандалын нөөц*. www.unesco.org/mab/faq_br.shtml 2008 оны 6 сарын 18-д үнэлэгдэв.

UNIDO [НҮБ-ын аж үйлдвэрийн хөгжлийн байгууллага] Гар аргаар алт олборлох цэвэр аргачлал ба олборлолтын технологийг хөтөлбөр болон уг үйл ажиллагааны эрүүл мэнд, байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг үнэлэх нь. http://www.natural-resources.org/minerals/cd/unido.htm 2008 оны 5 сарын 20-д үнэлэгдэв.

UNIDO [НҮБ-ын аж үйлдвэрийн хөгжлийн байгууллага] Мэдээлэл: Мөнгөн усны бохирдол үүсгэхгүйгээр гар аргаар алт олборлох онцлог (2003 он) http://www.natural-resources.org/minerals/cd/docs/unido/asm_mercury.pdf 2008 оны 5 сарын 20-д үнэлэгдэв.

АНУ-ын цэргийн инженерүүдийн корпус http://www.usace.army.mil/ 2008 оны 6 сарын 22-д үнэлэгдэв.

АНУ-ын цэргийн инженерүүдийн корпусаас чийглэг газрыг хамгаалалтгүй байлгахыг зөвшөөрөв, GAO-ын ололт http://pubs.acs.org/subscribe/journals/esthag-w/2005/nov/policy/cc_wetlands.html 2008 оны 5 сарын 22-д үнэлэгдэв.

АНУ-ын Байгаль орчны хамгааллын

агентлагаас гаргасан хөдөө аж ахуйн цэвэр усны тухай хууль. http://www.epa.gov/oecaagct/lcwa.html 2008 оны 6 сарын 22-д үнэлэгдсэн.

Wetlands International (2002 он) *Усны шувуудын популяцийн тооцоо*. Wageningen: Wetlands International.

Wigsten, J. (2005 он) *Хар ус нуурын байгалийн цогцолборт газар ба түүний орчны бүст хийгдэж буй байгалийн аялал жуулчлалын хөгжлийн үнэлгээ, Монгол. Монгол дахь ДБХС*.

Wingard, J. R. ба Zahler, P. (2006 он) *Нам жим тал нутаг:Зэрлэг ан амьтны хууль бус наймааны улмаас Монголд өрнөж буй хямрал*. Монгол: хэлэлцүүлгийн баримт бичиг, Зүүн Ази болон Номхон далайн байгаль орчин, нийгмийн хөгжлийн департамент. Вашингтон хот: Дэлхийн банк.

Дэлхийн банк (1999 он) *Орон зай,алслагдмал байдлыг даван туулах нь: Монголын тээврийн салбарын стратеги.* Вашингтон хот, Дэлхийн банк.

Дэлхийн банк (2006 он) *Монгол: Уул уурхайн салбарын байгаль орчин, нийгмийн нөлөөллийн үнэлгээ. Вашингтон хот*: Дэлхийн банк.

Дэлхийн банк ба PPIAF (2007 он) *Тогтвортой хөгжлийн үндэс суурь: Монгол дахь дэд бүтцийн үйлчилгээ хүргүүлэх тогтолцоог өөрчлөх нь. Гол тайлан ба хавсралт*I, II болон III. Вашингтон хот: Дэлхийн банк ба Улс- Хувийн хэвшлийн дэд бүтцийн зөвлөлгөө өгөх арга хэрэгсэл.

Дэлхийн алтны зөвлөл. Алтанд итгэхүй. http://www.trustingold.com/ 2008 оны 6 сарын 21-д үнэлэгдэв.

ДБХС (2008 он) Даурийн тал хээр - Глобал 200 экологийн бүс нутаг. http://www.panda.org/about_wwf/where_we_work/ecoregions/daurian_steppe.cfm 2008 оны 10 сарын 30 –д үнэлэгдэв.

Xstrata Тогтвортой байдлын веб хуудас – Байгаль орчин –Биологийн төрөл зүйлийн хамгаалал http://www.xstrata.com/sustainability/environment/biodiversity/ 2008 оны 6 сарын 24-д үнэлэгдэв.

Хавсралт 1. Монгол орны улсын тусгай хамгаалалттай газар нутгууд

№	Газрын нэр	Байгуулагдсан он	ГМТ-ны талбай (га)	Албан ёсны талбай (га)
	Дархан цаазат газар нутаг			
1	Богд Хаан уул	1778/1957/1978	41,383	41,651
2	Дорнод Монгол	1992	615,732	570,374
3	Их Говь “А”	1975	4,644,091	5,311,730
4	Их Говь “В”	1975	921,551	
5	Хан Хэнтий	1992	1,233,351	1,227,074
6	Хасагт хайрхан	1965	31,854	27,448
7	Хөх сэрхийн нууруу	1977	74,474	65,920
8	Хоридол сарьдаг	1997	227,968	188,634
9	Монгол дагуур “А”	1992	85,085	103,016
10	Монгол дагуур “В”	1992	18,617	
11	Нөмрөг	1992	333,155	311,205
12	Отгонтэнгэр	1992	96,620	95,510
13	Бага Говь “А”	1996	1,166,346	1,839,176
14	Бага Говь “В”	1996	695,036	
15	Увс нуур	1993/1995	462,503	712,545*
16	Алтан элс	1993/1995	171,203	
17	Цагаан шувуут	1993/1995	34,624	
18	Түргэн	1993/1995	133,810	
	Цогцолборт газрууд			
1	Алтай таван богд	1996	623,220	636,161
2	Дарьганга	1993/2004	70,086	62,860
3	Говь гурван сайхан	1993/2000	2,680,819	2,694,307
4	Горхи-тэрэлж	1993	292,010	293,168
5	Их богд уул	2007	262,858	282,931
6	Хан хөхий	2000	214,331	555,924**
7	Хяргас нуур	2000	374,746	
8	Хангайн нуруу	1996	889,986	888,455

№	Газрын нэр	Байгуулагдсан он	ГМТ-ны талбай (га)	Албан ёсны талбай (га)
9	Хар ус нуур	1997	862,014	850,272
10	Хөгнө тарна	2003	78,798	84,390
11	Хорго тэрхийн цагаан нуур	1965/1995	85,007	77,267
12	Хөвсгөл нуур	1992	848,828	838,070
13	Хустайн нуруу	1993/1998	57,341	50,620†
14	Молцог элс	1993/1998	488	
15	Мөнххайрхан уул	2006	308,230	300,000
16	Мянган угалзат	2002	63,129	60,000
17	Ноён хангай	1998	59,162	59,088
18	Онон балж “А”	2000	291,814	402,100
19	Онон балж “В”	2000	102,881	
20	Отхоны хөндийн	2006	92,955	90,000
21	Сийлхэм”А”	2000	77,843	142,778
22	Сийлхэм”В”	2000	76,647	
23	Тарвагатай нуруу	2000	557,447	545,609
24	Цамбагарав	2000	113,012	111,462
25	Тужийн нарс	2002	70,864	80,691
26	Улаантайга	2003	108,832	108,000
	Байгалийн нөөц газар			
1	Алаг хайрхан	1996	36,100	36,400
2	Батхаан	1957/1995	21,759	21,850
3	Булган гол	1965/1995	11,892	7,657
4	Бурхан буудай	1996	51,571	52,110
5	Дэвэлийн арал	2000	10,022	10,338
6	Эргэлийн зоо	1996	57,581	60,910
7	Их газрын чулуу	2003	34,096	35,000
8	Их найртын чулуу	1996	70,088	43,740
9	Ханжаргалант уул	2003	62,971	60,000
10	Хар ямаат	1998	51,274	50,594
11	Лхачинвандад	1964/1995	55,382	58,800
12	Хагалхаан	1957/1995	4,806	3,076
13	Намнан уул	2003	29,709	29,600
14	Шарга	1993	320,046	390,071‡
15	Манхан	1993	84,701	
16	Тэсиийн гол	2006	108,589	101,000
17	Тосон хулстай	1998	471,937	469,928
18	Угтам	1993	42,595	46,160
19	Яхий нуур	1998	248,672	251,388
20	Загийн ус	1996	283,832	273,606
	Байгалийн дурсгалт газрууд			
1	Булган уул	1965/1995	2,002	1,840

№	Газрын нэр	Байгуулагдсан он	ГМТ-ны талбай (га)	Албан ёсны талбай (га)
2	Даян дээрхийн агуй	2006	31,303	28,000
3	Ээж хайрхан	1992/1995	22,904	22,475
4	Хүйсийн найман нуур	1992/1995	11,158	11,500
5	Хөргийн хөндийн	2004	6,109	6,000
6	Шийлийн богд	2004	18,152	17,200
7	Сүйхэнт уул	1996	7,717	4,830
8	Уран тогоо-тулга уул	1965/1995	5,420	5,800
	Нийт		22,413,136	21,808,309

Мэдээллийн эх сурвалж: Монгол дахь ДБХС ба БОЯ; Монгол дахь ДБХС-ийн полигон дээр үндэслэн ГМТ-ны талбайг тооцоолов

Тэмдэглэл: * = Менежментийн нэг бүтэцтэй Увс нуур, Алтан элс, Цагаан шувуут болон Түргэний нийлбэр дүн бүхий албан ёсны талбай; ** = менежментийн нэг бүтэцтэй Хан хөхий ба Хяргас нуурын нийлбэр дүн бүхий албан ёсны талбай; † = менежментийн нэг бүтэцтэй Хустайн нуруу ба Молцог элсний нийлбэр дүн бүхий албан ёсны талбай; ‡ = менежментийн нэг бүтэцтэй Шарга ба Манханы нийлбэр дүн бүхий албан ёсны талбай.

Хавсралт 2. Монгол орны орон тусгай нутгийн хамгаалалттай газар нутгууд

Аймаг	Орон нутгийн ТХГ-ын тоо	Аймгийн төвшний орон нутгийн ТХГ-ууд	Сумын төвшний ТХГ-ууд	Тодорхойгүй төвшин	Орон нутгийн ТХГ-ын талбай (га)
Архангай	30	3	27	0	552,375
Баянхонгор	36	19	2	15	2,817,750
Баян-Өлгий	14	5	9	0	126,632
Булган	3	3	0	0	49,173
Дархан-Уул	16	4	12	0	56,830
Дорнод	57	57	0	0	3,211,381
Дорноговь	95	15	80	0	49,870
Дундговь	134	11	117	6	470,785
Говь-Алтай	43	5	33	5	759,360
Говь-Сүмбэр	0	0	0	0	0
Хэнтий	35	10	24	1	680,742
Ховд	10	7	3	0	257,499
Хөвсгөл	127	124	3	0	530,492
Өмнөговь	23	8	11	4	2,149,805
Орхон	1	1	0	0	3,544
Өвөрхангай	15	11	3	1	104,888
Сэлэнгэ	51	47	3	1	277,222
Сүхбаатар	56	28	27	1	2,461,656
Төв	145	131	2	12	1,413,616
Улаанбаатар	12	1	11	0	41,054
Увс	14	0	14	0	379,686
Завхан	20	2	18	0	137,145
Нийт	**937**	**492**	**399**	**46**	**16,531,505**

Мэдээллийн эх сурвалж: Монгол дахь ДБХС, Байгаль хамгаалал ба ГЗБГЗЗГ.

Хавсралт 3. Олон улсын хэмжээнд хамгаалагдсан газар нутгууд

Рамсарт орсон газар

Газрын нэр	Байгуулагдсан он	Албан ёсны талбай (га)	ГМТ-ны талбай (га)	Монголын хамгаалалтын статус	Хамгаалалтад хамрагдаагүй талбай (га)
Монгол дагуур (Монголын Дауриа)	1997	210,000	325,221	Хэсэгчлэн хамгаалагдсан (Монгол дагуурын дархан цаазат газар ба дөрвөн орон нутгийн ТХГ)	155,393
Өгий нуур	1998	2,510	3,859	Хэсэгчлэн хамгаалагдсан (Орон нутгийн ТХГ)	720
Тэрхийн цагаан нуур	1998	6,110	7,277	Бүрэн хамгаалагдсан (Хорго тэрхийн цагаан нуурын цогцолбор газар)	0
Нууруудын хотгор	1998	45,600	62,306	Хэсэгчлэн хамгаалагдсан (хоёр орон нутгийн ТХГ)	7,289
Айраг нуур	1999	45,000	45,799	Хэсэгчлэн хамгаалагдсан (Хяргас нуурын цогцолбор газар)	12,772
Хар ус нуурын цоголбор газар	1999	321,360	374,147	Хэсэгчлэн хамгаалагдсан (Хар ус нуурын цогцолбор газар)	26,851
Ачит нуур ба түүний ойр орчмын чийглэг газар	2004	73,730	100,133	Хэсэгчлэн хамгаалагдсан (Дэвэлийн арлын байгалийн нөөц газар)	91,955
Буйр нуур ба түүний ойр орчмын чийглэг газар	2004	104,000	106,305	Хэсэгчлэн хамгаалагдсан (орон нутгийн хоёр ТХГ)	16,767
Ганга нуур ба түүний ойр орчмын чийглэг газар	2004	3,280	31,595	Хэсэгчлэн хамгаалагдсан (Дариганга цогцолбор газар)	1,390
Хурх хүйтэн голын хөндийн нуурууд	2004	42,940	36,478	Хэсэгчлэн хамгаалагдсан (Орон нутгийн ТХГ)	33,929
Увс нуур ба түүний ойр орчмын чийглэг газар	2004	585,000	602,478	Хэсэгчлэн хамгаалагдсан (Увс нуурын дархан цаазат газар ба Тэсийн голын байгалийн нөөц газар)	108,004
Нийт		1,439,530	1,695,598		455,069

Мэдээллийн эх сурвалж: Рамсарын конвенцийн нарийн бичгийн дарга нарын газар; Рамсарт оруулах газрыг товлосон Монгол Улсын Шинжлэх ухааны академийн эрдэмдийн өгсөн полигоныг үндэслэн ГМТ-ны талбайг тооцов.

Монгол дахь дэлхийн өвд орсон газар нутгууд

Газрын нэр	Байгуулагд-сан он	Талбай (га)	Монголын хамгаалалтын статус	Хамгаалагдаа-гүй талбай (га)
Увс нуурын сав газар (байгалийн өв)	2003	810,234 (Орос дахь 258,619 га-г оролцуулахгүй)	Хэсэгчлэн хамгаалагдсан (Алтан элс, Цагаан шувуут, Түргэн ба Увс нуурын дархан цаазат газар, Тэсийн голын байгалийн нөөц газар)	16,191
Орхоны хөндий (соёлын өв)	2004	121,967	Хэсэгчлэн хамгаалагдсан (Хангайн нуруу ба отхоны хөндийн цогцолбор газар)	13,490
Нийт		932,201		29,681

Мэдээллийн эх сурвалж: UNESCO.

Монгол дахь Шим мандлын нөөц газрууд

Газрын нэр	Байгуулагд-сан он	Нийт талбай (га)	Гол талбай (га)	Монголын хамгаалалтын статус	Хамгаалаг-даагүй талбай (га)
Их Говь	1990	5,300,000	985,000	Бүрэн хамгаалагдсан (Их Говийн дархан цаазат газар)	0
Богд хаан уул	1996	67,300	41,651	Бүрэн хамгаалалттай (Богд хаан уулын дархан цаазат газар)	0
Увс нуурын сав газар	1997	771,700	366,080	Бүрэн хамгаалагдсан (Увс нуурын дархан цаазат газар)	0
Хустайн нуруу	2002	778,000	50,000	Бүрэн хамгаалагдсан (Хустайн нурууны цогцолбор газар)	0
Дорнод Монгол	2005	8,429,072	570,374	Бүрэн хамгаалалттай (Дорнод Монголын дархан цаазат газар)	0
Монгол дагуур	2007	732,000	51,400	Бүрэн хамгаалалттай (Монгол дагуурын дархан цаазат газар)	0
Нийт		16,078,072	2,064,505		0

Мэдээллийн эх сурвалж: UNESCO.

Хавсралт 4. Монгол дахь тахилага шүтлэгтэй газрууд

№	Газрын нэр	Төвшин	Аймаг	Монголын хамгаалалтын статус
1	Суврага хайрхан	Бүс нутгийн	Архангай	Бүрэн хамгаалагдсан (хангайн нурууны цогцолбор газар)
2	Цогт сүмбэр	Аймгийн	Архангай	Бүрэн хамгаалагдсан (Хангайн нурууны цогцолбор газар)
3	Их богд уул	Аймгийн	Баянхонгор	Бүрэн хамгаалагдсан (Их богд уулын цогцолбор газар ба Их халбагантын Орон нутгийн ТХГ)
4	Хонгорхайрхан	Аймгийн	Баянхонгор	
5	Хүрээманадал (Эдэнэмандал)	Аймгийн	Баянхонгор	
6	Хоёнхайрхан	Аймгийн	Баянхонгор	Бүрэн хамгаалагдсан (Хангайн бүс Орон нутгийн ТХГ)
7	Өлзийт уул	Аймгийн	Баянхонгор	
8	Алтай таван богд	Аймгийн	Баян-Өлгий	Бүрэн хамгаалагдсан (Алтай таван богдын цогцолбор газар)
9	Цамбагарав	Бүс нутгийн	Баян-Өлгийн, Ховд	Бүрэн хамгаалагдсан (Цамбагарав цогцолбор газар)
10	Булган уул	Аймгийн	Булган	
11	Хөгнөхаан	Бүс нутгийн	Булган, Төв	Бүрэн хамгаалагдсан (Хөгнө тарнын цогцолбор газар)
12	Дархан уул	Аймгийн	Дархан уул	
13	Найдаг уул (Халиар)	Аймгийн	Дархан уул	
14	Ноён хонгор	Аймгийн	Дархан уул	
15	Их бурхант	Бүс нутгийн	Дорнод	
16	Баянбогд	Аймгийн	Дорноговь	Бүрэн хамгаалагдсан (Баянбогдын орон нутгийн ТХГ)
17	Шарилын овоо	Аймгийн	Дорноговь	
18	Бага газрын чулуу	Аямгийн	Дундговь	Бүрэн хамгаалалттай (Бага газрын чулуу орон нутгийн ТХГ)
19	Гурвансайхан уул	Аймгийн	Дундговь	Бүрэн хамгаалалттай (Тэвш, Баруун, Дунд, Зуун сайхан уулын орон нутгийн)
20	Их газрын чулуу	Аймгийн	Дундговь	Бүрэн хамгаалагдсан (Их газрын чулуу орон нутгийн ТХГ)
21	Их хонгор	Аймгийн	Говь-Сүмбэр	

№	Газрын нэр	Төвшин	Аймаг	Монголын хамгаалалтын статус
22	Оцол сансар-чойрын	Бүс нутгийн	Говь-Сүмбэр	
23	Ээж хайрхан	Аймгийн	Говь-Алтай	Бүрэн хамгаалагдсан (Ээж хайрханы байгалийн дурсгал газар)
24	Бэрээвэн хийд	Бүс нутгийн	Хэнтий	
25	Бурханхалдуун	Улсын	Хэнтий	Бүрэн хамгаалагдсан (Хан хэнтийн дархан цаазат газар)
26	Өндөрхаан	Аймгийн	Хэнтий	Бүрэн хамгаалагдсан (Өндөрхааны орон нутгийн ТХГ)
27	Даяан дээрхийн агуу	Аймгийн	Хөсгөл	Бүрэн хамгаалагдсан (Даяан дээрхийн хүрээний сууриин орон нутгийн ТХГ)
28	Нуурын хүйс2хөвсгөл	Аймгийн	Хөвсгөл	Бүрэн хамгаалагдсан (Хөвсгөл нуурын цогцолбор газар)
29	Өлийн овоо	Аймгийн	Хөвсгөл	
30	Рэнчинлхүмбэ уул	Аймгийн	Хөвсгөл	
31	Гурвансайхан	Аймгийн	Өмнөговь	Бүрэн хамгаалагдсан (говь гурван сайхны цогцолбор газар)
32	Баян өндөр	Аймгийн	Орхон	
33	Батхаан	Бүс нутгийн	Өвөрхангай, Төв	Бүрэн хамгаалагдсан (Батхаан цогцолбор газар)
34	Их бага хангайн овоо	Бүс нутгийн	Өвөрхангай	Бүрэн хамгааладгсан (Отхоны хөндийн цогцолбор газар ба Хархорины орон нутгийн ТХГ)
35	Амарбаясгалант	Аймгийн	Сэлэнгэ	
36	Төвхөн хаан	Аймгийн	Сэлэнгэ	Бүрэн хамгаалагдсан (Төвхөн хааны орон нутгийн ТХГ)
37	Алтан овоо	Бүс нутгийн	Сүхбаатар	Бүрэн хамгаалагдсан (Дарьгангын цогцолбор газар)
38	Дархан хаан	Бүс нутгийн	Сүхбаатар	
39	Мөнххаан	Аймгийн	Сүхбаатар	
40	Ламтны овоо	Аймгийн	Төв	Бүрэн хамгаалагдсан (Богд хаан уулын дархан цаазат газар)
41	Богд хаан уул	Улсын	Улаанбаатар	Бүрэн хамгаалагдсан (Богд хаан уулын дархан цаазат газар)
42	Хан хөхий	Аймгийн	Увс	
43	Цагаан эргийн овоо	Аймгийн	Увс	
44	Улаан уул (Улаангом)	Аймгийн	Увс	
45	Алтан элс	Аймгийн	Завхан	
46	Баясгалант	Аймгийн	Завхан	
47	Отгонтэнгэр	Улсын	Завхан	Бүрэн хамгаалагдсан (Отгонтэнгэрийн дархан цаазат газар)

Мэдээллийн эх сурвалж: Шашин ба байгаль хамгааллын эвсэл.

Хавсралт 5. Монгол дахь шувуудад чухал газрууд

№	Газрын нэр	Аймаг	ШЧГ-ын шалгуурт таарах					Нийт талбай (га)	Хамгаалалтгүй талбай (га)
			A1	A2	A3	A4i	A4iii		
1	Хотон-хоргон нуур	Баян-Өлгий	X	X	X	X		19,629	0
2	Цэнгэл хайрхан уул	Баян-Өлгий	X	X	X			52,726	52,726
3	Даяан нуур	Баян-Өлгий	X	X	X	X		13,537	0
4	Булган гол	Ховд	X					32,700	29,197
5	Хөх сэрхийн нуруу ТХГ	Баян-Өлгийн, Ховд	X	X	X			74,502	8,365
6	Толбо нуур	Баян-Өлгий	X		X	X		16,334	9,342
7	Ачир нуур	Баян-Өлгийн, Увс	X		X	X		98,278	88,272
8	Үүрэг нуур	Увс	X		X	X		28,308	28,308
9	Увс нуур	Увс	X		X	X	X	502,462	49,319
10	Бага ба Баян нуур	Увс			X	X		5,317	749
11	Увсын хар ус нуур	Увс	X			X		13,601	13,601
12	Айраг нуур	Uvs	X		X	X	X	73,348	13,653
13	Хонгил	Ховд	X					6,027	4,939
14	Хар ус нуур	Ховд	X		X	X	X	297,265	38,272
15	Жаргалант хайрхан уул	Ховд	X	X	X			162,264	18,019
16	Шар нуур	Завхан, Ховд	X			X		83,798	3,701
17	Хөөмийн тал	Завхан, Ховд	X		X	X		78,059	73,644
18	Сантмаргацын баян нуур	Завхан	X			X		14,205	14,205
19	Улаагчин хар нуур	Завхан	X					13,439	13,439
20	Ойгон нуур	Завхан	X			X		20,189	20,189
21	Тэлмэн нуур	Завхан	X		X	X		24,175	24,175
22	Отгонтэнгэр уул	Завхан	X	X	X	X		88,753	4,733

№	Газрын нэр	Аймаг	ШЧГ-ын шалгуурт таарах					Нийт талбай (га)	Хамгаалалт-гүй талбай (га)
			A1	A2	A3	A4i	A4iii		
23	Завхан гол-Эрээн нуур	Говь-алтай	X			X		65,735	63,205
24	Хасагт хайрхан уул	Говь-Алтай	X		X			28,309	3,597
25	Тайгам нуур	Говь-Алтай	X			X		4,170	3,243
26	Бөөн цагаан нуур	Баянхонгор	X		X	X		43,262	3,588
27	Их богд уул	Баянхонгор	X		X			86,440	0
28	Орог нуур	Баянхонгор	X		X	X		20,195	0
29	Таацын цагаан нуур	Өвөрхангай	X		X	X		12,385	12,385
30	Хангайн нурууны цогцолбор газар	Архангай, Баянхонгор, Өвөрхангай	X		X			897,840	33,034
31	Тэрхийн цагаан нуур	Архангай	X			X		21,072	2,676
32	Хөвсгөлийн сангийн далай	Хөвсгөл, Завхан	X			X		25,194	25,175
33	Эрхэл нуур	Хөвсгөл	X		X	X		3,537	1,055
34	Дархадын хотгор	Хөвсгөл	X		X	X		195,223	187,117
35	Хөвсгөл нуур	Хөвсгөл	X			X		380,212	33
36	Булган тал	Хөвсгөл	X					40,445	40,420
37	Тэшигийн олон нуур	Булган	X			X		5,774	5,774
38	Айрхан нуур	Хөвсгөл, Булган	X			X		7,212	7,212
39	Тариалан	Хөвсгөл	X			X		31,630	31,630
40	Сэлэнгэ-Тээл	Булган	X		X			18,568	18,568
41	Шарга нуур	Булган	X			X		2,118	2,118
42	Өгий нуур	Архангай	X			X	X	10,189	6,998
43	Дашинчилэн баян нуур	Булган	X			X		1,598	1,598
44	Эрдэнэсант уул	Төв	X		X	X		34,776	34,323
45	Өлзийтийн сангийн далай нуур	Өвөрхангай	X		X	X		1,491	1,491
46	Говь гурван-сайхан уул	Өмнөговь	X	X	X			544,794	25,583
47	Борзон говь	Өмнөговь	X		X			399,467	45,483
48	Галбын говь	Өмнөговь	X		X			828,328	530,865
49	Их газрын чулуу	Дундговь	X					9,300	2,142

№	Газрын нэр	Аймаг	ШЧГ-ын шалгуурт таарах					Нийт талбай (га)	Хамгаалалт-гүй талбай (га)
			A1	A2	A3	A4i	A4iii		
50	Их нартын чулууны байгалийн нөөц газар	Дундговь	X		X			66,601	7,606
51	Ээж хад	Төв	X					36,867	36,828
52	Хустайн нурууны цогцолбор газар	Төв	X		X			49,932	690
53	Сэлэнгийн цагаан нуур	Сэлэнгэ	X			X		17,143	16,970
54	Орхон, Сэлэнгэ голын ундрага	Сэлэнгэ	X			X		21,405	19,203
55	Хан хэнтийн ТХГ	Төв, Хэнтий, Сэлэнгэ	X		X			1,234,755	8,059
56	Горхи-тэрэлжийн цогцолбор газар	Төв	X		X			293,937	1,762
57	Майхант уул	Хэнтий, Дорноговь	X					42,015	35,530
58	Хурх-хүйтэн голын хөндий	Хэнтий	X			X		35,722	31,302
59	Онон-балж	Хэнтий, Дорнод	X		X	X		104,841	25,797
60	Хар ямаатын байгалийн нөөц газар	Хэнтий, Сүхбаатар	X					51,404	3,792
61	Ганга нуур	Сүхбаатар	X		X	X		26,841	753
62	Шаазан нуур	Дорнод	X			X		5,485	164
63	Цэнгэлэг нуур	Дорнод	X		X	X		8,877	768
64	Түргэн цагаан зэгст, туулайтын бур	Дорнод	X					35,282	24,860
65	Угтамын байгалийн нөөц газар	Дорнод	X			X		46,162	6,111
66	Монгол дагуур	Дорнод	X		X	X		309,440	176,614
67	Хөх нуур	Дорнод	X		X	X	X	11,548	0
68	Буйр нуур	Дорнод	X		X	X		90,476	12,214
69	Ташгайн таван нуур	Дорнод	X		X	X		53,304	53,304
70	Нотгон	Дорнод	X		X			378,097	49,376
	Нийт							8,358,313	2,109,867

Мэлээлийн эх сурвалж: зэрлэг амьтан судлан хамгаалах төв.

Хавсралт 6: Байгаль хамгаалллын зохицуулалтын цар хүрээ

Ус бохирдуулж хөрс сүйтгэхийг бусад зүйлийн хамтаар хориглосон Чингис Хааны тэртээ арван гуравдугаар зуунд гаргасан Их Засаг хуулиас эхлэлтэй байгаль орчин хамгаалах өнө удаан жилийн түүх Монголд буй (Хамаганова 2001 онд биснэгийг Farrington-д 2005 онд хэвлэжээ).

1990 онд засаглалын ардчилсан тогтолцоонд шилжсэнээс хойш Монгол Улсын Үндсэн хууль (1992 он), Байгаль хамгаалах тухай хууль (1995 он), Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний тухай хууль (1998 он), Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль (1994 он), Буфер бүсийн тухай хууль (1997 он), Газрын тухай хууль (2002 он) болон Ойн тухай хууль (2007 он) зэрэг байгаль хамгаалалтай холбоотой хэд хэдэн гол хуулиуд батлан мөрдөж эхэлсэн билээ. Гэвч эдгээр хуулиудад орхигдуулсан зүйл болон хэд хэдэн хязгаарлалт байгаа бөлгөө.

Монгол Улсын Үндсэн хууль

1992 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр батлагдсан Үндсэн хуулиар Монгол Улсын иргэдийн үндсэн эрхийг баталгаажуулсан билээ. Үүнд: “эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй” (16.1.2 зүйл) гэж заажээ. Үндсэн хууль иргэддээ “байгаль орчноо хамгаалах” (17.2 зүйл) жухамт үүрэг ногдуулж засгийн газарт “байгаль орчин хамгаалах, байгалийн нөөцийн зохистой ашиглалт нөхөн сэргээх арга хэмжээ” (38.2.4 зүйл) эрх олгосон байна. Бүр тодорхойлбор Үндсэн хууль төрд “төр газрын эзэнд газартай нь холбогдсон үүрэг хүлээлгэх, улсын утгас хэрэгцээг үндэслэн нөхөн олговортойгоор газрыг солих буюу эргүүлэн авах, уг газрыг хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд ашглавал хураан авч болно” (6. 4 зүйл) гэсэн эрхийг олгожээ.

Байгаль орчныг хамгаалах тухай Монгол Улсын хууль

Байгаль орчныг хамгаалах тухай Монгол Улсын хуулийн зорилт (1995 оны 3 сарын 3ены өдөр батлагдсан) “хүний эрүүл, аюулгүй орчинд амьдрах рэхийг хангах, нийгэм, эдийн засгийн хөгжлийг байгаль орчны тэнцэлтэй уялдуулах, өнөө болон ирээдүйн үеийхний ашиг сонирхолын үүднээс байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, жам ёсны боломжтойг нь нөхөн сэргээхтэй холбогдож төр, иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хооронд үүсэх харилцааг зохицуулахад оршино” гэж заажээ (зүйл 1).

Зүйл 4-т байгаль орчин хамгаалахтай холбоотой иргэдэд ногдуулж буй үүргийн дурдахын зэрэгцээ “гэм буруутай этгээд байгаль орчинд хортой нөлөөлснөөс эрүүл мэнд, эд хөрөнгөндөө учирсан хохирлыг түүгээр нөхөн төлүүлэхээр нэхэмжлэх” (4.1.1) ба “байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн зөрчилтэй болон байгаль орчинд хортой нөлөөлсөн этгээдэд хариуцлага хүлээлгэхийг шаардах ” (4.1.2) зэрэг үндсэн эрхийг үүнтэй холбогдуулж олгожээ.

Зүйл 6-д байгалийн баялаг эзэмших талаар дурдсан байна. Уг зүйлийн дагуу “газар, түүний хэвлийн, ой, ус, амьтан, ургамал, болон байгалийн бусад баялаг ...төрийн хамгаалтад байх бөгөөд Монгол Улсын

иргэдэд өмчлүүлснээс бусад газар төрийн өмч мөн ” (6.1) гэсэн ба “хуульд өөрөөр заагаагүй бол Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, гадаадын байгууллага, хуулийн этгээд байгалийн баялгийг зохих төлбөр, хураамжийг төлж, гэрээ, тусгай зөвшөөрөл буюу эрхийн бичгийн дагуу ашиглаж болно” (6.2).

Зүйл 14-т “иргэн, аж ахуйн нэгж байгууллагын хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд хортой нөлөөлөл бүхий үйлдвэрлэлийн болон бусад үйл ажиллагаа явуулахыг өмчлөлийн хэлбэрийг үл харгалзан хориглох” (14.3.1) зэрэг байшаль орчны хамгаалалтай холбогдуулж засгийн газарт хэд хэдэн эрх мэдэл олгосон бөлгөө.

Зүйл 16-д аймгийн (буюу нийслэлийн) Иргэдийн хурлын төлөөлөлгчдөд орон нутгийн ТХГ байгуулах эрх мэдэл өгсөн. Тухайлбал, тэдгээрт “байгаль орчны улсын тусгай хамгаалалтад ороогүй обьектын орон нутгийн хамгаалалтад авах шийдвэр гаргаж, түүний хилийн зааг, хамгаалалтын дэглэм тогтоож, биелэлтэд нь хяналт тавих ” эрх олгодсон юм.

Зүйл 25-д “байгалийн баялаг ашигласан газар, орчныг сайжруулах, тохижуулах” зорилгоор арилжааны зорилгоор байгалийн баялаг ашиглах иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын ерөнхий үүрэг хариуцлагын тодорхойлсон (уул уурхай болон аялал жуулчлалыг хамран).

Зүйл 26 ба 27-д Улсын байгаль орчны байцаагчдыг томилох болон тэдгээрийн эрх, үүргийг тодорхойлжээ. Тухайлбал, Улсын байгаль орчны байцаагчид “хууль тогтоомж, стандарт, зөвшөөрөгдөх дээд хэмжээг зөрчиж байгаль орчинд хортой нөлөөлөл үзүлсэн иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад уг зөрчлийг арилгахыг шаардах, тодорхой хугацаагаар үйл ажиллагааг нь түдгэлзүүлэн зогсоох ” (27.1.3) ба “байгаль орчныг хамгаалах хууль зөрчсөн этгээдэд хуульд заасан захиргааны шийтгэл ногдуулах” (27.1.7) эрхтэй.

Зүйл 31-д байгаль орчин, байгалийн баялаг хамгаалахтай холбогдуулж хувийн аж ахуйн нэгжийн (ах ахуйн нэгж ба байгууллага) үүрэг хариуцлагыг тусгасан байна. Эдгээрт “байгаль орчинд сөрөг нөлөө бүхий үйлдвэрлэл” явуулдаг аж ахуйн нэгжид үйл ажиллагааныхаа сөрөг нөлөөллийг бууруулах, байгалийн баялаг хамгаалж нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг жил бүрийн төсөвт тусгахыг заажээ (31.1.4). Эдгээр үүрэг хариуцлагын талаар уул уурхайн аж ахуйн нэгжтэй холбож 2006 оны Ашигт малтмалын тухай хуульд заасан юм.

Зүйл 34-т “байгаль орчныг хамгаалах, түүний баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх, байгаль орчинд үзүүлэх хортой аюултай нөлөөллийг багасгах дэвшилтэт арга , хоргүй, аюулгүй, бохирдолгүй, хаягдалгүй технологи нэвтрүүлсэн” аж ахуйн нэгжийг урамшуулах эдийн засгийн хөшүүргийн талаар дурджээ (34.1.1). 34 дүгээр зүйлийн агуулгыг улмаар 35 дугаар агуулгатай уялдуулж байгалийн баялаг ашигласан болон хаягдал, бохирдлын хэмжээ гэрээ, тусгай зөвшөөрөлд тусгагдсан хэмжээнээс давсан нөхцөлд байгалийн баялаг ашигласны төлбөр, хураамж ногдуулахаар тусгажээ. Түүнчлэн зүйл 37 ба зүйл 38-д хууль бус үйл ажиллагааны улмаас байгаль орчин, байгалийн баялагт шууд хор хөнөөл учруулах аж ахуйн нэгж болон иргэдэд төлбөл зохих нөхөн төлбөр болон торгууль ногдуулах талаар заажээ.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хууль

1995 онд баталсан Байгаль орчин хамгаалах тухай хуулийн 7 дугаар зүйлд Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний (БОНБҮ) тухай дурдсан юм. Энэхүү зүйлийн утга агуулга улмаар “байгаль орчныг хамгаалах, экологийн тэнцэл алдагдахаас сэргийлэх, байгалийн баялгийн ашиглалтыг зохицуулах, төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлыг үнэлэх, төслийг хэрэгжүүлэх эсэх талаар шийдвэр гаргахтай холбогдсог харилцааг зохицуулахад орших” (Зүйл 1) зорилго бүхий Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хуулиар (1998 оны 1 сарын 22-д батлагдсан) баяжсан бөлгөө.

Зүйл 4-т уул уурхайн салбарыг онцлон үзэж шинэ төслийн ерөнхий үнэлгээг хийх үйл

явцын талаар заажээ. Уг зүйлийн дагуу “төсөл хэрэгжүүлэгч төслийн тодорхойлт ...бусад холбогдох баримт бичгийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл нутгийн захиргааны байгууллагад хүргүүлж байгаль орчинд нөлөөлөх байдлын ерөнхий үнэлгээ хийлгэнэ” (Зүйл 4.4). уг байгууллага улмаар “төслийн нарийвчилсан байгаль орчинд нөлөөлөх үнэлгээ ” хийлгэх шаардлагтай эсэхийг тогтооно (Зүйл 4.6).

Ерөнхий үнэлгээгээр БОНБ нарийвчилсан үнэлгээний ажлын цар хүрээг зүйл 5-д заасан агуулгын дагуу шаардлагтай бол тогтооно. Тухайлбал, БОНБҮ-д тус үнэлгээний зөвлөмжийг хэрэгжүүлэх Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө болон хэрэгжилт ба гүйцэтгэлийн мониторинг хийх Байгаль орчны мониторингийн төлөвлөгөөг оруулах учиртай (Зүйл 6.). Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд “байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, түүнийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байна” (Зүйл 6.1.1).

Зүйл 6-аад сумын байгаль орчин хамгаалах дансанд байгаль орчин хамгаалах арга хэмжээний зардлын 50-иас доошгүй хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг байршуулах батлагаааны тухай дурджээ. Гэвч уг зүйлийн энэхүү шаардлагыг уул уурхайн аж ахуйн нэгжүүдэд хамхагдахгүй ба “ашигт малтмалтай холбогдсон төслийн байгаль орчныг хамгаалах арга хэмжээний зардлын батлагааг ашигт малтмалын тухай хууль тогтоомжоор зохицуулна” гэж заажээ (Зүйл 6.3). Энэ тохиолдолд уул уурхайн аж ахуйн нэгжүүдийн батлагаат хөрөнгийн талаар 2006 онд батлагдсан Ашигт малтмалын тухай хуулийн 38, 39 дүгээр зүйлүүдээр зохицуулсан болно.

Зүйл 12,13-т БОНБҮ тухай хууль тогтоомжийг зөрчсөн нөхцөлд нөхцөлд ногдуулах эрүүгийн болон захиргааны шийтгэл, санхүүгийн нөхөн төлбөрийн талаар дурджээ. Тухайлбал, “байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгээр тавигдсан шаардлагыг биелүүлээгүй бол зөрчлийн арилгах хүртэл үйл ажиллагааг нь түдгэлзүүлэн зогсоох ” гэсэн байна (Зүйл 12.2.2).

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тайланд тусгагдсан “төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн иргэд, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчдийн санал ”-ын шаардлагаас гадна БОНБҮ-ий үйл явцад олон нийттэй зөвшилцөх тухай тодорхой заалт ороогүй байна. БОНБҮ-ий тайланг боловсруулж батласны дараа л уг тайланг олон нийтэд танилцуулдаг байна. Зүйл 7.5-ын дагуу “олон нийтэд танилцуулах” үүрэг бүхий байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад (БОЯ) БОНБҮ-д тайлангийн нэг хувийг хүргүүлэх тухай зүйл 5-д заажээ.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай Монгол Улсын хууль

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн зорилт нь “байгалийн бүс, бүслүүрийн онцлог, өвөрмөц тогтоц, ховор, ховордсон ургамал, амьтан бүхий газар, түүх, соёлын дурсгалт болон үзэсгэлэнт газрын хэв шинжийг хадгалах, хувьсч өөрчлөгдөх зүй тогтлыг судлах, танин мэдэх зорилгоор газар нутгийг тусгай хамгаалалтад авах ”-д оршино (Зүйл 1).

Зүйл 3-т дараах дөрвөн ангилалаас бүрдэх Улсын ТХГ байгуулах тухай дурджээ. Үүнд: (i) Дархан цаазат газар, (ii) Байгалийн цогцолборт газар, (iii) байгалийн нөөц газар ба (iv) дурсгалт газар орно (Зүйл 3). Уг зүйлд Орон нутгийн ТХГ-ыг аймгийн (эсхүл нийслэл хотын), сумын (эсхүл дүүргийн) төвшинд байгуулах талаар заажээ.

Зүйл 7-12-т дархан цаазат газрын менежментийн дүрэм журмыг нарийвчлан заажээ. Дархан цаазат газар онгон бүс, хамгаалалтын бүс болон хязгаарлалтын бүст хуваагдана (Зүйл 8). Зүй зохистой тусгай зөвшөөрөлтэй, мөн “байгаль орчинд эерэг технологи” ашигласан нөхцөлд хязгаалалтын бүст байгалийн аялал, жуулчлалыг зохион байгуулжхүнтүрбуудаллах,отоглохзорилгоор орон байр барихыг зөвшөөрчээ (Зүйл 11). **Зүйл 12-т Дархан цаазат газрын бүхий л бүст уул уурхайн хайгуул, олборлолт**

хийхийг хориглосон. Хориглосон үйл ажиллагаанд “газар хагалах, ухах, тэсэлгээ хийх, ашигт малтмал хайх, олборлох, элс, хайрга, чулуу авах...”, мөн “хөрс, ус, агаар бохирдуулах аливаа үйл ажиллагаа”явуулах, “нуур, мөрөн, гол, горхи, булаг, шанд зэргийг үйлдвэрлэлийн зориулалтаар ” ашиглах зэрэг оржээ (12.1).

Зүйл 13-18-д Байгалийн цогцолборт газруудын менежментийн зохицуулалтыг нарийвчлан тусгажээ. Байгалийн цогцолборт газар онцгой бүс, аялал жуулчлалын бүс болон хязгаарлалтын бүст хуваагдана (Зүйл 14). Байгалийн цогцолборт газрын менежментийн зохицуулалт аялал жуулчлалын үйл ажиллагаа зөвшөөрөх аваас дархан цаазат газрынхтай адилхан (аялал жуулчлалын болон хязгаарлалтын бүст; Зүйл 16,17) ба **Зүйл 18-д Байгалийн цогцолборт газрын бүхий л бүст уул уурхайн хайгуул, олборлолтыг хорилложээ.**

Зүйл 19-21-д Байгалийн нөөц газрын менежментийн зохицуулалтын талаар дурджээ. Байгалийн нөөц газрын дөрвөн ангилал байдаг ба үүнд: байгалийн иж бүрдлийн нөөц газар (байгалийн унаган төрх, хэв шинжийг хадгалах зорилго бүхий); биологийн нөөц газар (ховор, ховордсон ургамал, амьтныг хамгаалах зорилго бүхий); байгалийн түүхэн олдворын нөөц газар (эртний амьтан, ургамлын ховор олдворыг байгалийн байдлаар нь хадгалах зорилго бүхий) болон геологийн нөөц газар (газрын өвөрмөц тогтоц, илэрц, тэдгээрийн бүтцийн байгалийн байдлаар нь хадгалах зорилго бүхий) орно (Зүйл 20). Тухайлбал, энэхүү зүйлд “байгалийн нөөц газарт түүний байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй барилга байгууламжбарих, үйлдвэрлэлийн зориулалтаар газар ухах, тэсэлгээ хийх, ашигт малтмал хайх, олборлох зэрэг байгалийн унаган төрхийг өөрчлөх аливаа арилжааны үйл ажиллагаа явуулах”-ыг хорилложээ (21.2). Харин энэхүү зүйлд байгаль орчинд сөргөөр нөлөөлөхгүй бол байгалийн нөөц газар аялал жуулчлалын үйл ажиллагаа явуулахыг хориглоогүй болно.

Зүйл 22-24-т дараах дөрвөн ангилалд хуваагдах дурсгалт газруудын менежментийн зохицуулалтын тухай дурджээ. Үүнд: байгалийн дурсгалт газар ба түүх, соёлын дурсгалт газар орно (Зүйл 23). **Зүйл 24-ийн дагуу дурсгалт газар, ба түүний ойр орчимд уул уурхайн хайгуул, олборлолт хийхийг хориглосон байна.** Тухайлбал, “дурсгалт газар дахь байгалийн болон түүх, соёлын дурсгалт зүйлийн сүр бараа, үзэмжийг нь дарах барилга байгууламж барих, газар хагалах, ухах, тэсэлгээ хийх, ашигт малтмал хайх, олборлох, байгалийн болон түүх, соёлын дурсгалт зүйлийг хөндөх, эвдэх, буулгах, тэдгээрт хохирол учруулахуйц бусад үйл ажиллагаа явуулах”-ыг хорилложээ (24.2). Зүйл 24-тэй харшлаагүй нөхцөлд Дурсгалт газруудад хариуцлагатай аялал жуулчлал явуулахыг зөвшөөрсөн шиг байна.

Зүйл 6-аад хамгаалалттай газруудын санхүүжилтийн эх үүсвэрийн талаар заажээ. Улсын болон орон нутгийн төсвөөс гадна үүнд “иргэд, аж ахуйн нэжг, байгууллагын хандив, тусламж” болон “Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай Монгол Улсын хууль болон түүнтэй холбоотой дүрэм журам зөрчсөн этгээдийн төлсөн нөхөн төлбөр” зэрэг орно. Уул уурхайн болон аялал жуулчлалын аж ахуйн нэгжүүд уг заалтын дагуу сайн дурын үндсэн дээр эсхүл хууль зөрчсөн нөхцөлд хамгаалалттай газрын санхүүжилтэнд хувь хандив оруулах болно. Гэхдээ эдгээр салбараас хамгаалалттай газар нутагт аливаа гарах нөлөөллийн нөхөн төлбөр болгож хийх төлбөрийн замаар орлого оруулах ерөнхий механизмыг л дурдсан байна.

Бүс Улсын ТХГН байгуулах, Дархан цаазат газар болон Байгалийн цогцолборт газрын хил хязгаарыг өөрчлөхийг Монголын Парламент (Их Хурал) шийдвэрлэнэ (Зүйл 25). Харин Засгийн газар Байгалийн нөөц газар болон дурсгалт газруудын хил хязгаарын асуудлыг шийдвэрлэх эрхтэй (Зүйл 26). Эдгээр зүйлийн үр дүнд БОЯ хамгаалалттай газар нутаг байгуулах, хамгаалалттай газар нутгаас гаргах болон хил хязгаарыг нь өөрчлөх эрх мэдэлгүй болжээ. Уул уурхайн хайгуул, олборлолтын хөрөнгө оруулалтыг хөхиүлэн дэмжих зорилгоор 2002 онд 10 хамгаалалттай газар нутгийн 434 мянган га газар бүхий талбайн хамгаалалттай статусыг өөрчлөх

санал БОЯ-аас орсон саналыг Парламент хүлээж аваагүй байдлаар дээрх зүйлийн ач холбогдол харагджээ (Дэлхийн банк).

Зүйл 28-ын дагуу Орон нутгийн ТХГН-ыг байгуулах, тэдгээрийн хил хязгаар болон менежментийн зохицуулалтыг холбогдох төвшний Иргэдийн Хурлын төлөөлөгчид шийдвэрлэнэ (аймаг/ нийслэл хот, эсхүл сум/ дүүргийн төвшинд). Уг зүйлийн дагуу Орон нутгийн ТХГН-ад үйлчилдэг менежментийн стандарт дүрэм, журам үгүй ба иймээс **Орон нутгийн ТХГН-д аялал жуулчлалын үйл ажиллагааг зөвшөөрөх эсэхийг холбогдох ИТХ тухайн нөхцөл байдал бүрт шийдвэрлэнэ.** Уг хуулийн өөр нэг дутагдалтай тал бол Орон нутгийн ТХГН байгуулах шалгуурыг тодорхойлоогүй явдал юм (зүйл 7,13, 19 болон 22-т шалгуур нь тусгагдсан Улсын ТХГН-аас өөр). Иймээс Орон нутгийн ТХГН-ыг байгуулахад биологийн аливаа шалгуур баримтлыг уг хуулиар шаарддаггүй болно.

Зүйл 33-38-д хамгаалалтай газрын газар ашиглалтын асуудлыг зохицуулсан байна. Зүйл 33-ын 2-т тусгай хамгаалалттай газар нутагт гадаад улсын хуулийн этгээд, иргэн болон Монголын аж ахуйн нэгжүүдэд газар ашиглуулахыг хорихожээ. Гэвч энэхүү заалт дараахь 3 дугаар заалттай зөрчилдөж “энэхүү зүйлийн хоёр дахь хэсгийн заалт нь гадаад улсын болон олон улсын байгууллага тусгай хамгаалалттай газрын зохих бүсэд энэ хуулиар зөвшөөрөгдсөн хүрээнд төслийн дагуу үйл ажиллагаа явуулахад хамаарахгүй” гэжээ. Энэ нь ТХГН-т явагддаг аялал жуулчлалын үйл ажиллагаанд хэрхэн нөлөөлөх нь тодорхоогүй байна. Зүйл 33-ын тайлбарлах нэг тайлбар бол гадаадын аж ахуйн нэгж, иргэд эсхүл хөрөнгө оруулалттай хамааралтай арилжааны үйл ажиллагааг ТХГН-т хориглосон ч уг хориг гадаадын эсхүл олон улсын байгууллагын санхүүжилт бүхий байгаль орчин хамгаалах төслүүдэд хамаарахгүй уг хуулийн зорилтот нийцэж байгаа явдал юм.

Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн нэг цоорхой бол хэдийгээр хайгуул, олборлолтын үйл ажиллагааг хамгаалалттай газар нутагт хатуу хориглосон ч хамгаалалтанд орох санал бүхий талбайд хайгуул, олборлолтын тусгай зөвшөөрөл олгохыг хориглосон хориг алга байна (Фарингтон 2005 он). Энэ нь байгуулагдсан ТХГН болон засгийн газраас хамгаалалтанд авахаар албан ёсоор гаргасан санал бүхий газруудын орчныг үлэмж ихээр өөрчлөр эсхүл сүйрүүлэх нөлөөлөл бүхий төслүүдийг дэмждэггүй Дэлхийн банкны амьдрах орчны талаарх OP/BP 4.04-тэй зөрчилдөж байна. Хайгуулын тусгай зөвшөөрлийн хураамжийн хэмжээ хэтэрхий бага (эхний жилд нэг га-д зөвхөн 0.1 ам. доллар, ес дэх жилдээ 1.50 ам. доллар болох) тул уул уурхайн аж ахуйн нэгж болон дамлагчдад хэдхэн мянган долларын хураамжаар хайгуулын тусгай зөвшөөрлийг хуулийн дагуу авах боломжтой (Фарингтон 2001b).

Хэдийгээр уг асуудлаар 2004 оны Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль өнөөгийн байдлаар мөрдөх гол хууль ч БОЯ-аас уг хууль оруулах нэмэлт өөрчлөлтийг боловсруулж хэлэлцүүлгэд бэлтгэсэн болно. 2007 онд Дэлхийн банкны санхүүжилтээр IUCN-ны Бүс нутгийн байгаль орчны хуулийн хөтөлбөрөөс 2006 онд БОЯ-аас санал болгосон хууль нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй танилцаж саналаа өгсөн билээ. Уг саналтай танилцсаны дараа БОЯ-аас уг хуульд нэмэлт өөрчлөлт оруулах шинэ үзэл баримтлал боловсруулсан байна.

Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай Монгол Улсын хууль

Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүс байгуулах тухай анх 1994 оны Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан юм. Уг зүйл улмаар өргөжин 1997 оны 10 дугаар сарын 23-ны өдөр батлагдсан Тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн тухай хууль болсон ба үүнийг зорилт “тусгай хамгаалалттай газар нутагт орчны бүсийн тогтоон, орчны бүсэд үйл ажиллагаа явуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино” (Зүйл 1).

Зүйл 3-т тусгай хамгаалалтай газар нутгийн орчны бүсийг “үзүүлж байгаа болон үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийг багасгах,

арилгах, урьдчилан сэргийлэх”зорилгоор байгуулна гэж заажээ (3.1). Дархан цаазат газар болон байгалийн нөөц газар, дурсгалт газруудын хувьд орчны бүс нь хамгаалалттай газар нутгийн гадны байдаг ба Байгалийн цогцолборт газар нутгийн хувьд хязгаарлагдмал газартай давхардаж болзошгүй.

Зүйл 6-аад “орчны бүсийн хөгжлийг зохицуулах, байгалийн баялгийг зүй зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээхэд нутгийн иргэдийн оролцоог өргөжүүлэх ” зорилгоор орон тооны бус сайн дурын “Орчны бүсийн зөвлөл” байгуулах тухай заажээ (6.1). Орчны бүсийн зөвлөл нь “орчны бүсэд газар, байгалийн бусад байялаг ашиглахтай холбогдсон асуудлаар санал, зөвлөмж, төсөл, орчны бүсийн менежментийн төлөвлөгөө боловсруулах ” эрхтэй (6.4.2).

Зүйл 7-оод “байгаль орчныг нөхөн сэргээх, орчны доройтлыг бууруулах” (7.4.1), “нутгийн иргэдийн ахуй амьдралыг дэмжих, жижиг үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд тусламж, дэмжлэг үзүүлэх, төсөл хэрэгжүүлэх” (7.4.2) болон “байгаль орчныг хамгаалах сургалт, сурталчилгаа явуулах, орчны бүсэд судалгаа хийх” (7.4.4) зэрэг төрөл бүрийн зорилгоор ашиглах “Орчны бүсийн санг” байгуулах тухай заасан. Эдгээр санд “гадаадын болон дотоодын байгууллага, аж ахуйн нэгж, иргэдийн хандив” ба нутгийн ИТХ-ын тогтоох тодорхой хэмжээ бүхий “орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэх төсөл, ажил, үйлчилгээний орлогын тодорхой хэсэг” зэрэг төрөл бүрийн эх үүсвэрээс санд хөрөнгө хуримтлуулна. Иймээс энэ зүйлд тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүст үйл ажиллагаа явуулж буй уул уурхай, аялал жуулчлалын төслөөс орох орлогоос санд төвлөрүүлэх тухай заажээ.

Эцэст нь, Зүйл 9-д хамгаалалттай газар нутгийн орчны бүст хайгуул, олборлолтын үйл ажиллагаа явуулж буй бүх аж ахуйн нэгжид тухайн тусгай хамгаалалтай газар нутгийн захиргааны санал, дүгнэлтийг тусгасан байгаль орчнд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээ шаардлага тавьсан бөлгөө.

Тусгай хамгаалалттай газар нутгийн 1994 оны хуулийн нэгэн адил БОЯ-аас ТХГН-ийн орчны бүсийн тухай хуулийн оруулах нэмэлт өөрчлөлтийн тухай хуулийн төслийг 2006 онд боловсруулсан байна. Уг хуулийн төслийг хянаж 2007 онд IUCN-ны Азийн бүс нутгийн байгаль орчны хуулийн хөтөлбөрөөс гаргасан саналыг үндэслэн БОЯ-аас 2006 оны нэмэлт өөрчлөлтүүдийг дахин хянаж одоогоор хэлэлцэгдэх хуулийн шинэ үзэл баримтлалыг 2008 онд боловсруулжээ.

Газрын тухай онгол Улсын хууль

Газрын тухай Монгол Улсын шинэчлэгдсэн хууль өмнөх 1995 оны хуулийг оронд 2002 оны 7 дугаар сарын 7-нд хүчин төгөлдөр болсон юм. Уг хуулийн зорилт газрыг иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад эзэмшүүлэх, ашиглуулах болон түүнтэй холбоотой бусад харилцааг зохицуулахад оршино (Зүйл 1). Зүйл 3-т зааснаар “Газар” гэдэгт “газрын гадаргуу, түүний хөрс, ой, ус, ургамал бүхий орон зайн давхаргыг” (3.1.1) орох ба 1988 оны Газрын хэвлийн хуулиар (1995 онд шинэчлэгдсэн) зохицуулагдах газрын хэвлийг эзэмших, ашиглахтай холбоотой харилцааг үүнд оруулаагүй болно.

Төрийн өмчлөлийн бөгөөд хувийн эзэмшилд олгогдохгүй Тусгай хэрэгцээний газар хэмээх газрынтусгайангилалбуйболгосондугхуулийн байгаль орчны хамгааллын ач холбогдол оршино (Зүйл 5). **Тусгай хэрэгцээний газарт Улсын болон Орон нутгийн ТХГН орно (Зүйл 16).** Тусгай хэрэгцээний газрыг хувийн эзэмшилд олгохыг хориглосноор Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулийн дагуу хамгаалалттай газар нутагт уул уурхайн үйл ажиллагаа явуулахыг хориглосныг улам бүр баталгаажуулжээ.

Зүйл 27-48-д газар эзэмших эрхийн гэрчилгээ (зөвхөн Монгол Улсын иргэн, аж ахуйн нэгж болон байгууллагад олгогдох) болон газар ашиглах гэрчилгээний (гадаадын хуулийн этгээд, олон улсын байгууллага болон гадаад улс орнуудад олгож болох) тухай дурджээ. Зүйл 42,43-т засгийн газраас Тусгай хэрэгцээний газар болгохоор шийдвэрлэсэн талбайн хувьд газар эзэмших/ газар ашиглах гэрчилгээг эгүүлэн авах тухай заасан байна

(Жишээ нь Улсын болон Орон нутгийн ТХГН). Энэ тохиолдолд газар эзэмшигчид хэсэгчлэн эсхүл бүхэлд нь нөхөн олговор олгож, өөр газраар солих эсхүл сольж өгөхгүй байна. Нөгөөтэйгүүр газар ашиглагчидад нөхөн олговор олгохгүй.

Зүйл 50-д газар эзэмшигч, газар ашиглагчдыг газар хамгаалахыг шаардсан тухай заажээ. Тухайлбал, газар эзэмшигч болон ашиглагчид “газрын төлөв байдал, чанарыг хадгалах, байгалийн аясаар болон хүний үйл ажиллагааны улмаас хөрсний үржил шим буурах, газрын ургамлын бүрхэвч талхлагдах, хөрс элэгдэх, эвдрэх, хуурайших, намагжих, давжих, бохирдох, хордохоос (хиймийн бодисын бохирдол) сэргийлэх арга хэмжээг өөрийн зардлаар хариуцах ” хариуцлага хүлээнэ (50.1.1); “ашигт малтмал олборлох, барилгын материал бэлтгэх, төмөр зам, авто зам тавих, эрэл хайгуул, сорилт туршилт, шинжилгээний ажил хийх болон бусад хэрэгцээнд зориулан ухаж ашигласнаар эвдэрч гэмтсэн газрын тухай бүр өөрийн хүч, хөрөнгөөр нөхөн сэргээж, засаж тохижуулж байх ” (50.1.2); “газар, түүний баялаг, түгээмэл тархацтай ашигт малтмал ашиглахдаа байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхгүй байх” ба “ой төгөл, ховор, ховордсон амьтан, ургамал, түүх соёлын дурсгалт зүйл бүхий газрыг хамгаалах” (50.1.4) шаардлага тавигдсан байна.

Ойн тухай хууль

Анх 1995 онд батлагдсан Ойн тухай хууль шинэчлэгдэн 2007 оны 5 дугаар сарын 17-нд батлагдсан юм. Уг хуулийн зорилт “Монгол Улсын ой хамгаалах, эзэмших, зохистой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэхтэй холбогдсон харилцааг зохицуулахад оршино” (Зүйл 1).

Ойг хамгаалалтын бүсийн ой болон ашиглалтын бүсийн ой гэж ангилна (Зүйл 5). Зүйл 8-д “цармын бүслүүрийн ой, Тусгай хамгаалалттай газрын болон сургалт, судалгааны зориулалттай ой, ногоон бүс, хориотой зурвасын ой, заган ой, баянбүрдийн ой, 100 га хүртэлх хэмжээний төгөл ой, бут, сөөг, 30 хэмээс дээш налуу газрын ой ” (8.1) ба “хориотой зурвасын ойд нуур, рашаан, булаг, шандын ундаргын эргэн тойрон болон голын эргээс хоёр тийш 1000 метрийн доторхи ой, улсын чанартай авто болон төмөр замын дагуу хоёр талын 100 мутрийн доторхи ой” (8.2) зэргээс бүрдэх хамгаалалтын бүсийн ойн тодорхойлолт болон менежментийн зохицуулалтын талаар дурджээ. Хамгаалалттай бүсийн ойн менежментийн зохицуулалтын талаар Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хуулинд заажээ (8.4). бусад төрлийн ойн хувьд “зам, гүүр барих, ус, урчим хүч, холбооны шугам татах болон түймрээс хамгаалах шороон зурвас гаргах, ойн хэвийн өсөлт, нөхөн сэргээлтийг дэмжихэд чиглэгдсэн арчилгаа, цэвэрлэгээний арга хэмжээг хэрэгжүүлэх, ойн дагалт нөөцийг ашиглахаас ” бусад үйл ажиллагааг хориглосон байна (Зүйл 8.6). **Зүйл 8-д хамгаалалттай бүсийн бүх ойн орчинд уул уурхайн хайгуул, олборлолт явуулахыг хориглосон нь** нилээд өргөн утгыг хамарчээ. Гэхдээ хамгаалалттай бүсийн ойд уул уурхайн дэд бүтцийн барилга байгууламж (зам, цахилгааны шугам, г.м.) барихыг хориглоогүй шиг байна.

Ашиглалтын бүст хайгуул, олборлолтын үйл ажиллагааг хориглоогүй (Зүйл 9) ч ойтой холбоотой хэд хэдэн онцлог дүрэм журам үүнд үйлчлэх учиртай. Зүйл 35-д ашигт малтмал олборлох зэрэг үйл ажиллагааны явцад устгагдаж байгаа ойн нөхөн төлбөрийг аж ахуйн нэгж сум, дүүргийн төсөвт төлнө гэж заажээ. Түүнчлэн Зүйл 37-д хайгуул, олборлолтын тусгай зөвшөөрөлтэй эзэмшигчдийг ойн хамгаалал, нөхөн сэргээлтийн нөхөн төлбөрийг ойн ашиглалтаас олсон орлогын хамтаар төлөхийг аж ахуйн нэгжүүдээс шаарджээ.

Хавсралт 7: Уул уурхайн салбарын зохицуулалтын цар хүрээ

Сүүлийн арван жилд Монгол Улсын засгийн газар уурхайнуудын эзэмшигч болон ажиллуулагчаас менежер болон зохицуулалт болж өөрчлөгдсөн бөлгөө. Уг шилжилт уул уурхайн салбарыг зохицуулах хууль эрх зүйн цар хүрээг тодорхойлж байгаль орчны хувьд тогтвортой өсөлтийг хангахыг засгийн газраас шаардав (Дэлхийн банк 2006 он).

Монгол Улсын Үндсэн Хууль

Монголын уул уурхайн хайгуул, олборлолтын бааз суурийг 1992 онд батлагдсан Монгол Улсын Үндсэн Хуулиар таьсан бөлгөө. Эрдэс баялгийн өмчлөлийн тухайд Үндсэн хуулийн 3үйл 6-аад “Монгол Улсын иргэнд өмчлүүлснээс бусад газар, түүнчлэн газрын хэвлий, түүний баялаг, ой, усны нөөц, ан амьтан төрийн өмч мөн ” гэж заажээ (6.2). Газрыг хувьдаа эзэмших нь газрын хэвлийг өмчлөхөд хамаарахгүй гэж тус зүйлд цаашид дурдсан (6.3) ба төр улсын тусгай хэрэгцээг үндэслэн нөхөх олговортойгоор газрыг солих буюу эргүүлэн авах, “уг газрын хүн амын эрүүл мэнд, байгаль хамгаалал, үндэсний аюулгүй байдлын ашиг сонирхолд харшаар ашиглавал” хураан авч болно (6.4) гэж заажээ. Эцэст нь уг заалтад гадаадын иргэн болон аж ахуйн нэгжүүдэд “газрыг төлбөр, хугацаатайгаар болон хуульд заасан бусад болзол, журмаар ашиглуулж болно” гэсэн болой (6.5).

Монгол Улсын Ашигт малтмалын тухай хууль

1997 оны 7 дугаар сарын 1-ий өдөр хүчин төгөлдөр болсон хуулийг шинэчлэн 2006 оны 7 дугаар сарын 8-ны өдөр Монгол Улсын Ашигт малтмалын тухай хууль батлагдсан юм. Уг хуулийн зорилт “Монгол Улсын нутаг дэвсгэрт ашигт малтмал эрэх, хайх, ашиглахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино” (3үйл 1).

Ашигт малтмалын уг хууль “ус, газрын тос, байгалийн хийгээс бусад төрлийн ашигт малтмал эрэх, хайх, ашиглахтай холбогдсон харилцаа”-нд хамааралтай (3үйл 3.1). Харин гар аргаар болон бичил уурхайгаас ашигт малтмал ашиглахтай холбогдсон харилцааг тусд нь өөр хуулиар зохицуулах болжээ (3үйл 3.2).

3үйл 5-д Үндсэн хуулийн санааг “Монгол Улсын газрын гадаргуу болон түүний хэвлийд байгалийн байдлаараа оршиж байгаа ашигт малтмал төрийн өмч мөн” гэж дахин нотложээ (5.1). Уг заалтад цаашид “төр өмчлөгчийн хувьд ашигт малтмал эрэх, хайх, ашиглах эрхийг бусад этгээдэд олгох эрхтэй ” гэсэн байна (5.2). Мөн 5 дугаар зүйлд төр хувийн хэвшилтэй түншлэлийн зарчмаар хамтран ажиллаж болно гэсэн ба чингэхдээ төрийн оролцооны хэмжээ 50 хүртэлх (нөөцийг нь тогтооход улсын төсвийн хөрөнгө зарцуулагдсан нөхцөлд), эсхүл 34 хувь (нөөцийг бусад эх үүсвэрийн оролцоотойгоор тогтоосон нөхцөлд) байна гэж заажээ.

Монгол Улсын хуулийн дагуу бүртгэгдэж үйл ажиллагаа явуулж буй хувийн аж ахуйн нэгж болон нөхөрлөлд “хайгуулын тусгай зөвшөөрөл” болон “олборлолтын тусгай зөвшөөрөл” олож болно (3үйл 7.1). Хайгуулын тусгай зөвшөөрлөөр ашигт малтмалыг эрэх, хайх эрх олгох (3үйл 4.1.14) ба ашиглалтын тусгай зөвшөөрлөөр ашигт малтмал ашиглах эрх олгоно (3үйл 4.1.15). нөөц газар болон Тусгай хэрэгцээний газраас гадуул

хийгдэх нөхцөлд “ашигт малтмал байгаа эсхийг тогтоох зорилгоор газрын хэвлийг хөндөхгүйгээр чулуулгийн сорьц, дээж авах, геологи, ашигт малтмалын анхдагч мэдээлийг ашиглах, агаарын зураг авах рагаар геологийн судалгаа хийх аргыг” хэлэх тойм судалгаанд тусгай зөвшөөрөл шаардагдахгүй (Зүйл 4.1.2). Гэхдээ холбогдох аж ахуйн нэгж, нөхөрлөл ийнхүү үйл ажиллагаа явуулахаас өмнө төрийн төв болон орон нутгийн захиргааны байгууллагад урьдчилан мэдэгдэж холбогдох газар өмчлөгч, ашиглагчдаас зөвшөөрөл авах үүрэгтэй (Зүйл 15.2).

Хайгуулын тусгай зөвшөөрөл авах үйл явцын талаар Зүйл 17,19-д тусгажээ. Хайгуулын тусгай зөвшөөрлийг хамгийн түрүүнд өргөдөл гаргаж бүртгүүлсэн этгээдэд (Зүйл 18.1) гурван жилийн хугацаагаар (Зүйл 19.8) хоёр удаа сунгуулах боломжтойгоор (Зүйл 24.1.4) олгоно. Аж ахуйн нэгж, нөхөрлөлийн эзэмших тусгай зөвшөөрлийн тоонд хязгаар байхгүй (Зүйл 17.5).

Зүйл 19-д засгийн газрын эрх бүхий агентлаг (АМГТХЭГ) хайгуулын тусгай зөвшөөрлийн өргөдөл хүлээн авмагц өргөдлийг бүртгэн, урьдчилсан үнэлгээ хийж шаардлагад нийцэж буйг шалган, Тусгай хэрэгцээний газар зэргийг хамарсан уул уурхайн хайгуул, ашиглалт хийхийг хориглосон газар нутагтай давхардаж буйг тогтооно. Дээр дурдсан алхмыг хийсний дараа өргөдөл хүлээн авснаас хойш 20 хоногийн дотор АМГТХЭГ бичгээр өргөдөлд татгалзсан хариу өгсөн, хүссэн талбайд хайгуулын тусгай зөвшөөрөл олгож болох, эсхүл уг газрын тодорхой хэсэгт олгож болох (Тусгай хэрэгцээний газартай давхардсан нөхцөлд) тухай мэдэгдэнэ.

Зүйл 19-д олон нийтийн төлөөлөлтэй зөвшилцөх үйл явцын талаар дурджээ. АМГТХЭГ-аас холбогдох засаг даргад тухайн аймгийн (эсхүл нийслэл хотын) хайгуулын тусгай зөвшөөрлийн өргөдлийн тухай мэдэгдэнэ. Үүний дараа засаг дарга 30 хоногийн дотор холбогдох сумын (дүүргийн) ИХТ-ийн саналыг авч АМГТХЭГ-т хүргүүлнэ. “Монгол Улсын хуулинд заасан үндэслэлээр” засаг дарга хайгуулын тусгай зөвшөөрөл олгохоос татгалзаж болно (Зүйл 19.5). Гэхдээ засаг дарга уг шийдвэрийг дэмжих аваас АМГТХЭГ-аас хайгуулын тусгай зөвшөөрлийг олгох учиртай. Энэхүү заалтын нэг чухал онцлог бол тогтоосон 30 хоногийн дотор хариу өгөөгүй нөхцөлд “үүнийг зөвшөөрсөнд тооцож” (19.4) тусгай зөвшөөрлийг автоматаар олгоно.

2008 оны 1 дүгээр сарын 28-ны өдөр Улаанбаатар хотноо болсон Уул уурхайн тусгай зөвшөөрөл олгоход оролцох иргэдийн оролцоо уулзалтын үеэр болсон Хариуцлагатай уул уурхай ба эрдэс баялгийн ашилалтын цуврал хэлэлцүүлгийн хэсэгт орсон ТББ-ууд, орон нутгийн байгууллагуудын төлөөлөгчдийн хувьд 19 дүгээр зүйл анхаарлын цөм байлаа. ИТХ-аас санал авах төдий байдлаар олон нийтийн оролцооны албан ёсны хэрэгцээг хязгаарлаж буй, өргөдөлд санал өгөх хугацаа дэндүү бага бөгөөд 30 хоногийн дотор хариу аваагүй нөхцөлд өргөдөл автоматаар батлагддаг зэрэг асуудал гол санаа зовинол байлаа.

Хайгуулын тусгай зөвшөөрлийг олгосны дараа АМГТХЭГ-аас энэ тухай БОЯ, холбогдох аймаг, сум болон Улсын мэргэжлийн хяналтын албанд мэдэгдэнэ (Зүйл 19.10). БОЯ-ыг хайгуулын тусгай зөвшөөрөл олгосны дараа зөвхөн мэдээлж байгаа нь тэмдэглүүштэй ба энэ нь уг яаманд тухайн хайгуулын тусгай зөвшөөрөл бүхий талбай хамгаалалттай газар нутагтай давхардаж байгаа эсэхийг шалгах боломж олгодоггүй. Гэхдээ байгаль орчны тодорхой хамгааллын талаар Зүйл 37-оод “байгаль орчны албанаас зөвшөөрөл аваагүйгээр ашигт малтмал эрэх, хайх үйл ажиллагаа тусгай зөвшөөрөл эзэмшигч эхлэж болохгүй ” гэж заажээ (Зүйл 37.2).

Ашиглалтын өргөдөл гаргаж буй этгээд уг талбайн хайгуулын тусгай зөвшөөрөлтэй (Зүйл 24.1) байх ба уг тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн талбайд ашиглалтын тусгай зөвшөөрөл хүссэн өргөдөл гаргаагүй бол уг талбайд сонгон шалгаруулалтын журмаар ашиглалтын тусгай зөвшөөрөл олгоно (Зүйл 24.2). ашиглалтын тусгай зөвшөөрлийг 30 жилийн хугацаанд (Зүйл 26.5) хоёр удаа 20 жилийн хугацаагаар (Зүйл 27.1.6) сунгах боломжтойгоор олгоно.

Ашиглалтын тусгай зөвшөөрөл авах үйл

явцын талаар Зүйл 24, 26-аад дурдсан юм. Үйл явц бол ерөнхийдөө хайгуулын тусгай зөвшөөрлийнхтэй адилхан ба **үүнд хүсэлт гаргаж буй ашиглалтын талбай Тусгай хэрэгцээний газартай давхардаж болохгүй** (Зүйл 24.2.2) бөлгөө. Хайгуулын тусгай зөвшөөрлийн үйл явцаас ялгаатай нэг зүйл бол урьдчилсан үнэлгээний дараа АМГТХЭГ-аас “хайгуулаар тогтоосон ашигт малтмалын нөөцийн хэмжээ, үнэлгээ нь олборлолтоос үүсч болох экологийн хохирлыг нөхөн сэргээхэд хүрэлцэх эсэх”-ийг (Зүйл 26.2.3) тогтоох зорилгоор нэмэлт хянан шалгах үйл ажиллагаа явуулна. Үүний тулд ашилалтын өргөдөл гаргаж буй нэгэн өргөдлийн хамт БОНБҮ-ээг хамтаар хүргүүлэх шаардлагатай (Зүйл 25.1.7).

Өөр нэг гол ялгаа бол олон нийтийн хэлэлцүүлгийн тухай энд огт дурдаагүй юм: анхан шатны шүүлт хийсний дараа АМГТХЭГ өргөдөл бүртгэснээс хойш 20 хоногийн дотор өргөдлийн талаарх шийдвэрээ гаргана (Зүйл 26.3). Энэ алхамд байгаль хамгаалах тухай нэг гол санаа орсон ба хүсэлт гарагж буй талбай нь ямар нэгэн байдлаар Тусгай хэрэгцээний газартай давхардаж байвал “ашиглалтынтусгай зөвшөөрөл олгохгүй” гэсэн байна (Зүйл 26.3.4). Хайгуулын тусгай зөвшөөрлийн өргөдлийн үйл явцын нэгэн адил өргөдлийн дагуу тусгай зөвшөөрөл олгохоос өмнө БОЯ-нд мэдэгдэх заалт үгүй. Зүйл 26.7-ийн дагуу “Төрийн захиргааны байгууллага ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосноос хойш ажлын 7 хоногт байгтаан байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, татварын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбай байрших аймаг, сум, дүүргийн засаг дарга, мэргэжлийн хяналтын албанд энэ тухай тус тус мэдэгдэж, өдөр тутмын сонинд нийтлэнэ”.

Байгаль хамгаалахтай холбоотой тодорхой зохицуулалтыг Зүйл 37-40-д тусгажээ. Хайгуулын тусгай зөвшөөрөл авснаас 30 хоногийн дотор тусгай зөвшөөрөл эзэмшигчид Байгаль хамгаалах төлөвлөгөө боловсруулж хайгуулын талбай байрших сум, дүүргийн засаг даргаар батлуулна. Уг төлөвлөгөөнд бохирдолт тогтоосон хэмжээнээс даваагүй, ашигласан талбайн нөхөн сэргээлтийг явуулах арга хэмжээ авч ирээдүйд ард иргэд хэрэглэхэд тохиромжтой болгохыг батлагаажуулна. Эдгээр төлөвлөгөөг хайгуулын тусгай зөвшөөрөл олгохоос өмнө урьдчилан боловсруулж тусгай зөвшөөрлийг хянах үйл явцад үүнийг ашиглавал зүйд нийцнэ. Гэвч Зүйл 38.1.1-д хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд тусгай зөвшөөрөл хүлээн авснаас 30 хоногийн дотор уг төлөвлөгөө боловсруулах шаардлага тавьж байна.

Байгаль хамгаалах чиглэлээр тусгай зөвшөөрөл эзэмшигчид өөрийн үүрэг хариуцлагаа зөв зохистой биелүүлж буйг бататгах арга хэмжээ болгон хуулийн 38 дугаар зүйлд “байгаль орчны хамгаалах талаар хүлээсэн үүргээ биелүүлэх батлагаа болгон холбогдох сум, дүүргийн Засаг даргын нээсэн тусгай дансанд багаль орчныг хамгаалах арга хэмжээнд шаардагдах тухайн жилийн зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг шилжүүлнэ” гэжээ (38.1.8). байгаль хамгаалах төлөвлөгөөгөө биелүүлсэн нөхцөлд уг хөрөнгийг тусгай зөвшөөрөл эзэмшигчид эргүүлэн олгоно (38.4). Гэхдээ тэдгээр нь төлөвлөгөөгөө бүрэн биелүүлээгүй бол холбогдох сум (дүүргийн) засаг дарга байгаль орчин хамгаалах шаардлагатай арга хэмжээ авахад уг хөрөнгийг зарцуулах ба үүнд тусгай зөвшөөрөл эзэмшигч шаардлагатай бол нэмэлт хөрөнгө гаргаж өгнө (38.3).

Байгаль хамгаалах төлөвлөгөө боловсруулахын зэрэгцээ ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид 39 дүгээр заалтын дагуу БОНБҮ хийх шаардлагатай. Хайгуулын тусгай зөвшөөрлөөс ялгаатай нэг зүйл бол Байгаль хамгаалах төлөвлөгөө болон БОНБҮ-ээг ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохоос өмнө боловсруулах ёстой. БОНБҮ-нд “тухай уурхайн ажиллагааны явцад хүн амын эрүүл мэнд, байгаль орчинд учирч болзошгүй хортой нөлөөллийг урьдчилан тодорхойлж, түүнийг багасгах, арилгах арга хэмжээг тодорхойлох ” ёстой (39.1.2). Байгаль хамгаалах төлөвлөгөөнд “уурхайн ажиллагааг байгаль орчинд хохирол багатай явуулах, агаар мандал болон усны бохирдолт, хүн,

амьтан, ургамалд үзүүлэх сөрөг нөлөөллөөс сэргийлэх цогц арга хэмжээг тусгах” учиртай (39.1.3.) Түүнчлэн уг төлөвлөгөөнд : (i) “хортой болон хор хөнөөл учруулж болзошгүй бодис, материалыг хадгалах, хяналт тавих”; (ii) “газрын гадаргуугийн болон гүний усыг хамгаалах, ашиглах, хуримтлуулах”; (iii) “уурхайн хаягдлын далан барих, уурхайн талбайн аюулгүй байдлыг хангах” ба (iv) “нөхөн сэргээх арга хэмжээ” орно (39.1.4).

Ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид уул уурхайн үйл ажиллагаанаас байгаль орчинд нөлөөлөх бүх сөрөг нөлөөг агуулсан Байгаль орчин хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар жилийн тайлан боловсруулж БОЯ, мэргэжлийн хяналтын газар болон холбогдох аймаг (эсхүл нийслэл хотын) эсхүл сумын (эсхүл дүүргийн) засаг даргад хүргүүлнэ.

Хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн нэгэн адил ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид “(БОЯ)-аас нээсэн тусгай дансанд байгаль орчныг хамгаалах арга хэмжээ хэрэгжүүлэхэд шаардагдах тухайн жилийн зардлын 50 хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг шилжүүлэх” үүрэгтэй бөлгөө (39.1.9). дахин давтахад уг баталгаат хөрөнгийг Байгаль хамгаалах төлөвлөгөөгөө биелүүсэн нөхцөлд тусгай зөвшөөрөл эзэмшигчид эргүүлэн олгох юм (39.4). Гэхдээ тэдгээр нь төлөвлөгөөгөө биелүүлээгүй нөхцөлд БОЯ уг баталгаат хөрөнгийг хэрэгцээтэй байгаль хамгаалах арга хэмжээнд зарцуулж шаардлагатай бол тусгай зөвшөөрөл эзэмшигч нэмэлт хөрөнгө гаргах ёстой бөлгөө (39.3). Байгаль хамгаалах зорилгоот баталгаат хөрөнгө байршуулах тухай тусгай зөвшөөрөл эзэмшигчдэд тавигдах уг шаардлага байгаль орчны хамгааллын хүсэн хүлээж буй төвшин болон чанарт нөлөөлөөгүйг тэмдэглэх нь зүйтэй. Энэ нь гол төлөв байгаль хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг хангах хүчин чадавхи дутмаг, нөгөөтэйгүүр, уурхайн ажил зогссоны дараа байгаль орчин хамгаалах ажлыг дуустал бүрэн дүүрэн хийхэд шаардагдах нэмэлт санхүүжилт гаргах хүсэл эрмэлзлэл, чадавхиар ашигалалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид дутаг байсантай холбоотой (Дэлхийн банк 2006 он).

Ашигт малтмалын хуулинд төв болон орон нутгийн засаг захиргааны Газрын хуулинд тусгагдсан “хайгуул болон ашиглалт хязгаарлагдсан эсхүл хориглогдсон” Тусгай хэрэгцээний газар нутгийг хүлээн зөвшөөрсөн юм (3үйл 4.1.2). Тусгай хэрэгцээний газар нутгийн хувьд (улсын болон орон нутгийн ТХГН-ийг оруулсан) Монголын Парламентад “тодорхой нутаг дэвсгэрт ашигт ммалтмал эрэх, хайх, ашиглахыг, эсхүл хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл олгохыг хязгаарлах буюу хориглох ” эрх олгогдсон (3үйл 8.1.5.). Түүнчлэн Монголын Парламент Улсын ТХГН-т хийгдэх тойм судалгаа, хайгуул болон ашиглалтыг хянах үүрэгтэй (3үйл 8.1.3.) бол засгийн газар өөр төрлийн улсын төвшний Тусгай хэрэгцээний газар нутагт явагдах ийнхүү үйл ажиллагааг хянах үүрэгтэй (9.1.3.). орон нутгийн төвшинд Газрын хуулийн зохицуулалтын дагуу Тусгай хэрэгцээний газар нутгийг байгуулах үүргийг орон нутгийн засаг захиргааны байгууллага хариуцна (3үйл 12.1.4).

Тусгай хэрэгцээний газар нутагт хийгдэх ашиглалтын хязгаар болон хоригын талаар 3үйл 14-т тусгасан болно. Уг зүйлд төв болон орон нутгийн засаг захиргааны байгууллагыг АМГТХЭГ-т Тусгай хэрэгцээний газар нутаг байгуулсан талаар мэдэгдэж АМГТХЭГ-т хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл болон картографийн бүртгэлд тухайн газар нутгийн байршлыг бүртгэх үүргийн талаар дурджээ. Уг зүйлд мөн түүнчлэн “хүчин төгөлдөр хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлөөр олгогдсон талбайг бүхэлд нь, эсхүл хэсэгчлэн тусгай хэрэгцээнд авснаар тусгай зөвшөөрөл эзэмшигч ашигт малтмал эрэх, хайх, ашиглах боломжгүй болсон бол тухайн шийдвэр гаргасан байгууллага тусгай зөвшөөрөл эзэмшигчид нөхөн олговор төлнө” гэж заажээ (14.4). Нөхөн төлбөрийн хэмжээний хувьд “тусгай зөвшөөрөл эзэмшигч болон тухайн газрыг тусгай хэрэгцээнд авах шийдвэр гаргасан байгууллага хоорондоо тохиролцон тогтоох бөгөөд тохиролцоонд хүрээгүй бол эрх бүхий хөндлөнгийн этгээдийн дүгнэлтийг үндэслэн төрийн захиргааны байгууллага тогтооно”

гэжээ (14.5). Тухай газар Тусгай хэрэгцээний газар нутгаар тогтоогдсон үндэслэлээр хайгуулын буюу ашиглалтын тусгай зөвшөөрлийг цуцлаж тусгай зөвшөөрөл эзэмшигчид бүрэн нөхөн олговор олгох тухай Зүйл 56-аад дахин дурджээ.

Зүйл 14, 56-аад газар нутгийг тусгай хэрэгцээнд хайгуул буюу ашиглалтын тусгай зөвшөөрлөөс гаргах механизмыг буй болгож (хамгаалалттай газар нутаг байгуулах зэрэг) холбогдох байгууллагад тусгай зөвшөөрөл эзэмшигчид нөхөн олговор төлөх үүргийг ногдуулжээ. Практик дээр нөхөн олговор төлөх хөрөнгө хомс байгаа нь шинээр байгуулагдсан хамгаалалттай газар нутагтай давхардаж буй тусгай зөвшөөрлийг холбогдох байгууллагын хувьд (ихэвчлэн БОЯ) цуцлах болмжгүй байдагтай холбоотой (Фарингтон 2005 он). Иймээс хамгаалалттай газар нутгийг тусгай зөвшөөрлийг цуцлах замаар байгуулж нөхөн төлбөр олгогдоогүй нөхцөлд хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчид байгаль орчны нэмэлт ямар стандартад, хэрэв ямар нэг нь байдаг бол, нийцэх шаардлагатай нь тодорхойгүй байна.

Хайгуул болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн хил хязгаарын талаар гарах маргааныг шийдвэрлэхийн хувьд Зүйл 13-т урьд өмнө тусгай зөвшөөрөл олгогдсон газар нутгийг түр хугацаагаар улсын хяналтанд байлгаж тухайн газар нутагт хийгдэх тойм судлагаа, хайгуул, ашиглалтыг түр зогсоох эрх мэдэл засгийн газарт олгожээ. Бусад зүйлийн зэрэгцээ “нөөц газар” гэж нэрлэгдэх ийнхүү газрыг “тусгай зөвшөөрлийн бүртгэлийн чанарыг сайжруулах” (13.1.1) болон “тусгай зөвшөөрөл эзэмшигчдийн хооронд хил хязгаарын талаар үүссэн маргааныг шийдвэрлэх” зорилгоор байгуулж болно.

Ерөнхийдөө тусгай зөвшөөрөл цуцлагдсанаар тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх үүрэг дуусгавар болдог. Харин ганц тохиолдолд “байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, уурхайг хаах талаар ... болон байгаль орчныг хамгаалах тухай хуульд тогтоомжийн дагуу хүлээх үүргээс чөлөөлөгдөхгүй” (Зүйл 53.3). Энэ үүрэгт уурхайг хаахаас өмнө “уурхайн талбайг нийтийн зориулалтаар ашиглахад аюулгүй болгох, байгаль орчныг нөхөн сэргээх талаар холбогдох арга хэмжээг бүрэн авах” зэрэг орно (Зүйл 45.1).

Ашигт малтмалын тухай хуулийг зөрчсөнд ногдуулах эрүүгийн хэрэгт тооцогдохгүй шийтгэлийг зааж өгсөн байна. Уг шийтгэлд 100 мянган төгрөгийн торгууль ногдуулах, тусгай зөвшөөрлийг түр цуцлах буюу бүр мөсөн цуцлах зэрэг арга хэмжээ орно. Гэвч Ашигт малтмалын тухай хуулийн байгаль орчны заалтуудын биелэлт төдийлөн сайнгүй (Дэлхийн банк 2006), Улсын мэргэжлийн хяналтын газраас уурхайд ногдуулсан торгуулийн жагсаалтыг мэдээлэхээс татгалзсан зэрэг мэдээлэл байна.

Газрын хэвлийн тухай Монгол Улсын хууль

Газрын хэвлийн тухай Монгол Улсын хууль анх 1988 оны 11 дүгээр сарын 20-нд батлагдаж 1995 оны 4 дүгээр сарын 17-нд шинэчлэгдсэн юм. Уг хуулийн зорилт “өнөөгийн болон хойч үеийхний ашиг сонирхолд нийцүүлэн газрын хэвлийг ашиглах, хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино” (Зүйл 1). Уг хууль Газрын тухай хуулийг (газрын хэвлийг хөндөөгүй) нөхөж байгаа ба 2006 оны Ашигт малтмалын тухай хуулиар тэлэн өргөжсөн эрдэс баялгийн хайгуул, ашиглалтын талаар зарим ерөнхий зохицуулалтыг уг хуулиар хийлээ.

Газрын хэвлийд бүх төрлийн чулуулаг, ашигт малтмал болон геологийн бусад биет орно (Зүйл 4). Зүйл 3-ын дагуу газрын хэвлийн бол дан ганц төрийн өмч. Иймээс үүнийг ашиглаж болохоос хэзээ ч өмчлөхгүй. Зүйл 9-т Монголын хууль тогтоомжоор зөвшөөрөгдсөн нөхцөлд газрын хэвлийг Монголын болон гадаадын иргэд, аж ахуйн нэгж ашиглаж болно.

Зүйл 10-т газрын хэвлийг геологийн судлагааны зорилгоор ашиглаж “газрын хэвлийн ашигт малталын хайгуул, ашиглалттай холбоотой харилцааг Ашигт малтмалын хуулиар зохицуулна” гэж заажээ (10.2). Байгаль орчны хамгаалалын талаар Зүйл 20-д газрын хэвлий ашигласан этгээдээс

“газрын хэвлий ашиглахад үүсч болзошгүй хортой нөлөөнөөс хий мандлын агаар, газар, ой, ус, рашаан, мал, амьтан, байгаль орчны бусад обьект, барилгын байгууламжийг найдвартай хамгаалах, түүнчлэн тусгай хамгаалалттай газар, байгалийн болон түүх, соёлын дурсгалт зүйлийн хадгалалт, хамгаалалтыг хангах” (20.2.3) ба “орон нутгийн засаг захиргааны байгууллагад эргүүлж өгөхөөс өмнө газрын хэвлийг ашиглах явцад эвдэрсэн газрыг засаж тохижуулах”-ыг шаардаж байна (20.2.4).

Гар аргаар алт олборлолтын түр журам

Гар аргаар болон бичил уул уурхайн асуудлыг Ашигт малтмалын тухай хуульд огт тусгаагүй тухай урьд өмнө дурдсан билээ. 2001, 2002 онуудад засгийн газраас энэхүү асуудлыг зохицуулах зорилгоор уул уурхайн албас бус эдгээр төрлийн түр журам баталсан юм. Эдгээр журам төдийлөн үр дүнтэй байсангүй тул шинэчлэгдээгүй байна. Иймээс засгийн газар Гар аргаар олборлолт хийх тухай хууль боловсруулсан ч Парламентаас дэмжлэг аваагүйн улмаас 2005 оны 8 сард бүр мөсөн хэлэлцүүлгээс хасагдсан юм (Дэлхийн банк 2006 он). Швейцарийн хөгжил, хамтын ажиллагааны байгууллагаас АМГТХЭГ-тай хамтран хууль тогтоомжийн төсөл боловсруулах, зуучлал болон маргаан шийдвэрлэх, технологи шилжүүлэх, сургалт болон эрүүл мэндэд учруулах эрсдлийг бууруулах, аюулгүй байдал болон байгаль орчны зэрэг асуудлуудыг онцлон гар аргаар олборлолт хийх чиглэлээр санаачлага гаргажээ (Дэлхийн банк 2006 он).

Энэхүү санаа санаачлагт Гар аргаар болон бичил уул уурхайг 2015 он хүртэл хөгжүүлэх, Гар аргаар болон бичил уул уурхайн үйл ажиллагааг зохицуулах түр журамын тухай сүүлийн үед гарсан 2008 оны 2 дугаар сарын 27-ны өдрийн Засгийн газрын 71,72 дугаар тогтоолууд орно. Гар аргаар болон бичил уур уурхайн хууль батлагдтал үйлчлэх түр журам уурхайчдын холбоо байгуулах, гэрээний дагуу эдгээр холбоодод газар олгох зэрэг асуудлыг тусган гар аргаар болон бичил уул уурхайн үйл ажиллагааны зохицуулалтын хууль эрх зүйн үндсийг бүрдүүлсэн бөлгөө.

Түр журмын дагуу сумдын (эсхүл дүүргийн) ИТХ өөрийн мэдлийн хүрээнд гар аргаар болон бичил уул уурхайн үйл ажиллагаанд зориулж сумынхаа хоёр хүртэлх хэсэг газар олгох эрхтэй. Энэ газарт дараах орно: (i) ашигт малтмалын нөөцийн хэмжээ, чанарын хувьд томоохон уул уурхайн аж ахуйн нэгжүүдэд эдийн засгийн үр ашиг муутай ашигт малтал;(ii) уул уурхайн олборлолт явагдаж нөхөн сэргээлт хийдэзгүй газар ба (iii) тусгай зөвшөөрөл эзэмшигч, сум/дүүргийн засаг дарга болон холбоодын хооронд байгуулсан гурвалсан гэрээний дагуу ашиглалтын талбайн зарим газрыг гар аргаар болон бичил уул уурхайн үйл ажиллагаа эрхлэгчдэд өгөх. Энэ тохиолдолд уул уурхайн холбоод холбогдох сум/ дүүргийн засаг дарга нартай гэрээ байгуулна. Бусад зүйлийн зэрэгцээ эдгээр гэрээнд байгаль орчныг нөхөн сэргээх талаар санал болгож буй болон төлөвлөж буй арга хэмжээг онцолж зөвшөөрөлгүйгээр эсхүл тусгай зөвшөөрлөгүйгээр хиймийн болон тэсэрч дэлбэрэх бодис хэрэглэхгүй гэсэн заавал биелүүлэх үүрэг тусгагдах учиртай.

Түр журмын 10 дугаар зүйлд Тусгай ххамгаалаттай газар нутагт, Тусгай хэрэгцээний газар, нөөц газар (Ашигт малтмалын тухай хуулийн 3үйл 13-т тусгагдсан), орон нутгийн тахилага шүтлэгтэй газрууд, ойн болон усны нөөц бүхий газрууд болон бусад олон төрлийн талбайд **гар аргаар болон бичил уул уурхайн үйл ажиллагаа явуулахыг хатуу хориглосон байна.**

Олборлолтын салбарын ил тод байдлын санаачлага

Олборлолтын салбарын ил тод байдлын санаачлага (ОСИТБС) нь газрын тос, хий болон уул уурхайн аж ахуйн нэгжүүдээс засгийн газар, засгийн газрын аж ахуйн нэгжид төлөх төлбөрийн ил тод байдлыг сайжруулахын зэрэгцээ хүлээн авагч орны засгийн газрын орлогын ил тод байдлыг бататгах зорилго агуулна. 2006 оны 1 дүгээр сарын 4-ий өдөр Монгол Улсын засгийн газар тогтоол гаргаж уг санаачлагыг хэрэгжүүлэх үүрэг бүхий Үндэсний ОСИТБС-ын зөвлөл байгуулав (Дэлхийн банк 2006 он).

Хавсралт 8: Олон улсын хөгжлийн банкуудын баримталдаг байгаль орчныг хамгаалах бодлогууд

Дэлхийн банкны байгаль орчныг хамгаалах бодлого

Дэлхийн банкны байгаль орчныг хамгаалах тулгуур бодлого бол Байгаль орчны үнэлгээний Үйл ажиллагааны бодлого (ОР)/ Банкны процедур (ВР) 4.01 гэж урьд өмнө дурдсан билээ. Байгаль орчны үнэлгээг байгаль орчинд нөлөөлөх байдлын хийгдэх үнэлгээний цар хүрээ, төрлийг тодорхойлох, мөн уг төсөл байгаль хамгаалах бусад бодлогод харшилж буйг тогтоох зорилгоор хөрөнгө оруулалтын зээл болгоноор хийдэг. Үүнтэй холбоотой бусад бодлогод Амьдрах орчны тухай ОР/ВР 4.04, Нөөцийн талаар ОР/ВР 4.11 болон Ойн талаар ОР/ВР 4.36 зэрэг орно.

Дэлхийн банкны байгаль хамгаалах бодлогын дагуу үнэлгээ хийх нь зээлдэгч улс орны засгийн газрын хариуцлага бөгөөд Дэлхийн банк уг бодлогод хэрхэн нийцэж буй талаар ерөнхий хариуцлага хүлээнэ.

Амьдрах орчны талаар Дэлхийн банкны үйл ажиллагааны бодлого (ОР 4.04, 2001 оны 6 сар) нь дараах үгийг иш татдаг: “Амьдрах орчныг хамгаалах явдал...удаан хугацаанд тогтвортой хөгжихөд нэн чухал” ба үүний зэрэгцээ дараахийг агуулдаг. Үүнд:

- Банк өөрийн үйл ажиллагаа, эдийн засаг, салбарын ажил, төслийн санхүүжилт болон бодлогын яриа хэлэлцээнд амьдрах орчны хамгаалал, тохижилт болон нөхөн сэргээлтийг дэмждэг;
- Банкны эдийн засаг, салбарын ажилд дараахийг тодорхойлох орно. Үүнд: (а) тодорхой амьдрах орчинд учирч буй аюулын төвшин зэрэг амьдрах орчны тулгамдсан асуудлууд болон амьдрах орчны хамгааллын онцгой хэрэгцээ шаардлага (нэн ялангуяа чухал газар нутгуудын хувьд) ба (б) тухай улс орны хөгжлийн стратегийн агуулгатай уг газар нутгийн хамгааллыг уялдуулах;
- Байгаль хамгаалалд чухал газар нутгуудад ноцтой өөрчлөлт, доройтол үзүүлж болохуйц гэж үзсэн төслүүдэд дэмжлэг үзүүлэхгүй гэсэн зарчмыг банк баримталдаг;
- Чухал газар нутаг, тэдгээрийн гүйцэтгэдэг экологийн үүрэг функц, тухай газар нутагт учирч буй аюулын төвшин, байгаль хамгаалах асуудлын тэргүүн ач холбогдол, холбогдох санхүүжилт болон хүчин чадавхи бүрдүүлэх хэрэгцээ шаардлагыг тодорхойлох зэрэг газар нутгийн томоохон асуудлыг хөгжил, байгаль орчны стратегийн дүн шинжилгээндээ тусгахыг Банк зээлдэгч нарт уриалдаг.

Чухал газар нутгуудад (i) одоогоор хамгаалалттай болон засгийн газраас хамаалалтанд авах санал албан ёсоор дэвшүүлсэн газар нутгууд (Дэлхийн байгаль хамгаалах холбооны шалгуурт нийцэх нөөц газар) ба (ii) Банкнаас боловсруулсан нэмэлт жагсаалтанд тусгагдсан болон Бүс нутгийн байгаль орчны салбарын нэгжийн тогтоосон эх сурвалж бүхий газар нутгууд орно. Эдгээр газарт орон нутгийн ард иргэдийн хүлээн зөвшөөрсөн газрууд (тахилага шүтлэгтэй); биологийн төрөл зүйлийн хамгаалалд илүүтэй нийцэх газар нутгууд; болон ховор, эмзэг, нүүдлийн болон аюулд өртсөн амьтанд чухал газар нутгууд орно. Тухай ан амьтны элбэг байдал, эндемизмын төвшин, ховор байдал болон бүрэлдэхүүн зүйлийн эмзэг байдал, төлөөлөл ба эко тогтолцооны нэгдмэл байдал зэрэг хүчин зүйлийг үндэслэж жагсаалт боло всруулдаг.

Ноцтой өөрчлөлт гэдэг нь “газар эсхүл

усны ашиглалтанд урт хугацаанд орсон өөрчлөлтийн улмаас байгаль хамгаалалд чухал газар нутгууд эсхүл бусад газар нутгийн нэгдмэл байдал алдагдах буюу үлэмж багасах"-ыг хэлнэ. Харин *доройтол* гэдэг нь "уугуул популяцийг тогтвортой тэтгэн дэмжих тухайн амьдрах орчны чадавхийг үлэмж хорогдуулах байгаль хамгаалалд чухал газар нутаг буюу бусад газар нутгийн өөрчлөлт" юм.

***Олон улсын санхүүгийн корпорацийн байгаль хамгаалах* бодлого**

Олон улсын санхүүгийн корпораци нь Дэлхийн банкны бүлгийн хувийн хэвшилд зээл олгогч гар бөлгөө. Түүний байгаль хамгаалах гол бодлого нь Биологийн төрөл зүйлийн хамгаалал ба Байгалийн баялгийн тогтвортой менежмент гэгдэх Гүйцэтгэлийн стандарт 6 юм.

Энэхүү гүйцэтгэлийн стандартын дагуу дараах нөхцөл шаардлагад нийцэхээс бусад тохиолдолд зээлдэгч нь байгаль хамгаалалд чухал газар нутгийг ноцтой өөрчилж, доройтуулахгүй ажээ:

- Техник болон санхүүгийн хувьд боломжийн альтернатив хувилбар үгүй;
- Төслөөс гарах нийт ашиг байгаль орчин болон биологийн төрөл зүйл хамгаалахад зарцуулсан зардлаас илүү байх;
- Аливаа ноцтой өөрчлөлт болон доройтлыг зүй зохистой байдлаар багасгах.

"Байгаль хамгаалалд чухал газар нутгууд" гэгдэх газарт Гүйцэтгэлийн стандарт 6 бүр илүү хатуу нөхцөл тавьдаг. Эдгээр газар нутгат дараах шаардлагад нийцэхээс нааш зээлдэгч ямарваа нэгэн төсөл хэрэгжүүлэхгүй:

- Зүйлийн популяц буюу эко тогтолцоог тэтгэн дэмжих байгаль хамгаалалд чухал газар нутгийн чадавхид нөлөөлөх хэмжиж болохуйц сөрөг нөлөөлөл үгүй;
- Ноцтой ауюлд өртсөн буюу аюулд өртсөн хүлээн зөвшөөрөгдсөн зүйлийн популяци хорогдохгүй;
- Бусад бага зэргийг нөлөөллийг багасгах.

ОУСК-ийн хэрэглэж буй "байгаль хамгаалалд чухал газар нутаг" гэдэг тодорхойлолт нь Дэлхийн банкны хэрэглэж буй тодорхойлтоос бага зэрэг өөр юм. Чухал газруудад дараах газар нутаг орно. Үүнд:

- Ноцтой аюулд өртсөн буюу аюулд өртсөн зүйлийг оршин тогтноход шаардагдах газар нутаг зэрэг биологийн төрөл зүйлийн өндөр ач холбогдолтой газар;
- Эндемик буюу хязгаарлагдмал зүйлд чухал ач холбогдол бүхий;
- Зүйлийн өвөрмөц хослол, эсхүл шилжин хувирах гол үйл явцтай холбоотой буюу эко тогтолцооны гол үйлчилгээ үзүүлдэг;
- Нүүдлийн амьтны оршин тогтноход чухал;
- Даян дэлхийд ач холбогдолтой усны шувуудын үлэмж бөөгнөрөлийг тэтгэн дэмжих

Азийн хөгжлийн банкны (АХБ) байгаль хамаалах бодлого

Санал болгож буй зээлийн төслүүдийн байгаль орчны шинжилгээний системчилсэн процедурыг батлах зэрэг замаар АХБ өөрийн үйл ажиллагаандаа байгаль орчны хамгааллын асуудлыг харгалзан үздэг.

АХБ-ны байгаль орчин хамгаалах процедур Байгаль орчны бодлого болон Байгаль орчны үнэлгээний удирдамжинд тусгагдсан.

АХБ-аас өгч буй бүр зээл болон хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтад Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийх шаардлага тавьдаг. Дэлхийн банк болон ОУСК-тай нэгэн адил АХБ-ны байгаль орчны үнэлгээний шаардлагын дагуу үнэлгээ хийх хариуцлага зээлдэгч хүлээдэг бөгөөд АХБ-аас зээлдэгчтэй тохирсон байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг багасгах арга хэмжээний хэрэгжилтийг хангах, мониторинг хийх зэргийг хариуцна.

Төслийг шүүх үйл явцад байгаль орчинд нөлөөлөх байдлын ач холбогдолыг үнэлж БРНБҮ-ээг явуулах шаардлагатай эсэхийг тодорхойлсноор төслүүдийн байгаль орчны ангилалыг тогтоодог.

Байгаль орчны түргэн үнэлгээний асуудлын жагсаалтыг ашиглаж төслүүдийг үзэл баримтлалын эхний үе шатанд байгаль орчны ангилалаар ангилах зорилгоор дүн шинжилгээ болон баримтжуулалтыг сайжруулахыг зорьсон байгаль орчныг үнэлгээний шинэ удирдамжийг АХБ-аас 2003 онд боловсруулсан.

“Байгаль орчны хувьд эмзэг газар нутаг”-ыг ойролцоох буюу түүний дотор хэрэгжих төслүүдэд байгаль орчны хамгийн хатуу судлагаа хийх шаардлага тавигддаг. Эдгээр газрыг соёлын өвд орсон газар, хамгаалалттай газар нутаг ба ТХГН-ийн орчны бүсийн газар, чийгэрхэг газар болон биологийн төрөл зүйлийг хамгаалах тусгай газар нутаг орно.

Биологийн төрөл зүйлийн хувьд чухал газар нутгийн тухай мэдээлэл байгаль орчны түргэн үнэлгээ явуулахад тус дөхөмтэй ба төслүүдийг байгаль орчны хувьд эмзэг газар нутагт буюу түүнтэй ойрхон бүст байршилтайг тогтооно.

Европын сэргээн босголт, хөгжлийн банкны байгаль орчин хамгаалах бодлого

Байгаль орчны бодлогынхоо хүрээнд ЕСБХБ-аас хүрээлэн буй орчин хийгээд түүний тэтгэн дэмждэг биологийн төрөл зүйлийг хамгаалах арга хэмжээг үйл ажиллагаандаа хамрах хүчин чармайлт гаргадаг.

Байгаль орчны эрсдэлийг үнэлж шаардагдах байгаль орчны үнэлгээний төвшинг тодорхойлох үүднээс ЕСБХБ-аас бүс төслөө шүүн шалгадаг. Хөрөнгө оруулалтыг байгаль орчинд үзүүлж болзошгүй нөлөөллийн шинж чанар болон ач холбогдлоор нь гурав ангилдаг. Ирээдүйд байгаль орчинд үлэмж ихээр сөргөөр нөлөөлж болзошгүй төслүүдийг Ангилал А-аад оруулж, тэдгээрт заавал БОНБҮ хийн, сөрөг нөлөөллөөс зайлсхийх, багасгаж бууруулах арга хэмжээ авахыг шаарддаг.

Ангилал А-д орсон төслүүдэд “Эмзэг байршил” бүхий гэгдэх газар хэрэгжих буюу түүнд нөлөөлж болзошгүй төслүүд бас ордог. Эмзэг байршилд байгалийн цогцолборт газар, хамгаалалттай бусад газар, чийгэрхэг газар, биологийн төрөл зүйлийг өндөр ач холбогдол бүхий ой, археологийн болон соёлын ач холбогдолтой газар нутаг, уугуул иргэд болон эмзэг бүлгийн бусад хүмүүст чухал газар ордог.

Биологийн төрөл зүйлийн хувьд чухал газруудын талаарх мэдээллийн дөхөм байдал “Эмзэг байршлыг ” тодорхойлоход тус дэм болдог ба улмаар энэхүү байгаль хамгаалах бодлогыг тууштай хэрэгжүүлэхэд туслалцаа үзүүлдэг юм.

Японы олон улсын хөгжлийн банкны байгаль хамгаалах бодлого

ЯОУХБ-аас 2003 онд өмнөх хоёр багцыг нэгтгэн шинэчилсэн байгаль хамгаалах удирдамжийн шинэ багцыг хэрэгжүүлсэн юм. Эдгээр удирдамжийн дагуу ЯОУХБ-аас санхүүжилтийн шийдвэр гаргахаас өмнө бүс туөслийн үнэлгээ болон байгаль орчны судлагаа хийдэг.

Үнэлгээ буюу анхдагч шүүлтийн үе шатанд санал болгож буй төслүүдийг шаардагдах байгаль орчны судалгааны цар хүрээг тогтоох зорилгоор байгаль үзүүлэх нөлөөллийн шинж чанараар ангилдаг. Байгаль орчинд үлэмж сөрөг нөлөө үзүүлж болзошгүй төслүүдийг А-ангилалд оруулдаг. А ангилалын төслүүд дараах байршил бүхий Эмзэг газар нутаг буюу түүний ойролцоо газар байршдаг. Үүнд:

- Улсын ТХГН;
- Экологийн чухал үнэлэмж бүхий газар нутаг;
- Дотоодын хууль тогтоомж болон олон улсын гэрээ, хэлэлцээрээр хамгаалалтад байх учиртай ховор амьтдыг тэтгэх газар нутаг.

А ангилалын төслүүдэд байгаль орчны үнэлгээний өргөн цар хүрээ бүхий судалгаа хийдэг. Эдгээр судалгаагаар болзошгүй сөрөг нөлөөллийг нягталж байгаль нөлөөлөх эерэг нөлөөллийг тодорхойлон, сөрөг нөлөөллийг багасгаж, эерэг нөлөөллийг хөхиүлэх арга хэмжээг үнэлэх үйл ажиллагаа хийгддэг. Түүнчлэн зээлдэгч нар БОНБҮ-ий тайланг хүлээн авагч орны байгаль орчны хууль, стандартын дагуу боловсруулж хүргүүлнэ.

ЯОУХБ-ны байгаль орчин хамгаалах бодлогод чухал газар нутгийн тухай мэдээллийг тусгах нь байгаль орчны удирдамжийг хэрэгжүүлэхэд тус дэм болох учиртай. Нэгдүгээрт, ингэснээр төслийг шүүж үнэлэх үе шатанд Эмзэг газар нутгийн стандарт жагсаалтыг харгалзсанаар уг үе шатыг тууштай бөгөөд ойлгомжтой болгон. Хоёрдугаарт, төслүүдийн болзошгүй сөрөг нөлөөллийг тодотгосноор байгаль орчны үнэлгээний үйл явцад тус дэм болно.

Хавсралт 9: Улсын ТХГН ба хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл хийгээд уул уурхайтай холбоотой дэд бүтцийн улмаас өндөр эрсдэлд буй газар нутгийн хоорондын давхардал

№	Газрын нэр	Нийт талбай (га)	Хайгуулын давхардал (га)	Ашиглал-тын давхар-дал (га)	Нийт давхар-дал (га)	Давхард-лын %	Өндөр эсдэл бүхий талбай (га)	Өндөр эрсд-лийн %
	Дархан цаазат газар							
1	Богд хаан уул	41,383			0	0.0	41,383	100.0
2	Дорнод Монгол	615,732	698		698	0.1		0.0
3	Их говь “А”	4,644,091	2,450		2,450	0.1		0.0
4	Их говь “В”	921,551	358		358	0.0		0.0
5	Хан хэнтий	1,233,351			0	0.0	114,382	9.3
6	Хасагт хайрхан	31,854	1,149		1,149	3.6		0.0
7	Хөх сэрхийн нуруу	74,474			0	0.0		0.0
8	Хорьдол сарьдаг	227,968	1		1	0.0		0.0
9	Монгол дагуур “А”	85,085	676		676	0.8		0.0
10	Монгол дагуур “В”	18,617			0	0.0		0.0
11	Нөмрөг	333,155			0	0.0		0.0
12	Отгонтэнгэр	96,620			0	0.0		0.0
13	Бага говь “А”	1,166,346	14,989		14,989	1.3	66,368	5.7
14	Бага говь “В”	695,036	14,195		14,195	2.0	24,553	3.5
15	Улс нуур	462,503		48	48	0.0	26,030	5.6
16	Алтан элс	171,203			0	0.0		0.0
17	Цагаан шувуут	34,624			0	0.0		0.0

№	Газрын нэр	Нийт талбай (га)	Хайгуулын давхардал (га)	Ашиглал-тын давхар-дал (га)	Нийт давхар-дал (га)	Давхард-лын %	Өндөр эсдэл бүхий талбай (га)	Өндөр эрсд-лийн %
18	Түргэн	133,810	5,220		5,220	3.9	84,183	62.9
	Байгалийн цогцолборт газар							
1	Алтай таван богд	623,220			0	0.0	32,124	5.2
2	Дарьганга	70,086	2,421		2,421	3.5		0.0
3	Говь гурван сайхан	2,680,819	5,975		5,975	0.2	98,937	3.7
4	Горхи-тэрэлж	292,010			0	0.0	62,352	21.4
5	Их богд уул	262,858			0	0.0		0.0
6	Хан хөхий	214,331	10,724		10,724	5.0	38,306	17.9
7	Хяргас нуур	374,746	1,360		1,360	0.4	52,539	14.0
8	Хангайн нуруу	889,986	132	428	560	0.1	176,609	19.8
9	Хар ус нуур	862,014	11		11	0.0	78,934	9.2
10	Хөгнө тарна	78,798			0	0.0		0.0
11	Хорго тэрхийн цагаан нуур	85,007			0	0.0	16,602	19.5
12	Хөвсгөл нуур	848,828			0	0.0		0.0
13	Хустайн нуруу	57,341	1,637		1,637	2.9	533	0.9
14	Молцог элс	488			0	0.0		0.0
15	Мөнххайрхан уул	308,230	37		37	0.0	12,830	4.2
16	Мянган угалзат	63,129			0	0.0	15,408	24.4
17	Ноёнхангай	59,162	43		43	0.1		0.0
18	Онон балж “А”	291,814	626		626	0.2	47,913	16.4
19	Онон балж “В”	102,881	21		21	0.0		0.0
20	Отхоны хөндий	92,955			0	0.0	0	0.0
21	сийлхэм “А”	77,843			0	0.0	15,498	19.9
22	сийлхэм “В”	76,647	193		193	0.3	46,035	60.1
23	Тарвагатай нуруу	557,447			0	0.0		0.0
24	Цамбагарав	113,012	493		493	0.4		0.0
25	Тужийн нарс	70,864			0	0.0	20,642	29.1
26	Улаантайга	108,832			0	0.0		0.0
	Байгалийн нөөц газар							
1	Алаг хайрхан	36,100			0	0.0		0.0
2	Батхаан	21,759			0	0.0		0.0

№	Газрын нэр	Нийт талбай (га)	Хайгуулын давхардал (га)	Ашиглал-тын давхар-дал (га)	Нийт давхар-дал (га)	Давхард-лын %	Өндөр эсдэл бүхий талбай (га)	Өндөр эрсд-лийн %
3	Булган гол	11,892		2	2	0.0	11,892	100.0
4	Бурхан буудай	51,571	3,293		3,293	6.4		0.0
5	Дэвэлийн арал	10,022			0	0.0	10,022	100.0
6	Эргэлийн зоо	57,581	3,506		3,506	6.1		0.0
7	Их газрын чулуу	34,096	21,301		21,301	62.5		0.0
8	Их нартын чулуу	70,088	6,516	1	6,517	9.3	42,287	60.3
9	Ханжаргалант уул	62,971			0	0.0	17,530	27.8
10	Хар ямаат	51,274	343	1	344	0.7	40,653	79.3
11	Лхачинвандад	55,382	7		7	0.0	4,935	8.9
12	Нагалхан	4,806	1,455		1,455	30.3	4,806	100.0
13	Намнан уул	29,709			0	0.0		0.0
14	Шарга	320,046	10,298		10,298	3.2	75,684	23.6
15	Манхан	84,701			0	0.0		0.0
16	Тэсийн гол	108,589			0	0.0		0.0
17	Тосон хулстай	471,937	7,046	413	7,459	1.6	74,645	15.8
18	Угтам	42,595	2,823		2,823	6.6	10,852	25.5
19	Яхь гол	248,672	9,544		9,544	3.8	102,871	41.4
20	Загийн ус	283,832	9,358		9,358	3.3		0.0
	Дурсгалт газар							
1	Булган уул	2,002			0	0.0	577	28.8
2	Даяндээрхийн агуй	31,303			0	0.0		0.0
3	Ээж хайрхан	22,904			0	0.0	9,513	41.5
4	Хүйсийн найман нуур	11,158			0	0.0		0.0
5	Хүргийн хөндий	6,109	4		4	0.1		0.0
6	Шилийн богд	18,152			0	0.0		0.0
7	Сүйхэнт уул	7,717	2,112		2,112	27.4		0.0
8	Уран тогоо тулга уул	5,420			0	0.0	2,277	42.0
	Бүс газар	22,413,136	141,014	891	141,905	0.6	1,480,670	6.6

Хавсралт 10: ШЧГ ба хайгуул, ашиглалтын тусгай зөвшөөрөл хийгээд уул уурхайн дэд бүтэцтэй холбоотой өндөр эсдэл бүхий газар нутгийн хоорондын давхардал

№	Газрын нэр	Нийт талбай (га)	Хайгуулын давхардал (га)	Ашиглал-тын давхар-дал (га)	**Нийт давхар-дал (га)**	**Давхард-лын %**	**Өндөр эсдэл бүхий талбай (га)**	**Өндөр эрсд-лийн %**
1	Хотон-хоргон нуур	19,629			0	0.0	468	2.4
2	Цэнгэл хайрхан уул	52,726	49,663		49,663	94.2	12,027	22.8
3	Даяан нуур	13,537			0	0.0		0.0
4	Булган гол	32,700	7,212		7,212	22.1	3,731	11.4
5	Хөх сэрхийн нурууны ТХГН	74,502			0	0.0		0.0
6	Толбо нуур	16,334	2,761		2,761	16.9		0.0
7	Ачит нуур	98,278	7,273		7,273	7.4	30,592	31.1
8	Үүрэг нуур	28,308			0	0.0	10,312	36.4
9	Увс нуур	502,462		11.0	11	0.0	22,755	4.5
10	Бага ба баян нуур	5,317			0	0.0		0.0
11	Увсын хар ус нуур	13,601	4,239		4,239	31.2	8,773	64.5
12	Айраг нуур	73,348			0	0.0		0.0
13	Хонгил	6,027			0	0.0		0.0
14	Хар ус нуур	297,265			0	0.0	45,251	15.2
15	Жаргалант хайрхан уул	162,264	708		708	0.4		0.0
16	Хар нуур	83,798			0	0.0	39,930	47.7
17	Хөмийн тал	78,059			0	0.0	14,727	18.9

№	Газрын нэр	Нийт талбай (га)	Хайгуулын давхардал (га)	Ашиглал-тын давхар-дал (га)	**Нийт давхар-дал (га)**	**Давхард-лын %**	**Өндөр эсдэл бүхий талбай (га)**	**Өндөр эрсд-лийн %**
18	Сантмарга-цийн баян нуур	14,205	1,113		1,113	7.8		0.0
19	Улаагчин хар нуур	13,439	1,584		1,584	11.8		0.0
20	Ойгон нуур	20,189	4,758		4,758	23.6		0.0
21	Тэлмэн нуур	24,175			0	0.0		0.0
22	Отгонтэнгэр уул	88,753			0	0.0		0.0
23	Завхан гол-эрээн нуур	65,735			0	0.0		0.0
24	Хасагт хайрхан уул	28,309			0	0.0		0.0
25	Тайгам нуур	4,170			0	0.0		0.0
26	Бөөн цагаан нуур	43,262			0	0.0		0.0
27	Их богд уул	86,440			0	0.0		0.0
28	Оог нуур	20,195			0	0.0		0.0
29	Таацийн цагаан нуур	12,385			0	0.0		0.0
30	Хангайн нуруу байгалийн цогцолборт газар	897,840	191	18	209	0.0	175,263	19.5
31	Тэрхийн цагаан нуур	21,072			0	0.0	4,759	22.6
32	Хөвсгөлийн сангийн далай нуур	25,194			0	0.0		0.0
33	Эрхэл нуур	3,537			0	0.0	3,355	94.9
34	Дархадын хотгор	195,223	3,409		3,409	1.7	30,559	15.7
35	Хөвсгөл нуур	380,212			0	0.0		0.0
36	Булган тал	40,445	1,745		1,745	4.3		0.0
37	Тэшгийн олон нуур	5,774			0	0.0	4,947	85.7
38	Айрхан нуур	7,212			0	0.0		0.0
39	Тариалан	31,630	537		537	1.7		0.0
40	Сэлэнгэ тээл	18,568	323		323	1.7		0.0
41	Шарга нуур	2,118			0	0.0		0.0
42	Өгий нуур	10,189			0	0.0		0.0

№	Газрын нэр	Нийт талбай (га)	Хайгуулын давхардал (га)	Ашиглал-тын давхар-дал (га)	**Нийт давхар-дал (га)**	**Давхард-лын %**	**Өндөр эсдэл бүхий талбай (га)**	**Өндөр эрсд-лийн %**
43	Дашинчилэн баян нуур	1,598	1,598		1,598	100.0	1,598	100.0
44	Эрдэнэсант уул	34,776			0	0.0		0.0
45	Өлзийтийн сангийн далай нуур	1,491			0	0.0		0.0
46	Говь гурван сайхан уул	544,794	9,779		9,779	1.8	1,688	0.3
47	Борзон говь	399,467	43,487		43,487	10.9	3,026	0.8
48	Галбын говь	828,328	497,627		497,627	60.1	61,183	7.4
49	Их газрын чулуу	9,300			0	0.0		0.0
50	Их нартын чулуу байгалийн нөөц газар	66,601	242	7.6	250	0.4	40,709	61.1
51	Ээж хад	36,867			0	0.0	15,510	42.1
52	Хустайн нуруу байгалийн цогцолборт газар	49,932			0	0.0		0.0
53	Сэлэнгийн цагаан нуур	17,143			0	0.0		0.0
54	Орхон, Сэлэнгэ голын ундарга	21,405			0	0.0	15,758	73.6
55	Ханхэнтий ТХГН	1,234,755			0	0.0	111,675	9.0
56	Горхи тэрэлжийн цогцолборт газар	293,937			0	0.0	62,493	21.3
57	Майхант уул	42,015	1,721	138.0	1,859	4.4	42,015	100.0
58	Хөх хүйтэн голын хөндий	35,722	460		460	1.3		0.0
59	Онон балж	104,841	219		219	0.2	14,951	14.3
60	Хар ямаат байгалийн нөөц газар	51,404			0	0.0	41,521	80.8
61	Ганга нуур	26,841	43		43	0.2		0.0

№	Газрын нэр	Нийт талбай (га)	Хайгуулын давхардал (га)	Ашиглал-тын давхар-дал (га)	**Нийт давхар-дал (га)**	**Давхард-лын %**	**Өндөр эсдэл бүхий талбай (га)**	**Өндөр эрсд-лийн %**
62	Шаазан нуур	5,485	3,752		3,752	68.4	5,485	100.0
63	Цэнгэлэг нуур	8,877			0	0.0		0.0
64	Түргэн цагаан, Зэгст, Туулайтын бөөр	35,282	1,272		1,272	3.6	22,023	62.4
65	Угтам байгалийн нөөц газар	46,162	442		442	1.0	12,245	26.5
66	Монгол дагуур	309,440	25,049		25,049	8.1	15,179	4.9
67	Хөх нуур	11,548			0	0.0		0.0
68	Буйр нуур	90,476			0	0.0		0.0
69	Ташгайн таван нуур	53,304	53,304		53,304	100.0		0.0
70	Нөмрөг	378,097			0	0.0		0.0
	Бүх газар	8,358,313	724,512	175	724,687	8.7	874,505	10.5

Хавсралт 11. Улсын ТХГН-т буюу ойролцоо байршилтай жуулчны баазууд

Жуулчны баазын нэр	Улсын ТХГН-ийн нэр	Ангилал
Богдхаан цогцолбор	Богд хаан уул	Дархан цаазат газар
Манзушир	Богд хаан уул	Дархан цаазат газар
Овооны энгэр	Богд хаан уул	Дархан цаазат газар
Голын эрэг	Богд хаан уул	Дархан цаазат газар
Одон орон судлалын төв	Богд хаан уул	Дархан цаазат газар
Цагаан шонхор	Богд хаан уул	Дархан цаазат газар
Улаанбаатар бааз 1	Богд хаан уул	Дархан цаазат газар
Улаанбаатар бааз 2	Богд хаан уул	Дархан цаазат газар
Улаанбаатар бааз 3	Богд хаан уул	Дархан цаазат газар
Улаанбаатар бааз 4	Богд хаан уул	Дархан цаазат газар
Улаанбаатар бааз 7	Богд хаан уул	Дархан цаазат газар
Улаанбаатар бааз 8	Богд хаан уул	Дархан цаазат газар
Улаанбаатар бааз 9	Богд хаан уул	Дархан цаазат газар
Бүүвэйт	Горхи тэрэлж	Цогцолборт газар
Тэохий хад	Горхи тэрэлж	Цогцолборт газар
Сан жуулчин	Горхи тэрэлж	Цогцолборт газар
Тэрэлж бумбат	Горхи тэрэлж	Цогцолборт газар
Тэрэлж бааз 1	Горхи тэрэлж	Цогцолборт газар
Тэрэлж бааз 2	Горхи тэрэлж	Цогцолборт газар
Тэрэлж бааз 3	Горхи тэрэлж	Цогцолборт газар
Тэрэлж бааз 4	Горхи тэрэлж	Цогцолборт газар
Тэрэлж бааз 5	Горхи тэрэлж	Цогцолборт газар
Тэрэлж бааз 6	Горхи тэрэлж	Цогцолборт газар
Тэрэлж бааз 7	Горхи тэрэлж	Цогцолборт газар
Тэрэлж бааз 8	Горхи тэрэлж	Цогцолборт газар
Тэрэлж бааз 9	Горхи тэрэлж	Цогцолборт газар
Тэрэлж бааз 10	Горхи тэрэлж	Цогцолборт газар
Тэрэлж бааз 11	Горхи тэрэлж	Цогцолборт газар
Тэрэлж бааз 12	Горхи тэрэлж	Цогцолборт газар
Тэрэлж бааз 13	Горхи тэрэлж	Цогцолборт газар

Жуулчны баазын нэр	Улсын ТХГН-ийн нэр	Ангилал
Тэрэлж бааз 14	Горхи тэрэлж	Цогцолборт газар
Тэрэлж бааз 15	Горхи тэрэлж	Цогцолборт газар
Тэрэлж бааз 16	Горхи тэрэлж	Цогцолборт газар
Тэрэлж бааз 17	Горхи тэрэлж	Цогцолборт газар
Тэрэлж бааз 18	Горхи тэрэлж	Цогцолборт газар
Тэрэлж бааз 19	Горхи тэрэлж	Цогцолборт газар
Тэрэлж бааз 20	Горхи тэрэлж	Цогцолборт газар
Тэрэлж бааз 21	Горхи тэрэлж	Цогцолборт газар
Тэрэлж бааз 22	Горхи тэрэлж	Цогцолборт газар
Тэрэлж бааз 23	Горхи тэрэлж	Цогцолборт газар
Тэрэлж бааз 24	Горхи тэрэлж	Цогцолборт газар
Тэрэлж бааз 25	Горхи тэрэлж	Цогцолборт газар
Тэрэлж бааз 26	Горхи тэрэлж	Цогцолборт газар
Тэрэлж бааз 27	Горхи тэрэлж	Цогцолборт газар
Тэрэлж бааз 28	Горхи тэрэлж	Цогцолборт газар
Тэрэлж бааз 29	Горхи тэрэлж	Цогцолборт газар
Тэрэлж бааз 30	Горхи тэрэлж	Цогцолборт газар
Тэрэлж бааз 31	Горхи тэрэлж	Цогцолборт газар
Тэрэлж бааз 32	Горхи тэрэлж	Цогцолборт газар
Тэрэлж бааз 33	Горхи тэрэлж	Цогцолборт газар
UB 2	Горхи тэрэлж	Цогцолборт газар
Хашхан	Хангайн нуруу	Цогцолборт газар
Орхон бааз 1	Хангайн нуруу	Цогцолборт газар
Орхон бааз 2	Хангайн нуруу	Цогцолборт газар
Орхон бааз 3	Хангайн нуруу	Цогцолборт газар
Орхон бааз 4	Хангайн нуруу	Цогцолборт газар
Орхон бааз 5	Хангайн нуруу	Цогцолборт газар
Орхон бааз 6	Хангайн нуруу	Цогцолборт газар
Орхон бааз 7	Хангайн нуруу	Цогцолборт газар
Талбиун	Хангйн нуруу	Цогцолборт газар
Хөгнө бааз	Хөгнө тарна	Цогцолборт газар
Хөгнөхаан бааз 1	Хөгнө тарна	Цогцолборт газар
Хөгнөхаан бааз 3	Хөгнө тарна	Цогцолборт газар
Хөгнө бааз 1	Хорго тэхийн цагаан нуур	Цогцолборт газар
Хорго бааз 2	Хорго тэхийн цагаан нуур	Цогцолборт газар
Сортийн тулга	Хорго тэхийн цагаан нуур	Цогцолборт газар
Хөвсгөл бааз 1	Хөьсгөл нуур	Цогцолборт газар
Хөвсгөл бааз 2	Хөвсгөл нуур	Цогцолборт газар
Хөвсгөл бааз 3	Хөвсгөл нуур	Цогцолборт газар
Хөвсгөл бааз 4	Хөвсгөл нуур	Цогцолборт газар
Хөвсгөл бааз 5	Хөвсгөл нуур	Цогцолборт газар

Жуулчны баазын нэр	Улсын ТХГН-ийн нэр	Ангилал
Хөвсгөл бааз 6	Хөвсгөл нуур	Цогцолборт газар
Хөвсгөл бааз 7	Хөвсгөл нуур	Цогцолборт газар
Хөвсгөл бааз 8	Хөвсгөл нуур	Цогцолборт газар
Хөвсгөл далай	Хөвсгөл нуур	Цогцолборт газар
Хөвсгөл хаан	Хөвсгөл нуур	Цогцолборт газар
Уянга	Хөвсгөл нуур	Цогцолборт газар
Хэцүү хад	Хяргас нуур	Цогцолборт газар
Млцог элс	Молцог элс	Цогцолборт газар
Хаан тайж	Отхоны хөндий	Цогцолборт газар
Шивээт манхан	Отхоны хөндий	Цогцолборт газар
Цайдам	Отхоны хөндий	Цогцолборт газар
Цэнхэр жигүүр	Отхоны хөндий	Цогцолборт газар
Угтам	Угтам	Байгалийн нөөц газар

Хавсралт 12. Орон нутгийн ТХГН-т буюу ойролцоо байрших жуулчны баазууд

Жуулчны баазын нэр	Орон нутгийн ТХГН нэр
Багагазрын чулуу	Бага газрын чулуу
Энх	Баруун өл
Баянзаг бааз 1	Баянзаг
Хангай дисковери	Булган хангай уул
Говь бааз 2	Говь гурван сайхан
Жуулчин говь	Говь гурван сайхан
Түвшин	Говь гурван сайхан
Хаан тайж	Хархорин
Орхоны бааз 1	Хархорин
Молцог элс	Молцог элс
Бааз 5	Нарийн хамар
Хатан өгий	Өгий нуур ба ойр орчмын газар
Өгий бааз 1	Өгий нуур ба ойр орчмын газар
Өгий бааз 2	Өгий нуур ба ойр орчмын газар
Өгий бааз 3	Өгий нуур ба ойр орчмын газар
Их говь	Онгийн хийд
Шаргалжуут	Түйн голын хөндий

Хавсралт 13. ШЧГ-т буюу ойр орчмын газар байрших жуулчны баазуудын нэр

Жуулчны баазын нэр	ШЧГ-ын нэр
Хэцүү хад	Айраг нуур
Бүүвэйт	Горхи тэрэлжийн цогцолборт газар
Мэлхий хад	Горхи тэрэлжийн цогцолборт газар
Сан жуулчин	Горхи тэрэлжийн цогцолборт газар
Тэрэлж бумбан	Горхи тэрэлжийн цоцгоцлборт газар
Тэрэлж бааз 1	Горхи тэрэлжийн цогцолборт газар
Тэрэлж бааз 2	Горхи тэрэлжийн цогцолборт газар
Тэрэлж бааз 3	Горхи тэрэлжийн цогцолборт газар
Тэрэлж бааз 4	Горхи тэрэлжийн цогцолборт газар
Тэрэлж бааз 5	Горхи тэрэлжийн цогцолборт газар
Тэрэлж бааз 6	Горхи тэрэлжийн цогцолборт газар
Тэрэлж бааз 7	Горхи тэрэлжийн цогцолборт газар
Тэрэлж бааз 8	Горхи тэрэлжийн цогцолборт газар
Тэрэлж бааз 9	Горхи тэрэлжийн цогцолборт газар
Тэрэлж бааз 10	Горхи тэрэлжийн цогцолборт газар
Тэрэлж бааз 11	Горхи тэрэлжийн цогцолборт газар
Тэрэлж бааз 12	Горхи тэрэлжийн цогцолборт газар
Тэрэлж бааз 13	Горхи тэрэлжийн цогцолборт газар
Тэрэлж бааз 14	Горхи тэрэлжийн цогцолборт газар
Тэрэлж бааз 15	Горхи тэрэлжийн цогцолборт газар
Тэрэлж бааз 16	Горхи тэрэлжийн цогцолборт газар
Тэрэлж бааз 17	Горхи тэрэлжийн цогцолборт газар
Тэрэлж бааз 18	Горхи тэрэлжийн цогцолборт газар
Тэрэлж бааз 19	Горхи тэрэлжийн цогцолборт газар
Тэрэлж бааз 20	Горхи тэрэлжийн цогцолборт газар
Тэрэлж бааз 21	Горхи тэрэлжийн цогцолборт газар
Тэрэлж бааз 22	Горхи тэрэлжийн цогцолборт газар
Тэрэлж бааз 23	Горхи тэрэлжийн цогцолборт газар
Тэрэлж бааз 24	Горхи тэрэлжийн цогцолборт газар
Тэрэлж бааз 25	Горхи тэрэлжийн цогцолборт газар
Тэрэлж бааз 26	Горхи тэрэлжийн цогцолборт газар
Тэрэлж бааз 27	Горхи тэрэлжийн цогцолборт газар

Жуулчны баазын нэр	ШЧГ-ын нэр
Тэрэлж бааз 28	Горхи тэрэлжийн цогцолборт газар
Тэрэлж бааз 29	Горхи тэрэлжийн цогцолборт газар
Тэрэлж бааз 30	Горхи тэрэлжийн цогцолборт газар
Тэрэлж бааз 31	Горхи тэрэлжийн цогцолборт газар
Тэрэлж бааз 32	Горхи тэрэлжийн цогцолборт газар
Тэрэлж бааз 33	Горхи тэрэлжийн цогцолборт газар
Тэрэлж бааз 34	Горхи тэрэлжийн цогцолборт газар
UB 2	Горхи тэрэлжийн цогцолборт газар
Хашхан	Хангайн нуруцны цогцолборт газар
Орхон бааз 1	Хангайн нурууны цогцолборт газар
Орхон бааз 2	Хангайн нурууны цогцолборт газар
Орхон бааз 3	Хангайн нурууны цогцолборт газар
Орхон бааз 4	Хангайн нурууны цогцолборт газар
Орхон бааз 5	Хангайн нурууны цогцолборт газар
Орхон бааз 6	Хангайн нурууны цогцолборт газар
Орхон бааз 7	Хангайн нурууны цогцолборт газар
Талбиун	Хангайн нурууны цогцолборт газар
Хөвсгөл бааз 1	Хөвсгөл нуур
Хөвсгөл бааз 2	Хөвсгөл нуур
Хөвсгөл бааз 3	Хөвсгөл нуур
Хөвсгөл бааз 4	Хөвсгөл нуур
Хөвсгөл бааз 5	Хөвсгөл нуур
Хөвсгөл бааз 6	Хөвсгөл нуур
Хөвсгөл бааз 7	Хөвсгөл нуур
Хөвсгөл бааз 8	Хөвсгөл нуур
Хөвсгөл далай	Хөвсгөл нуур
Хөвсгөл хаан	Хөвсгөл нуур
Өгий	Өгий нуур
Өгий бааз 4	Өгийн нуур
Энх	Шаазан нуур
Хорго бааз 1	Тэрхийн цагаан нуур
Хорго бааз 2	Тэрхийн цагаан нуур
Угтам	Угтам байгалийн нөөц газар

Газрын зураг 1. Монгол орны Улсын тусгай хамгаалалттай газар нутаг, ***2008оны 6 сарын байдлаар***



Газрын зураг 2. Монгол орны Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутаг, *2008 оны 5 сарын байдлаар*



Газрын зураг 3. Монгол орны олон улсын хэмжээнд хамгаалагдсан газрууд



Газрын зураг 4. Монгол орны тахилага шүтлэгтэй газрууд



Газрын зураг 5. Монгол орны шувуудад чухал газрууд



Газрын зураг 6.Байгаль хамгаалалд чухал газар нутгуудын нэгдсэн байдлын зураг



Газрын зураг 7. Хайгуулын тусгай зөвшөөрөл олгогдсон газрын зураг, *2008 оны 6 сарын байдлаар*



Газрын зураг 8. Монгол орны жуулчны баазуудын байршил



Газрын зураг 9. Байгаль хамгаалахад чухал газар нутгууд болон хайгуулын тусгай зөвшөөрлийн давхардал



Газрын зураг 10. Байгаль хамгаалахад чухал газар нутгууд болон олборлолтын тусгай зөвшөөрлийн давхардал



Газрын зураг 11. Олборлолтын тусгай зөвшөөрөл бүхий талбай, түүнээс 20 км зайд орших газрууд болон байгаль хамгаалахад чухал газар нутгуудын давхардал



Газрын зураг 12. Байгаль хамгаалахад чухал газар нутгууд болон жуулчны баазуудын давхардал



Газрын зураг 13. Байгаль хамгаалахад чухал газар нутгууд болон Дорнод аймгийн зүүн хойд хэсгийн хайгуул, олборлолтын тусгай зөвшөөрөл бүхий газруудын давхардал

Газрын зураг 14. Улсын тусгай хамгаалалттай газрууд, шувуудад чухал газрууд болон Өмнөговь аймаг дахь олборлолтын тусгай зөвшөөрөл бүхий газруудын давхардал



Газрын зураг 15. Их газрын чулууны байгалийн нөөц газар болон хайгуул, олборлолтын тусгай зөвшөөрөл бүхий газруудын давхардал



Газрын зураг 16. Нагалханы байгалийн нөөц газар болон хайгуул, олборлолтын тусгай зөвшөөрөл бүхий газруудын давхардал



Газрын зураг 17. Сүйхэнт уулын дурсгалт газар болон хайгуул, олборлолтын тусгай зөвшөөрөл бүхий газруудын давхардал



Газрын зураг 18. Таван толгойн орон нутгийн тусгай хамгаалалттай газар болон хайгуул, олборлолтын тусгай зөвшөөрөл бүхий газруудын давхардал



Газрын зураг 19. Дашинчилэнгийн Баян нуурын шувуудад чухал газар болон хайгуул, олборлолтын тусгай зөвшөөрөл бүхий газруудын давхардал



Газрын зураг 20. Ташгайн таван нуурын шувуудад чухал газар болон хайгуул, олборлолтын тусгай зөвшөөрөл бүхий газруудын давхардал



Газрын зураг 21. Цэнгэл хайрхан уулын шувуудад чухал газар болон хайгуул, олборлолтын тусгай зөвшөөрөл бүхий газруудын давхардал



Газрын зураг 22. Шаазан нуурын шувуудад чухал газар болон хайгуул, олборлолтын тусгай зөвшөөрөл бүхий газруудын давхардал



Газрын зураг 23. Галбын говийн шувуудад чухал газар болон хайгуул, олборлолтын тусгай зөвшөөрөл бүхий газруудын давхардал



Хөдөөгийн хөгжил, Байгалийн Нөөц ба Байгаль орчин
Зүүн Ази, Номхон Далайн Бүс

Дэлхийн Банк
1818 Н гудамж, БХ
Вашингтон хот, 20499, АНУ

Утас: 202 473 1000
Факс: 202 522 1666

Интернет хуудас: worldbank.org/eapenvironment
www.worldbank.org/eaprural

Бердлайф Интернейшнал

ТМ Суйдобаши Байр, 4-р давхар, Миса
Чидояа-ку, Токио хот, 106-0061, Япон улс

Утас: +81 3 52130461
Факс: +81 3 52130422
Имэйл: info@birdlife-asia.org
Веб хуудас: www.birdlife-asia.org

Монголын Зэрлэг Амьтан Судлах Хамгаалах Төв

Ундрам Плаза Төв, 404
Баянзүрх Дүүрэг
Улаанбаатар 51, Монгол улс

Утас: +976 99 257886
Имэйл: info@wscc.org.mn
Вебхуудас: **www.**wscc.org.mn